



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ САЙН ДУРЫН ХОЁРДУГААР ИЛТГЭЛ 2023

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТ





МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ САЙН ДУРЫН ХОЁРДУГААР ИЛТГЭЛ 2023

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТ

УЛААНБААТАР ХОТ
2023



Монгол Улсын Засгийн газар

Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2023: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт
Улаанбаатар хот

Энэхүү илтгэл нь монгол, англи хэлээр хэвлэгдсэн болно. Энэхүү илтгэлд ашиглагдсан тоо, мэдээллийг тусгайлан дурдсанаас бусад тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын албан ёсны эх үүсвэрээс авсан болно.

Холбоо барих: Эдийн засаг, хөгжлийн яам
Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний Гудамж 5/1
Утас: (976) 51-263333
И-мэйл: info@med.gov.mn
Вэб сайт: www.med.gov.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН НЭР ТОМЬЁО	7
ЗУРАГ, ХҮСНЭГТ, ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ	8
ТАЛАРХАЛ	10
УДИРТГАЛ	11
ИЛТГЭЛИЙН ХУРААНГУЙ	12
БҮЛЭГ 1. ИЛТГЭЛ БОЛОВСРУУЛСАН ҮЙЛ ЯВЦ, АРГА ЗҮЙ	14
1.1. Үндэсний сайн дурын илтгэлийг боловсруулсан үйл явц	15
1.2. Арга зүйн хүрээ	16
1.3. ҮСДИ боловсруулах үйл явцаас олсон сургамж	16
БҮЛЭГ 2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БОДЛОГЫН ОРЧИН, ИНСТИТУЦИЙН ТОГТОЛЦООНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ	18
2.1. Монгол Улсын хөгжлийн бодлогууд ба зорилтууд	19
2.2. Институцийн тогтолцоонд гарсан өөрчлөлт	20
2.3. Олон талт оролцоо, түншлэл	21
2.4. Тогтвортой хөгжлийн зорилгын санхүүжилтийн механизм	25
2.5. Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн үр дүнгийн хяналт, үнэлгээ, тайлагнал	25
БҮЛЭГ 3. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, АХИЦ ДЭВШИЛ	28
3.1. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд хэр ахиц дэвшил гарсан бэ?	29
3.2. Монгол Улс 2030 он гэхэд зорилгодоо хүрэх үү?	29
3.3. ТХЗ-ын зорилго тус бүрийн хэрэгжилтийн төлөв байдал	30
Зорилго 1. Ядуурлыг бууруулах	32
Зорилго 2. Хүнсний аюулгүй байдлыг хангаж, тогтвортой хөдөө аж ахуйг хөхүүлэн дэмжих	33
Зорилго 3. Эрүүл мэндийг дэмжих	34
Зорилго 4. Чанартай боловсролыг дэмжих	36
Зорилго 5. Жендерийн тэгш байдал, охид эмэгтэйчүүдийн эрхийг хангах	37
Зорилго 6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	39
Зорилго 7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	40
Зорилго 8. Эдийн засгийн өсөлт, зохистой ажлын байрыг бий болгох	41
Зорилго 9. Инновацыг дэмжиж, дэд бүтцийг сайжруулах	47
Зорилго 10. Тэгш бус байдлыг бууруулах	48
Зорилго 11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	49
Зорилго 12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих	50
Зорилго 13. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг багасгах	51
Зорилго 15. Хуурай газрын эко системийг хамгаалах	52
Зорилго 16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох	54
Зорилго 17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	56
БҮЛЭГ 4. ЦАР ТАХАЛ, ГЕОПОЛИТИКИЙН ЗӨРЧИЛДӨӨНИЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТЭД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД	60
4.1. Монгол Улсад үүссэн онцгой нөхцөл байдал, бодлогын хариу арга хэрэгслийн тойм	61
4.2. Монгол Улсын тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлд үзүүлсэн нөлөө	62
4.3. Бизнесийн үйл ажиллагаа, зохистой хөдөлмөр эрхлэлтэд үзүүлсэн нөлөө	65
4.4. Өрхийн амьжиргаа, тогтвортой хэрэглээнд үзүүлсэн нөлөө	68
4.5. Эрүүл мэндийн салбарт үзүүлсэн нөлөө	69
4.6. Боловсролын салбарт үзүүлсэн нөлөө	70
4.7. Монгол Улсын дэд бүтцийн салбарт үзүүлсэн нөлөө	72



БҮЛЭГ 5. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯЗГААРЛАГЧ ХҮЧИН ЗҮЙЛ: БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ	74
5.1. Бүс, орон нутаг руу чиглэсэн хөгжлийн бодлого, төлөвлөлт	75
5.2. Бүс, орон нутгийн хөгжилд саад болж буй түлхүүр асуудлууд	76
5.3. Бүс, орон нутгийг хөгжүүлэх гарц шийдэл, зөвлөмж	90
БҮЛЭГ 6. ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙ БАЙХ ЗАРЧИМ	95
6.1. Хөгжлөөс алслагдсан бүлэг	96
6.2. Хөгжлөөс алслагдсан байдал: Суурь үйлчилгээний хүртээмжийн ялгаа	96
ДҮГНЭЛТ	101
ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	103
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	104
ХАВСРАЛТ	108



ТОВЧИЛСОН НЭР ТОМЬЁО

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АНДЭЗНК	Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комисс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ЗЗНДН	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МУТХҮБ	Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
МУИС	Монгол Улсын их сургууль
МҮХАҮТ	Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ХАА	Хөдөө аж ахуй
ХДХВ/ДОХ	Хүний дархлал хомсдолын вирус/Дархлалын олдмол хомсдол
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ШУА	Шинжлэх ухааны академи
УАӨ	Уур амьсгалын өөрчлөлт
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
ҮСДИ	Үндэсний сайн дурын илтгэл
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1. ТХЗ-ын хэрэгжилтийн үнэлгээ, ИНБ ба олон талт оролцогчдын үнэлгээгээр, 2022	24
Зураг 2.2. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийн бэлэн байдал	26
Зураг 3.1. Монгол Улсын ТХЗ-ын ахиц дэвшлийн урьдчилсан үр дүн, 2022 он	29
Зураг 3.2. Эрчим хүчний хэрэглээнд анхдагч болон сэргээгдэх эрчим хүчний оролцоо	40
Зураг 3.3. Нэг хүнд ногдох бодит ДНБ-ий өсөлт, хувиар	41
Зураг 3.4. Нэг ажилчинд ногдох бодит ДНБ-ий өсөлт, хувиар	41
Зураг 3.5. Хөдөлмөрийн бүтээмж, сая төгрөгөөр, 2015 оны зэрэгцүүлэх үнээр	42
Зураг 3.6. Салбаруудын хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт, 2020 он, хувиар	42
Зураг 3.7. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн эзлэх хувь, хувиар	43
Зураг 3.8. Дотоодын материалын хэрэглээ	43
Зураг 3.9. Ажилчдын нэг цагийн дундаж хөлс, мян.төг	44
Зураг 3.10. Ажилчдын нэг цагийн дундаж хөлс, насны бүлгээр, мян.төг	44
Зураг 3.11. Ажилчдын нэг цагийн дундаж хөлс, хөгжлийн бэрхшээлийн байдлаар, мян.төг	44
Зураг 3.12. Ажилгүйдлийн түвшин, хүйс, насны бүлгээр, хувиар	44
Зураг 3.13. Ажилгүйдлийн түвшин, байршлаар, хувиар	45
Зураг 3.14. Боловсрол, ажил эрхлэлт, сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуусын эзлэх хувь	45
Зураг 3.15. Үйлдвэрлэлийн ослын тоо	46
Зураг 3.16. 100,000 хүнд ногдох арилжааны банкны болон АТМ-ын тоо	46
Зураг 3.17. Боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртөг	47
Зураг 3.18. Нийт боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртөгт ЖДҮ эзлэх хувь, хувиар	47
Зураг 3.19. Дэд бүтцэд үзүүлэх олон улсын дэмжлэг ба технологийн салбарын нэмүү өртөг	48
Зураг 3. 20. Нийт хүн амын болон хамгийн бага 40 хувийн хэрэглээний жилийн дундаж хурд ба хэрэглээний өсөлтийн хүртээмж	48
Зураг 3.21. Монгол Улсын эдийн засагт голлох үүрэгтэй эдийн засгийн салбаруудын газар ашиглалт, ажиллах хүч, ДНБ-нд үйлдвэрлэлийн эзлэх хувь, 2020 оны байдлаар (3D график)	52
Зураг 3.22. Монгол орны цөлжилтийн үнэлгээ	53
Зураг 3.23. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг ба хүнийг санаатай алах гэмт хэрэг 2012-2021	54
Зураг 3.24. Амьдардаг орчиндоо ганцаараа явахад аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь, нас, 2018-2021	55
Зураг 3.25. Төрийн албан хаагчид авлига өгсөн, авлига өгөхийг гуйлгуулсан, төрийн албан хаагчтай хамгийн багадаа нэг удаа холбогдсон хүмүүсийн эзлэх хувь, 12 сарын хугацаанд, 2018-2021	56
Зураг 3.26. ДНБ-д төсвийн орлогын эзлэх хувь, нэгдсэн төсөвт татварын орлогын эзлэх хувь	56
Зураг 3.27. Улсын нийт төсөвт гадаадын шууд хөрөнгө оруулалт болон хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь	57
Зураг 3.28. Бараа, үйлчилгээний экспорт дахь өрийн үйлчилгээний эзлэх хувь	57
Зураг 3.29. Монгол Улсын нийт экспортод улсуудын эзлэх хувь	58
Зураг 3.30. Экспортын барааны бүтэц	58
Зураг 3.31. Гадаад худалдаа хийхэд хялбар байдал	59
Зураг 4.1. КОВИД-19 шинэ тохиолдлын тоо ба Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн хязгаарлалт	61
Зураг 4.2. Эдийн засгийн өсөлт, хувиар	62
Зураг 4.3. Инфляцын түвшин, хувиар	64
Зураг 4.4. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, тэрбум ам.доллороор	64
Зураг 4.5. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллороор	65
Зураг 4.6. Гадаад валютын нөөц, валютын ханш	65
Зураг 4.7. Бизнес итгэлийн индекс	66
Зураг 4.8. Бензин, түлшний үнэ	66
Зураг 4.9. Ажиллах хүчний оролцооны түвшин	67
Зураг 4.10. Улирлын чанартай ажлын байрыг харгалзаагүй тохиолдолд нийт ажилчдын тоо, мянган хүнээр	67
Зураг 4.11. Улирлын чанартай ажлын байрыг харгалзсан тохиолдолд нийт ажилчдын тоо, мянган хүнээр	67
Зураг 4.12. Хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө (тэрбум төгрөг)	68
Зураг 4.13. Өрхийн орлогын бүтэц (хувь)	68



Зураг 4.14. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд гарсан зардал	70
Зураг 5.1. Систем зураглал: Бүс, орон нутгийн хөгжил ба төвлөрөл, тулгамдсан асуудал, саад бэрхшээл, гарц шийдэл, тэдгээрийн учир шалтгаан, холбоо	78
Зураг 5.2. Хүн амын нутагшил, суурьшил ба амьдралын хэв шинж	80
Зураг 5.3. Хүн амын өөрчлөлтийн орон зайн тархалт, хот, сумын төв, хөдөө нутгийн суурьшлын хэлбэрээр, 1995-2000, 2000-2010, 2010-2020 оноор	81
Зураг 5.4. Ган, зудын үед хорогдсон малын тоо, Хөдөөгийн малчин өрхийн тоо болон Улаанбаатар хотод шилжин ирсэн хүн амын тооны динамик, 1990-2020 он,	82
Зураг 5.5. Хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар, аймгийн төв хотууд болон хөдөө нутгаар, 1990-2045.	84
Зураг 5.6. УИХ-аас 2001 онд тодорхойлсон Мянганы хөгжлийн зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл	86
Зураг 5.7. Тээврийн дэд бүтцийн төв тэнхлэг дагуух хүн амын төвлөрөл	87
Зураг 5.8. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт, хилийн боомтуудад газарзүйн байршлаар, дотоодын мах, ноос, ноолуурын үйлдвэрийн байршил, 2021	88
Зураг 5.9. ДНБ-д төрийн болон хувийн хэвшлийн оролцоо	89
Зураг 5.10. Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих, өрхийн орлого, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх гарц, шийдэл	91
Зураг 5.11. Хөнгөн үйлдвэр хөгжүүлэх бүс (санал)	92
Зураг 5.12. Хотуудын зэрэглэл, статус, үүрэг, газарзүйн байршил	93
Зураг 6.1. Суурь үйлчилгээний хүртээмж, боломж ба саад бэрхшээлээр, 2018 он	97
Зураг 6.2. Суурь үйлчилгээний хүртээмж, боломж ба саад бэрхшээлээр, 2021 он	97
Зураг 6.3. Тэгш бус байдал (D индекс), 2018, 2021 он	98
Зураг 6.4. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүн	98

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 3.1. Монгол Улсын ТХЗ-ын хүлээгдэж буй үр дүнгийн индекс	30
Хүснэгт 3.2. Ядуурлын түвшин, ядуу хүн амын тоо, 2018, 2020	32
Хүснэгт 4.1. Төрийн бүтээмжийн өсөлтийн эдийн засагт үзүүлэх нөлөө, өөрчлөлтийн хувиар	63
Хүснэгт 4.2. Гадаад шууд хөрөнгө оруулалтын орох урсгал, салбараар, сая доллароор	64
Хүснэгт 4.3. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо	69
Хүснэгт 4.4. Монгол Улсын 2017-2021 оны эрчим хүчний үйлдвэрлэлийн динамик	72
Хүснэгт 5.1. Хүн амын тооны өөрчлөлтийн газарзүйн ялгаа (Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тооны өөрчлөлтийн суурьшлын хэлбэрээр хийсэн дүн шинжилгээ, 1995-2020	81
Хүснэгт 5.2. Дэвшүүлж буй Монгол Улсын "Хотын зэрэглэл, статус, үүрэг"-ийн тогтолцоо	93

ШИГТГЭЭ

Шигтгээ 2.1. Тогтвортой хөгжлийн зорилго-Дээд түвшний чуулга уулзалт	21
Шигтгээ 2.2. "Тогтвортой хөгжлийн зорилго" өдөрлөг	22
Шигтгээ 2.3. ТХЗ-ын талаарх зорилтот бүлгийн иргэдийн ойлголт, хандлага	24
Шигтгээ 2.4. Уламжлалт бус мэдээллийн эх үүсвэр ашиглан, тоон мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлсэн туршлага	27
Шигтгээ 4.1. "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгасан төрийн бүтээмжийн сэргэлтийн эдийн засагт үзүүлэх нөлөө	62
Шигтгээ 4.2. КОВИД-19 вирусийн эсрэг дархлаажуулалтын үр нөлөө	70
Шигтгээ 5.1. Үндэсний зөвлөлдөх санал асуулга зохион байгуулагдав.	83
Шигтгээ 5.2. Иргэдийн төлөөлөгчийн санал	83
Шигтгээ 6.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд – Хөгжлөөс алслагдсан бүлэг	96
Шигтгээ 6.2. Хөгжлөөс алслагдсан хүн амд тохиолдож буй хүндрэл, бэрхшээлүүд	100

ТАЛАРХАЛ

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн хоёр дахь удаагийн Үндэсний сайн дурын илтгэл (ҮСДИ)-ийг Эдийн засаг, хөгжлийн сайдын ерөнхий удирдлага дор Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын дэмжлэгтэйгээр Зөвлөх баг бэлтгэв. ҮСДИ-ийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн гишүүдийн удирдлага, санал, зөвлөмжөөс гадна 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан Үндэсний хэлэлцүүлгийн үеэр оролцогч талуудаас гарсан санал, шүүмжлэлд дүн шинжилгээ хийн илтгэлийн төслийг сайжруулан боловсрууллаа.

Монгол Улсын хоёр дахь удаагийн Үндэсний сайн дурын илтгэлийг бэлтгэхэд санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлж ажилласан НҮБ-ын Монгол дахь Суурин Зохицуулагч Тапан Мишра, Суурин Зохицуулагчийн газар, НҮБ-ын Ази, Номхон Далайн Эдийн засаг, нийгмийн комисс болон бодитой хувь нэмэр оруулсан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүний эрхийн дээд комиссарын газар зэрэг бусад байгууллагуудад гүн талархал илэрхийлэе.

Арга зүйн зөвлөмж өгсөн:

Ж.Должинсүрэн
Даян Шаяни

НҮБ-ын Суурин Зохицуулагчийн газрын Стратегийн ахлагч
Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комиссын Статистикийн хэлтсийн статистикч

Зөвлөх баг

О.Идшинринжин
Др. Ц.Болормаа
Др. М.Алтанбагана

Д.Мөнхцэцэг

Багийн ахлагч, Грант Торнтон Аудит ХХК-ийн партнер
МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн профессор
ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбарын дарга
Санхүү, эдийн засгийн их сургуулийн ахлах багш

Ажлын хэсэг

Дарга:

Б.Дашпүрэв

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Мөнгөнсүх,

Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Э.Баасандорж
Др. Ш.Мөнхцэрэн
Л.Балчинлуvsан
Л.Энх-Амгалан
И.Батхүү

Улсын Их Хурлын Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргын зөвлөх
ЗГХЭГ-ын Салбарын удирдлага, зохицуулалтын газрын дарга
Эдийн засаг, хөгжлийн яамны ХНэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга
Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга

Л.Эрдэнэбаяр
Г.Золбоо
Г.Гийхнаран

Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн судалгааны газрын дарга
Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга
Сангийн яамны Хууль эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга

Б.Гэрэлцэцэг
С.Баясгалан

Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газрын зөвлөх
Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга

Др. Т.Чулуун

Монгол Улсын их сургуулийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн захирал

Б.Пүрэвсүрэн
Г.Ялалт

Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн захирал
Үндэсний статистикийн хорооны Бодлого, хамтын ажиллагааны газрын Бодлого, гадаад харилцааны хэлтсийн дарга

С.Батцэцэг

Жендерийн үндэсний хорооны Ажлын албаны Тогтвортой хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Г.Уранцоож
Т.Элбэрэл

Хүний эрх хөгжил төвийн тэргүүн

Хараат бус судалгааны хүрээлэнгийн ахлах судлаач

Статистик, өгөгдлийн удирдлага

Ж.Болортуяа

Үндэсний статистикийн хорооны Бодлого, хамтын ажиллагааны газрын Бодлого, гадаад харилцааны хэлтсийн статистикч

О.Энхмөнх

ЭЗХЯ-ны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн

Илтгэлийг хэвлэлд бэлтгэсэн:

Э.Тэмүүлэн
Э.Райымбек
Г.Төгөлдөр

ЭЗХЯ-ны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын зөвлөх
ЭЗХЯ-ны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
ЭЗХЯ-ны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн



УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газраас 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын хэрэгжилтийн төлөв байдлыг энэхүү Үндэсний сайн дурын илтгэл (ҮСДИ)-ээр танилцуулж байна. НҮБ-ын гишүүн орнууд 2016 оноос эхлэн ҮСДИ-ээ боловсруулан Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн ивээл дор жил бүр зохион байгуулагддаг Улс төрийн дээд түвшний чуулга уулзалтад танилцуулж ирсэн. Энэхүү чуулга уулзалтаар 2016-2022 онд улс орнуудын нийт 291 ҮСДИ-ийг хэлэлцсэн бөгөөд, 2023 онд танилцуулах 40 улсын нэг нь Монгол Улс юм.

Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгууд нь 2030 он хүртэл ядуурал, өлсгөлөнг эцэслэх, эх дэлхийгээ хамгаалах, шударга ёсыг дээдлэх, ялгаварлал, тэгш бус байдлыг арилгах, хөгжил цэцэглэлтийг өрнүүлэх 17 зорилго, 169 зорилтыг дэвшүүлсэн. Монгол Улсын Их Хурлаас 2020 онд "Алсын хараа - 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталж, урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлж байна.

Энэ илтгэлд ТХЗ-ын ахиц дэвшил, тулгамдаж буй асуудлыг тоон мэдээлэлд тулгуурлан тусгахыг зорилоо. Үндэсний хэмжээнд тодорхойлсон ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн

суурь түвшин, гүйцэтгэлийг зорилтот түвшинтэй харьцуулан индексийн аргаар үнэлснээрээ өмнөх ҮСДИ-ээс онцлог болж байна

ҮСДИ нь зургаан бүлгээс бүрдэх бөгөөд үндэсний шалгуур үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, зорилтот түвшнийг хавсралтад тусгасан болно. Нэгдүгээр бүлэгт ҮСДИ-ийг боловсруулсан үйл явц, арга зүйг, хоёрдугаар бүлэгт Тогтвортой хөгжлийг хангах бодлогын орчин, институцийн тогтолцоонд гарсан өөрчлөлтийг, гуравдугаар бүлэгт ТХЗ-ын хэрэгжилтэд гарсан өөрчлөлт, ахиц дэвшлийг, дөрөвдүгээр бүлэгт Цар тахал, геополитикийн зөрчилдөөний ТХЗ-ын хэрэгжилтэд үзүүлсэн нөлөө, тулгамдаж буй асуудлуудыг, тавдугаар бүлэгт Бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хязгаарлаж буй гол түлхүүр асуудлууд, шийдвэрлэх арга замуудыг, зургаадугаар бүлэгт Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын хүрээнд хамгийн эрсдэл бүхий өрх, хүн амын тухай, эцэст нь ТХЗ-ын хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэхэд чиглэсэн нэгдсэн дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг тусгалаа.

ТХЗ-ыг улс орныхоо онцлогт нийцүүлэн нутагшуулах үйл явц, хэрэгжилтийг дүгнэж, тогтвортой хөгжлийн асуудлаар нийгмийн зөвшилцлийг өргөжүүлэх, хамтын шийдвэр гаргах үйл ажиллагаа, хандлагыг бэхжүүлэхэд чиглэсэнд Илтгэлийн ач холбогдол оршино.



ИЛТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын хэрэгжилтийн Үндэсний сайн дурын илтгэл (ҮСДИ)-ийг Монгол Улсын Засгийн газраас санаачлан төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, хүний эрхийн үндэсний институци, олон улсын хөгжлийн байгууллагууд зэрэг төлөөллийн оролцоотойгоор, олон удаагийн хэлэлцүүлгийн үр дүнд 2 дахь удаагаа танилцуулж байна.

Энэ удаагийн илтгэл нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийг хангах бодлогын орчин, институцийн тогтолцоонд гарсан өөрчлөлт, ТХЗ-ын хэрэгжилтийн ахиц дэвшил, цар тахал, геополитикийн зөрчилдөөний ТХЗ-ын хэрэгжилтэд үзүүлсэн нөлөө, тулгамдаж буй асуудлууд, бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хязгаарлаж буй түлхүүр асуудлуудыг тодорхойлж, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын хүрээнд хөгжлөөс орхигдох эрсдэл бүхий өрх, хүн амын тухай болон ТХЗ-ын хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэхэд чиглэсэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг тусгасан 6 бүлэгтэй. Монгол Улс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн, баталснаар хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний эрх зүйн орчныг сайжруулж, энэ хүрээнд "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогыг ТХЗ-той уялдуулан баталсан. Мөн Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн төслийг сайжруулан боловсруулж, 16 зорилго, 154 зорилт, 2025, 2030 он хүртэлх зорилтот түвшин бүхий 253 шалгуур үзүүлэлтийг тодорхойлоод байна.

ТХЗ-ын хэрэгжилтийг хянах мэдээллийн бэлэн байдлыг сайжруулахын тулд Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос жил бүр мэдээллийн бэлэн байдлын үнэлгээг тогтмолхийж, зөвлөмжийн дагуу үзүүлэлтүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэлд шинээр судалгаа явуулах, одоо явуулж буй судалгаа, тооллогод шинэ үзүүлэлт, модуль нэмэх, дэлхийн хэмжээнд ТХЗ-ын үзүүлэлт хариуцсан олон улсын байгууллагуудын санал болгож буй шалгуур үзүүлэлтүүдийн аргачлалыг судлах, их өгөгдөл, газар зүйн мэдээллийн системийг ашиглах зэргээр санаачилга гарган ажиллаж байна.

Үндэсний 253 шалгуур үзүүлэлтээс одоогийн байдлаар тооцох боломжтой 191 шалгуур үзүүлэлт байгаа бөгөөд хоёр болон түүнээс дээш жилийн динамик мэдээлэл бүхий 135 үзүүлэлтийн 2010-2021 оны мэдээлэлд тулгуурлан НҮБ-ын АНДЭЗНК-ын Статистикийн хэлтсийн ТХЗ-ын хэрэгжилтийн явцын дүн шинжилгээний арга зүйгээр ТХЗ-ын хэрэгжилтийн ахиц дэвшлийг шинжилсэн. Бүс, орон нутгийн хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлохдоо Газарзүйн мэдээллийн сан үүсгэн, орон зайн

систем шинжилгээний аргыг ашигласан болно.

Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх чиглэлд ахиц, дэвшил гаргасан хэдий ч 2030 оны зорилтыг бүрэн хангахын тулд цаашид илүү их хүч чармайлт гаргах хэрэгтэй. Үндэсний онцлогийг харгалзан тодорхойлсон Тогтвортой хөгжлийн 15 зорилгын хүрээнд тодорхой түвшний ахиц гарсан бол Ядуурлыг бууруулах зорилгын хувьд 2014 оны суурь түвшинтэй харьцуулахад өссөн байгаа нь энэ чиглэлийн арга хэмжээг эрчимжүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Хэрэгжилтийн үнэлгээг зорилтын түвшинд авч үзвэл, 2030 онд зорьсон түвшиндээ хүрэхийн тулд нийт тодорхойлсон 134 зорилтын 27.6 хувийн одоогийн хэрэгжилтийн ахицыг хадгалах, 54.5 хувийн хэрэгжилтийг нэн даруй эрчимжүүлэх, харин 17.2 хувьд нь онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Тодруулбал, Хүнсний аюулгүй байдлыг хангаж, тогтвортой хөдөө аж ахуйг хөхүүлэн дэмжих (ТХЗ-2), Чанартай боловсролыг дэмжих (ТХЗ-4), Жендерийн тэгш байдал, охид эмэгтэйчүүдийн эрхийг хангах (ТХЗ-5), Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах (ТХЗ-6), Эдийн засгийн өсөлт, зохистой ажлын байрыг бий болгох (ТХЗ-8), Тэгш бус байдлыг бууруулах (ТХЗ-10), Хариуцлагатай хэрэглээг дэмжих (ТХЗ-12) зэрэг чиглэлээр тодорхой ахиц дэвшил гарсан хэдий ч Ядуурлыг бууруулах (ТХЗ-1), Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих (ТХЗ-11), Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг багасгах (ТХЗ-13), Энх тайван, шударга ёсыг цогцлоох (ТХЗ-16), Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх (ТХЗ-17) зэрэг зорилгуудын хэрэгжилтийг хангахын тулд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Цар тахал, геополитикийн зөрчилдөөн нь Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтийг удаашруулж, нийгмийн суурь үйлчилгээний тэгш бус байдлыг нэмэгдүүлжээ. Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар, тээвэр, логистик, түлш, эрчим хүчний үнэ, нийлүүлэлтээр дамжин эдийн засаг, нийгмийн гол үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлсөн байна. Ялангуяа, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн бэлэн байдал төдийлөн хангагдаагүй үед нийтийг хамарсан цар тахал дэгдсэн нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулж, тэгш бус байдлыг нэмэгдүүлсэн байна.

ТХЗ-ын "Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчмын хүрээнд "боломж нь хязгаарлагдаж, тэгш бус байдалд өртсөн" хүмүүсийг тодорхойлохоор үндэсний хэмжээний төлөөлөх чадвар бүхий Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (2018 он) болон Өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгаа (2021 он)-ны өгөгдлийн санд тулгуурлан боломжийн тэгш бус байдлын шинжилгээг гүйцэтгэв. Шинжилгээгээр, хөгжлөөс



хамгийн хол хоцрогдсон өрх, хүн амд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, идэр насны залуучууд, ахмад настан, дотоодын шилжигчид, гэр оронгүй тэнэмэл иргэд, хөдөөгийн, амьжиргааны түвшин доогуур (хамгийн доод 40 хувь) өрх, хүн ам болон бага боловсролтой эрэгтэй хүн ам багтаж байна. Монгол Улсын хувьд нийгмийн суурь үйлчилгээ өрх, хүн амд тэгш хүрэлцээтэй бус ялангуяа, хөгжлөөс алслагдмал буюу хоцрох байдал өрх, хүн амын байршил, боловсрол, амьжиргааны түвшний ялгаатай байдлаас шалтгаалж байна.

ТХЗ-ын хэрэгжилтийг хангахад бүс, орон нутгийн хөгжлийн ялгаатай байдал томоохон хязгаарлагч хүчин зүйл болж буйг онцолж, бүс, орон нутагт тулгамдсан 37 асуудлыг тодорхойлсон ба үүнд нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгаа, хөдөө, орон нутгаас суурин газар, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, хөдөөгийн малчин өрхийн эмзэг байдал зэрэг асуудлуудыг авч үзлээ. Нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгааг бууруулахад чиглэсэн эдийн засгийн газарзүйн бодлогыг хэрэгжүүлснээр бүс, орон нутгийн түвшинд ядуурал, тэгш бус байдлыг бууруулах, ажиллах хүчний нөөцийг оновчтой хуваарилах, эдийн засгийн чадавхыг сайжруулах, салбаруудын дасан зохицох чадавхыг бэхжүүлэх зэргээр ТХЗ-ыг хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой.

Засгийн газар, олон улсын байгууллагуудын түвшинд тогтвортой хөгжлийг дэмжих түншлэл өргөжсөнөөс гадна хувийн хэвшлийн санаачилга, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо идэвхжин, олон талт хамтын ажиллагаа улам бэхэжсээр байна. Тухайлбал, хувийн хэвшлийн Unread Media Старт-Ап компани нь Хаан банкттай хамтран “Тогтвортой хөгжил-2030” цахим товхимлыг 2019 оноос гаргаж, иргэд, олон нийтийн тогтвортой хөгжлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлд, үндэсний тэргүүлэх аж ахуйн нэгжүүд (Эм Си Эс Групп, Оюу Толгой ХХК зэрэг), арилжааны томоохон банкнууд (Хаан, Голомт, ХХБ зэрэг) Тогтвортой байдлын тайланг тогтмол гаргаж үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагааг ногоон, тогтвортой болгоход тус тус хувь нэмрээ оруулж байна. Гэсэн хэдий ч нийт хүн амын, ялангуяа хөгжлөөс алслагдсан эрсдэлт бүлгийн тогтвортой хөгжлийн талаарх ойлголт, мэдлэг, хандлага, оролцоо хангалттай бус байна.

Тогтвортой хөгжлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх хүрээнд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өргөжиж байна. Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл 2018 онд Монгол Улсын Ногоон таксономи, 2022 онд “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ийг баталснаар банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг үйл ажиллагаандаа ашиглах боломж бүрдсэн. Мөн Засгийн газраас Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратегийн төслийг боловсруулж, батлуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Тогтвортой хөгжлийн зорилгын 2030 оны зорилтод хүрэх, цаашдын хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд,

- Дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг хангахдаа хяналт, тайлагналын тогтолцоог сайжруулж, үнэлгээг чанаржуулах,
- Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх санхүүжилт, хөрөнгө оруулалтын орчныг тодорхой болгож, олон талын оролцоог идэвхжүүлэх арга хэрэгсэл болгон ашиглах,
- Дэлхий нийтийг хамарсан зөрчил, мөргөлдөөн, халдварт өвчин, байгалийн гамшигт үзэгдэл, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөг бууруулах, эрсдэлийг даван туулах, өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн олон улсын түншлэл, бүс, орон нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, нөөцийн эх үүсвэрийн бэлэн байдлыг хангах зэргээр нийгэм, эдийн засгийн суурь чадавхыг бэхжүүлэх,
- Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын хүрээнд бүс, орон нутгийн хөгжлийн ялгаатай байдлыг бууруулах, уул уурхайн болон уул уурхайн бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл, аялал жуулчлал, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн тээврийн дэд бүтэц, логикийн сүлжээг бий болгох, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг бүх хүн амд тэгш хүргэх зэрэгт хүчин чармайлт гаргаснаар тогтвортой хөгжлийн суурь зарчмыг хангах чухал ач холбогдолтой.



БҮЛЭГ 1.

ИЛТГЭЛ БОЛОВСРУУЛСАН ҮЙЛ ЯВЦ, АРГА ЗҮЙ



1.1. Үндэсний сайн дурын илтгэлийг боловсруулсан үйл явц

Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар ТХЗ-ын хэрэгжилтийн ҮСДИ-ийг 2 дахь удаагаа танилцуулж байна. Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх Тогтвортой хөгжлийн Үндэсний хорооны 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар ҮСДИ-ийг боловсруулах шийдвэр гарсан. Улмаар Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/92 дугаар тушаалаар Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтийн ҮСДИ-ийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан төр, төрийн бус, эрдэм шинжилгээ болон хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөллийн оролцоотой байгуулсан.

ҮСДИ-ийг боловсруулахад олон талт оролцогч талуудын үзэл бодол, саналыг тусгав. Сонирхогч талуудын хувь нэмрийг дэмжих үүднээс төр, иргэний нийгмийн байгууллага (ИНБ), хувийн хэвшил, үйлдвэрчний эвлэл, хүний эрхийн үндэсний институци, олон улсын хөгжлийн байгууллагууд гээд бүх салбар, шатлалыг авч үзсэн бөгөөд 10 гаруй хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг нь тусгах замаар илтгэлийг бэлтгэлээ.

Анхны хэлэлцүүлгийг 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулж, ҮСДИ боловсруулах ажлыг эхлүүлсэн ба 2022 оны 12 дугаар сарын 22-23-нд зохион байгуулсан Ажлын хэсгийн хэлэлцүүлэгт оролцсон 70 гаруй оролцогчдод хөгжлийн аливаа асуудлыг системтэйгээр шинжлэх аргыг ашиглан хямралын цаг үеийн болон бүс, орон нутгийн тулгамдсан асуудлыг тодорхойлох шаардлагын талаар танилцуулж, улмаар ҮСДИ-ийн хамрах хүрээ, агуулгыг хэлэлцэн тодорхойлсон. Мөн 2023 оны 03-04 дүгээр сард зохион байгуулсан Ажлын хэсгийн хурал, зорилтот бүлгийн ярилцлагууд болон Үндэсний хэлэлцүүлэгт олон талын сонирхогчдын 200 гаруй төлөөлөл оролцон ҮСДИ-д дэвшүүлсэн асуудлыг зөвшилцсөн нь олон талын санал, зөвлөмжийг сонсох боломжийг бий болгосон.

ҮСДИ-ийн төслийн агуулгын хүрээнд "ТХЗ-Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ"-тэй харилцан мэдээлэл солилцож, санал авах зэргээр хамтран ажилласан. Засгийн газар болон ИНБ-ууд ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бүтэц тогтолцоог улам сайжруулах, урт хугацааны бодлогыг дунд, богино хугацааны бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох, бүх түвшинд мэдээллийг нээлттэй болгож, хяналт тавих нь хариуцлагыг сайжруулж, бодитой үр дүнд хүрэхэд чухал ач холбогдолтой гэдэгтэй санал нийлсэн.

ТХЗ-ын "хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчмыг баримтлав. "Хөгжлөөс орхигдох эрсдэлтэй хүн амын бүлэг"-ийг тодорхойлж,

тэдгээрийн 40 гаруй төлөөллийг оролцуулсан зорилтот бүлгийн ярилцлагуудыг 2023 оны 04 дүгээр сард зохион байгуулж, тэдэнд тулгамдаж буй асуудал, сорилт бэрхшээл, тэдний онцлог хэрэгцээ, эрх ашиг хэрхэн хангагдаж байгаа талаар чанарын судалгаа хийсэн. Мөн эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулах, хүний эрхийг хэрэгжүүлэх талаарх үндэсний хүчин чармайлтад онцгой анхаарал хандууллаа.

Хөгжлийн тулгамдсан асуудлын нэгээр бүс, орон нутгийн хөгжлийн асуудлыг онцлов. Бүс, орон нутгийн (i) нийгэм, эдийн засаг, байгаль орчны болон Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулахад тулгамдаж буй асуудлууд, (ii) хөгжилд саад учруулж буй салбар дундын шинжтэй, уялдаа холбоо бүхий бодлогын зангилаа түлхүүр асуудлууд, (iii) эдгээр түлхүүр асуудлаас ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд тулгарч буй сорилт, бэрхшээл, тэдгээрийн холбоос, (iv) бүс, орон нутгийг хөгжүүлэх гарц, шийдвэрлэх арга замыг систем шинжилгээний аргаар тодорхойлсон. Энэ хүрээнд бүс, орон нутгийн асуудлаар мэргэшсэн салбарын мэргэжилтнүүд, судлаачид болон НҮБ-ын төлөөлөл, иргэд оролцсон хэд хэдэн хэлэлцүүлгийг 2023 оны 03-04 дүгээр сард зохион байгуулж, бүс, орон нутгийн хөгжлийн чиг хандлагын талаар санал солилцсон.

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллага, Швейцарын хөгжлийн агентлаг, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын залуучуудын холбоо, Жи Си Ай Монгол зэрэг байгууллагууд хамтран 2023 оны 03 дугаар сарын 10-нд "Хөдөөгийн сэргэлт Чуулган" зохион байгуулж, орон нутгийн бизнес эрхлэлт, орон нутагт суурьших боломжийг дэмжих төрийн бодлого, шийдвэрүүд, орон нутаг дахь бизнесийн шинэ гарц, боломжууд, тулгамдсан асуудал, түүний шийдэл, туршлагуудыг төр, хувийн хэвшил, бизнес эрхлэгчид, иргэдэд өргөн хүрээнд танилцуулж, үзэл бодлыг нь сонссон юм. Чуулганд 1,400 орчим иргэн оролцсон бөгөөд тэднээс 1,000 гаруй иргэн нь сайн дурын сонирхлоор оролцсон төдийгүй иргэдээс цахимаар 1,000 гаруй санал, санаачилгыг ирүүлснийг ҮСДИ-д эрэмбэлэн тусгасан.

Олон улсын харилцан туршлага солилцох хөтөлбөрт хамрагдаж, сайн туршлага судлав. ҮСДИ-ийн механизм нь "Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр" болон ТХЗ-ын үндэсний түвшин дэх хэрэгжилтийн тухай улс орнууд болон сонирхогч талууд хоорондоо нээлттэй туршлага солилцохыг дэмждэг. Энэ хүрээнд НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК)-ын санаачилга, дэмжлэгтэйгээр 2023 онд ҮСДИ-ээ бэлтгэж буй Монгол-Тажикстан-Узбекстан улсууд "ихэрлэх" хөтөлбөрт хамрагдсан нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх болон сайн дурын илтгэл бэлтгэх явцад харилцан суралцах, туршлага солилцох, ТХЗ-ын манлайлал, Өмнөд-Өмнөдийн



хамтын ажиллагааг бэхжүүлэхэд олон талын төлөөллийг холбох, татан оролцуулах, түншлэх боломжийг олгосон юм.

1.2. Арга зүйн хүрээ

ҮСДИ-ийг бэлтгэхдээ холбогдох баримт бичгүүдийн шинжилгээ, бодлогын судалгаа, тайлан, зорилтот бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага, хэлэлцүүлэг, албан ёсны статистикийн мэдээлэл болон захиргааны бүртгэл зэрэг олон төрлийн арга, аргачлалуудыг хослуулан ашиглаж, тоон болон чанарын шинжилгээ хийсэн. Мөн ҮСДИ-ийг боловсруулахад хүний эрхийн асуудлыг хэрхэн тусгах талаар НҮБХХ, Хүний эрхийн дээд комиссарын газраас гаргасан удирдамжийг судлан ашигласан.

ТХЗ-ын хэрэгжилтийн ахиц, дэвшлийг үнэлэх арга зүй

Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 2 дугаар захирамжаар ТХЗ-ын үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, ИНБ, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллөөс бүрдсэн 8 дэд ажлын хэсгийг байгуулан ажиллаж, ТХЗ-ын үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулсан. 2022 оноос эхлэн шинээр байгуулагдсан ЭЗХЯ-ны удирдлага дор зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн төслийг сайжруулан, батлуулахаар ажиллаж байна. Тус төсөл нь өөрийн орны онцлогт нийцүүлэн тодорхойлсон Тогтвортой хөгжлийн 16 зорилго, 154 зорилт, 2025, 2030 он хүртэлх зорилтот түвшин бүхий 253 шалгуур үзүүлэлтээс бүрдэнэ. Одоогийн байдлаар тооцох боломжтой 191 шалгуур үзүүлэлтээс хоёр болон түүнээс дээш жилийн динамик мэдээлэл бүхий 135 үзүүлэлтийн 2010-2021 оны мэдээлэлд тулгуурлан НҮБ-ын АНДЭЗНХ-ын Статистикийн хэлтсийн ТХЗ-ын хэрэгжилтийн явцын дүн шинжилгээний арга зүй (SDG progress analysis)-гээр ТХЗ-ын хэрэгжилт үндэсний түвшинд хэрхэн хангагдаж байгааг шинжилсэн.

Бүс, орон нутгийн хөгжлийн шинжилгээний арга зүй

ҮСДИ-д бүс, орон нутгийн хөгжлийн асуудлыг онцлон авч үзсэн. Энэ хүрээнд бүс, орон нутагтай холбоотой 2001 оноос хойш хийгдсэн тайлан, судалгааны ажлуудыг цогцоор авч үзсэн. Бүс, орон нутгийн хөгжилтэй холбоотой нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтэцтэй холбоотой хүчин зүйлс, мэдээллийг Газарзүйн мэдээллийн систем (GIS)-д сан үүсгэн, улмаар орон зайн систем шинжилгээг олон шалгуурт шийдвэр гаргалтын шинжилгээний (Spatial Multi Criteria Decision Analysis-MCDA) аргыг ашиглан хийсэн. Олон шалгуурт шийдвэр гаргалтын шинжилгээ нь орон зайн олон нөхцөлт асуудлуудыг цогц байдлаар шинжилж тооцоолох газарзүйн

мэдээллийн системийн аргагүйн нэгэн хэлбэр юм. Энэ аргачлал нь бүс нутаг, орон нутгийн болон хөгжлийн орон зайн төлөвлөлтийн анализ хийх, тулгамдаж буй асуудлыг шинжлэхэд олон улсад өргөн ашиглагдаж буй загвар юм. Бүс, орон нутгийн хөгжилд нөлөөлж буй түлхүүр хүчин зүйлс, тэдгээрийн учир шалтгааныг салбар дундын болон тогтвортой хөгжлийн хэд хэдэн зорилгын хүрээнд судалсан болно.

Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжихэд Засгийн газрын тууштай бодлого болон үйл ажиллагааны уялдааг хангах, институцийн тогтолцоог сайжруулах, төрийн байгууллага болон хувийн хэвшил, иргэдийн идэвх, санаачилга, манлайллыг тодорхой болгож, мэдлэг, нөлөөлөл, оролцоог сайжруулах тухай ерөнхий зөвлөмжийг ҮСДИ-д тусгасан.

Мөн систем шинжилгээний үр дүнд үндэслэн бүс, орон нутгийн хөгжлийн сорилт, тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх цаашдын арга замын хувилбаруудыг тодорхойлох оролдлого хийсэн.

Боломжийн тэгш бус байдлын шинжилгээний арга зүй

“Хэнийг ч орхигдуулахгүй” гэдэг бол “боломж нь хязгаарлагдаж, саад бэрхшээлд өртсөн” хүмүүсийг илрүүлж, анхаарах бөгөөд ихэвчлэн янз бүрийн ялгаварлан гадуурхалтын олон, огтлолцсон хэлбэрт өртөж буй хүмүүсийг багтаан авч үзэх гэсэн утгатай юм.

АНДЭЗНХ-оос ТХЗ-ын “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан, боломжийн тэгш бус байдлын шинжилгээ (LNOB Analysis) хийхийг зөвлөсний дагуу суурь үйлчилгээний хүртээмж хүн амын бүлгүүдэд хэрхэн тэгш бус хуваарилагдаж байгааг D индекс буюу Тэгш бус байдлын индексээр, хүртээмж хамгийн бага бүлгийг Ангилал ба регрессийн мод (буюу CART) шинжилгээний аргаар тодорхойлсон. Ийнхүү шинжлэхдээ үндэсний хэмжээний төлөөлөх чадвар бүхий 2 судалгаа (Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2021)-ны өгөгдлийн санг ашиглалаа.

1.3. ҮСДИ боловсруулах үйл явцаас олсон сургамж

ҮСДИ бэлтгэх үйл явцыг нарийн төлөвлөх, үнэлгээг аль болох эрт эхлүүлэх, тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр ялангуяа, төрийн байгууллагаас хэрэгжүүлсэн арга хэмжээ, ИНБ, хувийн хэвшил зэрэг бусад сонирхогч талын санаачилга, амжилт, сургамж, оролцооны тухай мэдээ, мэдээлэл бэлтгэх, цуглуулах, солилцох платформыг бий болгох, эсвэл Засгийн газрын байгууллагуудын хэрэглэж буй хяналт-шинжилгээ, үнэлгээний механизмыг оновчтой ашиглахад цаашид анхаарах нь зүйтэй байна.



Монгол Улсын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүд, 2030 онд хүрэх зорилтот түвшнийг оновчтой тогтоож, батлах нь үнэн зөв, бодитой мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, ТХЗ-ын хэрэгжилтийг хянах, үнэлэх, улмаар "Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхэд Монгол Улс хувь нэмэр оруулах, амлалтаа биелүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

ҮСДИ-д бодлогын шинжилгээ хийж, үйл явцад түлхүү анхаарч дэлгэрэнгүй тусгасан хэдий ч цаашид практикт гарч буй өөрчлөлтийн тогтвортой байдалд анхаарлаа хандуулах, үр нөлөөг тогтмол судалж байх шаардлагатай байна.

Анхны ҮСДИ-д дурдсан зөвлөмж (агаарын бохирдлын хэсгийг эс тооцвол)-ийн хэрэгжилтийн тухай хоёр дахь удаагийн ҮСДИ-д гүнзгийрүүлэн шинжилж үзсэн нь бодлогын залгамж халааг хадгалах, хэрэгжилтийн үр дүнг сайжруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээг хэвшүүлэхэд хувь нэмэр оруулах давуу талтай байна.

Дэлхийн тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг нутагшуулан хэрэгжүүлэх чиглэлд Монгол Улс идэвх зүтгэл гаргаж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, институцийн тогтолцоонд ахиц дэвшил гарсаар байна. 2023 он бол ТХЗ-д хүрэх замын дундах жил бөгөөд 2023 оны 09 дүгээр сард болох НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганд дэлхийн улс орны удирдагчид ТХЗ-ын хэрэгжилтийн явцаа хэлэлцэн дүгнэх юм. Энэ цаг үед Монгол Улс хоёр дахь удаагийн ҮСДИ-ээ танилцуулж байгаа нь ихээхэн онцлог үйл явдал болж байна.



БҮЛЭГ 2.

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БОДЛОГЫН ОРЧИН,
ИНСТИТУЦИЙН ТОГТОЛЦООНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ**

2.1. Монгол Улсын хөгжлийн бодлогууд ба зорилтууд

Монгол Улсын Засгийн газраас санаачлан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль эрхзүйн баримт бичигт өөрчлөлт оруулж, урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг шинээр боловсруулан, батлуулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн эрхзүйн орчин сайжрав. УИХ-аас 2020 оны 05 дугаар сард Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн баталсан нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт, тэдгээрийн уялдаа, хоорондын нийцлийг хангаж, түүнийг боловсруулан батлах тогтолцоог бэхжүүлсэн.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан үндэсний, салбарын болон салбар дундын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийн, уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хууль тогтоомжид нийцээгүй бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг илрүүлэн, хүчингүй болгох хууль эрхзүйн үндэслэлийг боловсруулж, шийдвэр гаргуулах ажлууд хийгдсэн байна. Тухайлбал, Монгол Улсын хэмжээнд 1990 оноос хойш хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан бодлогын баримт бичгээс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөлд хамаарахгүй, мөн хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцээгүй нийт 392 бодлогын баримт бичгийг хүчингүй болгох хууль зүйн үндэслэлийг тогтоож, эхний байдлаар Засгийн газрын тогтоолоор баталсан, хуульд нийцээгүй нийт 62 бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгож, салбар, орон нутгийн түвшинд батлан хэрэгжүүлж байгаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, хуульд нийцүүлэх арга хэмжээг эхлүүлсэн байна. Мөн УИХ-ын тогтоолоор баталсан, хуульд нийцээгүй 17 бодлогын баримт бичгийг УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журмыг Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор батлан, хэрэгжилтийг хангах хүрээнд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар, дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлалыг Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/25 дугаар тушаалаар, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар тус тус батлан, хэрэгжүүлж эхэлсэн нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг

боловсруулах арга зүйг үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагад чиглүүлж, шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаанд суурилсан бодлогыг баталж, хэрэгжүүлэх таатай нөхцөл бүрдэж эхэлж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого тогтвортой, цогц байдлаар хэрэгжиж эхлэв. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан. Тус бодлогоор Монгол Улс "нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт болон иргэдийн амьдралын чанар"-аар Азид тэргүүлэгч орнуудын нэг болохын зэрэгцээ байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг дэмжих, экосистемийн тэнцвэрт байдал, байгаль орчны тогтвортой байдлыг хангах, одоо болон ирээдүйн хойч үедээ үр шимийг нь хүртээх нөхцөлийг бүрдүүлж, дундаж давхарга давамгайлсан нийгмийг бий болгох зорилго тавьсан.

Энэхүү зорилгын хүрээнд хүчирхэг, олон талт, ногоон эдийн засгийг цогцлоох, иргэн



бүрийн амьдралын чанарыг дээшлүүлэх, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зэрэг томоохон зорилтуудыг дэвшүүлсэн бөгөөд 2030, 2040, 2050 он хүртэл 3 үе шаттайгаар харилцан уялдаа бүхий дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтөөр дамжин хэрэгжих юм.

Цар тахлын дараах эдийн засгийг сэргээх, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг шийдвэрлэх, урт хугацааны зорилтуудыг хангахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр "Шинэ сэргэлтийн бодлого" (Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр)-ыг УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлан, хэрэгжүүлж байна. Уг бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Түүнчлэн, урт, дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, түүнийг дагасан Улсын



хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг 2020 оны 08 дугаар сард батлан хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бүх оролцогч талуудад урт, дунд хугацааны бодлогын агуулга, зорилго, зорилтыг ойлгомжтой, хялбаршуулсан хэлбэрээр хүргэж ажлыг амжилттай зохион байгуулж байна. Тухайлбал, урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн агуулга, уялдаа холбоог сурталчлан таниулах, хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх тухай сургалтыг Монгол Улсын Ерөнхий сайдын Ажлын алба, ЗГХЭГ, Удирдлагын академи, аймгуудын ЗДТГ хамтран төрийн байгууллагын удирдлага, албан хаагчдад зориулан зохион байгуулж байна. Энэ хүрээнд урт хугацааны хөгжлийн бодлогын тулгуур 9 зорилго тус бүрээр танин мэдэхүйн, хялбаршуулсан агуулга бүхий ном, видео контент зэргийг олон нийтэд түгээжээ.

Хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд ТХЗ, түүний шалгуур үзүүлэлтүүдийг тусгах ажил хийгдэж байна. Монгол Улс ТХЗ-ыг урт хугацааны хөгжлийн бодлоготой зорилго, зорилтын түвшинд сайн уялдуулсан хэдий ч шалгуур үзүүлэлтийн түвшинд уялдуулж чадаагүйг ЗГХЭГ-аас НҮБХХ-тэй хамтран хийсэн бодлогын уялдааны шинжилгээгээр тодорхойлж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд ТХЗ-ын 80 хувь нь тусгагдсан байна гэж дүгнэжээ. Дэлхийн ТХЗ-ын 169 зорилтын 116 нь “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлоготой бүрэн уялдаатай, 24 зорилт агуулгаараа уялдаатай, 12 зорилт огт тусгагдаагүй, 13 зорилт хамааралгүй, 4 зорилт бүрэн хэрэгжсэн байна. Тухайлбал, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны 39 зорилт нь ТХЗ-той нийтлэг байдлаар, шалгуур үзүүлэлтийн зөвхөн 11 нь ТХЗ-той уялдаж байгаа нь олон улсын хэмжээнд тодорхойлсон 13 зорилт, 27 үзүүлэлттэй харьцуулахад эрс ялгаатай байна. Цаашид эрүүл мэндийг дэмжих зорилтуудыг

үр дүнтэй хэрэгжүүлж, хянахын тулд шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан тусгаж, сайжруулах хэрэгцээ шаардлага байгааг судалгаагаар харуулжээ.

Иймд, Монгол Улсын Засгийн газар 2021 оноос эхлэн боловсруулж, УИХ-д өргөн барихаар бэлтгэж буй дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих Хөгжлийн 6 зорилтот хөтөлбөр (Хүний хөгжил, Нийгмийн хөгжил, Байгаль орчин, Засаглал, Бүсийн хөгжил, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх)-ийн төсөлд дээр дурдсан ТХЗ-ын тусгагдаагүй зорилт, шалгуур үзүүлэлтийг бүрэн тусгахаар ажиллаж байна.

“Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлогоор тодорхойлсон хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд, ТХЗ болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн болон хүний эрхийн бусад зорилт, үүрэг амлалтыг биелүүлэхэд Монгол Улсын Засгийн газар болон НҮБ хамтран ажиллахаа илэрхийлсэн “НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ 2023–2027” баримт бичгийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр батламжиллаа. Энэхүү баримт бичгээр Монгол Улсын Засгийн газар, УИХ, иргэний нийгэм, хувийн хэвшил, хөгжлийн түншүүд, НҮБ-ын системийн байгууллагууд зэрэг олон талын төлөөллийн идэвхтэй оролцоо, харилцан зөвшилцлийн үндсэн дээр ойрын таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратеги, төлөвлөлтийн нэгдсэн хүрээг тодорхойлжээ.

2.2. Институцийн тогтолцоонд гарсан өөрчлөлт

Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоонд ахиц гарав. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг харилцан уялдаатай, хоорондын нийцлийг хангаж боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах, үнэлэх харилцаанд оролцогч талуудын бүрэн эрх, чиг үүргийг зохицуулсан институцийн тогтолцоог тодорхой болгож, оролцогчдын хариуцлагыг бодитой болгох эрхзүйн таатай орчин бүрдсэн байна.

Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн нэгдсэн бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэгтэй үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Эдийн засаг, хөгжлийн яам 2022 оны 01 дүгээр сард байгуулагдсан. Ийнхүү яам байгуулагдсанаар Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газрыг татан буулгаж, чиг үүргийг тус яаманд шилжүүлсэн байна.

Яамны дэргэд Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулахаар төлөвлөсөн ба үндэсний хэмжээний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, бодлогын баримт бичиг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай

судалгаа, шинжилгээ хийж, тус яамнаас өгсөн чиглэлийн дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон нэмж тусгах төсөл, хөтөлбөрийн бодлогын судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, үндэслэлийг боловсруулах зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

Тогтвортой хөгжлийн зорилгуудыг үндэсний хэмжээнд нутагшуулах институт бэхжиж байна.

УИХ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо нь төрийн бодлого, шийдвэрт ТХЗ-ыг тусгуулах, хэрэгжилтийг хангуулах зорилгоор Эдийн засгийн бодлогын байнгын хорооны харьяанд ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн олон талт зөвлөл нь Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны ажлыг дэмжих, УИХ, Засгийн газар, хөгжлийн түншүүд, хувийн хэвшил, ИНБ-ууд болон эрдэмтэн судлаачдын өргөн бүрэлдэхүүнтэй олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, оролцоог хангах үүднээс 2022 онд байгуулагдсан бөгөөд ТХЗ-ын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтийг эрчимжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх, шийдвэр гаргалтад мэргэжлийн зөвлөмж хүргүүлэх, ТХЗ-ын талаар олон нийтэд мэдээлэл түгээх, таниулах үүрэгтэй. Иймд, цаашид тус зөвлөлийн байнгын ажиллагааг эхлүүлж, үйл ажиллагааг идэвхжүүлэх хэрэгтэй.

Яамд, агентлагууд, Монгол Улс дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд зэрэг оролцогч талуудаас бүрдсэн Тогтвортой хөгжлийн Үндэсний хороо 2016 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улсын тогтвортой хөгжлийн удирдах хороо байв. Тус хороог Монгол Улсын Ерөнхий сайд ахалж, дэд даргаар Сангийн сайд ажиллаж, 2021 онд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан хэдий ч 2022 онд Засгийн газрын 350 дугаар тогтоолоор татан буугдаж, чиг үүрэг нь ЭЗХЯ-д шилжсэн байна.

ЭЗХЯ нь ТХЗ-ыг үндэсний хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтөд тусган нутагшуулах, хэрэгжилтийг хангуулах, салбар хоорондын уялдааг зохицуулах, хэрэгжилтийг үнэлэх, тайлагнах чиг үүргийг хүлээн, төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан чиг үүргээ хэрэгжүүлж байна.

ҮСХ нь ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг тодорхойлох, бий болгоход арга зүйн дэмжлэг, мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх, албан ёсны статистикийн мэдээллээр тухай бүр хангах, мэдээллийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх үүрэгтэйгээр ажиллаж байна.

2.3. Олон талт оролцоо, түншлэл

ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд бүх талын оролцоо чухал. ТХЗ-ын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд иргэд, байгууллагуудын оролцоо, түншлэлийг дэмжихэд чиглэсэн цаг үеийн шинжтэй томоохон арга хэмжээг төрийн байгууллагууд, ИНБ-ууд, хувийн хэвшил болон олон улсын байгууллагууд хамтарч болон өөрсдийн нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулж байна. Тус чуулга уулзалт нь оролцогч талуудыг тогтвортой хөгжлийн талаарх нэгдмэл нэг ойлголтод чиглүүлсэн, мөн цаашид тогтвортой хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд институцийн тогтолцоог бэхжүүлэх, санхүүжилтийн стратегийг тодорхойлох, хамтын ажиллагааг уялдуулах шаардлагын талаар зөвшилцөлд хүрсэн үр дүнтэй арга хэмжээ болсон.

Хувийн хэвшлийн оролцоо, түншлэл. Unread Media Старт-Ап нь Тогтвортой хөгжлийг дэмжигч ХААН банктэй хамтран "Тогтвортой хөгжил-2030" цахим товхимлыг 2019 оноос

Шигтгээ 2.1. Тогтвортой хөгжлийн зорилго-Дээд түвшний чуулга уулзалт



"Тогтвортой хөгжлийн зорилго-Дээд түвшний чуулга уулзалт"-ыг Монгол Улсад анх удаа УИХ, Засгийн газар, НҮБ-тай хамтран 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулав.

Чуулга уулзалтад танхим болон цахимаар УИХ-ын гишүүд, төр, олон улс, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, иргэний нийгэм, эрдэм шинжилгээ болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, Монгол Улсад оршин суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд нар зэрэг нийт 200 орчим зочид, төлөөлөгчид оролцсон байна. Чуулга уулзалтаар "Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилгыг нутагшуулах нь: Үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг УИХ-аар батлуулах нь", "Цар тахлын үед Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь: Хувийн хэвшлийн үүрэг оролцоо" сэдэвт панел хэлэлцүүлгүүд өрнөж, ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр цаашид анхаарах шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлж, КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй сөрөг нөлөөг даван туулах, эдийн засгийн сэргэлтийг хурдасгах гарц, шийдлийн талаар хэлэлцэж, санал солилцсон байна.



хойш гаргаж, тогтвортой хөгжлийн тухай сэдвийг хүн бүрд хүргэх, алхам бүрдээ хариуцлагатай байх дадал хэвшил, эх дэлхийгээ хайрлах ухамсрыг бүтээхийн тулд ТХЗ-той холбоотой мэдээлэл, үйл явдал, сайн жишээнүүдийг энгийн, сонирхолтойгоор тайлбарлан, давхар блог нийтлэл болгон 70 орчим бүтээлийг олон нийтэд хүргэжээ. Тус байгууллага нь 2015 оны 09 дүгээр сард

Шигтгээ 2.2. “Тогтвортой хөгжлийн зорилго” өдөрлөг

“Тогтвортой хөгжлийн зорилго-Дээд түвшний чуулга уулзалт”-ыг Монгол Улсад анх удаа УИХ, Засгийн газар, НҮБ-тай хамтран 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулав.



Чуулга уулзалтад танхим болон цахимаар УИХ-ын гишүүд, төр, олон улс, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, иргэний нийгэм, эрдэм шинжилгээ болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, Монгол Улсад оршин суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд нар зэрэг нийт 200 орчим зочид, төлөөлөгчид оролцсон байна. Чуулга уулзалтаар “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилгыг нутагшуулах нь: Үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг УИХ-аар батлуулах нь”, “Цар тахлын үед Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь: Хувийн хэвшлийн үүрэг оролцоо” сэдэвт панел хэлэлцүүлгүүд өрнөж, ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр цаашид анхаарах шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлж, КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй сөрөг нөлөөг даван туулах, эдийн засгийн сэргэлтийг хурдасгах гарц, шийдлийн талаар хэлэлцэж, санал солилцсон байна.

өөрийн цахим хуудаснаа тогтвортой хөгжлийн сэдэвтэй хамгийн анхны нийтлэл “Глобал зорилгууд: Тогтвортой хөгжлийн төлөө хамтдаа”-г гарган ТХЗ-ыг танилцуулж байсан бөгөөд түүнээс хойш тогтвортой хөгжлийг туштай дэмжиж, хэрэгжилтийг хангах үйл явцад идэвхтэй оролцож

буй хувийн хэвшлийн нэг юм.

ТХЗ-ын хэрэгжилтийг хангах үйл явцад арилжааны банкнууд идэвх, санаачилгатай оролцож байна. Тухайлбал, ХААН банк 2018 оноос “Тогтвортой хөгжлийн тайлан” гарган, компанийн нийгмийн хариуцлага болон тогтвортой хөгжлийн чиглэлээр хийгдсэн ажлуудаа олон нийтэд толилуулж байна. Тус банк нь Тогтвортой санхүүжилтийн хүрээнд ТХЗ 2, 6, 7, 9, 12, 13, 15, 17-д, Тогтвортой үйл ажиллагааны хүрээнд ТХЗ 5, 6, 7, 8, 10, 11, 12, 16-д, Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалтын хүрээнд ТХЗ 3, 4, 5, 11, 15-д, Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагналын хүрээнд ТХЗ 16, 17-г хэрэгжүүлэхэд нийцтэй үйл ажиллагааг явуулж байна.

Голомт банк 2020 онд Тогтвортой хөгжлийн бодлогоо шинэчилж, Жендерийн хороо, 2021 онд Тогтвортой хөгжлийн хороо байгуулж, “Тогтвортой хөгжлийн стратеги (2022-2025)” батлан, тайлан гаргаж байна. Голомт банкны Тогтвортой хөгжлийн стратеги (2022-2025)-ийн Тогтвортой засаглал хэсэг нь ТХЗ 5, 8, 13, 16, 17-д, Тогтвортой санхүүжилтийн бүрэлдэхүүн нь ТХЗ 3, 5, 8, 11-д, Тогтвортой үйл ажиллагаа, хүний нөөцийн удирдлага нь ТХЗ 7, 8, 9, 12, 13-т, Нийгмийн хариуцлага нь ТХЗ 3, 4, 10-д хувь нэмэр оруулахаар боловсруулагджээ.

Худалдаа хөгжлийн банк (ХХБ) нь дунд хугацааны стратеги зорилтдоо тогтвортой хөгжлийн 17 зорилгоос ТХЗ 4, 5, 8, 13-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ хэмээн тусгайлан тусгаж, холбогдох төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна. Ялангуяа, жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилгын хүрээнд эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэн олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, сангуудаас боломжит сургалт, судалгаа, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, эмэгтэй бизнес эрхлэгчдэд ээлтэй банкны бүхий л төрлийн үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

М-Си-Эс Групп нь тогтвортой хөгжилд нийцсэн бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэл, ажилчид болон харилцагч, ханган нийлүүлэгчид, нийгмийн бүлгүүдэд чиглэсэн бодлого, сайн дурын үйл ажиллагаа, хамтын ажиллагаа болон нийгмийн хариуцлага зэрэг ажлуудыг олон нийтэд нээлттэй, ил тод тайлагнах зорилгоор Тогтвортой хөгжлийн тайланг 2017 оноос эхлэн гаргажээ. Тус группийн харилцаа холбоо болон өргөн хэрэглээний барааны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг таван компани 2030 оноос эхлэн хүлэмжийн хийн ялгаруулалт шингээлтийг тэнцвэржүүлэх алхмаа эхлүүлэх суурь тогтолцоог бий болгохоор ажиллаж байна. Тухайлбал, Группийн зарим компани 2021 онд хүлэмжийн хийн тооллогыг анх удаа хийж, “Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарлыг 2030 онд 22.7 хувиар бууруулах”-д тодорхой хувь нэмэр оруулах зорилт тавьжээ. Тус групп нь тогтвортой хөгжилд нийцсэн үйл ажиллагаагаа ТХЗ 7, 9, 11, 17-д, бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэлээ ТХЗ 2, 6,



9, 12, 15-д, ажилчид руу чиглэсэн бодлогоо ТХЗ 3, 4, 5, 8, 10, 12-д, тогтвортой нийлүүлэлтийн гинжин хэлхээ ба хэрэглэгчдээ ТХЗ 1, 3, 5, 6, 8, 12, 15-д, хамтын ажиллагаа ба сайн дурын үйл ажиллагааг ТХЗ 8, 11, 15, 17-д, иргэдийн оролцоо, нийгмийн бүлгүүдийг дэмжих ба нийгмийн хариуцлагаа ТХЗ 1, 2, 3, 4, 5, 10, 11, 17 зэрэгтэй нийцүүлэхэд чиглэжээ.

Хувийн хэвшлийн үзүүлж буй дэмжлэг, хөрөнгө оруулалтын ил тод зарцуулалтад орон нутгийн оролцоог хангах зорилгоор бие даасан сан байгуулах нь сайн туршлага болж байна. Тухайлбал, Оюу толгой ХХК-ийн 2015 онд байгуулсан Говийн Оюу хөгжлийг дэмжих санг дурдаж болно. Тус сангаар дамжуулан 2015 оноос хойш Өмнөговь аймгийн сумдад 100 тэрбум төгрөгийн өртөг бүхий 330 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн. Үүний дотор НҮБ-ын Хүн амын сан болон Хүүхдийн сантай хамтран эрүүл мэнд, боловсролын салбарт 5 жилийн нэгдсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр орон нутгийн иргэд, хөдөлгөөнт хүн амд үзүүлэх суурь үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, ялангуяа, аймагтаа эрүүл мэндийн үзлэгт орж өвчнийг эрт илрүүлэх боломж бүрдсэн. Оюу толгойн гүний уурхайн тогтвортой үйл ажиллагаа 2023 оны 03 дугаар сард эхэлснээр орон нутгийн хөгжилд



тус уурхайн үзүүлэх нөлөөлөл улам нэмэгдэж байна. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг улам оновчтой, орон нутгийн оролцоотой, ил тод байлгах зорилгоор тус компани нь Ханбогдын хөгжлийн хурдасгуур Оюу толгой санг байгуулсан байна. Уг сан нь эрчим хүч, ус, зам, эрүүл мэнд, байгаль орчин, боловсролын чиглэлээр нэн чухал дэд бүтцийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж улмаар Ханбогд сумын хувьд бие даасан хөгжлийг хангаж, хот болж хөгжих суурь бүрдэнэ.

ТХЗ-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ, ҮСДИ БЭЛТГЭХ ҮЙЛ ЯВЦАД ИНБ-УУД ИДЭВХ САНААЧИЛГАТАЙ ОРОЛЦОЖ БАЙНА.


Тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ИНБ-ууд нэгдэж "ТХЗ ба ИНБ сүлжээ" байгуулан түншлэлийг хөгжүүлж, үр дүнтэй хамтын ажиллагааны механизм бүрдүүлж, нэгдсэн зохион байгуулалттай ажиллах санаачилгыг 2018 оноос хэрэгжүүлж байна. Тэд ТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл явцад оролцох, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үнэлгээ хийх, үндэсний болон олон улсын хэмжээний хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтад оролцох, ТХЗ-ын ач холбогдол, хэрэгжилтийг олон нийт, ялангуяа орон нутгийн иргэдэд ойлгуулахтай холбоотой үйл ажиллагаанд идэвх, санаачилгатай оролцож байна. Тус сүлжээнээс ТХЗ-ын хэрэгжилтийн талаарх "Сүүдрийн илтгэл"-ийг 2019 онд гарган, ИНБ-уудын үнэлгээ, дүгнэлтийг төр, засаг, олон нийтэд хүргэж байсан туршлагатай.

"ТХЗ ба ИНБ" сүлжээ, Хүний эрх, хөгжил төв хамтран ТХЗ-ын хэрэгжилтийг оноогоор үнэлэх аргачлалыг ашиглан, хоёр удаа үнэлгээ хийжээ. Эхний үнэлгээг ИНБ-уудын экспертийн баг хийж ТХЗ (ТХЗ 14-өөс бусад)-ын улсын хэмжээн дэх хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгсөн бол, хоёр дахь үнэлгээг олон талт оролцогчдын төлөөлөл хийсэн. Олон талт оролцогчдын үнэлгээнд яам, агентлаг, орон нутгийн захиргаа, нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон улсын байгууллага, иргэд, судлаачдын төлөөлөл оролцсон байна.

ИНБ-уудын үнэлгээгээр, ТХЗ-ын хэрэгжилтэд (ерөнхий оноо -1.1) мэдэгдэхүйц үр дүн гараагүй, ахиц дэвшилгүй, ухралттай гэж үзсэн бол, олон талт оролцогчдын үнэлгээгээр ТХЗ-ын хэрэгжилтэд өөрчлөлт (ерөнхий оноо 0.09) байхгүй гэж дүгнэжээ.



Зураг 2.1. ТХЗ-ын хэрэгжилтийн үнэлгээ, ИНБ ба олон талт оролцогчдын үнэлгээгээр, 2022



Тайлбар: Энэхүү аргачлал нь хүртээмжтэй хэрэгжилтийн үзэл баримтлалд суурилсан “Онооны арга” бөгөөд -5-аас +5 хооронд үнэлэгдэнэ. Өөрөөр хэлбэл, ИНБ-ууд болон Олон талт оролцогчдын ТХЗ-ын хэрэгжилтийн тухай үзэл бодлын төсөөллийн үнэлгээ юм.

ИНБ болон олон талт оролцогчдын үнэлгээ хоорондоо ихээхэн зөрүүтэй байгаа нь нэг талаас үнэлгээнд оролцогч талуудын тухайн ТХЗ-той холбоотой мэдээ, мэдээллийн хүртээмж ялгаатай, нөгөө талаас ТХЗ-той холбоотой асуудлыг хариуцан ажилладаг эсвэл сонирхон оролцдог туршлага нь ялгаатай байх талтай.

Монгол Улсын Сайн дурынхны байгууллагуудын сүлжээ ТХЗ-ыг хангахад

идэвхтэй оролцож байна. Сайн дурынхан ТХЗ 1, 3, 4, 5, 8, 10, 11, 13, 16, 17-ын хүрээнд тодорхой үйл ажиллагаанд, тухайлбал, сургалт, нөлөөллийн ажил, туслалцаа үзүүлэх, мэдээлэл, зөвлөх үйлчилгээ, судалгаа явуулах, ТХЗ-ын ач холбогдлыг таниулах зохион байгуулалттай ажилд биечлэн оролцуулах, хандив цуглуулах, ухуулга сурталчилгаа хийх зэрэг ажлуудыг сайн дурынхны санаачилга, дэмжлэгтэйгээр гүйцэтгэжээ.

Шигтгээ 2.3 ТХЗ-ын талаарх зорилтот бүлгийн иргэдийн ойлголт, хандлага

Иргэдийн ойлголт, хандлага, оролцоо: Иргэдийн тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг, хандлага, оролцоо төдийлөн хангалттай байж чадахгүй байна. “Тогтвортой хөгжлийн зорилго” өдөрлөгийн үеэр (2022) иргэдийн ТХЗ-ын талаарх ерөнхий ойлголт, хандлагын тандан судалгааг ҮСХ болон НҮБ-ын Суурин зохицуулагчийн газраас хамтран зохион байгуулжээ. Тус судалгаанд 203 хүн хамрагдсан бөгөөд бараг 60 орчим хувь нь 29-өөс доош насны хүүхэд, залуучууд байжээ. Нийт оролцогчдын гурван хүн тутмын нэг нь ТХЗ-ын талаар сайн мэддэг, бусад хүмүүсийн хувьд бага зэрэг мэднэ, сонсож байсан ч тодорхой мэдэхгүй эсвэл огт мэдэхгүй байна. Мөн тэдний талаас илүү хувь (63 хувь) нь ус, цахилгааны хэрэглээгээ бууруулж, мод тарьж байгаль орчноо хамгаалан, хуванцар сав, гялгар уутны хэрэглээгээ багасган тогтвортой хөгжилд өөрсдийн хувь нэмрээ оруулж байгаа хэмээн үзжээ.

ҮСДИ-ийг бэлтгэх явцад зорилтот бүлгийнхэн (ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 15-19 насны өсвөр үеийнхэн, 20-40 насны залуучууд)-тэй уулзаж, ТХЗ-ын талаарх ойлголт, мэдлэг, иргэдийн оролцооны талаар чанарын судалгааг хийсэн. Тус судалгааны үр дүнгээр, иргэдийн ТХЗ-ын талаарх ойлголт хангалтгүй, 4 хүн тутмын нэг нь энэ талаар сонссон төдий байна. Ялангуяа, 15-19 насны оролцогчдын тухайд дунд сургуулийн сургалтын хөтөлбөрөөр нэг хичээлийн цөөн цагийн багтаамжтай тогтвортой хөгжлийн тухай үзсэн ч хангалттай мэдлэг өгөөгүй байна.

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шинжлэх ухаан, танин мэдэхүй, хөгжлийн үйл явцын тухай мэдээлэл түгээлт хангалтгүй, нотолгоогүй худал мэдээлэл ихээхэн цацагддаг. Төр, засгийн зүгээс, ялангуяа үндэсний олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хөгжлийн үйл явцыг үнэлэн дүгнэсэн, нотолгоонд суурилсан, танин мэдэхүйг дээшлүүлэх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн нэвтрүүлэг, контентыг түгээж, иргэдийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, хөгжлийн үйл явцад оролцох хүсэл эрмэлзлийг өдөөх хэрэгтэй. Тодруулбал, иргэдийг татан оролцуулах боломж, сонголтыг бий болгосон арга хэрэгслүүд (онлайн платформ ажиллуулах, иргэний танхимуудад уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, нийгмийн сүлжээгээр дамжуулан зөв мэдээлэл бүхий контентууд түгээх)-ийг бий болгож, байнгын ажиллагаатай байхад анхааран ажиллах хэрэгтэй байгааг судалгаанд оролцогчид онцолж байна.

Өнөөгийн байдлаар хөгжлийн үйл явцад бүх талын оролцоог хангасан, байнгын, албан ёсны

механизм үгүйлэгдсэн хэвээр, тухайлбал, ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үндэсний



хэмжээний албан ёсны механизм, уулзалт-мэдээлэл солилцооны байнгын платформ, дижитал оролцооны сонголтууд байхгүй байна. ТХЗ-ын хэрэгжилтэд бүх оролцогч талуудыг дайчлах, оролцуулах, өөрчлөлтийг дэмжихийн тулд тэдгээр байгууллагуудын үндсэн үйл ажиллагааг ТХЗ-той холбон үнэлэх, үнэлгээний үр дүн, ТХЗ-ын хэрэгжилтийг хангахад чиглэсэн бодлогын хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтуудыг олон талын оролцоотойгоор тогтмол зохион байгуулах хэрэгтэй. Ингэснээр салбар хоорондын, үндэсний болон орон нутгийн түвшний бодлогын уялдаа, нийцлийг хангах, бодлого хэрэгжүүлэх механизм, чадавх, санхүүжилтийг, ялангуяа орон нутгийн анхдагч нэгж түвшинд сайжруулах, хөрөнгийг дайчлах олон талын түншлэлийг хөгжүүлэхэд үр дүнтэй. Мөн "хэнийг ч үл орхих" үзэл баримтлал, зарчим бодитой хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Хүүхэд бол өөрчлөлт, шинэчлэлийн төлөөлөл-хөдөлгөгч хүч, залуучууд бол тогтвортой хөгжлийг дэмжих бүхий л хүчин чармайлт дахь гол тоглогч, хувь нэмэр оруулагчид тул бүх түвшний боловсролын байгууллагууд сургалтын хөтөлбөрөө тогтвортой хөгжлийн зарчмуудтай нийцүүлэн, сургалтын агуулгаараа тогтвортой хөгжлийн төлөө өөрчлөлт хийх мэдлэг, ур чадвар олгох хэрэгтэй.

Түүнчлэн, тогтвортой хөгжлийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрүүд боловсруулах, түгээх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажилд залуучуудыг бүрэн хамруулах, ялангуяа залуучууд өөрсдөө дуу хоолойгоо хүргэж, идэвх гарган, тогтвортой хөгжлийн талаар шийдвэртэй өөрчлөлт хийхийг шаарддаг, төр, засгийн удирдлагуудаас эгэх хариуцлага нэхэж чаддаг байх хэрэгтэй.

2.4. Тогтвортой хөгжлийн зорилгын санхүүжилтийн механизм

Хөгжлийн бодлого, төлөвлөлт болон төсөвлөлтийн уялдаа холбоог сайжруулах, ТХЗ-той уялдсан, үр дүнд чиглэсэн төсөвлөлт рүү шилжих шат дараатай арга хэмжээнүүдийг Засгийн газраас хэрэгжүүлж байна. Тухайлбал, Төсвийн бодлогын хүрээнд 2021 оноос эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл эхэлсэн бол 2022 онд боловсрол, соёл, нийтийн биеийн тамир, хүүхэд хамгааллын салбарын санхүүжилтийг үр дүн, чанар, гүйцэтгэлтэй уялдуулах ажлыг эхлүүлсэн. НҮБ-аас зөвлөсний дагуу Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратегийн төслийг 2022 онд боловсруулж, Тогтвортой хөгжлийн Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэн батлуулахыг дэмжсэн байна.

Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлэх, санхүүжилтээ оновчтой, зөв удирдах, гадаад, дотоод санхүүгийн шинэ эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх, одоо байгаа боломжит нөөцөө үр ашигтайгаар зарцуулахын тулд төсөв, санхүүгийн шинэчлэлийг эрчимжүүлэх,

санхүүгийн шинэ механизм, хэрэгслүүдийг туршиж, нэвтрүүлэх шаардлага байсаар байна.

Монгол Улсыг тогтвортой хөгжилд хүргэхэд шаардлагатай санхүүжилтийг бий болгоход төр, хувийн хэвшлийн түншлэлийг чухалчилдаг. Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл 2018 онд Монгол Улсын Ногоон таксономийг баталснаар банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг үйл ажиллагаандаа ашиглах боломж бүрдсэний зэрэгцээ 2022 онд "Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг"-ийг баталсан. Банк, санхүүгийн байгууллагууд, ялангуяа арилжааны банкнууд 2020 оноос байгаль орчинд ээлтэй эдийн засгийн үйл ажиллагааны ангилал "Ногоон таксономи"-г нэвтрүүлсэн. Ингэснээр зээл хүсэгч ААН байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, ажлын байр шинээр бий болгох, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан эсэх зэргийг зээл олгоход анхаардаг болж, банк, санхүүгийн байгууллагууд харилцагч нартаа ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хүн бүрийн хувь нэмэр чухал гэдгийг ойлгуулж, уриалахад оролцож байна. Мөн арилжааны банкнууд тогтвортой санхүүжилтийг дэмжих урт хугацааны хөнгөлөлттэй эх үүсвэр татах чиглэлд идэвхтэй ажилласаар байна. Ялангуяа, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны тулгамдаж буй асуудалд хувь нэмрээ оруулахын тулд арилжааны банкнууд өөрсдийн санаачилгаар Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, Дэлхийн Уур амьсгалын хамтын ажиллагааны сангийн хөнгөлөлттэй санхүүжилт татжээ.

Мөн, Монголын хөрөнгийн бирж 2017 онд НҮБ-ын дэргэдэх Тогтвортой хөрөнгийн биржүүдийн холбоонд элссэн нь компаниуд үйл ажиллагааныхаа эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг тодорхойлох, танин мэдэх, олон нийтэд мэдээлэх, сөрөг нөлөөллийг бууруулж, нийгэмд үзүүлэх эерэг өөрчлөлтийг улам нэмэгдүүлэх төдийгүй эргээд компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эрсдэлийг бууруулах, удаан хугацаанд амжилттай оршин тогтнох нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5. Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт, үнэлгээ, тайлагнал

Монгол Улс нь ТХЗ-ыг амжилттай хэрэгжүүлэхэд олон талын оролцоог хангасан хяналт-шинжилгээ, үнэлгээний байнгын тогтолцоог бүрдүүлэх хүчин чармайлт гаргасан ч хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явцын тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг иргэд, олон нийтэд хүргэх, иргэдийн оролцоотой хяналтад ашиглагдах мэдээллийн хэрэгцээ шаардлага сорилт хэвээр байна.

ЭЗХЯ-ны нэг үндсэн чиг үүрэг нь үндэсний хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн



хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бөгөөд энэхүү үйл ажиллагаандаа Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг мөрдөн ажиллаж байна. Монгол Улс ТХЗ-ын хэрэгжилтийн явцын тайлагналын хувьд хэрэгжилтийг хянах гол арга хэрэгслээр ҮСДИ-ийг ашиглаж байна. Анхны ҮСДИ-ийг 2019 онд танилцуулж, Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтийн төлөв байдлыг танилцуулахын зэрэгцээ ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд саад болж буй хөгжлийн тулгамдсан асуудлаар агаарын бохирдлыг сонгон шинжилж, түүнийг бууруулахын тулд хэрэгжүүлж болох арга хэмжээний шийдлүүдийг танилцуулсан. Ахиц дэвшил гаргахад чиглэсэн үйл ажиллагааны жил бүрийн төлөвлөгөө хийж, хэрэгжилтийг хангахын тулд олон талт оролцооны аргад тулгуурлан хяналт, үнэлгээг тогтмол хийх шаардлагатай байна. Анхны ҮСДИ-ийг танилцуулснаас хойш ийм арга замаар ажиллаж чадаагүйн улмаас зөвлөмжүүдийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.


ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг үнэлэх, тайлагнахад нэн тэргүүнд ТХЗ-ын үндэсний шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоодог хандлага дэлхийн улс орнуудад түгээмэл байна. Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 2 дугаар захирамжаар 8 дэд ажлын хэсэг байгуулж, "ТХЗ-ын үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт"-ийн төслийг 2022 онд боловсруулсан бөгөөд, энэхүү төслийг ЭЗХЯ, ҮСХ-той хамтран шинэчилж, ТХЗ-ын үндэсний шалгуур үзүүлэлтүүдийг зорилтот түвшний хамт тодорхойлж, холбогдох дээд байгууллагаар батлуулахад бэлэн болгожээ. Үндэсний аудитын газраас хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд төлөвлөгөөт аудит, хяналтыг тогтмол гүйцэтгэдэг. Тус газраас 2021 онд гүйцэтгэлийн аудитаар "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилт, шалгуур үзүүлэлтүүд тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой байх

шинжийг хангасан эсэх, мөн ТХЗ-той уялдсан эсэхэд дүн шинжилгээ хийжээ.

ТХЗ-ын хэрэгжилтийг үр дүнтэй хянахын тулд тоо мэдээллийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг зөв тогтоон хэрэглэх, тоо мэдээллийн бэлэн байдал маш чухал. ҮСХ нь Монгол Улсад ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээг НҮБХХ, НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөртэй хамтран санхүүжүүлсэн төслийн хүрээнд 2015 онд анх удаа хийсэн. Үүнээс хойш ТХЗ-ын хэрэгжилтийг хянах, дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийн бэлэн байдлын үнэлгээг жил бүр тогтмол хийж, НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын дэмжлэгтэйгээр "ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн замын зураглал"-ыг 2022 онд боловсруулсан. Замын зураглал нь одоогийн байдлаар тооцож буй үзүүлэлтүүдийг цаашид хэрхэн сайжруулах, шинээр тооцох боломжтой эсвэл боломжгүй байгаа үзүүлэлтүүдийг тооцох боломжийн талаар зөвлөмж өгчээ. Мөн төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сул, шалгуур үзүүлэлтүүдийн ач холбогдлын талаарх ойлголт хангалттай бус байгаагаас шалтгаалж ТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн мэдээллийн бэлэн байдал сайжрахгүй байгаа ч тооцож буй үзүүлэлтүүдийн тоог нэмэгдүүлэх бололцоо бий гэж үзжээ. Түүнчлэн, шинээр судалгаа явуулах, одоо явуулж буй судалгаа, тооллогод шинэ үзүүлэлт, модуль нэмэх, дэлхийн хэмжээнд ТХЗ-ын үзүүлэлт хариуцсан олон улсын байгууллагуудын санал болгож буй шалгуур үзүүлэлтүүдийн аргачлалыг судлах, их өгөгдөл, газар зүйн мэдээллийн системийг ашиглах зэргээр мэдээллийн бэлэн байдлыг нэмэгдүүлэхийг зөвлөсөн.

ҮСХ нь дээрх зөвлөмжийн дагуу мэдээллийн эх үүсвэр, ТХЗ-ын үзүүлэлт хариуцсан олон улсын байгууллагуудын дэлхийн түвшинд тооцсон тооцоолол зэргийг дахин хянаж үзсэний үр дүнд 2023 оны эхний 02 сарын байдлаар 18 үзүүлэлтүүдийг нэмж, үндэсний түвшинд тооцсон нийт үзүүлэлтийн тоо 138-аас 156 болж нэмэгджээ. Мөн Засгийн газрын байгуулсан "ТХЗ-ын Үндэсний үзүүлэлтийн хүрээ боловсруулах" ажлын хүрээнд 35 үзүүлэлтийг нэмэх боломж бүрдсэн.

Зураг 2.2. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийн бэлэн байдал



ҮСХ нь ТХЗ-ын тоо мэдээлэлд уламжлалт бус мэдээллийн эх үүсвэрийг ашиглах, хэрэглээг нэмэгдүүлэхэд бусад талуудтай хамтран идэвх санаачилгатай ажиллаж байна.

Шигтгээ 2.4. Уламжлалт бус мэдээллийн эх үүсвэр ашиглан, тоон мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлсэн туршлага

ҮСХ нь НҮБ-ын АНДЭЗНХ-той хамтран хэрэгжүүлсэн “Их өгөгдөл ашиглан байгаль орчин-жендэрийн үзүүлэлтийг тооцох нь” төслийн хүрээнд “Эрүүл ахуйн нөхцөл хангагдаагүй, стандартын бус байр, сууцанд амьдарч буй хотын хүн амын эзлэх хувь” гэсэн ТХЗ-ын 11.1.1-р үзүүлэлтийг тооцох туршилт тооцоо хийсэн. Тооцооллын хүрээнд хиймэл дагуулын зургаас Google earth engine болон QGIS (нэмэлтээр OrfeoToolbox) программ ашиглан гэр сууцыг ялгах аргуудыг харьцуулан турших үйл ажиллагаа хийгдсэн. Туршилтад Random forest, Decision tree, K nearest neighbours зэрэг моделиудыг ашигласан бөгөөд харьцуулалтын үр дүнд Random Forest модель илүү үр дүн үзүүлсэн. Үүний дагуу Random Forest моделийг ашиглан нийслэлийн томоохон дүүргийн хэмжээнд тооцооллыг боловсруулахад 85.2 хувийн ерөнхий нарийвчлалтай үр дүн гарсан. Энэ боловсруулсан загварын дагуу нийслэлийн болон улсын хэмжээнд ТХЗ 11.1.1 үзүүлэлтийг бүрэн тооцохоор ажиллаж байна. Ийнхүү Монгол Улс нь энэхүү сонгосон үзүүлэлтийн тухайд сууцны уламжлалт төрөл болох гэр сууцтай гэдгээрээ ялгарч бүс нутгийн хэмжээнд онцлог тооцоолол хийсэн туршлага болсон.

Мөн ТХЗ-ын 9.1.1-ийн хувьд бүх улирлын туршид замаас 2 км зайтай амьдарч байгаа хөдөөгийн хүн амын эзлэх хувь гэсэн үзүүлэлтийн авто замын сүлжээний мэдээлэл (Open Street Map) болон хүн амын статистикийн мэдээллийн эх үүсвэрийг ашиглан туршилт тооцоо хийсэн.

ТХЗ-ын хэрэгжилтийг хянах систем (SDGs Dashboard) -ийг 2019 оны 01 дүгээр сараас эхлэн ажиллуулсан бөгөөд ТХЗ-ын хэрэгжилтийн явцад хяналт, үнэлгээхийх, мэдээллийн нурсгалыг тогтоож, үүрэгжүүлэх, төрийн байгууллагууд хоорондын тоо мэдээллийн солилцоог боловсронгуй болгох боломжийг бүрдүүлснээс гадна тоо мэдээллийг олон нийтэд түгээж байна.

ТХЗ-ын тоо мэдээллийг цуглуулах, удирдахад багагүй бэрхшээл тулгарч байна. Тухайлбал, Монгол Улсын хувьд зарим тоо мэдээллийн эх үүсвэр хангалтгүй, төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сул, ТХЗ, шалгуур үзүүлэлтүүдийн ач холбогдлын талаарх ойлголт хангалттай бус, ажилтнуудын тогтворсуурьшилтай ажиллах боломж муу, залгамж



халаа байхгүй, зарим төрийн байгууллагууд статистик мэдээлэл хариуцсан ажилтангүй, ТХЗ-ын үзүүлэлтийг тооцох тусгайлсан санхүүжилт байдаггүй, төрийн, хувийн, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоо сул байна.

Дэлхийн улс орнууд ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг зөвхөн үндэсний хэмжээний мэдээллийн эх сурвалжаас харахаас гадна НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын санаачилсан ТХЗ-ын ахиц дэвшлийн талаарх хөдөлгөөнт дүрслэл бүхий янз бүрийн платформуудыг ашиглаж байна. Үүний нэг нь НҮБХХ-ийн SDG Push Diagnostic буюу ТХЗ-ын динамик дүрслэл бүхий үнэлгээний платформ бөгөөд улс орнуудын статистикийн байгууллагаас ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн тоо мэдээллийг цуглуулан, дижитал технологийн шийдэл ашигласан хэлбэрээр ахиц дэвшлийн үнэлгээг түгээдэг байна. Энэ үнэлгээ нь олон мэдээллийн эх сурвалжид тулгуурлан, дижитал инновацлаг хэлбэр, газар зүйн ялгаатай байдлаар ТХЗ-ын хэрэгжилтийн одоогийн болон ирээдүйн чиг хандлага, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог тогтвортой хөгжлийн 17 зорилгын 169 зорилтын 232 шалгуур үзүүлэлтээр гаргахын зэрэгцээ, ирээдүйн чиг хандлагыг тооцоолохдоо засаглал, нийгмийн хамгаалал, ногоон эдийн засаг болон дижитал хуваагдал гэсэн дэд хэсгүүдийн хурдасгуурт суурилан тооцжээ. Энэхүү платформд харуулснаар Монгол Улсын хувьд тогтвортой хөгжлийн 2 зорилгыг 2030 он гэхэд хангах боломжтой, 14 зорилготой холбоотой үйл ажиллагаануудыг хурдасгаж, хүчин чармайлт гаргах шаардлагатай, 1 зорилгын хувьд мэдээлэл байхгүй гэж үнэлэгдсэн байна.



БҮЛЭГ 3.


**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТЭД
ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, АХИЦ ДЭВШИЛ**



3.1. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд хэр ахиц дэвшил гарсан бэ?

Монгол Улс ТХЗ-ын хэрэгжилтийг хангахад ихээхэн хүчин чармайлт, тодорхой ахиц дэвшил гаргаж буй хэдий ч тавьсан зорилтдоо хүрэхэд 2030 оноос хойш олон жил шаардагдаж магадгүй тул хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд цаашид олон арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Дэлхий даяар эдийн засаг, нийгэм, байгаль орчны гэсэн хөгжлийн тулгуур хэмжигдэхүүнийг хамарсан сорилтуудтай тулгарч буй тул зорилгодоо хүрэх нь урьд өмнөхөөс илүү чухал юм.

Зураг 3.1. Монгол Улсын ТХЗ-ын ахиц дэвшлийн урьдчилсан үр дүн, 2022 он



Эх сурвалж: YCX, 2023.

Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих (ТХЗ 11), Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг багасгах (ТХЗ 13), Энх тайван, шударга ёсыг цогцлоох (ТХЗ 16), Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх (ТХЗ 17) зэрэг зорилгуудын хэрэгжилт хангагдах түвшинд буюу 2030 оны зорилгодоо хүрэхэд эерэг хандлагатай байна. Харин ядуурлыг бууруулах (ТХЗ 1) зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангаж, тогтвортой хөдөө аж ахуйг хөхүүлэн дэмжих (ТХЗ 2), Чанартай боловсролыг дэмжих (ТХЗ 4), Жендерийн тэгш байдал, охид эмэгтэйчүүдийн эрхийг хангах (ТХЗ 5), Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах (ТХЗ 6), Эдийн засгийн өсөлт, зохистой ажлын байрыг бий болгох (ТХЗ 8), Тэгш бус байдлыг бууруулах (ТХЗ 10), Хариуцлагатай хэрэглээг дэмжих (ТХЗ 12) зэрэг зорилгуудын хэрэгжилт тодорой түвшинд тодорхой ахицтай байгаа хэдий ч Монгол Улс 2030 он хүртэлх зорилгыг биелүүлэхийн тулд улам их хүчин чармайлт гаргах хэрэгтэй.

Эрүүл мэндийг дэмжих (ТХЗ 3), Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх (ТХЗ 7), Инновацыг дэмжиж, дэд бүтцийг сайжруулах (ТХЗ 9), Хуурай газрын экосистемийг хамгаалах (ТХЗ 15) зэрэг зорилгуудын хувьд хэрэгжилт бага буюу зогсонги

байдалтай байгаа тул илүү анхаарах хэрэгтэй.

3.2. Монгол Улс 2030 он гэхэд зорилгодоо хүрэх үү?

Даян дэлхийн ТХЗ-ын 169 зорилтын 248 шалгуур үзүүлэлтүүдээс Монгол Улсын хувьд 83 зорилтыг хэмжих боломжтой байна. 2030 он гэхэд хэмжигдэхүйц зорилтуудын 32 (38.6%) нь зорьсондоо хүрэх явцад, 36 (43.4%) зорилтын ахиц дэвшлийг нэн даруй хурдасгах, харин 15 (18.0%) зорилт урвуу хандлагатай байна (Хүснэгт 3.1).

2015 оны суурь үзүүлэлттэй харьцуулахад хамгийн их буурсан зорилго, зорилт нь ядуурал хүнсний нөөц, эхийн эндэгдэл, халдварт бус өвчин, эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн бэлэн байдал, мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ур чадвар, мэргэжлийн багшийн хомсдол, ус ашиглалт, эдийн засгийн өсөлт, дотоодын материалын хэрэглээ, үйлдвэрлэлийн осол гэмтэл, хүлэмжийн хийн ялгарал, ялгаварлан гадуурхалт, ногоон байгууламж, газрын доройтол зэрэг юм. Монгол Улсын ТХЗ-ын явцын талаар хангалттай мэдээлэлгүйгээр үнэн дүр зургийг гаргах боломжгүй юм. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийн хүртээмж жилээс жилд сайжирч, дүр зураг илүү тодорхой болж байгаа хэдий ч мэдээллийн томоохон цоорхой



байсаар байна. Өгөгдөл хангалтгүй эсвэл зорилтот утгууд тодорхойгүй байгаа гэсэн шалтгаанаар 78 шалгуур үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэр дутмаг байна. Мэдээллийн хүртээмжийн талаар илүү дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг Бүлэг 2-оос харна уу.

3.3. ТХЗ-ын зорилго тус бүрийн хэрэгжилтийн төлөв байдал

Монгол Улс тогтвортой хөгжлийн үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулж, үндэсний онцлогт нийцүүлэн 16 зорилго, 154 зорилт, 2025, 2030 он хүртэлх зорилтот түвшин бүхий 253 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. Эдгээрээс одоогийн байдлаар тооцох боломжтой 191 шалгуур үзүүлэлтийн хоёр болон түүнээс дээш жилийн динамик мэдээлэл

	1.1 Ядуурлын олон улсын түвшин	■		7.2 Сэргээгдэх эрчим хүч	■
	1.2 Үндэсний ядуурлын түвшин	■		8.1 Нэг хүнд ногдох эдийн засгийн өсөлт	■
	1.5 Гамшгийн эрсдлийг бууруулах	■		8.2 Эдийн засгийн бүтэц	■
	2.2 Өсөлт, хоол тэжээлийн дутагдал	■		8.3 Жижиг дунд үйлдвэр, бизнесүүдийн өсөлт	■
	2.5 ХАА-н зориулалтаар хадгалсан генетик нөөц	■		8.4 Материаллаг нөөцийг хадгалж, өргөтгөх	■
	2.a ХАА-д оруулсан хөрөнгө оруулалт	■		8.5 Ажил эрхлэлт, зохион байгуулалт	■
	2.b ХАА-н экспортын татаас	■		8.6 Ажил эрхлэлтэд хамрагдал	■
	3.1 Эхийн эндэгдэл	■		8.8 Хөдөлмөрийн эрх, хамгаалалт	■
	3.2 Хүүхдийн эндэгдэл	■		8.9 Тогтвортой аялал хөдөлгөөн	■
	3.3 Халдварт өвчин	■		8.10 Санхүүгийн үйлчилгээ	■
	3.4 Архаг өвчин, сэтгэцийн эрүүл мэнд	■		8.b Залуучуудын хөдөлгөөн	■
	3.6 Зам тээврийн ослын шалтгаант нас баралт	■		9.1 Дэд бүтцийн хөгжил	■
	3.7 Нөхөн үржихүйн эрүүл мэнд	■		9.2 Тогтвортой/хүртээмжтэй өмчлөлт	■
	3.8 Бүх нийтийн эрүүл мэндийн даатгал	■		9.3 Бичил бизнесүүдийг дэмжих	■
	3.9 Бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх нөлөө	■		9.4 Тогтвортой, цэвэр, хөгжилтэй хотууд	■
	3.c Эрүүл мэндийн санхүүжилт, ажиллах хүч	■		9.5 Судалгаа, хөгжил, инноваци	■
	3.d Эрүүл мэндийн эрсдэлийн менежмент	■		9.b Дотоодын технологийн хөгжил	■
	4.1 Өгөөжтэй сургалтын үр дүн	■		10.1 Орлогын өсөлт (дотоод)	■
	4.2 Бага насны хүүхдийн хөгжил	■		10.2 Оролцуулах (нийгмийн)	■
	4.4 Ажил эрхлэлтийн ур чадвар	■		10.3 Ялгаварлан гадуурхах	■
	4.6 Бичиг үсэг тайлагдалт	■		10.4 Төсөв, нийгмийн хамтын ажиллагаа	■
	4.a Сургалтын байгууламж тоног төхөөрөмж	■		11.4 Соёлын болон байгалийн мөхөөгч	■
	4.c Мэргэшсэн багшлах боловсон хүчин	■		11.5 Гамшгийн эсрэг төлөв	■
	5.1 Эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах	■		11.6 Агаарын чанар, хот, хотууд	■
	5.5 Удирдлагад байгаа эмэгтэйчүүд	■		11.7 Хотын нийтийн эзэмшил	■
	6.4 Ус ашиглалтын үр ашиг	■		11.b Гамшгийн эрсдэлийн менежмент	■
	6.5 Хил дамнасан усны хамтын ажиллагаа	■		12.1 Тогтвортой хэрэглээ	■
	6.b Оролцоотой ус, ариун цэврийн менежмент	■		12.2 Байгалийн нөөцийг хадгалж, өргөтгөх	■
				12.5 Хаягдал үүсгүүрийг бууруулах	■
				12.7 Төрийн худалдан авалт	■
				12.b Тогтвортой аялал	■



бүхий 135 шалгуур үзүүлэлтийн 2010-2021 оны мэдээлэлд тулгуурлан зорилго тус бүрийн хүрээнд хүлээгдэж буй ахиц дэвшлийг шалгуур үзүүлэлтээр шинжлэв.

Хүлээгдэж буй ахиц дэвшлийг Хүснэгт 3.1-д нэгтгэн илэрхийлж, зорилт бүрийг дараах

өнгөөр ялган харуулсан: зорилгодоо хүрэхийн тулд явцыг хадгалах үзүүлэлтүүдийг ногоон өнгөөр, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай үзүүлэлтүүдийг шар өнгөөр, зорилгоосоо ухарсан хандлагатайг улаан өнгөөр, үнэлгээ хийх боломжгүйг саарал өнгөөр харуулав.

Хүснэгт 3.1. Монгол Улсын ТХЗ-ын хүлээгдэж буй үр дүнгийн индекс





Зорилго 1. Ядуурлыг бууруулах

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын дагуу Монгол Улс 2030 он гэхэд ядуурлыг 2 дахин бууруулах зорилготой. Гэвч Ядуурлыг бууруулах зорилгын хэрэгжилт ухралттай үнэлэгдсэн бөгөөд ийнхүү үнэлэгдэхэд ядуурлын олон улсын болон үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын нийт хүн амд эзлэх хувь суурь онтой харьцуулахад өссөн нь голлон нөлөөлжээ.

Эдийн засгийн хямралаас улбаалан ядуурлын түвшний буурах хурд удааширсан. Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин 2010-2014 оны хооронд буурч байсан хэдий ч 2016 онд 29.6 хувьд хүрч огцом өссөнөөс хойш дорвитой буураагүй байна. Энэ нь 2016 оны эдийн засгийн уналтын үеийн нөлөөгөөр хүн амын хэрэглээний өсөлт буурч, хэрэглээний хуваарилалтын тэгш бус байдал нэмэгдсэнтэй холбоотой. 2018 онд 28.4 хувь, 2020 онд 27.8 хувьд хүрч бага зэрэг буурсан хэдий ч Ази, номхон далайн бүс нутгийн дунджаас өндөр, бууралтын эрч сул, удаан байна. Насны

бүлгээр авч үзвэл, 0-18 насны хүүхдүүд (35.7%) ядууралд илүү өртсөн байна.

Бүс хоорондын ядуурлын түвшний ялгаа багасаж байна. Зүүн бүсийн ядуурлын түвшин буураад бүстэй харьцуулахад хамгийн өндөр нь боловч 2018-2020 онд 4.1 нэгж хувь буюу хамгийн өндөр бууралтыг үзүүлэв. Харин энэ хугацаанд Хангайн бүс дэх ядуурлын түвшин 0.6 нэгж хувиар өсжээ.

Хот, хөдөөгийн ядуурлын түвшний ялгаа дорвитой буурсангүй. Хөдөөгийн ядуурлын түвшин хотынхоос даруй 6 нэгж хувиар их хэдий ч хотынхтой харьцуулахад бууралтын хурд илүү байна. Хот, суурин газрын ядуурлын бууралт удаан байгаа нь жилээс жилд нэмэгдэж буй хотжилтын түвшинтэй хамаараалтай. Тодруулбал, хот, суурин газрын хүн ам, ялангуяа Улаанбаатар хотын хүн ам 2010 оноос хойш жилд дунджаар 2.6 хувиар өссөн. Үүний дүнд нийт ядуу хүн амын тоонд хот, суурин газарт амьдарч буй ядуу хүн амын эзлэх хувь 2010 онд 55 хувь байсан бол 2020 онд 64 хувь болж тасралтгүй өсжээ.

Хүснэгт 3.2. Ядуурлын түвшин, ядуу хүн амын тоо, 2018, 2020

Үзүүлэлт	Ядуурлын түвшин, хувиар						Ядуу хүн амын тоо, мян.хүн	
	2018	95 хувийн итгэх интервал		2020	95 хувийн итгэх интервал		2018	2020
		Доод	Дээд		Доод	Дээд		
Улсын дундаж	28.4	27.1	29.7	27.8	26.4	29.2	904.9	903.4
Хот	27.2	25.4	29.0	26.5	24.6	28.3	574.6	577.6
Хөдөө	30.8	29.2	32.4	30.5	28.3	32.6	330.3	325.8

Эх сурвалж: УСХ, Дэлхийн банк 2022. “Ядуурлын дүр төрх 2020”

Дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдал өндөр байна. Хүн амын ундны усны хэрэглээний түвшин 2021 оны байдлаар 85 хувьтай буюу боломжийн түвшин гэж үзэж болох ч хүн амын дунд хүртээмжийн тэгш бус байдал өндөр байна. Тодруулбал, ундны усны хүртээмжээс хамгийн хол хоцорсон бүлэг (хөдөөгийн, амьжиргааны түвшин доогуур, бага боловсролтой өрх, хүн ам) болон хүртээмж өндөртэй бүлэг хоорондын зөрүү бараг 70 орчим нэгж хувь байна. Ариун цэврийн байгууламжийн хүртээмж нийт хүн амын тухайд 66 хувьтай байхад хүртээмжээс хамгийн хол хоцорсон бүлэг болон хүртээмж өндөртэй бүлэг хоорондын зөрүү 84 нэгж хувь байна. Эрчим хүч, гар утас, интернэтийн хэрэглээний түвшин өндөр, тэгш бус байдал харьцангуй бага байна.

Гамшгийн улмаас учирсан эдийн засгийн шууд хохирол буурч буй хэдий ч гамшгийн аюул, түүнээс учрах хохирол өсөн нэмэгдсээр байна. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хүний

үзүүлсээр байна.

Монгол Улсын газарзүйн байршил, цаг агаарын эрс тэс уур амьсгал нь гамшгийн эрсдэлийг нэмэгдүүлдэг гол хүчин зүйл бөгөөд зонхилон тохиолддог ган, зуд, үер, цасан болон шороон шуурга, хүн, мал амьтны гоц халдварт өвчин, газар хөдлөлт, хөрсний гулсалт, аянга цахилгаан зэрэг байгалийн гаралтай аюулт үзэгдлүүдийн шалтгаан болж байна.

Гамшгийн улмаас амь насаа алдсан, сураггүй алга болсон, гамшигт нэрвэгдсэн хүн амын тоо сүүлийн жилүүдэд буурч байна. Тухайлбал, аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо 2022 онд нийт 247-д хүрсэн нь өмнөх оноос 22.6 хувиар буурсан үзүүлэлт юм.

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 онд 4,299 болж, өмнөх оноос давтамж нь 6.1 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс объектын түймэр 3,075 удаа бүртгэгдэж, өмнөх оноос 15.1 хувиар, биологийн гаралтай аюулт үзэгдэл 204 болж, 19.7 хувиар тус тус нэмэгджээ.



Манай улсад тохиолдож буй гамшгийн ихэнх нь байгалийн аюулт үзэгдлийн үр нөлөөнөөс илүүтэйгээр хувь хүний хариуцлагагүй байдал, хууль, дүрэм журам биелүүлдэггүй, олон улсын болон үндэсний стандартыг дагаж мөрддөггүйтэй холбоотой байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах дунд хугацааны стратегийг үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлж байна. "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийг Засгийн газрын 2017 оны 355 дугаар

тогтоолоор батлан хэрэгжүүлж эхэлсэн. Орон нутгийн засаг захиргаа дэд стратегийг батлан, 2022 оны байдлаар бүх орон нутгийн түвшинд тус стратегийг хэрэгжүүлж байна.

Ийнхүү гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийг үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлж эхэлснээр Тогтвортой хөгжлийн 1 дүгээр зорилгын 5 дахь зорилтод хүрсэн гэж үзэж болох хэдий ч стратегийн хэрэгжилтийг хангахын тулд үйл ажиллагааг улам эрчимжүүлэх, орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийн тойм судалгаа, үнэлгээ хийх шаардлагатай байна.



Зорилго 2. Хүнсний аюулгүй байдлыг хангаж, тогтвортой хөдөө аж ахуйг хөхүүлэн дэмжих

Хүнсний аюулгүй байдлыг хангаж, тогтвортой хөдөө аж ахуйг хөхүүлэн дэмжих зорилгын хэрэгжилт тодорхой ахиц дэвшилтэй буюу 2030 оны зорилтдоо хүрэх эерэг хандлагатай гэж үнэлэгдсэн хэдий ч зорилт нэг бүрийн хувьд хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Зохистой бус хооллолттой хүүхдүүдийн дунд өсөлтийн хоцролтын тархалт харьцангуй илүү байна. Нялх, бага насны хүүхдийн зохистой хооллолт гэдэг нь өдөр бүр долоон бүлэг хүнсний бүтээгдэхүүнээс хамгийн багадаа дөрвөн нэр төрлийн хүнсийг тогтмол хэрэглэх явдал юм. Тав хүртэлх насны хүүхдүүдийн дунд өсөлтийн хоцролттой хүүхдүүд 2013 онд 10.8 хувь байсан бол 2018 оны байдлаар 9.4 хувь болж бага зэрэг буурсан хэдий ч зохистой хооллодог хүүхдийн 4.6 хувь, харин зөвлөмжийн дагуу хооллож чаддаггүй хүүхдүүдийн 7.6 хувь нь өсөлтийн хоцролттой байна. Нөгөө талаар, хүүхэд насанд хоол тэжээлийн дутагдалд өртөх нь бодисын солилцооны хямралаас үүдэлтэй илүүдэл жин, таргалалттай болох эрсдэлийг нэмэгдүүлж байна. Тухайлбал, өсөлтийн хоцролттой хүүхдүүд дэх илүүдэл жинтэй хүүхдийн эзлэх хувь (20.5%) хэвийн өндөртэй хүүхдүүд (11.0%)-тэй харьцуулахад өндөр ($p < 0.01$) байна.

Хүн амын дунд илүүдэл жин ба таргалалт, чанартай хүнсний хүртээмжийн сорилт үргэлжилсээр байна. Ядуу, эмзэг бүлгийн хүмүүст чанартай, аюулгүй хүнсний хүртээмжийг хангах зорилтот хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч хүнсний баталгаат байдал нь ноцтой болон дунд зэрэг алдагдсан өрхийн эзлэх хувь 2018 онд 26.2 хувь болж 2015 оны түвшнээс 5.2 нэгж хувиар өссөн байна. Ялангуяа, амьжиргааны түвшин доогуур (хамгийн доод 40 хувь), 5-аас доош насны 2 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн хүүхдүүд илүү өртөж байна.

Тав хүртэлх насны илүүдэл жинтэй болон

тураалтай хүүхдийн хувийн жин 2013-108 онд маш бага хэмжээгээр буурсан. Амьжиргааны түвшин доогуур хотын хүүхдүүдийн дунд илүүдэл жин, таргалалт өндөр байгаа хэдий ч 5 хүртэлх насны хүүхдийн илүүдэл жинтэй байх нь тэдгээр хүүхдийн нас, хүйс, амьжиргааны түвшин, бүс нутгийн ялгаатай байдлаас илүүтэй төрөх үеийн биеийн жин, эхийн хоол тэжээлийн байдалтай хүчтэй хамааралтай байна. Тухайлбал, төрөхдөө том жинтэй төрсөн хүүхэд илүүдэл жинтэй байх нь хэвийн болон бага жинтэй төрсөн хүүхдүүдтэй харьцуулахад илүү өндөр байна. Түүнчлэн эх илүүдэл жинтэй эсвэл таргалалттай бол хүүхэд нь илүүдэл жинтэй байх хандлагатай байна. Иймд илүүдэл жин, таргалалтын тархалтыг зогсоохын тулд хүүхэд наснаас нь амьдралын эрүүл хэв маягийг төлөвшүүлэх орчныг бүрдүүлэх, жирэмсэн эхчүүдийн эрүүл, зохистой хооллолтыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Жирэмсэн эхчүүдийн дундах цус багадалтын тархалт аажмаар өссөөр байна.

Улсын хэмжээнд 2021 онд шинээр хяналтад орсон нийт жирэмсэн эхчүүдийн 4.0 хувь нь цус багадалттай байна. Тоон өгөгдлөөс ажиглахад тус үзүүлэлт 2018 оноос хойш тасралтгүй бага багаар өссөөр 2021 онд 0.4 нэгж хувиар өсөж, суурь буюу 2015 оны түвшин рүү дөхөж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр дунд, урт хугацаанд ашиглахаар зориулалтын байгууламжид хадгалсан ургамал, амьтны генетикийн нөөц 2015 оны түвшинтэй харьцуулахад 1.5-2 дахин буурчээ. Малын генетик нөөцийн тухай хууль (2017), Генетик нөөцийн тухай хууль (2021) зэрэг хуулиуд батлагдсанаар Монгол Улсад ургамал, амьтны генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэх эрхзүйн орчин бүрдсэн. Мөн малын үндэсний генийн санг үндэсний, бүс нутгийн, төрөл зүйлийн



түвшинд бүрдүүлэн сайжруулж, тэдгээрийг доройтох, мөхөх, устахаас хамгаалах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, малын чанар, үүлдрийг сайжруулах, малын үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, нутагшуулах, дэлгэрүүлэх, хүний нөөцийг сургаж бэлтгэх үйл ажиллагааг ХХААХҮЯ чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч урт, дунд хугацаанд зориулалтын хадгалалтын байгууламжид байгаа хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр ашиглах ургамал, амьтны генетикийн нөөц буурсан тул цаашид ургамал, үр тариа, амьтан, малын генетикийн олон янз байдлыг хадгалж, хамгаалах, генетик нөөцийн банк үүсгэх төлөвлөлт, бодлогын арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг тогтвортой хангах суурь нөхцөлийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Монгол оронд тариалангийн газар нутгийн нөөц их, нийт 71 гаруй сая мал байгаа хэдий ч хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах тогтвортой хүнс, хөдөө аж ахуйг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага байна. Мах, махан

бүтээгдэхүүнээс бусад гурил, будаа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, давс зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дийлэнхийг импортоос хангаж байгаа нь хүнсний хангамжийн аюулгүй байдлын зэрэглэл эрсдэлтэй буюу гадаад улсаас хараат байдалтай болсныг харуулна. Иймд 2022 онд Засгийн газраас хүнсний хангамж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлж эхлээд байна.

Хөдөө аж ахуйн салбарын экспортын бараанд татаас олгохгүй байх бодлого баримталж байна. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн 162 орон 2015 онд хөдөө аж ахуйн салбарын экспортын бараа бүтээгдэхүүнд татаас олгохоо зогсоохоор тохиролцсоны дагуу Монгол Улс 2015 оноос хойш ХАА-н экспортод татаас олгоогүй бөгөөд цаашид 2030 гэхэд ч мөн татаас олгохгүй байх зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Хөдөө аж ахуйн салбарын экспортын бүтээгдэхүүнд олгох санхүүгийн дэмжлэгийг зогсоосноор буурай орнуудын аж ахуй эрхлэгчид олон улсын зах зээлд өрсөлдөх боломж нэмэгдэх боломжтой.



Зорилго 3. Эрүүл мэндийг дэмжих

Эрүүл мэндийг дэмжих зорилгын хэрэгжилт дунд зэрэг, 2030 оны зорилтдоо хүрэх эерэг хандлагатай гэж үнэлэгдсэн хэдий ч эхийн эндэгдэл, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн бэлэн байдал зэрэг зорилтын хувьд онцгойлон анхаарах шаардлагатай.

Өсвөр насны охидын төрөлт аажмаар буурч байна. Өсвөр нас (15-19 нас)-ны 1,000 охидод ногдох төрөлтийн түвшин 24.2 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 8.4, өмнөх онтой харьцуулахад 3.8-оор тус тус буурсан байна. 2010 оны байдлаар нийт төрсөн эхчүүдийн 8.0 хувийг өсвөр насны охидын төрөлт эзэлж байсан бол сүүлийн 20 жилийн хугацаанд 4.7 хувиар буурсан байна. Гэсэн хэдий ч АНД-н орнуудын бүсийн дунджаас дээгүүр хэвээр байна.

Эхийн эндэгдлийн түвшин Ковид-19 цар тахлын үед огцом өсөв. 1,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 2021 онд 94.9-д хүрсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 54.8, өмнөх оноос 64.7-оор нэмэгдсэн ба АНД-н орнуудын дунджаас 35 орчим тохиолдлоор өндөр байна. Энэхүү үзүүлэлт 2016-2019 онд 2 дахин буурч 23-т хүрээд байсан ч 2020, 2021 онд эрс нэмэгджээ. Нийт эхийн эндэгдлийн бараг 85 орчим хувь нь эх барихын шууд бус шалтгаант эндэгдэл байна. Ялангуяа, 2021 онд коронавируст халдварын шалтгаант эхийн эндэгдэл нийт тохиолдлын

67.6 хувийг эзэлж байна. Зарим судалгаанаас харахад, эхийн эрүүл мэнд, эндэгдэл дан ганц эрүүл мэндийн системийн асуудал бус, маш өргөн хүрээний, орчин үеийн нотолгоонд суурилсан эмчилгээний арга, технологи шаардсан нийгмийн эрүүл мэндийн архаг өвчин болж буйг анхааруулсан чухал асуудлуудыг хөндсөн байна. Тухайлбал, эхийн эндэгдэлд хувь хүн, гэр бүлээс шалтгаалсан хожимдол илүүтэй нөлөөлж байгаагаас гадна эмэгтэйчүүдийн дундах архины хэрэглээ, гэр бүлийн хүчирхийлэл, амиа хорлолт, сэтгэцийн асуудлууд зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна. Улсын хэмжээнд 2021 оны байдлаар нийт төрөлтийн 99.2 хувийг эмнэлгийн мэргэжилтэн удирдан явуулсан хэдий ч эмнэлгийн тусламжгүй төрөлтийн 80 тохиолдол бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 14 тохиолдлоор буюу 17.5 хувиар өссөн байна.

Нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин дэлхийн болон АНД-н орнуудын бүсийн дунджаас доогуур байна. Нярайн эндэгдлийн тэргүүлэх гурван шалтгааныг харвал, 2017-2021 онд амьсгалын гачаал, тархины хүчилтөрөгчийн дутмагшил, төрөлхийн хөгжлийн гажиг орж байна. Харин 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаанд төрөлтийн өмнөх үед үүссэн эмгэг, осол гэмтэл, төрөлхийн хөгжлийн гажиг зонхилж



байна. Иймд тав хүртэлх насны болон нялхсын эндэгдэлд урьдчилан сэргийлж (осол гэмтэл), эмчилж болохуйц (амьсгалын тогтолцооны өвчин) шалтгаант эндэгдлийг бууруулах чиглэлд анхаарах хэрэгтэй. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн олонх нярайн үед, нярайн эндэгдлийн дийлэнх нь эрт үед, эрүүл мэндийн анхан ба яаралтай тусламж үйлчилгээнээс голчлон хамаарах үедээ эндсэн нь төрөлтийн өмнөх үеийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх шаардлага буйг харуулж байна.

Халдварт болон халдварт бус өвчний тархалт тулгамдсан асуудал хэвээр байна. Монгол Улс хүн амын дундах сүрьеэгийн өвчлөлийн түвшнээр АНД-н баруун бүсийн орнуудын дунд 4 дэх өндөр тархалттай орон болж, ДЭМБ-ын тооцооллоор 2020 онд 100,000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшин 428 байгаа нь дэлхийн дундаж (132)-аас 296, бүсийн дундаж (96)-аас 332-оор тус тус өндөр байна. Нийт хүн амын дунд ХДХВ-ийн халдварын тархалтын түвшин 0.1 хувиас бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд 5.0 хувиас бага байгаа нь нийт хүн амын дунд бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд төвлөрсөн тархалттай орны тоонд ордог.

Халдварт бус өвчний голлох дөрвөн шалтгаан болох зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөс шалтгаалсан эрт нас барах эрсдэл буурч байгаа ч 2021 онд зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөр нас барсан 30-70 насны хүний нас баралтын 6,230 тохиолдол бүртгэгдсэн нь нийт нас баралтын 31.3 хувийг эзэлж байна. Эдгээр өвчлөлийн шалтгаант нас баралтын түвшин 30-70 насны эрэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдээс харьцангуй өндөр байна.

Монгол Улс зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшнээр АНД-н орнуудын дунд 9 дэх өндөр тархалттай орон болж байна. Хүйсийн хувьд бусад тээврийн ослын улмаас нас барсан эрчүүд эмэгтэйчүүдээс 2.3 дахин их, явган зорчигч нас барсан тохиолдол 1.5 дахин их байгаа бол мотоциклтой зорчигч нас барсан тохиолдол эрэгтэйчүүдэд 13 дахин илүү байна. Зам тээврийн ослоор нас барсан тохиолдлыг 2021 оны байдлаар насны бүлгээр харвал, 15 хүртэлх насны хүүхэд 14.0 хувь, 15-29 насныхан 19.6 хувийг эзэлж байгаа бол 30-39 насныхан 20.6 хувь, 40-49 насныхан 24.3 хувийг тус тус эзэлж байна.

Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Улсын хэмжээнд 2021 онд нийт 1,019 тохиолдол бүртгэгдсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 326, өмнөх оноос 249 тохиолдлоор нэмэгдсэн. Санамсаргүй хордож, хорт бодист өртөж нас барсан тохиолдлын түвшин 100,000 хүн амд 31 ногдож байгаа ба эрэгтэй хүн амынх эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад 3.5 дахин өндөр байна. Хорт бодисын шалтгаант нас баралтад архи, спиртийн төрлийн бодист хордож нас барсан тохиолдол дийлэнх буюу 84 хувийг эзэлж байна.

Мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо өсөж, эмчилгээнд хамрагдалтад төдийлөн ахиц гарахгүй байна. 2015 онд 90 байсан мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо 2016 онд 174, 2018 онд 966 болж эрс нэмэгдсэн. Энэхүү өсөлт нь нөгөө талаас цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, илрүүлэлт сайжирсантай мөн холбоотой. СЭМҮТ оношилгоо, эмчилгээний 11 шинэ стандарт боловсруулсан бөгөөд сэтгэцэд нөлөөлөх 19 шинэ эмийг сүүлийн 3 жилийн дотор эмчилгээнд хэрэглэж, шээс, шүлснээс 13 төрлийн шинжилгээ авах шинэ арга, сорилуудыг нэвтрүүлжээ. Мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүсийн эмчилгээнд Монгол Улсад бүртгэлтэй, стандартын шаардлага хангасан эм тариа хэрэглэж, сэтгэл заслын орчин үеийн эмчилгээ хийж байгаа хэдий ч 2018 онд 16.5 хувь эмчилгээнд хамрагдагчдын хувийн жин 2019 онд 17.5 хувь болж ердөө 1 нэгж хувиар өсжээ.

Архи, согтууруулах ундаа хэрэглэдэг хүн амын эзлэх хувь буурч байгаа хэдий ч хүйсийн ялгаа өндөр байна. Үндэсний хэмжээний судалгаанаас үзэхэд 15-64 насны, сүүлийн нэг жилд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувийн жин 2019 онд 57.7 хувь байгаа нь 2013 онтой харьцуулахад 6.9 нэгж хувиар буурсан эерэг хандлагатай байна. Харин сүүлийн нэг сард 15-64 насны нийт хүн амын 34.8 хувь архи, согтууруулах ундаа хэрэглэсэн ба нэг удаад "6 ба түүнээс олон стандарт уулт"-аар архи, согтууруулах ундааг хэрэглэдэг буюу "хэтрүүлэн хэрэглэсэн" хүн амын хувийн жин улсын хэмжээнд 19.8 хувь байна. Архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх эрсдэлт зан үйлийн хүйсийн ялгаа өндөр буюу эрэгтэйчүүдийнх (28.2 хувь) эмэгтэйчүүд (11.5 хувь)-ийнхтэй харьцуулахад ойролцоогоор 2.5 дахин их байна.

Арван тав ба түүнээс дээш насны хүн амын дундах тамхи таталтын тархалт нэмэгдэж байна. 2018 оны байдлаар 15-49 насны эрэгтэйчүүдийн 58.0 хувь тамхи хэрэглэж байгаа нь 2013 оноос хойш 1.9 нэгж хувиар, мөн насны эмэгтэйчүүдийн 9.20 хувь тамхи татаж байгаа нь ижил хугацаанд 1.4 нэгж хувиар тус тус өссөн байна. Харин тамхины хэрэглээний түвшнийг 15-69 насныхны хувьд авч үзвэл, тухайн насны хүн амын дөрвөн хүн тутмын нэг нь тамхи татаж байна. Хүйсээр харвал, эрэгтэйчүүдийн тамхины хэрэглээ эмэгтэйчүүдийнхээс 8.7 дахин их байна. Хүн амын таван хүн тутмын нэг нь тамхийг өдөр бүр, эрэгтэйчүүдийн 39.5 хувь, эмэгтэйчүүдийн 4.1 хувь тогтмол татдаг байна. Хүн амын тамхи татаж эхэлсэн дундаж нас 18.9, тамхи татсан дундаж хугацаа 19.9 жил байна.

Хүн бүрд эрүүл мэндийн үйлчилгээ, түүний дотор санхүүгийн эрсдэлийн хамгаалалт, нэн шаардлагатай чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, аюулгүй, үр дүнтэй, чанартай, боломжийн үнэтэй нэн шаардлагатай эм, вакциныг хүртээмжтэй хүргэх. Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний



хамралтын хувь 2020 онд 85 хувь байгаа нь дэлхийн дундаж (66)-аас 19, бүсийн дундаж (77)-аас 8 нэгж хувиар тус тус өндөр байна.

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан бүх төрлийн вакцинжуулалтад хамрагдсан зорилтот хүн амын эзлэх хувийн жинг 2025 онд 97.5 хувь, 2030 он гэхэд 99.0 хувьд хүргэх. Хүүхдийн вакцинжуулалт хамрагдалтын түвшин 90-ээс дээш хувьтай байна. Тухайлбал, сахуу, хөхүүл ханиад, татран, гепатит Б, хемофиллюс инфлюэнза Б (тавт) өвчлөлийн эсрэг вакцинд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн хувийн жин 2018 онд 91.9 хувь, 2021 онд 95.3 хувь болж даруй 3.4 нэгж хувиар нэмэгдсэн байна. Улаан бурхан, гахайн хавдар, улаанууд1 (УГУ1) өвчлөлийн эсрэг вакцины эхний тунд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн хувийн жин 2018 онд 91.6 хувь, хоёр дах удаагийн тунд хамрагдсан 30-35 сартай хүүхдийн хувийн жин 2018 онд 81.3 хувь байсан бол 2021 онд 93.7 хувь болж өсчээ. Тухайн үзүүлэлтийн хувьд зорилтот түвшиндээ хүрэхэд эерэг хандлагатай байна.

Эрүүл мэндийн ажилтны нягтрал нэмэгдэж байгаа хэдий ч нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн бэлэн байдал хангалтгүй байна.

2021 оны байдлаар 10,000 хүн тутамд 178.8 эрүүл мэндийн ажиллагчид ногдож байгаагийн 22.1 хувийг их эмч, 23.0 хувийг сувилагч, 5.0 хувийг эм зүйч, 3.1 хувийг бага эмч, 2.2 хувийг удирдах ажилтан, 2.3 хувийг лабораторийн техникч эзэлж байна. Үүнээс хүний их эмчийн 80 хувь нь үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр ажиллаж байна. 10,000 хүн ам тутамд 39.5 эмч, 41.0 сувилагч ногдож байгаа нь өмнөх онтой харьцуулахад их эмч 1.0-ээр, сувилагч 0.4-өөр тус тус нэмэгдсэн байна. Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх чадавх, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн бэлэн байдал 2015 оноос хойш 5.0 нэгж хувиар буурч, 2021 онд 80.0 хувьтай байна. Хэдийгээр энэхүү бууралтад Ковид-19 цар тахлын нөлөөлөл байгаа ч цаашид зорилтот түвшинд хүрэхийн энэ чиглэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хурдасгах шаардлагатай.



Зорилго 4. Чанартай боловсролыг дэмжих

Чанартай боловсролыг дэмжих зорилгын зарим үзүүлэлтийн хэрэгжилт хангалтгүй, гүйцэтгэлийн хандлага буурсан. Боловсролын үйлчилгээний ачаалал хот, хөдөөд ялгаатай, боловсролын түвшний хүйсийн ялгаа их, хүртээмжийн тэгш бус байдал өндөр байна.

Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, хангамжийг нэмэгдүүлэхэд төрөөс анхаарч байна. Цэцэрлэгийн "сугалаатай" бүртгэлийг халж, хүүхдийг анх удаа И-Монголиа цахим системээр харьяаллын дагуу 100 хувь бүртгэж, бүх хүүхдийг цэцэрлэгт хамруулах бодлого баримталж, хамран сургалтыг нэмэгдүүлжээ. Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн дэргэд салбар бүлэг байгуулж, ачаалалтай дүүргийн хувийн цэцэрлэгт хувьсах болон хоолны зардлыг нэмэгдүүлэн олгож, байгууллагын, түрээсийн, цомцог гэр зэргээр цэцэрлэгийн олон хэлбэрийг бий болгосон нь хүртээмжийг нэмэгдүүлэх боломж олгосон.

Бага насны хүүхдийн хөгжлийн индекс төдийлөн сайжирсангүй. Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх, бие бялдрын хөгжил, нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, суралцах чадварууд нь зохих түвшинд байгаа 5 хүртэлх насны хүүхдийн хувь 2018 онд 75.7 хувь байгаа нь 2013 оны түвшнээс 0.03 нэгж хувиар буурсан буюу энэ төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байна.

Суурь дэд бүтцээр хангагдсан сургууль, цэцэрлэгүүд нэмэгдэж, сурагчдын суралцах орчинд сайжирч байна. Сургууль, цэцэрлэгийн хичээлийн болоод дотуур байрны ариун цэврийн

байгууламж, орчин ахуйн шаардлага хангахгүй байсан тул төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих ажлыг эхлүүлж, Монгол Улсын 330 гаруй сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нөхцөл байдалд судалгаа хийж, нийгмийн хариуцлагын хүрээнд "Эрдэнэт" ТӨҮГ-тай хамтран эхний ээлжид 2021 онд 16 аймгийн 92 суманд 307 сургууль, цэцэрлэг, дотуур байрыг хамруулсан бол 2022 онд 12 аймгийн 55 сумын 174 объект боловсон ариун цэврийн өрөөтэй болжээ.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль 2019 онд батлагдсанаар суралцагчдын "Үдийн цай" хөтөлбөр "Үдийн хоол" болгох ажил эхэлж, 2021-2022 оны хичээлийн жилд 1-5 дугаар ангийн 382.0 мянган хүүхэд үдийн хоолны үйлчилгээнд хамрагджээ. Энэхүү хууль хэрэгжсэнээр ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй, тогтвортой, хүртээмжтэй тогтолцоо бий болох, суралцагчийг шим тэжээллэг хоол, хүнсээр хангаж, эрүүл мэндийг дэмжинэ.

Боловсролын тэгш бус байдал ахлах ангид илүү өндөр байна. 2013-2018 онд боловсролын түвшнээр тооцсон "Тэгш байдал (паритет)-ын индекс бага, дунд ангийн түвшинд бараг өөрчлөлтгүй бөгөөд хүйс, байршил, өрхийн аж байдлын түвшнээр харьцангуй тэгш байгаа бол дунд, ахлах ангийн хувьд тэгш бус байна. Ялангуяа, хөдөө, хотын ахлах ангийн хамран сургалтын цэвэр



жингийн харьцаа 0.8 буюу хөдөөд хамран сургалт бага байна. Хүйсийн тэгш байдлын үзүүлэлт төдийлөн өөрчлөгдөөгүй ч доогуур аж байдалтай өрх болон хөдөө амьдарч буй дунд, ахлах ангийн хүүхдүүдийн хамран сургалт дээгүүр аж байдалтай болон хотод амьдарч буй хүүхдүүдийнхтэй харьцангуйгаар буурчээ.

Бүх шатны боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх хэрэгцээ байсаар байна.

Бага, суурь болон дунд боловсролын хамран сургалтын байдалд анхаарал татсан асуудал байхгүй ч КОВИД-19 цар тахлын нөлөөний улмаас 2021 онд бүх түвшний боловсролын хамран сургалтын цэвэр жин бага зэрэг багасаж, ялангуяа нэгдүгээр ангид элсэгчдийн цэвэр жин өмнөх оноос 2.5 нэгж хувиар буурчээ. Ийм учраас цар тахлаас үүдэлтэй сурлагын хоцрогдол болон хүүхдийн сэтгэл зүйн дарамт, багш нарын ажлын ачааллыг бууруулахын тулд сурлагын болон нийгэм, сэтгэл хөдлөлийн ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр үндсэн сургалтаас гадуур сургалтыг дэмжсэн цахим сургалтыг хэрэгжүүлж байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээс үзэхэд, бүрэн дунд ба түүнээс доош түвшний боловсролтой эрэгтэйчүүдийн хувийн жин өндөр, харин тусгай мэргэжлийн болон дээд боловсролтой хүн амын хувьд эмэгтэйчүүдийн хувийн жин харьцангуй өндөр байна. Гэхдээ хөдөөгийн, амьжиргааны түвшин доогуур (хамгийн доод 40 хувь), эрэгтэй хүн ам боловсролын үйлчилгээнээс “хамгийн хол хоцорсон” байна.

Хүн бүрийг боловсролд тэгш хамруулах, ялангуяа үндэсний, хэлний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, амьжиргааны түвшин доогуур, алслагдсан нутгийн, малчин өрхийн хүүхэд, залуучуудад хүрэх хүртээмжийг нэмэгдүүлэхээр тууштай ажиллаж байгаа ч хангалттай өөрчлөлт гаргахгүй байна.

Мэргэжлийн болон дээд боловсролын

тогтолцоо сул, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх хэрэгцээ хэвээр байна. Энэ чиглэлд мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлэн хөгжүүлэх, салбар дундын дадлагын бааз чиглэлээр хөгжүүлэх багш нарыг сургах, мэргэжлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулах, сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах, их, дээд сургуулийг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хот болон орон нутагт хотхон байгуулах шийдвэр гаргасан ч хэрэгжилт хангалтгүй байна.

Хүн амын бичиг үсэг тайлагдалтын хүйсийн ялгаа багасаж байна. Нийт хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин 2013 оноос хойш тасралтгүй өсөж, эмэгтэйчүүдийн бичиг үсэг тайлагдалтын түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байгаа хэдий ч хоорондын зөрүү багассан байна. Тухайлбал, 2013 онд эрэгтэйчүүдийн бичиг үсэг тайлагдалтын түвшин 95.2 хувьтай байсан бол 2020 он гэхэд 98.6 хувь болж, харин эмэгтэйчүүдийнх 2013 онд 97.5 хувь байсан бол нэмэгдсээр 2020 онд 98.9 хувьд хүрч, хүйсийн ялгаа 2 нэгж хувиар буурчээ.

Боловсролын зохих түвшинд багшлах шаардлагыг хангасан мэргэжлийн багш нарын хувийн жин буурсан байна. Бага боловсролын нэг багшид ногдох суралцагчийн тоо болон бүлэг дүүргэлт хот, хөдөөд стандарт утга (25-30)-аас өндөр байгаа ч хотод илүү өндөр, боловсролын үйлчилгээ ачаалал ихтэй байна. Мэргэжлийн багшийн хомсдол байршлаас үл хамааран боловсролын хүртээмж, чанарыг бууруулах нэг хүчин зүйл болж байгаа бөгөөд энэ нь цалин хөлсний хэт бага түвшин, ажлын ачаалал зэргээс шалтгаалж байна. Иймд БШУЯ-аас “Үр дүн гүйцэтгэлд суурилсан боловсролын санхүүжилт”-ийн механизмыг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд багш нарын цалин хөлс тодорхой хэмжээнд нэмэгдсэн.



Зорилго 5. Жендэрийн тэгш байдал, охид эмэгтэйчүүдийн эрхийг хангах

Дэлхийн эдийн засгийн форумас гаргадаг жендерийн зөрүүтэй байдлын индексээр Монгол Улс 2018 онд 149 орноос 58 дугаар, 2020 онд 153 орноос 79 дүгээр, 2021 онд 156 орноос 69 дүгээр байранд тус тус эрэмбэлэгджээ. Дэд үзүүлэлтээр харвал, улс төрийн эрх мэдлийн үзүүлэлт 156 орноос 116 дугаар байрт жагссан нь дэлхийн ба Азийн дунджаас доогуур байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах хууль эрхзүйн орчин бүрдсэн хэдий ч жендерийн хэвшмэл ойлголтоос үүдэлтэй асуудлууд байсаар байна. 2011 онд батлагдсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба

гэр бүлийн харилцаанд жендерийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг баталгаажуулсан бөгөөд энэ хүрээнд 2 үндэсний хөтөлбөр, 1 стратеги төлөвлөгөө, мөн 12 салбар, нийслэл, 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт жендерийн тусгайлсан хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Батлагдсан хууль, бодлого хөтөлбөрийг жендерийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх, үр нөлөөг нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалын хувьд үнэлэх практик туршлагыг бэхжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэсэн “Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө” (2022-2031)-г Монгол Улсын Ерөнхий



сайдын тэргүүлдэг Жендерийн үндэсний хорооноос баталсан. Мөн Монгол Улс эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар нэлээдгүй хүчин чармайлт гаргаж, НҮБ болон бусад олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орж, тэдгээрийн зарчим, заалтуудыг үндэсний хууль тогтоомж, бодлого хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлж ирсэн. Ийнхүү эрх зүйн орчны хувьд дэвшилт байгаа хэдий ч нийгэмд тогтсон жендерийн хэвшмэл ойлголт, тэдгээрийг дэмжсэн бүтэц, тогтолцоо, өөрчлөлтийг үл зөвшөөрөх хандлагаас хамаарсан асуудлууд хэвээр байна.

Жендерийн талаарх уламжлалт хандлага, эмэгтэйчүүд өмчлөх эрхийнхээ талаар бага мэддэг нь жендерийн эрх тэгш байдлыг хангахад гол саад болж байна. Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар газар, хөрөнгийн эрхийг ижил тэгш эдлэх эрхтэй боловч эмэгтэйчүүдийн хөрөнгө эзэмших эрх нь тодорхой хүчин зүйлээр хязгаарлагдсаар байна. ҮСХ-ны 2018 оны судалгаагаар, үндсэн сууцаа өөрсдөө эзэмшдэг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бараг 2 дахин, хөдөө аж ахуйн газрын хувьд 3-6 дахин, бусад үл хөдлөх хөрөнгийн хувьд 1.5 дахин их байна.

Шийдвэр гаргах түвшний албан тушаалд хүйсийн эрх тэгш байдал хангагдахгүй байна. Эмэгтэйчүүд нь нийт хүн амын тал хувь, хөдөлмөрийн насны хүн амын тал хувь, сонгогчийн насны хүн амын тал хувь хэдий ч улс төр, шийдвэр гаргах түвшинд томилогдон ажиллах байдал 30 хувьд хүрэхгүй байна. 2020 онд УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь өмнөх сонгуулийн үр дүнгээ бататгасан ч нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн тоо буурсан, мөн дэлхийн дунджаас доогуур байна. Сүүлийн сонгуулиудад хуулиар тогтоосон квотыг хэрэглэж байгаа ч дан ганц квотыг хуульчилснаар улс төрд жендерийн эрх тэгш байдал хангагдахгүй гэдэг нь улам бүр батлагдсаар байна.

Төрийн албанд албан тушаалын зэрэглэлээр хүйсийн ялгаа маш өндөр, эрх мэдлийн тэнцвэргүй байдал хамгийн тод илэрч байна. Төрийн албанд ажиллагсдын талаас илүү (60.4 хувь) нь эмэгтэйчүүд байгаа явдал төрийн албанд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлага, хөгжилд оруулж буй хувь нэмэр өндөр байгааг нэг талаас илтгэж байна. Ерөнхий дүр зургаар төрийн захиргааны албан хаагчдын хүйсийн харьцаа боломжийн түвшинд буй мэт байгаа ч шийдвэр гаргах өндөр албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөлөл харьцангуй бага, харин гүйцэтгэх албан тушаалд илүү төлөөлөлтэй байна. Улс төрийн албан тушаалаар томилогдон ажиллаж буй шийдвэр гаргагчдын үнэмлэхүй олонх нь эрэгтэйчүүд, тухайлбал, Засгийн газрын түвшинд 2 эмэгтэй сайд, орон нутгийн түвшинд 1 эмэгтэй Засаг дарга томилогдон ажиллаж байна. Улс төрийн томилгоогоор дэд сайд, аймаг, нийслэлийн засаг даргын орлогчийн албан тушаалд эмэгтэйчүүд дэвшүүлэх явдал бага зэрэг

нэмэгдэж байна.

ЖЭТБХТХ-ийн дагуу төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагууд нь хүйсийн тэнцвэрт байдлын тайлан болон жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг Жендерийн үндэсний хороонд жил бүр хүргүүлэх үүрэгтэй. Гэвч энэхүү хуульд заасан чиг үүргийн хэрэгжилтийг үйл ажиллагааны болон үр дүнгийн 47 шалгуураар үнэлж үзэхэд 38 хувь буюу "хэрэгжилт хангалтгүй" гэж үнэлэгдсэн бөгөөд, үүнд төрийн албанд жендерийн тэгш байдлыг хангах баталгаа (хуулиар тогтоосон квот)-ны хэрэгжилт хангалтгүй байсан нь нөлөөлсөн байна.

Дээрх хуульд зааснаар томилогдох улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар 15 хувиас доошгүй байхаас сайд, дэд сайдын түвшинд 11.4 хувь буюу хангагдаагүй, төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн даргын түвшинд 15 хувиас доошгүй байхаас 8.3 хувь буюу хангагдаагүй, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас доошгүй байхаас 11.1 хувь буюу хангагдаагүй, төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас доошгүй байхаас дунджаар 26.3 хувь байна. Нутгийн захиргааны байгууллагуудын хувьд дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нараас бусад түвшинд хуульд заасан квот хангагдсан үзүүлэлттэй байна.

Ийнхүү шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэхгүй байгаа нь институцийн хүчин зүйлтэй холбоотой бөгөөд нийгмийн тогтсон хандлага, жендерийн хэвшмэл ойлголт, эмэгтэйчүүдийн олон нийтэд танигдах, хүлээн зөвшөөрөгдөх байдал, эмэгтэйчүүдийн эдийн засгийн болон ажил, амьдралын тэнцвэрт байдал, сонгуулийн компанит ажлын санхүүжилт зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг гэж судлаачид дүгнэж байна.

Хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн зөрүүтэй байдал цаашид үргэлжлэх хандлагатай байна. Улс орны, аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийн бодлого төлөвлөлтийн шатанд жендерийн дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцох, нөлөөлж залруулах чадвар, нөөц байхгүйгээс жендерийн тэгш бус байдлын суурь шалтгааныг арилгахад ахиц гаргаж чадаагүй нь нийгэм дэх тэгш бус байдлыг, түүний дотор хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн зөрүүг ихэсгэсээр байна. Энэ нь орлогын ялгаа гүнзгийрэх нөхцөлийг бүрдүүлж, нийгэм дэх зөрчил, стресс, түүний дотор жендерт суурилсан хүчирхийлэл нэмэгдэх суурь шалтгаан болох төлөвтэй байна. Эдийн засгийн уналт эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд илүү нөлөөлж, ажиллах хүчин дэх эмэгтэйчүүдийн оролцооны түвшин буурсны зэрэгцээ эмэгтэйчүүдийн цалингийн дундаж эрэгтэйчүүдийнхээс доогуур хэвээр, зөрүү нь багасаагүй, ажилд авахад эмэгтэйчүүдийг нөхөн



үржихүйн үүргээр нь ялгаварлан гадуурхах явдал гарсаар байна. Залуу эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх байдал буурч байгаа нь бага насны хүүхдээ асрахтай шууд уялдаатай байна. Хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэхэд саад болж буй асуудлыг тодорхойлж, түүнд тулгуурласан бодлого, шийдвэр дутагдаж байна.

Жендерт суурилсан хүчирхийлэл тулгамдсан асуудал хэвээр байна. Монгол дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн түвшин дэлхийн түвшинтэй ойролцоо буюу 10 эмэгтэй тутмын 3 нь амьдралынхаа туршид бие махбодын болон эсхүл бэлгийн хүчирхийлэлд өртөж байна. Гэр бүлийн хүчирхийлэл өндөр болон бага орлоготой гэр бүл, хөдөө орон нутаг болон хот, суурин газарт аль алинд нь үйлдэгдсээр, нийгмийн амьдрал болон ажлын байран дахь бэлгийн дарамт ч өндөр байна. Хүүхдүүдийн 33 хувь нь онлайн орчинд хүүхдийн бэлгийн хүчирхийллийн агуулгатай материалтай тааралддаг, эмэгтэйчүүдийн 10 хувь нь ажлын байран дээрээ ямар нэгэн төрлийн бэлгийн дарамтад өртөж байсныг судлаачид илрүүлсэн байна. Мөн 2022 оны эхний 7 сарын байдлаар цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийллийн 6,263 дуудлага, мэдээлэл

бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 19 хувиар өссөн байна. Ковид-19 цар тахлын үед гэр бүлийн хүчирхийллийн бүртгэгдсэн тохиолдлын огцом өсөлт ажиглагдсан. Эмэгтэйчүүдийн эсрэг жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын хэмжээнд хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо мэдэгдэхүйц өсөж, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын дундын нийт 38 нэгж, 323 ортой болсон. Эдгээр төвүүдийг үргэлжлүүлэн бэхжүүлж, зайлшгүй шаардлагатай тусламж үзүүлэхээс гадна орон нутагт эдгээр тусламж, үйлчилгээг үзүүлэх боломж, нөхцөлөөр хангах нь зүйтэй.

Насанд хүрэхээсээ өмнө буюу хүүхэд байхдаа гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай болсон 20-24 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь өссөн байна. 15 наснаас өмнө гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай болсон 20-24 насны эмэгтэйчүүдийн тухайн насны эмэгтэйчүүдэд эзлэх хувийн жин 2015-2018 онд 0.1-ээс 0.9 хувь болж нэмэгдсэн бол 18 наснаас өмнө гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай болсон мөн насны эмэгтэйчүүдийн хувь 5.2-оос 12.0 хувь болж нэмэгджээ.



Зорилго 6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах

Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах зорилгын хэрэгжилт эерэг хандлагатай гэж үнэлэгдсэн хэдий ч баталгаат ариун цэврийн байгууламжийн үйлчилгээгээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэх, усны үр ашгийн үзүүлэлтийг дээшлүүлэх чиглэлд анхаарах шаардлагатай байна.

Нийт өрхийн 30.4 хувь нь цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон байна. Монгол Улсын хэмжээнд 2020 оны тооллогоор нийт 897.4 мянган өрх тоологдсон бөгөөд цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд нийт 273.0 мянган өрх (30.4 хувь) холбогдсон, 624.4 мянган өрх (69.6 хувь) холбогдоогүй байна. Тэдгээрийг байршлаар харвал, нийт өрхийн 74.4 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн нь аймаг, орон нутагт байхад, холбогдоогүй өрхийн 66.8 хувь нь аймаг, орон нутагт амьдарч байна. Аймгийн төвийн сумдын өрхийн 41.6-93.0 хувь нь цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон байхад хөдөөгийн (сумдын) 90.0 болон түүнээс дээш хувь нь цэвэрлэх байгууламжид холбогдоогүй байгаа нь Монгол Улсын хүн амын цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон байдал хангалтгүй байна.

Улсын тусгай хамгаалалт, урсац бүрэлдэх

эхийг хамгаалах үйл ажиллагаагаар дамжуулан гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэхийг зорьж байна. Засгийн газраас гадаргын усны нөөц, гол мөрөн, горхи, булаг, рашааны урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах, хашиж хамгаалах замаар усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан. Нийт газар нутгийн 0.4 хувийг буюу 685.8 мян.га талбайг усны сан бүхий газар эзлэх бөгөөд үүний 33.3 хувийг гол мөрөн, 64.6 хувийг нуур, цөөрөм, тойром, 1.8 хувийг горхи, булаг, шанд, 0.2 хувийг мөнх цас, мөсөн гол тус тус бүрдүүлнэ. Улсын хэмжээнд гол мөрний урсац бүрэлдэх эхийн нийт талбайн хэмжээ 144.0 мян.км² бөгөөд үүнээс 2019 оны байдлаар 44.7 хувь буюу 64.4 мян.км² талбай улсын тусгай хамгаалалтад хамрагдсан бол 2020 онд 49.9 хувь болж өссөн байна.

Усны сав газрын нэгдсэн менежментийн тогтолцоо нэвтрэв. Усны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн дагуу улсын болон сав газруудын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх эрхзүйн орчин бүрдсэн. Монгол орон усны 29 сав газарт хуваагдах бөгөөд эдгээр сав газруудын менежментийг хариуцсан



усны 21 сав газрын захиргаа үйл ажиллагаа явуулдаг. Монгол Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг 2013-2021 оны хугацаанд хэрэгжүүлсэн бөгөөд, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажил хийгдэж байна. Цаашид улсын болон 29 сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг усны салбар дахь нийгэм, эдийн засгийн эрэлт хэрэгцээг тооцон, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох агуулгаар үе шаттай шинэчлэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Бохир усыг дахин боловсруулж, цэвэршүүлэн ашиглах замаар усны нөөцийг хэмнэх бодлого баримталж байна. Монгол орны

усны хэрэглээ нь хүн амын унд ахуй, хөдөө аж ахуй, уул уурхай, эрчим хүч, аялал жуулчлал, ногоон байгууламжийн зориулалттай болон бусад гэсэн бүтэцтэй. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайланд 2018 онд нийт 463.9 сая.м3 ус ашигласнаас 57.5 хувь буюу 266.7 сая.м3 усыг дахин ашигласан байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаар хаягдал ус болон саарал усыг цэвэршүүлэн дахин ашиглахыг бодлогоор дэмжих, “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлогод усны нөөцийг хэмнэх, хаягдал усыг дахин ашиглах техник, технологи, эдийн засгийн боломжийг бүрдүүлэх зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.




Зорилго 7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх

Монгол Улсын нийт хүн амын дийлэнх хэсэг цахилгаан эрчим хүчинд холбогдсон хэдий ч хөдөө, орон нутагт эх үүсвэрт холбогдоогүй өрх байсаар байна. Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ нэмэгдсэн хэдий ч 2030 оны зорилтдоо хүрэхийн тулд сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлтийг улам нэмэгдүүлж, нүүрсний хэрэглээнээс татгалзах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгахын төлөө хичээл зүтгэл гаргах шаардлагатай.

Бүс нутгийн цахилгаан эрчим хүчний хангамж сайжирч, цахилгаан эрчим хүчний хүртээмж нэмэгджээ. 2015 онд нийт хүн амын 96.7 хувь, 2018 онд 98.1 хувь нь цахилгаан эрчим хүчээр хангагдсан байсан бол 2020 онд нийт өрхийн 99.5 хувь нь цахилгаан эрчим хүчээр хангагдсан нь АНД-н бүсийн орнуудын дунджаас дээгүүр үзүүлэлт юм. 2020 онд улсын хэмжээнд нийт өрхийн 81.6 хувь нь төвлөрсөн системээс, 16.9 хувь нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс, 0.9 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүрээс, 0.1 хувь нь дизель станцаас цахилгаан эрчим хүчээ хангаж байгаа бол 0.5 хувь буюу 4,817 өрх цахилгааны эх үүсвэргүй байна. Улаанбаатар хотын бараг бүх өрх зөвхөн төвлөрсөн системээс цахилгаан эрчим хүчээ авдаг бол хангайн бүс, зүүн бүс, төвийн бүсийн өрхүүд төвлөрсөн системээс гадна сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах хандлагатай байна. Баруун болон төвийн бүстэй харьцуулахад зүүн болон хангайн бүсэд цахилгааны эх үүсвэрт холбогдоогүй өрхийн эзлэх хувь харьцангуй өндөр байна.

Нийт эрчим хүчний эцсийн хэрэглээний 0.18 хувийг сэргээгдэх эрчим хүчнээс хангаж байна. Эрчим хүчний эцсийн хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 2015 онд 0.14 хувь байсан бол 2021 онд 0.18 хувь болж өсжээ.

Зураг 3.2. Эрчим хүчний хэрэглээнд анхдагч болон сэргээгдэх эрчим хүчний оролцоо



Эх сурвалж: Сангийн яам, ҮСХ

Байгальд ээлтэй, хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд эрчим хүчний хэрэглээнд анхдагч эрчим хүчний хэрэглээг бууруулснаар хувь нэмэр оруулах боломжтой. Нэг сая ДНБ үйлдвэрлэхэд ашигласан анхдагч эрчим хүчний хэмжээ 2016-2019 онуудад өссөн бол 2020-2021 онуудад буурч байна. Сүүлийн 2 жилийн бууралтын төлөвийг хадгалж чадвал 2025, 2030 онд дэвшүүлсэн зорилтдоо хүрэх боломжтой.

Монгол Улс 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтыг бизнесийн ердийн буюу суурь хувилбараас 22.7 хувиар бууруулах төлөвлөгөөгөө 2019 онд шинэчилсэн (МУЗГ, 2019). Эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэгцээгээ хангахын тулд сэргээгдэх эрчим хүчний хүчин чадлаа бага багаар хөгжүүлж байгаа ч үүний зэрэгцээ нүүрсэнд анхаарлаа хандуулсан хэвээр байна. Ийм практик нь нүүрстөрөгч багатай хөгжлийн төлөвлөгөөг биелэхгүйд хүргэж болзошгүй тул нүүрстөрөгч багатай эрчим хүчний шилжилт, түүнийг санхүүжүүлэх орчныг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.



Зорилго 8. Эдийн засгийн өсөлт, зохистой ажлын байрыг бий болгох

Зохистой хөдөлмөр эрхлэлт нь иргэдийн амьжиргааны чадварын суурь нөхцөл юм. Боловсрол, мэдлэг, ур чадвар, дадлага туршлагатай иргэд хөдөлмөрлөх эрх, аюулгүй ажиллагаа хангагдсан ажлын байранд өндөр бүтээмжтэй ажилласнаар өндөр цалин, хөлс авах боломж бүрдэж, амьжиргаа сайжирна. Иргэдийн амьжиргаа сайжирч, хэрэглээний зардал нэмэгдсэнээр үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаа идэвхэждэг бол амьжиргаа сайтай иргэд хэрэглээнээсээ давсан орлогоо хуримтлуулж, тухайн эдийн засгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлдэг. Иргэдийн зохистой хөдөлмөр эрхлэлт улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжиж, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурь хүчин зүйл болдог.

Нэг хүнд ногдох бодит ДНБ-ий өсөлтийг 2030 онд 4.45 хувьд хүргэнэ. Монгол Улсын эдийн засгийн өсөлт тогтворгүй бөгөөд зарим жилүүдэд хүн амын өсөлтийн хурдаа гүйцэхгүй байна. Тодруулбал, сүүлийн 6 жилийн хугацаанд Монгол Улсын хүн ам дунджаар 1.9 хувиар тогтвортой өссөн байхад бодит ДНБ дунджаар 2.8 хувь өссөн хэдий ч хэлбэлзэл ихтэй байлаа. КОВИД-19 цар тахлын үе болох 2020 онд хүн ам 1.8 хувиар өссөн байхад эдийн засаг 4.6 хувиар буурсан бол 2021 онд хүн амын өсөлт, эдийн засгийн өсөлт ижил 1.6 хувь байв. 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон нэг хүнд ногдох бодит ДНБ 2015 онд 3,920 ам.доллар байсан бол 2021 онд 4,188 ам.доллар болж, 6.8 хувиар өссөн байна. Харин КОВИД-19 цар тахлын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад 5.7 хувиар буурчээ. Зохистой хөдөлмөр эрхлэлтийн үршмийг нэг хүнд ногдох бодит ДНБ-ээр илэрхийлбэл цар тахал Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшин, сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлсөн байна.

Зураг 3.3. Нэг хүнд ногдох бодит ДНБ-ий өсөлт, хувиар



Эх сурвалж: УСХ


ТХЗ 8-ын эхний шалгуур болох нэг хүнд ногдох бодит ДНБ-ий өсөлтийн хувийн динамикийг зураг 3.3-д үзүүлэв. Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ, ханшийн бууралт зэрэг гадаад орчны нөлөө болон дотоод дахь уул уурхайн томоохон төслүүдийн санхүүжилтийн асуудал, санхүүгийн салбарын нөхцөл байдал, улс төрийн тогтворгүй байдал зэргээс хамаарч, нэг хүнд ногдох бодит ДНБ 2016 онд буурсан байна.

Засгийн газраас Олон улсын валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдах зэргээр хөгжлийн түншүүдийн дэмжлэгтэйгээр эдийн засагт тохируулга хийх хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлснээр 2017 оноос нэг хүнд ногдох ДНБ өсөж эхэлжээ. Гэвч 2020 онд дэлхий нийтэд тархсан КОВИД-19 халдварт өвчний улмаас эрүүл мэнд, эдийн засгийн хязгаарлалтуудтай тулгарч, энэ үзүүлэлт 5.5 хувиар буурчээ. 2021 оноос нөхцөл байдал дээрдэж, эдийн засгийн үйл ажиллагаа идэвхжисний үр дүнд нэг хүнд ногдох бодит ДНБ-ий бууралтын хувь багассан байна.

Монгол Улс 2030 он гэхэд нэг хүнд ногдох бодит ДНБ-ий өсөлтийг 4.5 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн хэдий ч 2021 оны байдлаар энэ үзүүлэлт -0.2 хувьтай гарч, 2016 оны суурь түвшнээсээ ч ухарсан байна. Иймд уг шалгуур үзүүлэлтийг зорилтот түвшинд хүргэхийн төлөө онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

Нэг ажилчинд ногдох бодит ДНБ-ий өсөлтийг 2030 онд 2.47 хувьд хүргэнэ. Монгол Улс эдийн засгийн төрөлжилт, технологийн шинэчлэл, инновацаар дамжуулан, түүний дотор өндөр өртөг шингэсэн, ажиллах хүч ихээр шаарддаг салбаруудад голлон анхаарч нэг ажилчинд ногдох бодит ДНБ-ий өсөлт буюу хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, 2030 онд 2.47 хувийн өсөлт үзүүлэх зорилтыг дэвшүүлсэн ба 2021 онд энэ үзүүлэлт 5.1 хувьтай (Зураг 3.4.) болж, зорилтот үр дүнд хүрсэн учир Монгол Улс уг шалгуурыг бүрэн хангасан гэж үзэж байна.

Зураг 3.4. Нэг ажилчинд ногдох бодит ДНБ-ий өсөлт, хувиар



Эх сурвалж: УСХ




Нэг ажилчинд ногдох ДНБ-ий өсөлт буюу хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт хэлбэлзэл ихтэй, тогтворгүй байна. 2015 онд -1.5 хувийн суурь түвшнээс эхэлсэн энэ үзүүлэлт 2016-2021 онуудад дунджаар 0.52 хувь өсөлттэй гарч, 2021 онд 5.1 хувьд хүрсэн ч хэлбэлзлийн далайц ихтэй байна.

Монгол Улсын эдийн засгийн салбаруудын хөдөлмөрийн бүтээмжийг ялгаж харвал сүүлийн 6 жилийн турш уул уурхай, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, мэдээлэл холбоо,

цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн салбарууд хамгийн өндөр бүтээмжтэй бол зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, ХАА, ойн аж ахуй, загас, ан агнуур, барилгын салбарууд хамгийн бага бүтээмжтэй байна. Гэхдээ уул уурхайн салбарын бүтээмж 2016 оноос хойш тасралтгүй буурсан байхад санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, барилгын салбаруудын бүтээмж сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна (Зураг 3.5).

Зураг 3.5. Хөдөлмөрийн бүтээмж, сая төгрөгөөр, 2015 оны зэрэгцүүлэх үнээр



Эх сурвалж: УСХ

КОВИД-19 цар тахал дэгдсэн 2020 онд Монгол Улсын хөдөлмөрийн бүтээмж хамгийн ихээр буюу 6.3 хувиар буурсан. Цар тахалд эдийн засгийн ямар салбарууд өртөж, бүтээмж буурсныг харуулах зорилгоор Зураг 3.6-д салбаруудын бүтээмжийн өөрчлөлтийн 2020 оны нөхцөл байдлыг дүрслэв. Зургаас харахад КОВИД-19-ийн үед цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж, усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа, ХАА, ойн аж ахуй, загас,

ан агнуурын салбарын бүтээмж ихээр нэмэгдсэн байхад бусад дийлэнх салбарын бүтээмж буурсан байна. Иймээс **КОВИД-19 цар тахал мэдээлэл холбоо, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, барилга, зочид буудал, байр, сууц, нийтийн хоолны үйлчилгээ, бусад үйлчилгээний салбарт сөргөөр нөлөөлсөн** байна.

Зураг 3.6. Салбаруудын хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт, 2020 он, хувиар



Эх сурвалж: УСХ

Дээрх шинжилгээний үр дүнд **Монгол Улс 2030 гэхэд нэг ажилчинд ногдох бодит ДНБ-ий өсөлт буюу хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийг 2.47 хувьд хүргэх шалгуураа хангасан байна.** Гэвч энэ шалгуур үзүүлэлт нь тогтворгүй, хэлбэлзэл ихтэй байсан. Хэрээ уг үзүүлэлтийн сүүлийн 6 жилийн дундаж утга (0.52%)-аар шалгуурыг

үнэлбэл зорилтот түвшиндээ хүрээгүй байна. Тиймээс **ТХЗ 8-ын 2 дахь шалгуур үзүүлэлт, зорилтыг ахин томъёолох шаардлагатай.**


Нийт хөдөлмөр эрхлэлтэд албан бус хөдөлмөр эрхлэлтийн эзлэх хувийн 2030 онд хүрэх зорилтот түвшин дараах шалгуур үзүүлэлт бүрээр ялгаатай. Үүнд: (i) ХАА-н салбарт 25



хувь, үүнээс эрэгтэйчүүд 27.1 хувь, эмэгтэйчүүд 22.7 хувь, (ii) ХАА-аас бусад салбарт 7.5 хувь, үүнээс эрэгтэйчүүд 9.4 хувь, эмэгтэйчүүд 6.1 хувь юм. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 75 хувь нь хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй, хуулиар хамгаалагдаагүй, уртасгасан цагаар ажиллах хандлагатай, нийгмийн хамгаалалд хамрагддаггүй, цалин хөлс тогтворгүй, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муу, зээл авах зэрэг санхүүгийн үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал зэргээр албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрлөх эрхийг хамгаалахад

бэрхшээлтэй. Түүнчлэн, улс орны эдийн засгийн нийт гүйцэтгэлийн хэмжилтийг гажуудуулдаг, далд эдийн засгийг бий болгодог зэрэг сөрөг үр дагавруудыг бий болгодог учраас зохистой хөдөлмөр эрхлэлт ба эдийн засгийн өсөлтийг хангах ТХЗ-ын гол шалгуур болсон байна. Монгол Улсын ХАА-н салбарт албан бус хөдөлмөр эрхлэлт бусад салбараас өндөр байдаг. Тиймээс 2030 онд хүрэх зорилтот түвшнийг тогтоохдоо ХАА болон ХАА-аас бусад салбарт эрэгтэй, эмэгтэй болон нийт ажилчдын албан бус хөдөлмөр эрхлэлтээр ялгасан байна.

Зураг 3.7. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн эзлэх хувь, хувиар



ХАА-н салбарын албан бус хөдөлмөр эрхлэлтийн нийт хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувийг 2025 онд 30 хувь, 2030 онд 25 хувьд тус тус хүргэх зорилт тавьсан. Гэвч 2019 оноос хойш албан бус хөдөлмөр эрхлэлтийн хувь 0.3 хувиар буурч, 2021 онд 41.2 хувьтай байна. Зураг 3.7-оос харахад сүүлийн гурван жилд ХАА-н салбарт эмэгтэйчүүдийн албан бус хөдөлмөр эрхлэлтийн хувь буурсан байхад эрэгтэйчүүдийнх нэмэгдсэний үр дүнд ХАА-н салбарын нийт ажиллагсдын албан бус хөдөлмөр эрхлэлтэд дорвитой ахиц гараагүй байна.

Эх сурвалж: ҮСХ, Ажиллах хүчний судалгаа дал, нийтийн хоол, бусад үйлчилгээний салбарт мөн албан бус хөдөлмөр эрхлэлт түгээмэл ажиглагдсан байна.

ХАА-аас бусад салбарт албан бус хөдөлмөр эрхлэлт 2021 онд 21.4 хувь байгаа нь 2015 онтой харьцуулахад 3.6 хувиар буурсан үр дүн юм. Цаашид энэ үзүүлэлтийг 2025 онд 13.7 хувь, 2030 онд 7.9 хувьд хүргэх зорилттой. Зураг 3.7-оос харахад ХАА-аас бусад салбарт эмэгтэйчүүдийн албан бус хөдөлмөр эрхлэлт алгуур буурах хандлагатай байхад, эрэгтэйчүүдийн албан бус хөдөлмөр эрхлэлт өсөж, буурсан, хэлбэлзэлтэй байна.

ДНБ-д ногдох дотоодын материалын хэрэглээг 6 кг/мян.төгрөгт хүргэнэ. Хөгжингүй орнууд манлайлан 2030 гэхэд байгаль орчинд ээлтэй, баялгийг зохистой ашигладаг хэрэглээ, үйлдвэрлэлийг бий болгож, эдийн засгийн өсөлтийг хангах зорилтыг дэвшүүлсэн. ДНБ-д ногдох дотоодын материалын хэрэглээ нь эдийн засагт дотоодын материалын ашиглалтын үйлдвэрлэлийн талын хэмжилт юм. Үйлдвэрлэлийн ихэнх хэсгийг аутсорсинг хийж, дэлхийн бусад улс орноос материал импортолж ашигладаг бол тухайн улсын ДНБ-д ногдох дотоодын материалын хэрэглээ бага байдаг.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2021 онд хийсэн судалгаагаар бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээний салбарт хамгийн их албан бус хөдөлмөр эрхлэлт байдаг бол боловсруулах үйлдвэр, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, зочид буу-

Монгол Улсын **ДНБ-д ногдох дотоодын материалын хэрэглээг** 2025 онд 10.0 тн/мян.төг, 2030 онд 6.0 тн/мян.төг-д тус тус хүргэх зорилт тавьсан хэдий ч дорвитой ахиц гаргаагүй (2018 онд 15 тн/мян.төг, 2020 онд 17.9 тн/мян.төг, 2021 онд 16.0 тн/мян.төг) учраас Монгол Улс уг үзүүлэлтээр **2015 оны суурь түвшнээс ухарсан** байна. ДНБ-д ногдох дотоодын материалын хэрэглээг тооцоход ашиглагддаг бүрэлдэхүүн үзүүлэлтүүд хугацаа өнгөрөхийн хэрээр буурах бус, өсөх ерөнхий хандлагатай байгааг Зураг 3.8-д үзүүлэв.

Зураг 3.8. Дотоодын материалын хэрэглээ




Эх сурвалж: ҮСХ



Ажилчдын нэг цагийн дундаж хөлсийг 2025 онд 6.64 мянган төгрөг, 2030 онд 8.78 мянган төгрөгт хүргэнэ. Цалин, хөлс бол бүтээмжтэй ажил эрхлэлт, амьдрах орчны чанарын гол хүчин зүйл юм. Нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн байдлаар ажилчдын цагийн дундаж хөлсийг ялгаж авч үзэх нь тухайн улсад ажилчдын тэгш байдлыг хэр зэрэг хүндэтгэн, хангаж байгааг хэмжих үзүүлэлт юм.

Зураг 3.9. Ажилчдын нэг цагийн дундаж хөлс, мян.төг




Эх сурвалж: ҮСХ

Монгол Улсын нэг цагийн ажлын дундаж хөлсийг нийт ажилчдын хувьд болон тэдний нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн байдлаас хамааруулан ялган дүрслэв. Нийт ажилчдын нэг цагийн дундаж хөлс 2015 онд 3.20 мянган төгрөг байсан бол 2021 онд 4.80 мянган төгрөг болж, 50 хувиар өссөн байна. 2030 оны зорилтот түвшинд хүргэхийн тулд ажлын цагийн дундаж хөлсийг 2021 оны түвшнээс 83 хувиар өсгөх шаардлагатай байна.

Монгол Улсад эрэгтэй, эмэгтэй ажилчдын нэг цагийн дундаж хөлс ялгаатай тогтох хандлагатай ба 2020, 2021 онуудад энэ ялгаа улам өссөн байна. Тухайлбал, 2015 онд эмэгтэйчүүдийн цалингаас эрэгтэйчүүдийн цалин 10.0 хувиар өндөр байсан бол 2021 онд 15.6 хувиар өндөр болж, ялгаа нэмэгджээ.

Зураг 3.10. Ажилчдын нэг цагийн дундаж хөлс, насны бүлгээр, мян.төг



Эх сурвалж: ҮСХ

15-24 насныхан болон 65+ насныхантай харьцуулахад 25-64 насны ажилчид харьцангуй өндөр цалин авдаг байна. 2015 оноос хойш 15-64 насны ажилчдын цалин алгуур, тогтмол өссөн байхад 65+ насны ажилчдын цалин буурсан хандлагатай байна. Энэ нь 65+ насныхан дийлэнх нь тэтгэврийн насныхан байдагтай холбоотой байх магадлалтай.

Монгол Улс 2030 он гэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр зүтгэлийг өндрөөр үнэлж, тэдэнд тэгш, хүндэтгэлтэй хандан, нэг цагийн дундаж хөлсийг хурдтай өсгөх зорилт дэвшүүлсэн байна.

Зураг 3.11. Ажилчдын нэг цагийн дундаж хөлс, хөгжлийн бэрхшээлийн байдлаар, мян.төг




Эх сурвалж: ҮСХ

2015 онд хөгжлийн бэрхшээлгүй ажилчны нэг цагийн дундаж хөлс 3.2 мянган төгрөг байсан бол хөгжлийн бэрхшээлтэй ажилчных түүний 2/3 хэсэгтэй тэнцэх хэмжээний доогуур хөлс авдаг байжээ. 2016 оноос хойш тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлж, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй, тэгш байдлыг чухалчилсны үр дүнд 2018 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй ажилчдын цалин ялгаагүй болжээ.


Ажилгүйдлийн түвшнийг 2025 онд 7.8 хувь, 2030 онд 7.0 хувьд хүргэнэ. Хөдөлмөр дутуу ашиглалтыг хэмжих нэг үзүүлэлт нь ажилгүйдлийн түвшин бөгөөд Монгол Улс 2015 онд 7.45 хувь ажилгүйдэлтэй байсан 2021 онд 8.14 хувь ажилгүйдлийн түвшинтэй болж, нэмэгдсэн байна. Энэ хугацаанд ажилгүйдлийн түвшин хэлбэлзэл ихтэй, 2016, 2019 онуудад 10.0 хувьд хүрч байсан бол 2018, 2020 онуудад 7.0-8.0 хувьтай байна. 2015 оноос хойших ажилгүйдлийн түвшний үзүүлэлтийг ахиц дэвшил гараагүй, буурсан гэж үнэлж байна.

Зураг 3.12-д 2015 оноос хойших ажилгүйдлийн түвшнийг хүйс, насны бүлгээр ялган үзүүлэв. Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшинтэй харьцуулахад эрэгтэйчүүдийнх өндөр бөгөөд хэлбэлзэл ихтэй байна. Насны бүлгээр авч үзвэл 25-64 насныхантай харьцуулахад 15-24 насныхны ажилгүйдлийн түвшин өндөр, хэлбэлзэл ихтэй байна.

Зураг 3.12. Ажилгүйдлийн түвшин, хүйс, насны бүлгээр, хувиар




Зураг 3.14. Боловсрол, ажил эрхлэлт, сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуусын эзлэх хувь



Эх сурвалж: ҮСХ


Зураг 3.13-д ажилгүйдлийн түвшнийг бүсээр болон хот, хөдөөгөөр ялгаж, харуулав. 2015 оноос хойш хөдөөгийн ажилгүйдлийн түвшин алгуур, тогтмол буурах хандлагатай байхад хотын ажилгүйдлийн түвшин хөдөөгийнхөөс өндөр бөгөөд хэлбэлзэл ихтэй байна. Хот, суурин газарт иргэд төвлөрсөн бүтэцтэй Монгол Улсын хувьд хотын иргэдийг ажлын байраар хангах, хөдөлмөрлөх чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлага байгаа нь эндээс харагдана. Ажилгүйдлийн түвшнийг бүсээр ялгаж харвал баруун болон зүүн бүсэд ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр, хангайн болон төвийн бүсийн ажилгүйдлийн түвшин харьцангуй бага байна. Ялангуяа, баруун бүсэд ажилгүйдлийн түвшин өндөр бөгөөд 2019 оноос хойш ажилгүйдлийн түвшин илүү хурдтай өсөх хандлагатай болжээ.

Зураг 3.13. Ажилгүйдлийн түвшин, байршлаар, хувиар



Эх сурвалж: ҮСХ

Боловсрол, ажил эрхлэлт, сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуучуудын эзлэх хувийг 2025 онд 14.9 хувьд, 2030 онд 10.0 хувьд хүргэнэ.



Эх сурвалж: ҮСХ

Хөдөлмөрийн насанд хүрсэн, 15-24 насны залуус сурч боловсроход, эсвэл ажил эрхлэхэд цагаа зарцуулаагүй бол ажил хайж буй, эсвэл эдийн засгийн идэвхгүй хүн амд тооцогдоно. Энэ насны залуусын хөдөлмөр ашиглалтгүй байх нь тэдний амьжиргаанд төдийгүй эдийн засгийн нийт гүйцэтгэлд муу үр дүнтэй. 2015 онд Монгол Улсын 15-24 насны нийт залуусын 16.81 хувь нь сурч боловсроход, эсвэл ажил эрхлэхэд цагаа зарцуулаагүй байна. Долоон жилийн дараа буюу 2021 онд энэ үзүүлэлт 17.97 хувь болж өссөн нь ахиц дэвшил гараагүйг илтгэнэ.

Хөдөлмөр эрхэлж буй 5-17 насны хүүхдийн тоо, эзлэх хувийг 2025 онд 8.0 хувь, 2030 онд 2.6 хувьд хүргэнэ. ҮСХ-оос хийсэн "Нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгаа"-ны үр дүнг ашиглан 2013 онд Монгол Улсын нийт 5-17 насны хүүхдүүдийн 17.3 хувь нь хөдөлмөр эрхэлж байгааг тогтоосон. 2018 оны судалгаагаар 16.7 хувь болж бага хэмжээгээр буурсан үр дүнтэй байсан бол 2018 оноос хойш уг үзүүлэлтийг гаргах судалгаа, мэдээлэл алга байна. Мөн "Нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгаа"-ны үр дүнгээс харахад 2013, 2018 онуудад 5-17 насны эмэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад эрэгтэй хүүхдүүд хөдөлмөр эрхлэх хандлага түгээмэл байсан ба насны бүлгээр ялгавал 5-11 насны бүлгийн хүүхдүүд хөдөлмөр эрхлэх байдал харьцангуй бага 12-17 насны хүүхдүүд хөдөлмөр эрхлэх нь харьцангуй түгээмэл байжээ.

100,000 ажилчинд ногдох үйлдвэрлэлийн ослын тоог 2025 онд 20, 2030 онд 15-д хүргэнэ.

Зураг 3.15. Үйлдвэрлэлийн ослын тоо

Ажилтнуудын ажлын орчныг сайжруулж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, Монгол Улс 100,000 ажилчинд ногдох үйлдвэрлэлийн ослын тоог 2025 онд 20, 2030 онд 15 болгож бууруулах зорилт тавьсан хэдий ч дорвитой ахиц гараагүй байна. Ялангуяа 2019, 2020 онуудад үйлдвэрлэлийн ослын нийт тоо өндөр гарсны дотор үхэлд хүргэсэн ослын давтамж нэмэгдсэн байна.



Зураг 3.15. Үйлдвэрлэлийн ослын тоо



Эх сурвалж: ҮСХ

Үндэсний хэмжээнд хөдөлмөрлөх эрхийн зөрчлийн түвшнийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын үнэлгээгээр 2025 онд 0.15, 2030 онд 0.10-д хүргэж, бууруулна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын үнэлгээгээр 2019, 2020 онуудад Монгол Улс 0.15-тай тэнцэх хөдөлмөрлөх эрхийн зөрчлийн оноотой гарчээ. Энэ оноо 0-10 хооронд утга авдаг бөгөөд 10 руу ойртвол хөдөлмөрлөх эрхийн зөрчил их гардаг, харин 0 рүү ойртвол хөдөлмөрлөх эрхийн зөрчил багатайг илтгэнэ.

Аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувийг 2025 онд 1.0 хувь, 2030 онд 3.0 хувьд хүргэнэ. Ажлын байр бий болгож, орон нутгийн соёл, бүтээгдэхүүнийг дэмждэг тогтвортой аялал жуулчлалыг хөхиүлэн дэмжих бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь иргэдийн амьжиргаа, эдийн засгийн гүйцэтгэлд өндөр ач холбогдолтой. Харамсалтай нь КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр зогсонги байдалд орсон салбар бол аялал жуулчлалын салбар юм.

Аялал жуулчлалын салбар нь Монгол Улсын ДНБ-ий 0.20 хүрэхгүй хувийг бүрдүүлдэг ба КОВИД-19 цар тахал дэгдсэн 2020-2021 онуудад салбарын эзлэх хувь бараг 0 болсон. Цар тахлын дараах он жилүүдэд нийгэм, эдийн засгийн байдал хэвийн голдиролд орж, аялал жуулчлал зэрэг үйлчилгээний салбарууд хөгжинө гэсэн хүлээлттэй байна. **Насанд хүрсэн 100,000 хүнд**

ногдох арилжааны банкны салбарын тоог 2025 онд 75.4-д, 2030 онд 76.5-д, автомат теллер машин (АТМ)-ы тоог 2025 онд 117.5-д, 2030 онд 119.2-д тус тус хүргэнэ.

Зураг 3.16. 100,000 хүнд ногдох арилжааны банкны болон АТМ-ын тоо



Эх сурвалж: ҮСХ

Хүн бүрд банк, даатгал, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг хүргэж өргөжүүлэх, түүнийг дэмжих дотоодын санхүүгийн институцийн чадавхыг бэхжүүлэх зорилгын ахиц, дэвшлийг хэмжихдээ 100,000 хүнд ногдох арилжааны банк, АТМ-ын тоог ашиглана. 2015 онтой харьцуулахад 2021 онд 100,000 хүнд ноогдох арилжааны банкны тоо 70 хувиар, АТМ машины тоо 49 хувиар тус тус өссөн байна. Арилжааны банкны тоогоор зорилтот түвшиндээ хүрсэн бол АТМ машины тоогоор зорилтот түвшиндээ тун ойртсон байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний стратеги баримталдаг байх. Монгол Улс залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж ирсэн. Үүний жишээ нь, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 1 дүгээр тогтоолоор "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг баталж, залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх, ажилд дадлагажуулан зуучлах цогц үйлчилгээг нэвтрүүлэх, аж ахуй эрхлэх, бүтээлч, шинэлэг санал, санаачилгыг дэмжин ажиллаж байна.



Зорилго 9. Инновацыг дэмжиж, дэд бүтцийг сайжруулах

Дэд бүтцийг хөгжүүлснээр нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж, аж үйлдвэржилт, инновацын хөгжлийг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ. Хүн ам нийгмийн үйлчилгээг тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлнэ. Инновацыг дэмжиж, дэд бүтцийг сайжруулах зорилгын хэрэгжилт ахиц дэвшилтэй байгаа боловч нэмэгдэл өртгийн нэгжид ногдох нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээ нэмэгдсэн нь хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Зорчигч болон ачаа тээврийн нийт эргэлт нэмэгдсэн хэдий ч КОВИД-19 цар тахлаас шалтгаалж, сүүлийн 2 жилд буурсан байна. Монгол Улсын тээврийн салбарын гол хэмжилт болох зорчигч болон ачаа тээврийн нийт эргэлтийн 2019 оны үзүүлэлтийг 2015 онтой харьцуулахад зорчигч тээвэр ойролцоогоор 45 хувиар, ачаа тээвэр 70 хувиар тус тус өссөн байв. Харин дэлхий нийтэд тархсан КОВИД-19 цар тахлаас үүдэж, хил гаальд хязгаарлалт хийгдэж, зарим үед зорчих хөдөлгөөнийг зогсоосны улмаас 2020-2021 онуудад тээврийн нийт эргэлт саарсан байна.

КОВИД-19 цар тахлаас өмнө боловсруулах үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртөг тогтвортой өсөж байсан хэдий ч жижиг, дунд үйлдвэрийн эзлэх хувь бага, 2015 оноос хойш дорвитой ахиц, дэвшил гараагүй байна. Сүүлийн 7 жилийн хугацаанд ДНБ-д боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь өссөн төдийгүй КОВИД-19 цар тахлын үед мэдэгдэхүйц бууралт ажиглагдаагүй. Харин зэрэгцүүлэх үнээр тооцсон нэг хүнд ногдох боловсруулах үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртөг 2020 онд 900.7 мянган төгрөг байсан бол 2021 онд 680.7 мянган төгрөг болж, 2017-2018 оны түвшиндээ хүрсэн байна. Нийт ажилчдад боловсруулах салбарын ажилчдын эзлэх хувь 2015 оноос хойш харьцангуй тогтвортой, өсөх хандлагатай байсан бол нийт боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртөгт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн оруулах хувь нэмэр хэлбэлзэл ихтэй, тогтворгүй, өсөлтийн хурд багатай байна.

Зураг 3.17. Боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртөг



Эх сурвалж: УСХ

Зураг 3.18. Нийт боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртөгт ЖДҮ эзлэх хувь, хувиар



Эх сурвалж: УСХ

Үйлдвэрлэл, үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тал дээр ахиц дэвшил гараагүй байна. Эдийн засаг, бизнесийн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг ДНБ-ий нэгжид ногдох нүүрстөрөгчийн ислийн ялгарал, үйлдвэрлэлийн нэмүү өртөгт ногдох нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт, түлшний шаталтаас үүссэн нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт гэсэн гурван үзүүлэлтээр хэмжихэд 2015 оноос хойш эдгээр үзүүлэлт нэмэгдсэн буюу байгальд үзүүлэх сөрөг нөлөө нэмэгдсэн байна.

Инновац, шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, туршилт, судалгаа хийхэд хангалттай хүчин чармайлт гаргаагүй байна. 2015 оноос хойш ДНБ-ий дунджаар 0.49 хувийг судалгаа, хөгжүүлэлтэд зарцуулж ирсэн бөгөөд 2021 оны байдлаар нийт ДНБ-ий 0.7 хувь болж өссөн байна. Гэсэн хэдий зорилтот түвшин бодит гүйцэтгэл хооронд зөрүү их байгаа бөгөөд 2030 онд тус хувийг 3.0 хувь хүртэл өсгөх шаардлагатай. Түүнчлэн нэг сая хүн амд ногдох бүтэн цагаар ажилладаг судлаачдын тоо 2021 оны байдлаар 1,335 байгаа бөгөөд 2030 онд энэ тоог 2,500-д хүргэх зорилт дэвшүүлсэн.

Үйлдвэрлэлийн нийт нэмүү өртөгт дунд болон өндөр технологийн салбарын эзлэх хувь тасралтгүй өссөн байна. 2015 онд 2.4 хувьтай байсан энэ үзүүлэлт 2021 онд 4.3 хувь болж 1.8 дахин нэмэгджээ.

ТХЗ-ын хүрээнд хөгжингүй улс орнууд нь хөгжиж буй эдийн засагтай орнуудад санхүү, технологи, техникийн туслалцааны дэмжлэг өгөх замаар тогтвортой, уян хатан дэд бүтцийг хөгжүүлэхэд тусалж иржээ. Монгол Улс 2015-2020 оны хооронд дунджаар 233.8 сая ам.долларын дэд бүтцийг хөгжүүлэх олон улсын албан ёсны дэмжлэг авч байсан бол 2021 онд эрс багасаж, 101.8 сая ам.доллар болсон байна.



Зураг 3.19. Дэд бүтцэд үзүүлэх олон улсын дэмжлэг ба технологийн салбарын нэмүү өртөг



Эх сурвалж: Сангийн яам, УСХ

Хүн ам хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамрагдах боломж нэмэгдсээр байна. 2015 онд нийт хүн амын 71.0 хувь нь 3G сүлжээ, 2019 онд нийт хүн амын 46 хувь 4G сүлжээ хэрэглэх боломжтой болжээ.

Интернэтийн сүлжээ нэвтэрсэн хэрэглэгчдийн тоо нэмэгдэж байгаа нь иргэд мэдээ, мэдээллээс хоцрохгүй байж, төрийн үйлчилгээг цахимаар авах, хувийн хэрэглээгээ хялбар, хямд, шуурхай хангах, харилцаа холбоогоо сайжруулах давуу талуудыг бий болгож байна.



Зорилго 10. Тэгш бус байдлыг бууруулах

Тэгш бус байдлыг бууруулах зорилгын хэрэгжилт эерэг хандлагатай, тэгш бус байдал харьцангуй тогтвортой байгаа хэдий ч хөгжлийн томоохон сорилт хэвээр байна.

Доогуур орлоготой 40 хувийн хэрэглээний жилийн дундаж өсөлт нийт хүн амынхаас бага хурдацтай өсжээ. Жини коэффициент сүүлийн 10 жилийн хугацаанд 32-33 нэгжийн хооронд бага зэрэг өссөн ч тэгш бус байдлын индекс хөрш зэргэлдээ орнуудаас харьцангуй бага

байна. Улсын хэмжээнд 2016-2020 онд жилийн хэрэглээний өсөлт ердөө 1.0 хувь, хүн амын доогуур орлоготой 40 хувийнхны нэг хүнд ногдох дундаж орлогын өсөлт 1.75 хувь, зарлагын өсөлт 1.89 хувь, хандлагын хувьд харьцангуй тогтвортой, өөрчлөлт багатай байна. Нийт хүн ам болон хамгийн ядуу 40 хувийн хүн амын жилийн дундаж хэрэглээний өсөлтийн зөрүүгээр тодорхойлогддог хэмжигдэхүүн бол өсөлтийн хүртээмж бөгөөд хэрэглээний өсөлт хэр шударга байгааг харуулдаг.

Зураг 3.20. Нийт хүн амын болон хамгийн бага 40 хувийн хэрэглээний жилийн дундаж хурд ба хэрэглээний өсөлтийн хүртээмж



Эх сурвалж: ӨНЭЭС 2020

Өсөлтийн хүртээмж 2016-2020 онд сөрөг байгаа нь хүн амын хамгийн ядуу 40 хувийн хэрэглээний жилийн дундаж өсөлт нийт хүн амынхаас бага хурдацтай өссөнийг илэрхийлэх буюу хэрэглээний жилийн дундаж өсөлт мэдэгдэхүйц буурч, хүртээмж тэгш бус болжээ.

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал хүн амын дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний

хүртээмжийн тэгш бус байдлыг улам нэмэгдүүлж байна. Дундаж орлоготой 50 хувиас доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувийн жин аажмаар буурч байгаа бөгөөд хэрэгжилт зогсонги байдалтай байна. 2018 оны байдлаар нийт хүн амын 16.8 хувь нь дундаж орлоготой 50 хувиас доогуур амьжиргаатай байсан бол 2020 онд 15.6 хувь болж буурчээ. Хөдөөгийн, амьдралын түвшин доогуур



(хамгийн бага 40), бага боловсролтой, эрэгтэй хүн амын хөгжлөөс хүртэх байдал хангалтгүй, хөгжлөөс алслагдсан хамгийн хоцрогдсон бүлэгт тооцогдож байна.

Монгол Улсын олон хэмжээст ядуурлын хамралт харьцангуй бага байгаа нь туйлын ядуурал бараг тэг, хүний капиталын хөгжил өндөр байгааг харуулж байна. Гэхдээ таван хүн тутмын нэг нь олон хэмжээсний дор хаяж нэг үзүүлэлтээр нь гачигдалтай байна. Олон хэмжээст ядууралд газарзүйн ялгаа их байна. Улаанбаатар хотын хүн амын 95 хувь нь ямар нэгэн гачигдалгүй байхад, хөдөөд дөрвөн хүн тутмын гурав нь дор хаяж нэг үзүүлэлтээр гачигдалтай байна. Хөдөөд хэд хэдэн үзүүлэлтээр зэрэг гачигдалтай байх нь түгээмэл бөгөөд хөдөөгийн хүн амын 42 хувь нь 2-оос дээш үзүүлэлтээр гачигдалтай байна.



Зорилго 11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих

Монгол Улсад нийслэл Улаанбаатар хот болон 21 аймгийн төв хотууд байна. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон Монгол Улсын онцлогт нийцүүлэн тодорхойлсон нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтцийн 4 бүлгийн 19 шалгуур үзүүлэлтэд тулгуурлан Монгол орны 22 хотын хөгжлийн боломжийн үнэлгээг хийхэд Дархан, Эрдэнэт, Улаанбаатар, Өлгий, Чойбалсан, Сүхбаатар, Сайншанд хотууд хамгийн өндөр, харин Булган, Цэцэрлэг, Арвайхээр хотууд хамгийн бага үнэлгээ авчээ.

Монгол орны нийт хүн амын 69 хувь нь хот, суурин газар суурьшиж, улмаар нийгэм, эдийн засгийн хөгжилд хотын гүйцэтгэх үүрэг эрс нэмэгдсэн. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын тухайд баримтлах бодлого, төлөвлөлт тодорхой бус явж ирсэн бөгөөд үндэсний хэмжээнд нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоо алдагдсан. БХБЯ-аас удирдлага, зохион байгуулалтаар ханган 2020 оноос "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд уг орон зайн хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийг УИХ-аар батлуулж, тогтвортой хэрэгжүүлэх, институцийн тогтолцоог бүрдүүлэх сорилт хүлээгдэж байна. Цаашид Тогтвортой хөгжлийн 11 дүгээр зорилго, Шинэ хотжилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах үүднээс тогтвортой нутагшуулан, суурьшуулах зорилгоор салбар хоорондын уялдааг ханган, нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд бүс нутаг, хот, тосгоны оновчтой бүтэц, тогтолцоог бүрдүүлэн үндэсний хэмжээнд хөгжлийн орон зайн нэгдсэн төлөвлөлтийн

Олон улсын хүний эрхийн хуулиар хориглосон ялгаварлан гадуурхах явдлын аль нэг тохиолдлоор сүүлийн 12 сард гадуурхагдсан, доромжлуулсан гэж мэдэрсэн хүн амын хувь буурах хандлагатай байна. Тодруулбал, энэ үзүүлэлт 2020 онд 18.7 хувь байснаа 2021 онд 16.5 хувь болж буурчээ. Хүн амын дунд нийгэм-эдийн засгийн статус, нас, яс үндэс, газар зүйн байршлын хувьд гадуурхагдсан байдал бусад тохиолдолтой харьцуулахад өндөр байна.

ДНБ-д цалин, түүнтэй адилтгах орлогын эзлэх хувь 27.7 хувьтай байна. ДНБ-д цалин, түүнтэй адилтгах орлогын эзлэх хувь 2020 онд 29.5 хувь болж, 2030 оны зорилтот түвшин буюу 30 хувьд хүрч байсан хэдий ч 2021 онд 27.7 хувь болж 1.8 нэгж хувиар буурсан байна.

урт хугацааны тулгуур бодлогын баримт бичиг болох хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийг Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай.

Нийслэлд нийтийн тээврээр үйлчлүүлэгсдийн тоо буурсаар байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 2021 оны байдлаар 1,639,172 хүн амьдарч байгаа бөгөөд улсын нийт хүн амын 48.1 хувийг эзэлж байна. Нийслэлийн нийт хүн амаас нийтийн тээврээр үйлчлүүлэгсдийн тоо 2015 онд 238.3 сая байсан ч жил бүр буурсаар 2021 онд 146.6 саяд хүрчээ.

Хотын агаарын чанарын үзүүлэлтэд өнгөрсөн хугацаанд дорвитой өөрчлөлт ажиглагдахгүй байна. Хотын агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцор (PM_{2.5})-ын жилийн дундаж хэмжээ 2021 онд 0.05 мг/м³-д хүрсэн нь 2015 оноос 0.03 мг/м³-р буурсан байна. Харин том ширхэглэгт тоосонцор (PM)-ын хувьд мөн хугацаанд 0.05 мг/м³-р буурч, 0.09 мг/м³-д хүрээд байна.

Үндэсний соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалахад зарцуулсан зардлыг нэмэгдүүлнэ. Монгол Улс 1990 онд ЮНЕСКО-гийн Дэлхийн Өвийн Конвенцод нэгдэн орсон бөгөөд дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байна. Монгол Улсаас Увс нуурын ай сав газар нутаг, Орхоны хөндийн соёлын дурсгалт газар нутаг, Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор, Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг, Монгол-Оросын хил дамнасан Дауриагийн ландшафт (Landscapes of Dauria) бүхий газар нутаг зэрэг 5 байршлыг дэлхийн байгаль, соёлын өвд бүртгүүлсэн. ЮНЕСКО-гийн



Хүн ба Шим мандал хөтөлбөрт Монгол Улсаас 8 байршил бүхий газар нутгийг бүртгүүлсэн бөгөөд эдгээрээс Монгол Улсын тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуулийн дагуу 5 нь Дархан цаазат газар, 2 нь Байгалийн цогцолборт газарт, 1 нь Байгалийн нөөц газарт бүртгэгдсэн байна.

Монгол Улсын хувьд үндэсний соёл, байгалийн өвийг хадгалалт, хамгаалалтын зардлын нэг хүнд ногдох хэмжээ 2021 он (2017 оны худалдан авах чадварын паритетаар 12.28 ам.доллар)-д 2019 оны үетэй (2017 оны худалдан авах чадварын паритетаар 1.9 ам.доллар) харьцуу-

лахад нэмэгдсэн ч өмнөх он (2017 оны худалдан авах чадварын паритетаар 24.66)-той харьцуулахад бараг 2 дахин буурчээ. Үндэсний соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын нэг хүнд ногдох зардлын хандлага дээрх ерөнхий үзүүлэлтийнхтэй адилхан байна. Харин байгалийн өвийн хадгалалт, хамгаалалтын нэг хүнд ногдох зардлын түвшин 2015 он (2017 оны худалдан авах чадварын паритетаар 0.08 ам.доллар)-оос 2017 он (2017 оны худалдан авах чадварын паритетаар 0.17 ам.доллар) хүртэл өссөн боловч 2018 оноос буурч 2021 онд эргээд суурь үеийн түвшинд хүрчээ.



Зорилго 12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих

Хариуцлагатай хэрэглээг дэмжих зорилгын хэрэгжилт эерэг хандлагатай гэж үнэлэгдсэн хэдий ч нэгж ам.долларын ДНБ-д ногдох дотоодын материалын хэрэглээний үзүүлэлтийг бууруулах чиглэлд анхаарах шаардлагатай байна.

Монгол Улс хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэл рүү шилжихэд чиглэсэн бодлогын арга хэрэгсэл боловсруулан баталж, хэрэгжүүлж байна. “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тогтвортой хөгжил, хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг хэрэгжүүлэх, дэмжихэд чиглэсэн дэд хөтөлбөр, төслүүд тусгагдсан байна. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Ногоон хөгжлийн сэргэлт” зорилгын хүрээнд мод, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх; ус хангамжийн эх үүсвэрийн болон томоохон голуудад барьсан усан сангийн тоог нэмэгдүүлэх; эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан ундны усаар ханагдсан хүн амын эзлэх хувийг өсгөх; нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг ногоон технологийн дагуу барьж, урсгал зардлыг бууруулах; хог хаягдлын дахин боловсруулалтын түвшнийг 40 хувьд хүргэх; цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлд өртсөн газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэхгүй тогтоон барих зэрэг зорилтыг дэвшүүлсэн. Түүнчлэн хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилготой “Хог хаягдлын тухай” хуулийг 2017 онд батлан хэрэгжүүлж байна.

ДНБ-ий нэгжид ногдох дотоодын материалын хэрэглээ буураагүй буюу нөөцийн бүтээмжийг сайжруулахад дорвитой ахиц дэвшил гарсангүй. Монгол Улс байгалийн нөөц, баялгаас хамаарал ихтэй, ДНБ-ий ихэнх хэсгийг уул уурхай, олборлолтын бүтээгдэхүүн, хөдөө аж

ахуйн бүтээгдэхүүнээс бүрдүүлдэг бөгөөд нөөцийн бүтээмжийг сайжруулах шаардлагатай байдаг. Гэвч 2018 онд 15.0 кг материалаар 1.0 мянган төгрөгийн ДНБ үйлдвэрлэж байсан бол 2020 онд 17.9 кг материалаар, 2021 онд 16.0 кг материалаар тус тус 1.0 мянган төгрөгийн ДНБ үйлдвэрлэсэн байна.

Байгаль орчны олон талт гэрээ, хэлэлцээрийн дагуу аюултай хог хаягдал болон бусад химийн бодисын талаар мэдээлэл солилцох үүргээ 65 хувьтай биелүүлжээ. Хог хаягдлаас сэргийлэх, түүнийг бууруулах, дахин боловсруулах, дахин хэрэглэх замаар хог хаягдал бий болгож буй хэмжээг үлэмж хэмжээгээр бууруулах чиглэлээр Монгол Улс хичээл зүтгэл гаргаж, ахиц дэвшил үзүүлсэн байна. Үндэсний хэмжээнд хог, хаягдал дахин боловсруулах түвшин 2018-2021 онд 7.6-аас 15.7 хувь болж нэмэгджээ. Мөн 2021 оны байдлаар 76 буюу нийт аж ахуйн нэгжүүдийн 0.1 хувь нь ISO14001 сертификат эзэмшиж байна.

Сүүлийн жилүүдэд хог, хаягдлыг дахин боловсруулах түвшин нэмэгдэж байгаа ч хог, хаягдлын менежментийг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх, нийтийн оролцоог дээшлүүлэх шаардлагатай байна. Улсын хэмжээнд цуглуулсан хатуу хог хаягдлаас дахин боловсруулалт хийгдсэн хатуу хог хаягдлын эзлэх хувь 2015 оноос хойш тасралтгүй өссөөр 2021 онд 0.3-43.5 хувьд хүрчээ. Хэрэгжилтийн хурлыг энэ хэвээр хадгалж чадвал 2030 оны зорилтдоо хүрэх боломжтой. Гэсэн хэдий ч хог хаягдлыг ангилах хууль, журмын хэрэгжилт сул байна. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд хогоо ангилан ялгасан ч хогийг тээвэрлэхдээ хольж, ачдаг, эсвэл хогны машин ангилж ачсан хэдий ч хогийн цэгт очоод нийлүүлдэг байдал нийтлэг байсаар байна. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжилтнүүдийн хог хаягдал, түүнийг зохицуулах хууль, дүрэм, журмын талаар мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай.



Зорилго 13. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг багасгах

Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицох чадвар, хөгжлийг дэмжихэд чиглэсэн бодлогын баримт бичгүүдийг тодорхой түвшинд тодорхойлж, батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч бодит байдал дээр уур амьсгалын өөрчлөлтөд эдийн засаг, нийгэм, байгаль орчны салбаруудын урт, дунд хугацаанд эрсдэлийг даван туулах, дасан зохицох чадавч бүрдээгүй байна. Цаашид уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшигт үзэгдэлд хүн ам, нийгмийн бүлгүүд, эдийн засгийн гол салбаруудын эмзэг байдал, эрсдэлийг бууруулах, дасан зохицох, сэргэн хөгжих чадавчыг бэхжүүлэх нь чухал байна.

Гамшгийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн урт, дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлж байна. Гамшгийн аюул, өртөнгө, эмзэг байдлыг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавчыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулж, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх зорилгоор "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийг 2017 онд батлан хэрэгжүүлж байна. Мөн Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу аймаг, сум, нийслэл, дүүрэг гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Монгол Улс 2016 онд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь конвенцын Парисын хэлэлцээрийг соёрхон баталсан.


Хэдийгээр Монгол улсын ялгаруулж буй хүлэмжийн хий нь дэлхийн нийт ялгаралд маш бага (0.09 хувь) хувийг эзэлж байгаа боловч, нэг хүнд ногдох болон ДНБ-д ногдох хэмжээгээр дэлхийн болон бүсийн дунджаас хэд дахин өндөр байна. Иймд, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах,

дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 22.7 хувиар бууруулах зорилтыг урт хугацааны хөгжлийн бодлогод тусган хэрэгжүүлж байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд Монгол орны нийгмийн эмзэг бүлэг, эдийн засгийн гол салбаруудын дасан зохицох чадавчыг бэхжүүлэх нь илүү чухал байна. Монгол орны сүүлийн 80 жилийн агаарын дундаж температур 2.46°C-аар дулаарсан нь дэлхийн сүүлийн 100 жилийн дунджаас 2-3 дахин илүү байна. Монгол орон нь газарзүйн байршил, эмзэг экосистем, ард түмний амьдралын хэв шинж, эдийн засгийн тогтолцоо зэргээс шалтгаалан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий, нийгэм-экологийн тогтолцооны хувьд эмзэг, эрсдэл өндөртэй орны нэг. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ган, зудын давтамж болон эрчим, гадаргуудын ууршилт, халуун өдрийн тоо, хуурайшил нэмэгдэж, цөлжилт, бэлчээрийн экосистем доройтох хандлагатай байна. Улмаар малын зүй бүс хорогдол нэмэгдэж, малчдын амьжиргаа доройтох, хөдөөгийн ядуурал ба хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэх үзэгдэл ажиглагдаж байна. Монгол Улсын нөхцөлд ядуурал, шилжих хөдөлгөөн нь хөдөөгөөс үүсэлтэй бөгөөд үүнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө багагүй нөлөөтэй байна.

Нийгэм, эдийн засгийн хувьд уур амьсгалын нөхцөлөөс ихээхэн хараат, илүү өртөмтгий, эмзэг байх нь ирээдүйд учирч болзошгүй байгалийн гамшигт үзэгдэлд өртөх эрсдэл өндөртэй байгааг илтгэнэ. Иймд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль, эрхзүйн орчныг тодорхой болгож, уур амьсгалын өөрчлөлтөд хүн ам, нийгэм, эмзэг бүлэг, эдийн засгийн салбаруудын дасан зохицох төлөвлөлт, санхүүжилтийн эрхзүй, институцийн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

Зураг 3.21. Монгол Улсын эдийн засагт голлох үүрэгтэй эдийн засгийн салбаруудын газар ашиглалт, ажиллах хүч, ДНБ-нд үйлдвэрлэлийн эзлэх хувь, 2020 оны байдлаар (3D график)



М.Алтанбагана, М.Баяржаргал, 2021.

Дата эх сурвалж: ҮСХ, Нэгдсэн мэдээллийн сангийн

1. Ажилчдын тоо

2. Дотоодын нийт бүтээгдэхүүн

3. МУ-ын газрын нэгдмэл сангийн мэдээлэлд үндэслэв.



Зорилго 15. Хуурай газрын эко системийг хамгаалах

Хуурай газрын эко системийг хамгаалах зорилгын хэрэгжилт тодорхой ахиц дэвшилтэй буюу 2030 оны зорилтдоо хүрэх эерэг хандлагатай гэж үнэлэгдсэн хэдий ч зорилт нэг бүрийн хувьд хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Нийт газар нутгийн 7.7 хувь ойгоор бүрхэгдсэн байна. Дэлхийн дулаарал, хуурайшил явагдаж байгаа өнөө үед ойн түймэр гарах, хөнөөлт шавжийн олшрох давтамж нэмэгдэж, Монгол орны ойг хомсдолд оруулах гол хүчин зүйл болсон байна. Монгол орон нь дэлхийн бөмбөрцгийн хойд хэсгийн сэрүүн бүсийн шилмүүст ойн өмнөд захад, эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай, түймрийн өндөр аюултай нөхцөлд оршдог. 2020 онд ойн сангийн нийт талбай 18,596.1, үүнээс ойн талбай 18,075.7 мян. га байна. Ой модоор бүрхэгдсэн талбай 12,619.4 мян.га, үүнээс байгалийн ой 11,850.7 мян.га, сөөг торлог 759.7 мян.га, таримал ой 7.96 мян.га, харин ой модоор бүрхэгдээгүй талбай 5,456.3 мян.га байна. Судалгаагаар Монгол орны ойн талбай уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ирээдүйд 1 хувиас хэтрэхгүйгээр буурч, ихсэх хэдий ч одоо ажиглагдаж буй уур амьсгалын дулааралтын улмаас өндөр ууланд ойн дээд хил өгсөж, цармын бүслүүр огших үйл явц гарч болзошгүй. Энэхүү өөрчлөлтийн орон зайн тархалтыг үндэс болгож ойн нөөцийн менежментийг оновчтой хийх, дасан зохицох технологийг нэвтрүүлэх нь зүйтэй юм. Уур

амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулахаас гадна давхар дасан зохицох асуудлыг илүү тэнцвэртэй авч үзэх арга зам руу шилжихийн тулд ойн эмзэг байдал, эрсдэлийг үнэлж, түүнд суурилсан ойн салбарын дасан зохицох олон зайн ялгаатай бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилготой “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн амжилттай хэрэгжиж байна. 2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж, Засгийн газраас тус үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Энэ хүрээнд ойн хомсдол, доройтлыг бууруулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, усны нөөцийг хамгаалах, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, эрүүл амьдрах таатай орчныг бүрдүүлэх, ойн зурвас байгуулах, ногоон дэд бүтцийн сүлжээг бий болгох чиглэлээр олон сая мод тарьж ургуулах зорилтыг дэвшүүлсэн. 2021-2022 онд улсын хэмжээнд 39 зүйлийн мод, сөөгийн 12 тонн үрийн нөөц бүрдүүлсэн нь өмнөх


оны мөн үетэй харьцуулахад 4.5 дахин нэмэгдсэн бөгөөд 10 гаруй сая мод тарьж, арчилж, хамгаалж байна. Мөн 306 мод үржүүлгийн газар 46 сая тарьц, суулгацын нөөцтэй болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад дөрөв дахин нэмэгджээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нэмэгдсэнээр гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, зарим зүйлийн ховор болон нэн ховор амьтан, ургамлыг хамгаалах боломж нэмэгдсэн. 2015 онд нийт газар нутгийн 17.4 хувийг хамгаалалтад авсан байсан бол 2020 оны байдлаар 21 хувь буюу нийт 32.8 сая га талбай бүхий 120 байршил бүхий газар нутгийг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулаад байна. Газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авснаар гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 50 хувь, ойн сан бүхий газрын 40 хувь, 350

орчим зүйлийн ховор болон нэн ховор амьтан, ургамлыг хамгаалах боломж бүрдсэн.

Газрын доройтлыг бууруулах, цөлжилт-тэй тэмцэх чиглэлд ихээхэн хүчин чармайлт шаардахаар байна. Цөлжилтөд хүргэж байгаа байгалийн хүчин зүйл нь уур амьсгалын өөрчлөлтийн дор эрчимжиж байгаа ган, хуурайшил бөгөөд хүний хүчин зүйлийн нэг гол шалтгаан нь малын тооны хэт өсөлт, бэлчээрийн зохисгүй ашиглалт юм. 2020 оны байдлаар Монгол орны цөлжилтийн үнэлгээгээр нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай доройтсон. Үүнээс нэн хүчтэй 4.7 хувь, хүчтэй 18.6 хувийг эзлэх ба засаг захиргааны нэгжийн хувьд Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говь-сүмбэр, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Төв аймгийн нийт газар нутгийн 50-70 хувь цөлжилт, газрын доройтолд өртсөн.

Зураг 3.22. Монгол орны цөлжилтийн үнэлгээ



Монгол орны 16 ургамал газарзүйн тойргуудын ургамалжилт, тархац, нөөцийг тодорхойлж, Улаан дансны бүртгэлийг нэмэгдүүлэх шаардлагатай. Монгол оронд ховорт тооцогдох 148 зүйл ургамлыг Байгаль, байгалийн нөөцийг хамгаалах Олон улсын Холбоо (IUCN, 2001)-ны Улаан дансны зэрэглэл болон шалгуураар үнэлж 74 хувь нь бүс нутгийн хэмжээнд ховордлын зэрэглэлд орсны дотроос 16 зүйл буюу 11 хувь нь устаж байгаа (CR), 39 зүйл буюу 26 хувь нь устаж болзошгүй (EN), 55 зүйл буюу 37 хувь нь эмзэг (VU), 2 зүйл буюу 1 хувь нь үнэлэх боломжгүй (NA), 4 зүйл буюу 3 хувь нь мэдээлэл дутмаг (DD) зэрэглэлд хамруулжээ. 2013 онд шинэчлэн боловсруулсан Монгол Улсын Улаан номд 110 зүйл амьтан, 192 зүйл ургамал устах аюулд өртсөнийг бүртгэсэн байна. Монгол Улсын ургамлын Улаан дансны 2 дахь цувралд

анх удаа гуурсгүй (доод) ургамлын (2018) нийт 121 зүйлийг үнэлснээс 12 зүйл (9.9 хувь) нь устаж байгаа (CR), 41 зүйл (33.8 хувь) нь устаж болзошгүй (EN), 50 зүйл (41.3 хувь) нь эмзэг (VU), 12 зүйл (9.9 хувь) нь ховордож болзошгүй (NT), 6 зүйл (1.2 хувь) нь анхааралд өртөхөөргүй (LC) зэрэглэлд тус тус хамруулаад байна. Улаан дансны шалгуураар үнэлсэн устаж байгаа (CR), устаж болзошгүй (EN), эмзэг (VU) ховордлын зэрэглэлд орсон ургамлын төрөл зүйлийг уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий, эмзэг гэж үздэг. Монгол орны ховор, ховордож буй зүйл ургамлын ховордлын үнэлгээг олон улсын аргачлалаар (Улаан дансны бүс нутгийн үнэлгээ (Regional IUCN Red List)) ойрын үед хийж, олон улсын өнөөгийн жишигт Монгол орны ховордож буй ургамлын өнөөгийн бүртгэл, хамгааллын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.



Зорилго 16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох

Энх тайван, шударга ёсыг цогцлоох зорилгын хэрэгжилт тодорхой ахиц дэвшилтэй буюу 2030 оны зорилтдоо хүрэх эерэг хандлагатай гэж үнэлэгдсэн бөгөөд анх батлагдсан улсын нэгдсэн төсөвт Засгийн газрын зардлын эзлэх хувийг нэмэгдүүлэх, хүчирхийллээс сэргийлэх, терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор бүх түвшний чадавхыг бэхжүүлэх зорилгоор олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан үндэсний холбогдох байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг

2021 онд 448 бүртгэгдсэн нь өмнөх оноос 66 (17.3 хувь)-аар өссөн үзүүлэлт бөгөөд энэхүү өсөлтөд золгүй явдлаар нас барсан хэрэг 30 (21.6 хувь)-аар өссөн нь голлон нөлөөлжээ. 2021 онд бүртгэгдсэн нийт 194 хүнийг санаатай хөнөөх гэмт хэргийн 109 (56.2 хувь) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оноос 14 (14.7 хувь)-өөр өссөн байна. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч болсон 100 хүн тутмын 8 нь 18 хүртэлх насны хүүхдүүд, 22 нь эмэгтэй хүн байна.

Зураг 3.23. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг ба хүнийг санаатай алах гэмт хэрэг, 2012-2021



Эх сурвалж: УСХ, 2021.

Гэр бүлийн хүчирхийлэл нь Ковид-19 цар тахалтай зэрэгцэн сүүдрийн цар тахал байдлаар нэмэгдсэн бөгөөд гэр бүлийн орчинд үйлдэгдэж байгаа хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах чадавхыг нэмэгдүүлэх шаардлага байна. НҮБ-ын Хүн амын сан, УСХ-ны хамтарсан "Жендерт суурилсан хүчирхийллийн судалгаа (2017)"-аар бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн нь

31.2 хувь, хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн гэсэн нь 57.9 хувьтай байгаа бол бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйн 44.9 хувь нь бэртэл гэмтэл авсан нь хүчирхийлэл буурахгүй байгааг харуулж байна.


Бусдын зүгээс үйлдсэн хүчирхийллийн дийлэнх нь гэр бүлийн аль нэг гишүүний зүгээс үйлдэгджээ. Жендерт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-ийн тархалтын энэхүү тоо мэдээлэл нь гэр бүлийн орчинд үйлдэгдэж байгаа хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах шаардлага илүү чухал байгааг харуулж байна.

Мөн 2017 оноос хойш тогтмол буурч байсан гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)-ийн хүнд болон давтан гэмт хэргийн тоо 2020 оны 1 дүгээр улирлаас эхлэн 2 дахин өссөн нь цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлсэн үр нөлөө ЖСХ-ийн нөхцөл байдлыг илүү хүндрүүлэх хүчин зүйл болсон байх өндөр магадлалтай. Нөгөө талаас цагдаагийн байгууллагад мэдээлсэн ГБХ-ийн зөрчлийн тоо буурсан үзүүлэлттэй байгаа нь хүчирхийллийн хохирогчид хөл хорионы үед хүчирхийлэгчтэй байнга хамт байх шаардлагатай тулгарсан тул нөхцөл байдал бүр их хүндрээгүй л бол тусламж эрэх боломж хязгаарлагдмал байсантай холбоотой.

2021 оны ЖСХ-ийн эсрэг 16 хоногийн аяныг ЖСХ/ГБХ нь хүн бүрд хамаатай асуудал гэсэн үндсэн агуулгыг олон нийтэд хүргэх, хамгийн энгийн хэлбэрийн хүчирхийллийн тохиолдлыг зүгээр хараад өнгөрүүлэх нь олон нийт тухайн хүчирхийллийг хүлээн зөвшөөрч, хор хөнөөл бүхий ийм үйлдэл үргэлжлэх боломжийг олгож байгаа гэдгийг олон нийтэд ойлгуулахыг зорьсон байна. Энэ хүрээнд эрэгтэйчүүд, хөвгүүдийг олноор татан оролцуулж, ЖСХ/ГБХ-ийг таслан зогсооход тэдний манлайлал, идэвхтэй оролцоог хангахад онцлон анхаарах шаардлагатай.

Монгол Улсын хүн амын гуравны нэг орчим нь, голдуу 15-аас дээш насныхан шөнийн цагаар амьдардаг орчиндоо ганцаар алхаж явахдаа аюулгүй байдлыг мэдэрдэггүй гэж үзэв. Олон нийтийн газар өөрийгөө аюулгүй гэж мэдэрдэггүй байх нь хүний сайн сайхан аж байдлын мэдрэмжийг үндсэнд нь доройтуулж, итгэлцэл, олон нийтийн оролцоог бууруулж, хөгжилд саад болдог. Дунджаар хүн амын 66 хувь нь амьдарч буй орчиндоо шөнө ганцаараа аюулгүй алхаж байгаагаа мэдэрдэг бөгөөд, энэ хувь 2018-2021 он хүртэл тогтвортой өсжээ.

Зураг 3.24. Амьдардаг орчиндоо ганцаараа явахад аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь, нас, 2018-2021



Эх сурвалж: УСХ

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл өсөж, цар тахлын улмаас энэ төрлийн хүчирхийллийн дуудлага нэмэгдэж, хүүхдийн эрхийн суурь зарчим зөрчигдөж байгаа нь анхаарал хандуулах асуудал болоод байна. Хүүхэдтэй зэрлэгээр харьцах, тэднийг мөлжих, наймаалах, тамлан зовоох зэрэг хүчирхийллийн хэлбэр нэмэгдсэн байна. УСХ-ны Гэр бүлийн хүчирхийллийн статистик (2021) судалгаагаар хүүхдийн эсрэг хүчирхийлэл 2016, 2017 онд бүртгэгдээгүй, 2018 онд 7, 2019 онд 2, 2020 онд 4 бүртгэгдсэн байна. Харин 2020 онд нийт 58 дуудлага ирсний 42 нь 108 утсанд хандсан бөгөөд, эдгээрийн 19 нь үл хайхрах, сэтгэл санааны 8, бие махбодын 17, бэлгийн 14 удаагийн хүчирхийлэл байна. Эдгээрийн дийлэнх шалтгаан нь ахуйн хүрээний архидалттай холбоотой. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ахуйн хүрээнд архидахгүй, хүүхдийнхээ дэргэд согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, хүүхдэдээ анхаарал хандуулж, тэднийг сонсох, цаг гаргах, сэтгэл зүйн хэрэгцээг орхигдуулахгүй байх нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход хамгийн чухал нөлөөтэй.

Мөн Улсын Ерөнхий Прокурорын газраас гаргасан судалгаанаас үзэхэд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь удаан хугацааны туршид далд хэлбэрээр үйлдэгддэг бөгөөд илрүүлэхэд хэцүү, дахин давтагдах эрсдэл өндөртэй болохыг тэмдэглэжээ. ЕХ, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэй төслийн хүрээнд хүүхэд хамгаалал, хүүхдийн хүчирхийллийн эсрэг чиглэлээр ажиллаж буй ИНБ-ууд нэгдэн, 2021 оноос 'Амлая' нөлөөллийн аянаар дамжуулан хүүхдийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, олон нийт, эцэг эхчүүдийн мэдлэг ойлголтыг сайжруулахад томоохон хувь нэмэр оруулж байна.

Монгол Улс Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох Дэлхийн түншлэлд нэгдэж,

INSPIRE стратегийг хэрэгжүүлэхээр 2021 оноос ажиллаж байна. Боловсролын, хүүхэд хамгааллын, хүүхдийн эрхийн, эрүүгийн, зөрчлийн зэрэг олон хуулиудыг шинэчлэн, Засгийн газрын зүгээс хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тууштай тэмцэх чиглэлээр нийгмийн салбар бүрийг оролцуулан ажиллаж байна. Хүүхэд хамгааллын тухай хуульд (2016) хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг тусгайлан заасны дагуу цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх салбар дундын ажлын хүрээнд ЦЕГ-аас энэ төрлийн гэмт хэргийн судалгаа, цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэх, цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах фильтр программ, аппликэйшн хөгжүүлэх, (www.ekids.mn) сайтын хөгжүүлэлт, цахим орчинд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх гомдлыг мэдүүлэх порталыг бий болгох, хүүхдийн тусламжийн 108 дугаартай утасны үйлчилгээний төвийн программ сайжруулалт хийгдсэн байна.

Засгийн газар хүн худалдаалах гэмт хэргийг таслан зогсооход тавигдах суурь шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байгаа хэдий ч энэ чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийн үед Засгийн газар ихээхэн хүчин чармайлт гаргасны дүнд Монгол Улсын хүний наймаатай тэмцэх чадавх II-р шатлалд хэвээр үлдсэн (АНУ-ын Төрийн Департамент, 2022).

Өмнөх жилийн тайлангийн хугацаатай харьцуулбал илүү олон тооны хүний наймааны хэргийг мөрдөн шалгаж, хохирогсдыг илрүүлсэн, яамд болон олон улсын түншүүдтэй үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэдээлэл солилцоог сайжруулсан, хүний наймаатай тэмцэх зорилгоор салбар дундын хамтарсан багийг Монгол Улсад анх удаа байгуулсан, энэ чиглэлээр мэргэшсэн прокурорын шинэ орон тоог бий болгон ажиллуулсан, хөдөлмөрийн харилцааны хэд хэдэн эмзэг асуудлуудыг тусгасан Хөдөлмөрийн шинэ хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн зэрэг хүчин чармайлтуудыг дурдаж болж байна. Гэсэн хэдий ч Засгийн газар хэд хэдэн гол чиглэлээр суурь шаардлагыг хангаагүй. Сүүлийн есөн жилийн туршид холбогдох эрх бүхий байгууллага эрэгтэй хохирогчийг албан ёсоор олж тогтоогоогүй байна. Цагдаагаас бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдийг албан ёсоор таньж илрүүлэн, хамгаалах үйлчилгээний албатай холбон зуучлахын оронд биеэ үнэлэх гэмт хэргээр шийтгэсээр байна. Давхардсан, заримдаа хоорондоо зөрчилдөх Эрүүгийн хуулийн зүйл заалтууд нь хүний наймаатай холбоотой шүүхийн үйл ажиллагааг хүндрүүлж, бага ялтай зүйл ангиар зүйлчлэн доогуур ял оноосоор байна.

Монгол Улс авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй байдлаар ил тод явуулахад онцгой анхаарч байна. Монгол




Улсын авлигатай тэмцэх талаар баримталж буй гол зарчим нь авлигын хэргийг өндөр, нам түвшнийг гэлтгүй бүх мэдээлэлд ижил хандахад оршиж байна. Мөн Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нь “үндэсний авлигатай тэмцэх гол стратеги бөгөөд улс төрийн бодлогын амин чухал зорилт” байх ёстой гэсэн нь төр, засгийн зүгээс авлигатай тууштай тэмцэх эрмэлзэлтэйг харууллаа гэж олон нийт үзэж байна. Учир нь хохирлыг нөхөн төлүүлэх нь төрийн үйл ажиллагааны шударга байдал, ардчиллын үнэт зүйлс, иргэдийн хүртэх ёстой байсан боломжид учирсан хор уршгийг бүрэн эдгээж нөхөж чадахгүй ч нийгэмд шударга ёсыг тогтоох нэг чухал зүйл яах аргагүй мөн. Тиймээс ч хохирлыг нөхөн төлүүлэхэд онцгой анхаарч 2019 онд 11.3 тэрбум төгрөг, 2020 онд 35.6 тэрбум төгрөг, 2021 онд 96.2 тэрбум, 2022 онд 2.3 их наяд төгрөгийг нөхөн төлүүлсэн нь тэмцэлд ахиц гарч байгааг харуулж байна.

Авлигын гэмт хэрэгт эрүүгийн хуулиар ял ногдуулсан шүүхийн шийдвэрийн тоо 2022 онд 318 болж нэмэгдсэн нь 2018 онтой харьцуулахад даруй 10 дахин нэмэгдсэн тоо бөгөөд авлигын гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэнийг харуулж байна.

Сүүлийн 12 сарын хугацаанд, төрийн албан хаагчид авлига өгсөн, эсвэл төрийн албан хаагчаас авлига өгөхийг гуйлгуулсан, төрийн албан хаагчтай хамгийн багадаа нэг удаа холбогдсон хүмүүсийн эзлэх хувь 2018 оны судалгаанаас харахад 4.65 (аж ахуй нэгжийн эзлэх хувь 3.85) байсан бол 2019

онд 4.13 (4.02), 2020 онд 3.70 (3.00), 2021 онд 2.16 (1.81) хувь болж жил дараалан буурчээ.

Зураг 3.25. Төрийн албан хаагчид авлига өгсөн, авлига өгөхийг гуйлгуулсан, төрийн албан хаагчтай хамгийн багадаа нэг удаа холбогдсон хүмүүсийн эзлэх хувь, 12 сарын хугацаанд, 2018-2021



Эх сурвалж: УСХ, 2021

Иргэдээс төрийн үйлчилгээний хүнд суртал, шат дамжлага бусад хүндрэлийн талаар мэдээлэл авах цахим цонхыг e-Mongolia системд байршуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах ажлын хүрээнд e-Mongolia платформд (contact@iaac.mn) хаягт хандан авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол гаргах тусдаа талбар үүсгэн мэдээлэл хүлээн авах цонхны хөгжүүлэлтийг хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээний иргэд, олон нийттэй харилцах төвийн “11-11” тусгай утсаар төрийн байгууллагын хүнд суртал, авлигын шинж чанартай гомдол, мэдээллийг АТГ-ын 110 тусгай дугаарт шууд шилжүүлэн холбох ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.



Зорилго 17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх

Тогтвортой хөгжлийн төлөө дэлхий нийтээрээ түншлэн, хамтран ажиллахыг уриалдаг ба үүний тулд макро эдийн засгийн тогтвортой байдлыг чухалчилж, хөгжиж буй орнууд олон улсын болон дотоодын санхүүгийн эх үүсвэрийг татдаг байхыг онцолдог. Түүнчлэн хөгжиж буй орнуудын хувьд гадаад худалдааны ач холбогдол, олон улсын худалдааг зохицуулах эрх тэгш дүрмийг хангах, шинжлэх ухаан, технологи, инновац, интернэтэд суурилсан мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашигладаг болсноор хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зорилгод хүрэх боломжтой.

Ковид-19 цар тахлын улмаас буураад байсан төсвийн нийт орлогын ДНБ-д эзлэх хувь 2021 онд цар тахлын өмнөх үеэс өндөр түвшинд хүрч өсжээ. Засгийн газар эдийн засаг дахь нөөцөө хэр үр дүнтэй ашиглаж байгааг тодорхойлохдоо ДНБ-д төсвийн нийт орлогын эзлэх хувиар хэмждэг. Хөгжиж буй орнуудтай харьцуулахад хөгжингүй орнуудын ДНБ-д төсвийн

орлогын эзлэх хувь өндөр гардаг ажээ. Монгол Улс ДНБ-д эзлэх төсвийн нийт орлогын хувийг 2030 онд 32.2 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн ба 2021 оны байдлаар 33.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 3.26. ДНБ-д төсвийн орлогын эзлэх хувь, нэгдсэн төсөвт татварын орлогын эзлэх хувь



Эх сурвалж: Сангийн яам




Суурь он буюу 2015 онд Монгол Улсын ДНБ-д төсвийн орлогын эзлэх хувь 25.8 хувь байсан ба 2016 оноос хойш уг үзүүлэлт өссөн үр дүнтэй байна. Харин 2020 онд КОВИД-19 цар тахлаас үүдэж, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаа хязгаарлагдсаны улмаас ДНБ-д эзлэх төсвийн орлогын эзлэх хувь 28.1 хувь болж буурчээ.

2020 оныг үл харгалзвал Монгол Улс уг үзүүлэлтээр 2025, 2030 онуудад дэвшүүлсэн зорилгодоо хүрэх бүрэн боломжтой байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагад татварын орлогын эзлэх хувийн хэлбэлзэлд КОВИД-19 цар тахал хүчтэй нөлөөлжээ. Монгол Улс төсөв, сангийн бодлогын гол арга хэрэгсэл болох татвараар дамжуулж, эдийн засгийн үйл ажиллагааг удирдан, улсын төсвийн нэгдсэн зарлагын 80.7 хувийг татварын орлогоор санхүүжүүлэх зорилгыг дэвшүүлсэн бөгөөд 2015-2021 оны гүйцэтгэлийг харахад улсын төсвийн нэгдсэн зарлагын дунджаар 71.3 хувийг татварын орлого бүрдүүлж байсан хэдий ч хэлбэлзэл ихтэй, тогтворгүй байжээ.

Макро эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад гадаадын хувийн секторын болон нийгмийн секторын санхүүжилтийг татаж, хөгжлийн төлөөх түншлэлийг гүнзгийрүүлэх нь чухал. Энэ нөхцөл байдлыг тухайн улсын төсөвт ГШХО болон ХАЁТ-ийн эзлэх хувиар ерөнхийлөн хэмждэг.

Зураг 3.27. Улсын нийт төсөвт ГШХО болон ХАЁТ-ийн эзлэх хувь




Эх сурвалж: ҮСХ

2015 онд улсын нийт төсвийн бараг тэн хагастай тэнцэх ГШХО, ХАЁТ орж байсан ба 2016-2019 оныг хүртэл энэ үзүүлэлт эрчимтэй өсөж байв. Харин 2020 онд цар тахлын улмаас гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалт, хөгжлийн тусламжийн урсгалууд багасаж, 2020 онд 78 хувь, 2021 онд 58.8 хувьд хүрч буурсан байна. Засгийн газраас цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах олон үйл ажиллагаа явуулж байгаагийн үр дүнд энэ үзүүлэлт өсөх хүлээлттэй байна.

Гадаад валютаарх өр нэмэгдэх нь түүхий эдийн үнийн хэлбэлзэл зэрэг гадаад шокуудад өртөмтгий байдлыг улам нэмэгдүүлж байна. Өрийн үйлчилгээг барагдуулахын тулд экспортын орлогоо хангалттай их байлгах шаардлагатай.

Түүнчлэн валютын ханшийн тогтворгүй байдал нь гадаад өрийн өртөгт нөлөөлдөг ба экспортын орлогод эсрэгээр нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, дотоодын валютын сулралт нь экспортын орлогыг нэмэгдүүлэх боломжтой ч гадаадын валютаарх өрийн үйлчилгээний дотоодын валютаар илэрхийлэгдэх өртгийг автоматаар өсгөнө.

Зураг 3.28. Бараа, үйлчилгээний экспорт дахь өрийн үйлчилгээний эзлэх хувь



Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын бараа, үйлчилгээний экспортод өрийн үйлчилгээний эзлэх хувь 2015 онд 30.8 хувь байсан бол 2017 онд 51.2 хувь болж өссөн байна. Энэ өсөлт нь нөхцөл байдал нь манай улсыг олон улсын санхүүгийн зах зээлд оролцоход бэрхшээл учруулж байв.

Засгийн газраас хэрэгжүүлсэн бодлого, ОУВС-ын "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-т хамрагдсан байдал зэргээс хамаарч 2017 оноос хойш экспортын дүнд өрийн үйлчилгээний эзлэх хувь буурсан хэдий ч 2020 онд дэгдсэн КОВИД-19 цар тахлаас үүдэж бага зэрэг өссөн байна.

Иргэдийн интернэт хэрэглэх боломж нэмэгдсэнээр шинжлэх ухаан, технологи, инновацын чадавх бэхжих суурь тавигдана. Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийг хөгжүүлэх замаар шинжлэх ухаан, технологи, инновацын чадавхыг бэхжүүлэх механизмын суурь нь интернэтийн хэрэглэх боломжийг хямд, тэгш, хүртээмжтэй болгохоос эхэлнэ. МХХТ-ыг өргөн нэвтрүүлснээр хөдөлмөрийн бүтээмж, худалдаа, эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хэдий ч зарим бүлгүүдэд тэгш бус байдал, гадуурхалтыг нэмэгдүүлэх зэрэг эрсдэлийг үүсэж болзошгүй. Тиймээс интернэт ашигладаг иргэдийн тоог тасралтгүй нэмэгдүүлэх, ялангуяа 15 болон түүнээс дээш насны иргэдийн дотор интернэт ашигладаг хүний эзлэх хувийг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам, ҮСХ-той хамтран "Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээний судалгаа (2022)"-г анх удаа хийсэн нь тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг бодитой тооцоход Монгол Улсын тоо баримтыг



тусгах, цаашид салбарын хөгжлийн бодлогыг боловсруулах, стратегийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах суурь судалгаа, статистик тоо, мэдээллээр хангах, харилцаа холбоо, мэдээллийн технологийн өнөөгийн байдлыг үнэлэх ач холбогдолтой юм.


Монгол Улсын 335 сум, суурин газарт өндөр хурдны интернэт сүлжээ орсноор нийт өрхийн 67.2 хувь нь интернэт хэрэглэж байна. Мөн үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо жил бүр өсөн нэмэгдэж, 2021 оны байдлаар нийт иргэдийн 97.6 хувь нь гар утас хэрэглэж, үүнээс ухаалаг гар утасны хэрэглээ 84.7 хувьд хүрсэн. Ингэснээр төрийн үйлчилгээг цахимаар хурдан шуурхай, нээлттэй, хүртээмжтэй авах боломжийг иргэдэд олгож байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 98 хувь нь гар утастай бол, үүнээс боловсролгүй иргэдийн 54.8 хувь нь гар утастай байжээ. Мөн 15 ба түүнээс дээш насны хүмүүсийн 31.5 хувь нь суурин компьютер ашигладаг бол цахим худалдаанд иргэдийн 29.9 хувь нь тодорхой хэмжээгээр оролцсон байна. Сүүлийн 3 сарын хугацаанд судалгаанд оролцсон иргэдийн 84.3 хувь нь интернэт ашигласан, тэдний 95 хувь нь мэдээлэл авах зорилгоор ашигласан гэжээ.

Монгол Улсын экспорт нэг улс, нэг салбараас хэт хамаарч байна. Дэлхийн экспортод эзлэх Монгол Улсын экспортын хувь сүүлийн 7 жилийн хугацаанд дорвитой өөрчлөгдөөгүй бөгөөд 2015-2017 онд 0.03 хувь орчим, 2018-2021 онд 0.04 хувь орчим гүйцэтгэлтэй байна. 2021 онд нийт экспортын 83 хувийг БНХАУ-тай хийсэн бол 2022 онд нийт экспортын 93 хувийг уул уурхайн салбарын бүтээгдэхүүн, үлдсэн 7 хувийг хөдөө аж ахуйн болон аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн бүрдүүлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүн дотроо нүүрс, тунгаасан зэс, хайлш, төмрийн хүдэр, баяжмал, пирит, боловсруулаагүй нефть, зэсийн баяжмал ихээхэн хэмжээгээр экспортлогдож байна. Үндсэндээ, Монгол Улс экспортын гол орлогоо БНХАУ-д уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох замаар олж байна. Дэлхийн түүхий эдийн зах зээлийн үнэд нөлөөлөх чадвар сул, жижиг, нээлттэй эдийн засгийн хувьд уул уурхайн түүхий эдээс хамаарах хамаарлаа бууруулж, урт хугацааны тогтвортой хөгжлийн сууриа өргөжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд уул уурхайн бус, нэмүү өртөг шингэсэн аж үйлдвэрийн болон ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг өсгөх, экспортлох боломжийг тэлэх шаардлагатай байна.


Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-т нэгдсэн хэдий ч худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааны хэрэгжилт сул байна. НҮБ-аас дэлхийн 144 улсын худалдаа хийхэд хялбар байдлыг 58 үзүүлэлтээр хэмждэг судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсын худалдааг хөнгөвчлөх талаарх үйл ажиллагааны хэрэгжилт 51 хувьтай байна.

Зураг 3.29. Монгол Улсын нийт экспортод улсуудын эзлэх хувь



Эх сурвалж: ҮСХ

Зураг 3.30. Экспортын барааны бүтэц




Эх сурвалж: Монголбанк

Гадаад худалдаанд баримтлах бодлого, дүрэм, журам, зохицуулалтууд нээлттэй, ил тод, транзит тээвэр хийхэд хялбар хэдий ч хил дамнасан худалдаа хийхэд хялбар биш, цаасгүй худалдаа эрхлэх боломж хязгаарлагдмал байна. Ялангуяа, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдаа эрхлэхэд бэрхшээлтэй, ЖДҮ-чид гадаад худалдаанд оролцоход саад, бэрхшээл ихтэй байна. Түүнчлэн худалдааг зохицуулсан байгууллагуудын зохион байгуулалтын хамтын ажиллагаа, уялдаа сул байна. Мөн дэлхийн зах зээлд гарч, бизнес эрхлэх, гэрээ хэлцэл хийх, олон улсын гэрээ, хэлцлийг ашиглах мэргэжлийн мэдлэг, чадвартай, гадаад худалдаа эрхлэх ажлын туршлагатай, гадаад хэлний мэдлэг, чадвартай хүний нөөц дутагдалтай байна.

Хил дамнасан цахим худалдаанд гаалийн мэдүүлгийг цахимаар солилцох, баримт бичгийн төлбөрийг цаасгүйгээр цуглуулах боломж бага, цахим гүйлгээний тухай хууль тогтоомж байхгүй, цаасгүй худалдааг гэрчилгээжүүлэх хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагагүй, гарал үүслийн, эрүүл ахуйн болон ариун цэврийн шаардлага хангасан гэрчилгээг цахимаар олгодоггүй зэрэг нь хязгаарлалт болж байна.

Зураг 3.31. Гадаад худалдаа хийхэд хялбар байдал



Эх сурвалж: Худалдааг хөнгөвчлөх, цаасгүй худалдааны хэрэгжилтийн талаарх НҮБ-ын глобал судалгаа

Хил дамнансан цахим худалдаанд гаалийн мэдүүлгийг цахимаар солилцох, баримт бичгийн төлбөрийг цаасгүйгээр цуглуулах боломж бага, цахим гүйлгээний тухай хууль тогтоомж байхгүй, цаасгүй худалдааг гэрчилгээжүүлэх хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагууд, гарал үүслийн, эрүүл ахуйн болон ариун цэврийн шаардлага хангасан гэрчилгээг цахимаар олгодоггүй зэрэг нь хязгаарлалт болж байна. Гаалийн болон бусад худалдааны хяналтын байгууллагууд интернэтэд бүрэн холбогдсон, гаалийн татвар, хураамжийг цахимаар төлөх бүрэн боломжтой, гаалийн мэдүүлгийг цахимаар олгох болон гаалийн автоматжуулсан системийг хэсэгчлэн хэрэгжүүлж байгаа ч цахим нэг цонхны үйлчилгээгүй нь бэрхшээл болсоор байна.

ҮСХ нь Статистикийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд албан ёсны статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр бүх түвшний хэрэглэгчдийг ижил тэгш, шуурхай хангахад анхаарч байна. Монгол Улсад бүртгэл, статистикийн алба 1924 онд үүсэж, Монгол Улсын Статистикийн тухай хууль 1997 онд батлагдсан бөгөөд статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, статистикийн байгууллага, мэдээлэгчийн бүрэн эрхийг тогтоож, тэдгээрийн хооронд болон хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр хангах явцад үүсэх харилцааг зохицуулж байна. ҮСХ нь Олон улсын валютын сан (ОУВС)-гийн Мэдээлэл тархаалтын тусгай стандарт (SDDS)-ыг хэрэгжүүлдэг бөгөөд статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг өргөн ашигласнаар мэдээллийн нээлттэй байдал нэмэгдэж, хэрэглэгчид статистикийн мэдээллийг орон зайнаас үл хамааран цаг алдалгүй авах боломжийг бүрдүүлсээр байна. Үүний үр дүнд Дэлхийн банкнаас улс орнуудын статистикийн байгууллагын чадавхыг үнэлдэг үнэлгээний гурван үндсэн үзүүлэлтийн нэг болох мэдээллийн давтамж, шуурхай байдлын үнэлгээгээр 2018 онд 83.3 оноо авч байсан бол 2020 оны үнэлгээгээр 86.7 оноо авсан. Мөн Open Data Watch олон улсын байгууллагаас дэлхийн 192 орны статистикийн байгууллагуудын мэдээллийн хүртээмж болон нээлттэй байдлыг үнэлсэн 2022 оны үнэлгээгээр Монгол Улс дэлхийд 8 дугаар байрт орсон амжилт гаргалаа.

Статистикийн салбарыг хөгжүүлэх 4 дэх таван жилийн хөтөлбөр хэрэгжиж байна. Статистикийн тухай хуульд заасны дагуу статистикийн

салбарыг хөгжүүлэх 5 жилийн хугацаатай үндэсний хөтөлбөрийг 2006 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөр нь статистикийн байгууллагын үйл ажиллагаа, үзүүлэлтүүдийг олон улсын стандартад нийцүүлэх, зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлж, түүнд хүрэх арга зам, шаардагдах хөрөнгө, хүн хүчний нөөцийг нарийвчлан тооцсон дэс дараатай хэрэгжүүлэх тулгуур баримт бичиг юм. **КОВИД-19 цар тахлын үеэр цаг хугацааны мэдрэмжтэй шийдвэр гаргалтад мэдээллийн бэлэн байдлын ач холбогдол, хамтын ажиллагаа онцлог байв.** КОВИД-19 цар тахал эхэлснээс хойш бодлого боловсруулагчид болон бизнесийн удирдагчид цаг хугацааны мэдрэмжтэй шийдвэрүүдийг тогтмол гаргах шаардлагатай болсон. Гэсэн ч эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн талаар шийдвэр гаргахад чиглүүлэх үндсэн мэдээлэл ихэвчлэн дутагдалтай байсаар байна. Цар тахал нь ийм мэдээллийн нэн чухал ач холбогдлыг онцлон ойлгуулсан. Мөн өгөгдөл, статистикийн тогтолцооны өөрчлөлтийг хурдасгаж, олон нийт уг мэдээллийг хэрхэн хүлээн авч, ашигладаг болохыг харуулав. Өгөгдлийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах хүчин чармайлтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ шинэ хамтын ажиллагааг бий болгож, мэдээллийн өөр шийдлүүдийг ашигласан. ҮСХ нь КОВИД-19 болон түүний нөлөөллийн талаарх мэдээлэл цуглуулж, онлайн болон утсаар судалгаа хийх зэрэг мэдээлэл боловсруулах шинэлэг арга, хэрэгслийг нэвтрүүлж, түүнчлэн захиргааны, төрд суурилсан мэдээллийн өгөгдлийг ашиглаж байв. Мөн ТХЗ-ын талаарх олон улсын хэмжээнд харьцуулах боломжтой тоон мэдээлэлтэй болох тал дээр мэдэгдэхүйц ахиц дэвшил гарсан.

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2020 оны тооллогыг хосолмол аргаар зохион байгуулсан нь онцлог байв. Хүн амын статистикийн мэдээллийн үндсэн эх үүсвэр нь 10 жил тутамд явуулдаг хүн ам, орон сууцны тооллого, хүн амын ердийн болон шилжих хөдөлгөөний жил бүрийн мэдээ тайлан юм. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогыг бүртгэл буюу төрд суурилсан мэдээллийн сан болон санамсаргүй, түүврийн аргаар мэдүүлгийг авах гэсэн хосолмол аргаар зохион байгуулсны дүнд мэдээлэл боловсруулах хурд нэмэгдэж, зардал хэмнэсэн ач холбогдолтой. Тус улсын тооллогын бэлтгэл болгож, 2019 онд байшин, орон сууцны тооллогыг зохион байгуулсан байна.



БҮЛЭГ 4.

**ЦАР ТАХАЛ, ГЕОПОЛИТИКИЙН ЗӨРЧИЛДӨӨНИЙ
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТЭД
ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД**



2020 оны эхээр дэлхий нийтэд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал тархсанаар хүн төрөлхтөн эрүүл мэндийн онцгой эрсдэлтэй нүүр тулж, эдийн засаг, нийгмийн тодорхойгүй орчинд шилжив. КОВИД-19 цар тахлыг давж, “шинэ эгэл” байдал руу шилжих үйл явцыг Орос-Украины зөрчилдөөн дэгдсэнээр хурдан тасалж, олон арван жилийн ахиц дэвшлийг эргүүлэн олох, цаашдын тогтвортой хөгжилд хөтлөх шинэ стратеги, бодлого, төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх сорилт бий болов.

Энэ бүлэгт Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтэд КОВИД-19 цар тахал, Орос-Украины зөрчилдөөн зэрэг дэлхий нийтэд үүссэн сүүлийн үеийн онцгой нөхцөл байдал хэрхэн нөлөөлснийг шинжлэх болно.


4.1. Монгол Улсад үүссэн онцгой нөхцөл байдал, бодлогын хариу арга хэрэгслийн тойм

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2020 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр БНХАУ-ын Ухань хотын хүн амын дунд амьсгалын замаар халдварладаг КОВИД-19 вируст халдвар тархсаныг

зарласан. Монгол Улсын Засгийн газар 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр “Шинэ коронавирусийн /КОВИД-19/ эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол гарган, дараагийн өдрөөс эхлэн БНХАУ, Монгол Улсын хоорондох агаарын тээвэр, газрын хилийн боомтыг хааж, цаашлаад олон улсын нислэг, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хойшлуулав. Мөн сургууль, цэцэрлэг, боловсролын байгууллагын танхимын сургалтыг зогсоож, хурал, уулзалт, урлаг, спортын тэмцээн, наадам зэрэг олон нийтийг хамарсан үйл ажиллагааг орон даяар цуцалсан.

Засгийн газар, Улсын онцгой комиссоос шинэ вируст халдварын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн хязгаарлалтуудын нэгдсэн индексийг Зураг 4.1-д үзүүлэв. 2020-2021 онд 4 удаа нийт 83 хоногийн хугацаанд орон даяар хатуу хөл хорио тогтоосноос гадна хэсэгчилсэн байршилд онцгой байдал зарлах замаар иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлаж байсныг хязгаарлалтын индексийн өндөр утгууд илэрхийлнэ.

Зураг 4.1. КОВИД-19 шинэ тохиолдлын тоо ба Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн хязгаарлалт



Эх сурвалж: <https://ourworldindata.org/metrics-explained-covid19-stringency-index>

Олны хөдөлгөөнийг хязгаарлаж, халдвараас хамгаалах дэглэмийг бүх нийтээр даган мөрдөж байсан ч 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр КОВИД-19 вируст халдварын анхны тохиолдол Улаанбаатарт бүртгэгдэв. 2020 оны эцэст халдварын нийт 1,195 тохиолдол илэрч, өдөрт шинээр бүртгэгддэг өвчтөний тоо улам нэмэгдэх болов. Өвчний тархалт даамжирсан нь хөл хорио тогтоох, хөдөлгөөнийг хязгаарлах бодлогын үр дүнг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн идэвхжилийг сулруулсан тул Засгийн газар 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс хойш хатуу хөл хорио тогтоогоогүй бөгөөд хэсэгчилсэн хязгаарлалтуудыг сулласан.

Засгийн газраас тогтоол гаргаж, үүссэн онцгой нөхцөл байдалд цаг алдалгүй хариу арга хэмжээнүүд авч байснаас гадна УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр “КОВИД-19-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль баталж, хэрэгжүүлэв. УИХ болон

Засгийн газраас хэрэгжүүлсэн эдгээр бодлогын арга хэрэгсэл нь богино хугацааны асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байв.

Түүнчлэн цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын нийгэм, эдийн засагт уналт, сорилт үүссэн нь “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтыг хангах суурь нөхцөлийг өөрчлөв. Тиймээс КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг тодорхойлж, цаг алдалгүй шийдвэрлэх, “Алсын хараа 2050-ыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн дунд хугацааны зорилтот хөтөлбөр болох “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлан, хэрэгжүүлж байна.

Ийнхүү КОВИД-19 хэмээх вируст халдварын дараах шинэ эгэл амьдралын хэв маягт шилжих замын эхэнд 2022 оны 2 сард ОХУ Украин Улс хооронд зөрчилдөөн эхлэв. Хэдий ОХУ,



Украин улсад хамааралтай зөрчил, мөргөлдөөн мэт боловч дэлхийн улс орнууд тэдний хоорондох зөрчлийг дэмжих, дэмжихгүй талаар байр сууриа илэрхийлж, зарим талаар тусламж, дэмжлэг үзүүлж, зарим талаар хориг, хязгаарлалт тавьснаар энэ нь тодорхой бүс нутгийг хамарсан геополитикийн асуудал болж хувирчээ.

Монгол Улсын хувьд олон улс руу дамжин өнгөрөх агаарын нислэг, аялал жуулчлал, зорчигч тээвэр, цахилгаан, эрчим хүчний хангамж, шатахуун, дизель түлшний импорт зэрэг гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын сувгаас гадна барууны орнуудын ОХУ-д тавьсан эдийн засгийн хориг арга хэмжээнээс үүдэлтэй мөнгө, санхүүгийн урсгалын шилжих механизмаар дамжин уг зөрчилдөөний нөлөө илэрч байна.

КОВИД-19 цар тахал болон геополитикийн зөрчилдөөн нь олон улсын харилцаа, худалдаа, хөрөнгө оруулалтын суваг, мөнгө, санхүүгийн урсгалаар дамжин Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд хэрхэн нөлөөлснийг дараагийн дэд хэсгүүдэд үнэлнэ. Ингэхдээ Бүлэг 3 дахь ТХЗ-д гарсан өөрчлөлт, ахиц, дэвшлийн шинжилгээний үр дүнд тулгуурлан хамгийн ихээр, хүчтэй нөлөө үзүүлсэн ТХЗ-уудыг онцолно.


4.2. Монгол Улсын тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлд үзүүлсэн нөлөө

“Тогтвортой хөгжлийн зорилго 2030” нь дэлхий нийтийн хүсэж буй ирээдүйн төлөө олон улсын хамтын ажиллагааг цоо шинэ түвшинд хүргэх төлөвлөгөө юм. Энэ төлөвлөгөөг биелүүлэх нь улс, үндэстэн бүрийн хүлээсэн үүрэг хэдий боловч олон улсын дэмжлэг, түншлэл чухал юм. Энэ хэсэгт дэлхий нийтэд үүссэн КОВИД-19 цар тахал, геополитикийн зөрчилдөөнтэй байдал нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн төлөөх

түншлэл буюу ТХЗ-17-д хэрхэн нөлөөлснийг шинжилнэ.

КОВИД-19 цар тахал, геополитикийн зөрчилдөөний нөлөөгөөр макро эдийн засгийн тогтворгүй байдал үүсэж, бизнесийн мөчлөг хэлбэлзэв. 2016 оноос хойш харьцангуй эрчимтэй өсөж байсан эдийн засаг 2020 онд 4.6 хувиар агшив. (Зураг 4.2)

Зураг 4.2. Эдийн засгийн өсөлт, хувиар



Эх сурвалж: ҮСХ

2020 оны 11 дүгээр сард вирусийн халдвар дотоодод тархаж бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал зарласан нь уул уурхай, хөдөө аж ахуй, мэдээлэл холбооны салбараас бусад салбаруудад сөргөөр нөлөөлж, эдийн засгийн идэвхжилийг сулруулсан байна.

Харин Засгийн газраас КОВИД-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг цаг алдалгүй шийдвэрлэж, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2021 онд баталж, хэрэгжүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үр дүнд 2022 онд эдийн засаг 4.8 хувийн өсөлттэй гарлаа.

Шигтгээ 4.1. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгасан төрийн бүтээмжийн сэргэлтийн эдийн засагт үзүүлэх нөлөө

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого” нь хөгжлийн хязгаарлагч 6 хүчин зүйлийг арилгах, эдийн засгийн өсөлтийг тэтгэх хүрээнд 98 үйл ажиллагааг эхний үе шатанд хэрэгжүүлэхээр тусгасан. Төрийн бүтээмжийн хэсэгт төрөөс өгч буй үйл ажиллагааг цахимжуулах, төрийн өмчит аж ахуй нэгжийн үйл ажиллагааны үр ашиг засаглалыг сайжруулах, авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг нэмэгдүүлж авлигыг бууруулах гэсэн зорилтуудыг тусгасан. Энэхүү бодлогын үнэлгээгээр төрийн бүтээмжийн сэргэлт хэсгийн “төрийн оновчтой бүтцийг зохион байгуулах, төрийн үйлчилгээг цахимжуулах” хүрээнд авч хэрэгжүүлэх 3 зорилтын эдийн засагт үзүүлэх нөлөөг “Динамик тооцоологдох ерөнхий тэнцвэрийн загвар”-ыг ашиглан тооцоолохыг зориллоо.

Тоон мэдээлэл болон загварын талаар:

Төрийн бүтээмжийн сэргэлтийн эдийн

засагт үзүүлэх нөлөөллийг шинжлэхдээ динамик тооцоологдох ерөнхий тэнцвэр (ДТЕТ)-ийн загварыг ашиглав. МУ-ын хувьд ДТЕТ-ийн загварт 2019 оны нөөц болон ашиглалтын хүснэгт, нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд, төлбөрийн тэнцлийн тоон мэдээлэлд үндэслэн байгуулсан нийгмийн тооцооллын матриц (НТМ)-ыг үндсэн тоо мэдээлэл болгон ашиглав. 2019 оны НТМ нь 19 салбартай, 20 бүтээгдэхүүн, 2 үйлдвэрлэлийн хүчин зүйлс /L,K/, 3 төрлийн институт /h, g, row/, 3 төрлийн татвартай /орлогын албан татвар, импортын татвар, бараа бүтээгдэхүүний татвар/, улсын болон хувийн секторын хадгаламж-хөрөнгө оруулалттай гэсэн бүтэцтэй.

Макро НТМ-аас харахад 2019 онд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 37.8 их наяд төгрөг бөгөөд өрхийн хэрэглээ, засгийн газрын зардал, хөрөнгө оруулалт, экспорт болон импортын ДНБ-д эзлэх хувь 57%, 13%, 35%, 59% болон 65% байна.



Эдийн засагт капиталын багтаамж хөдөлмөрөөс өндөр байна /Капитал 68.7%, хөдөлмөр 31.3%/. Нийт хөдөлмөрийн 20 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 11.1 хувь нь уул уурхай, 16.5 хувь нь боловсруулах аж үйлдвэр салбар, 52.4 хувь нь үйлчилгээний салбарт ногдож байна. Капиталын орлогын 8 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 40.4 хувь нь уул уурхайн салбарт, 12.6 хувь нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт, 39 хувь нь үйлчилгээний салбарт хуваарилагдаж байна. Гадаад худалдааны талаас нь авч үзвэл нийт импортын 71 хувь нь боловсруулах аж үйлдвэрийн салбар, 28.4 хувь нь үйлчилгээний салбар хийж байгаа бол экспортын 75.4 хувийг уул уурхайн салбар, 12.2 хувийг боловсруулах аж үйлдвэрийн салбар, 12.4 хувийг үйлчилгээний салбар эзэлж байна.

Өрхийн дансны бүтцээс харахад өрхийн орлогын 42.9 хувийг капиталын орлого, 39.6 хувийг хөдөлмөрийн орлого эзэлж байгаа бол зардлын 59.4 хувийг хэрэглээ 18.7 хувийг хадгаламж, засгийн газар руу хийж буй шилжүүлэг 15.5 хувь эзэлж байна. Харин Засгийн газрын орлогын 46.9 хувийг шууд татвар, 26.8 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар, импортын татвар 6.6 хувь, зарлагын хувьд өрх рүү хийж буй шилжүүлэг 46.5 хувь, бараа бүтээгдэхүүний зардал 41.2 хувийг эзэлж байна.

Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх бодлогын үнэлгээ:

Энэхүү үнэлгээ нь суурь хувилбар буюу

Хүснэгт 4.1. Төрийн бүтээмжийн өсөлтийн эдийн засагт үзүүлэх нөлөө, өөрчлөлтийн хувиар

	I үе	II үе	III үе	IV үе	V үе	VI үе	VII үе	VIII үе
Нэрлэсэн ДНБ	0.31	0.60	0.85	1.10	0.68	0.95	1.17	1.23
Бодит ДНБ	0.58	1.09	1.54	1.98	1.2	1.7	2.07	2.18
Үнийн индекс	-0.15	-0.29	-0.41	-0.53	-0.33	-0.47	-0.57	-0.60
Нийт хөрөнгө оруулалт	0.13	0.25	0.36	0.48	0.33	0.45	0.55	0.06
Өрхийн бодит хэрэглээ	0.16	0.31	0.44	0.58	0.39	0.54	0.66	0.71
Засгийн газрын орлого	0.06	0.11	0.17	0.22	0.16	0.21	0.26	0.28
Засгийн газрын хадгаламж	2.68	5.22	7.66	10.17	6.9	9.67	11.99	13.13
Нэрлэсэн цалин	-0.87	-1.58	-2.15	-2.65	-1.35	-1.99	-2.41	-2.42

КОВИД-19 цар тахлын хөл хорионы үед нам дор байсан инфляцын түвшин 2021 оны дунд үеэс эрчимтэй нэмэгдсэн байна. 2020 онд цар тахлын нөлөөгөөр хөрөнгө оруулалт хумигдан, эдийн засгийн эрэлт бага байсан тул эрэлтийн инфляцын дарамт бага байжээ. Түүнчлэн инфляцад үзүүлэх нийлүүлэлтийн талын хүчин зүйлсийн үнийн өсөлт тогтвортой байсан нь инфляц буурахад нөлөөлсөн байна. (Монголбанк, 2020 оны 12-р сар) Зураг 4.4-өөс харахад 2021 оны 4-р сараас эхлэн инфляц эрчимтэй нэмэгдэж, 2022 оны 6-р сард хамгийн өндөр түвшиндээ


дараагийн 8 жилийн хэвийн өсөлтийн түвшин дэх нийт эдийн засгийн тэнцвэрт байдал болон бодлогын хувилбар 1 буюу төрийн удирдлагын салбарт бүтээмжийн өсөлт бий болсон байдал гэсэн 2 хувилбарыг харьцуулна. Динамик РЕР-1 загварыг нийт хүчин зүйлийн бүтээмж болон салбар бүр дэх хөдөлмөр хэмнэсэн хүчин зүйлийн бүтээмжээр өргөтгөсөн. Монгол Улсын хувьд Дэлхийн банкны засаглалын индексээр 2021 онд 137 дугаар байранд 34.62 оноотой жагсаж байгаа бол 2030 он гэхэд 71.9 оноотой 60 дугаар байранд жагсах зорилт тавьж байна /төрийн үйлчилгээний чанар, төрийн хүнд суртал, бодлогын хэрэгжилт, тууштай байдал/. Иймд төрийн салбарын хөдөлмөр хэмнэсэн бүтээмжийг 2030 он хүртэл эхний таван жилд 10 хувиар, сүүлийн 3 жилд 8 хувиар нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

Энэхүү зорилтыг бүрэн хэрэгжүүлснээр төрийн салбарт бүтээмж бий болсноор төрийн салбарт ажиллагсад дунджаар 10-аас 30 хувиар буурч бусад салбар руу шилжиж зарим салбарын /барилга, санхүү, удирдлагын салбар/ хөдөлмөр нэмэгдсэн байна. Нэрлэсэн ДНБ жилд дунджаар 0.8 хувиар, бодит ДНБ жилд 1.5 хувиар нэмэгдэхээр байна. Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх бодлого үр дүнтэй хэрэгжсэнээр ирэх жилүүд дэх хэрэглээний үнийн өсөлтийн бууралтад 0.4 хувийн эерэг нөлөө үзүүлж байна. Өрхийн бодит хэрэглээ үнийн бууралтаас хамааран жил бүр өсөхөөр байна.

хүрсэн байна. Инфляцын энэ өсөлт нь цар тахлын нөлөөгөөр нийлүүлэлт болон эрэлтийн аль аль хүчин зүйлсээр тайлбарлагдаж байна.


Тодруулбал, богино хугацаанд КОВИД-19 цар тахлын үед хил, гааль дээр үүссэн импортын хадгалалт, тээвэрлэлтийн зардал, малын халдварт өвчин дэгдсэнээс шалтгаалсан махны үнийн өсөлт, шатахууны үнийн өсөлт, түүний дам нөлөө нийлүүлэлтийн инфляцыг үүсгэсэн бол дунд хугацаанд эрэлтийн шалтгаант инфляц эдийн засгийн идэвхжилийг даган алгуур нэмэгдэв. (Монголбанк, 2021 оны 9-р сар)

Зураг 4.3. Инфляцын түвшин, хувиар



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4.4. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, тэрбум ам.доллороор



Эх сурвалж: YCX

Цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, Монгол Улсад орох гадаадын хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламжийн хэмжээ буурсан байна. Улсын нэгдсэн төсөвт гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь 2019 онд 86.15 хувь байсан бол 2020 онд 77.96 хувь, 2021 онд 58.77 хувьд хүртэл буурчээ.

2015 оноос хойш тогтвортой өсөж байсан ГШХО-ын дотогшлох урсгал 2020 онд 2.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 16.1 хувиар буурав. Засгийн газар КОВИД-19-ийн дараах эдийн засгийг сэргээх “Шинэ сэргэлтийн бодлого” хэрэгжүүлж, ГШХО-ын урсгалыг нэмэгдүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч дэлхий эдийн засгийн тогтворгүй байдлаас хамааран өсөлт төдийлөн нэмэгдэхгүй байна.

Цар тахлаас хойш үйлчилгээний салбарууд болон боловсруулах үйлдвэр, ХАА, барилгын салбарт орох ГШХО-ын хэмжээ эрс буурсан байна. Хүснэгт 4.2-оос харахад цар тахлын дараах гурван жилд зочид буудал, байр, сууц, нийтийн хоолны

үйлчилгээ, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, боловсрол, урлаг, үзвэр, тоглоом наадам, санхүү, даатгалын үйл ажиллагаа олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа, бөөний болон жижиглэнгийн худалдаа зэрэг үйлчилгээний бүхий л салбарт орох ГШХО-ын хэмжээ буурсан байна. Түүнчлэн цар тахлын өмнөх гурван жилтэй харьцуулахад боловсруулах үйлдвэрлэлд орсон ГШХО-ын урсгал 84.7 хувиар, ХАА-н салбарт орсон ГШХО 55.7 хувиар, барилгын салбарт орсон ГШХО 17.9-аар тус тус буурсан байна. Цаашид хөдөлмөрийн оролцоо ихтэй үйлчилгээний салбар болон нэмүү өртөг шингэдэг үйлдвэрлэлийн салбаруудад орох ГШХО-ыг нэмэгдүүлж, уул уурхайгаас бусад салбарын өсөлтийг бий болгох, эдийн засгийн төрөлжилтийг дэмжихэд илүү анхаарч ажиллах шаардлага үүсэж байна.

Хүснэгт 4.2. Гадаад шууд хөрөнгө оруулалтын орох урсгал, салбараар, сая доллароор

№	Салбар	ГШХО-ын орох урсгал, сая ам.доллороор		Өөрчлөлт, %
		2017-2019 он	2020-2022 он	
1	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	47.2	0.3	-99.30%
2	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	22.1	0.9	-95.90%
3	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1.4	0.1	-92.90%
4	Боловсрол	3.2	0.5	-84.70%
5	Боловсруулах үйлдвэрлэл	102.9	34.1	-66.90%
6	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	12.2	5.4	-55.70%
7	Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.4	0.2	-42.50%
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	470.2	323.6	-31.20%
9	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	12.1	9.2	-24.40%
10	Барилга	129.9	106.7	-17.90%
11	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	701.6	637.2	-9.20%

Эх сурвалж: YCX




Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ нэмэгдэж, капиталын урсгалыг чөлөөлөх, олон улсын санхүүгийн зах зээлд интеграцлагдхад бэрхшээл тулгарч байна. Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2021 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өсөж 33.8 тэрбум ам.доллар хүрснээс 21.1 тэрбум ам.долларыг аж ахуй нэгжүүдийн гадаад өр, 8.5 тэрбум ам.долларыг Засгийн газрын гадаад өр, 2.6 тэрбум ам.долларыг Төв банкны өр, үлдсэн 1.6 тэрбум ам.долларыг арилжааны банкуудын өр тус тус эзэлж байна. Жижиг, нээлттэй эдийн засгийн хувьд гадаад өрийн хэмжээ нэмэгдэх нь гадаад шокт өртөмтгий байдлыг улам нэмэгдүүлдэг.

Улс орнууд өрийн үйлчилгээг барагдуулахын тулд экспортын орлогоо хангалттай их байлгах шаардлага үүсдэг. КОВИД-19 цар тахлын үед Монгол Улсын гадаад өрийн үйлчилгээ нэмэгдэж, Цар тахлын нөлөөгөөр экспортын гол боомтуудын үйл ажиллагаа саатсанаас хамааран экспортын орлогоо буурсан байна. **Уул уурхайн голлох бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээлд өссөн, гадаад эрэлт нэмэгдсэн, Засгийн газраас экспортын орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлд үе шаттай авч хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд экспортын орлого 2021 оны сүүлийн хагасаас нэмэгдсэн байна.** Түүнчлэн, 2019 онд экспортын орлогынхоо 6.7 хувьтай тэнцэх өрийн үйлчилгээтэй байсан бол энэ үзүүлэлт 2020 онд 16.0 хувь, 2021 онд 16.8 хувь болж, гадаад шокт өртөх эмзэг байдал нэмэгдсэн байна.

КОВИД-19 цар тахал болон геополитикийн зөрчилдөөний нөлөөгөөр Монгол Улсын урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэж, төлбөрийн тэнцэлд дарамт нэмэгдэв. Цар тахлаас үүдэлтэй хил гаалийн үйл ажиллагаа доголдож, гадаад худалдаанд саад бэрхшээл учрав.

Зураг 4.5. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллаароор




Эх сурвалж: Монголбанк

4.5-д 2019 оны нэгдүгээр улирлаас хойш төлбөрийн тэнцлийг харуулав. КОВИД-19 цар тахлын үед хөл хорио тогтоосонтой холбогдуулан 2021 оны хоёрдугаар улирлаас эхлэн урсгал дансны алдагдал нэмэгдэж, төлбөрийн тэнцлийн алдагдал өсөв.

ҮСХ-ны мэдээллээр 2021 оны байдлаар Монгол Улс худалдааны нийт эргэлтийн 63.1 хувийг БНХАУ-тай, 12.9 хувийг ОХУ-тай хийж экспортын төрөлжилт муу байгаа нь гадаад шокт өртөмтгий байдлыг нэмэгдүүлж, худалдааны сувгаар дамжиж КОВИД-19 цар тахал, Орос-Украины зөрчлийн нөлөө Монгол Улсад шууд нөлөөлсөн байна. 2019 онтой харьцуулахад 2020 онд ОХУ-тай хийсэн худалдааны нийт эргэлт 19.0 хувиар, БНХАУ-тай хийсэн худалдааны нийт эргэлт 16.3 хувиар тус тус буурсан байна. Харин 2021 оноос Засгийн газраас цар тахлыг бууруулахад чиглэсэн шат дараалсан арга хэмжээний үр дүнд дотоодын эдийн засаг эргэн сэргэж, эдийн засаг цар тахлын өмнөх түвшиндээ хүрчээ.

Цар тахлын үед хилийн боомт дээрх саатлаас шалтгаалж, төлбөрийн тэнцлийн нөхцөл байдал муудсан нь, төгрөгийн ханш сулрахад голлон нөлөөлсөн байна. 2020, 2021 онуудад төгрөгийн ханшийг харьцангуй тогтворжуулж чадсан хэдий ч 2022 оны 2-р сараас эхэлж, ам.долларын эсрэг төгрөг огцом суларч байна. Зураг 3-аас харахад төгрөгийн ханшийн сулралтын эсрэг төв банк нээлттэй зах зээл дээр валют арилжих, зохицуулалт хийж нөөц багассан байгаа нь цаашид ханш улам сулрах эрсдэлийг дагуулж байна.

Зураг 4.6. Гадаад валютын нөөц, валютын ханш



Эх сурвалж: Монголбанк

КОВИД-19 цар тахлаас үүдэж, 2020 онд мал аж ахуйн бүтээгдэхүүний экспорт 35.5 хувиар, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт 31.1 хувиар тус тус буурсан байна. Харин уул уурхайн бүтээгдэхүүний экспорт 14.3 хувиар, газар тариалангийн бүтээгдэхүүний экспорт 3.9 хувиар өссөн байна.

Ийнхүү хил боомтын саатал, хориг арга хэмжээ, геополитикийн зөрчилдөөн, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт, хязгаарлалт нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн бүтцэд ерөнхий цочрол болж, бусад хямралд тэсвэрлэх чадварыг бууруулж, нийгэм, эдийн засаг, улс төр, байгаль орчны асуудлуудад гүнзгий нөлөөлжээ.

4.3. Бизнесийн үйл ажиллагаа, зохистой хөдөлмөр эрхлэлтэд үзүүлсэн нөлөө

Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт нь бизнесийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хүн бүрд зохистой ажлын байрыг бий болгон,




амьжиргааны түвшинг дээшлүүлдэг. КОВИД-19 цар тахал, геополитикийн зөрчилдөөнт байдал нь бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулж, ажлын байрыг хомсдуулах, өрхийн орлогыг бууруулах эрсдэлийг бий болгосон юм. Энэ хэсэгт цар тахал болон геополитикийн зөрчилдөөнт байдал нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн найм дахь зорилго буюу бүх нийтээрээ бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэх зорилгын хэрэгжилтэд хэрхэн нөлөөлснийг шинжилнэ.

КОВИД-19 цар тахал нь хөдөлмөрийн оролцоо ихтэй үйлчилгээний салбарт хамгийн хүчтэй сөргөөр нөлөөлсөн байна. Тодруулбал, 2020 онд зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ, тээвэр агуулахын үйл ажиллагаа, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарын ДНБ дунджаар 18.3 хувиар буурчээ. КОВИД-19 вируст халдвараас сэргийлж гаалийн үйл ажиллагаа хэвийн бус горимоор ажиллаж, ачаа, бараа хилээр чөлөөтэй нэвтрэхгүй удах, тээврийн зардал өсөх, бараа, материалын хомсдолд орох зэрэг бэрхшээлтэй, хязгаарлалттай, хатуу хөл хориотой өдрүүд үргэлжилснээр 2021 онд барилгын салбарын ДНБ 22.85 хувиар, 2022 онд уул уурхайн салбарын ДНБ 11.9 хувиар тус тус агшив. Харин мэдээлэл, харилцаа холбооны салбар, цахилгаан, хий, уур, агааржуулалтын үйл ажиллагаа, санхүү, даатгалын салбарын ДНБ цар тахалтай жилүүдэд өссөн байна.

Сүүлийн гурван жилд олон аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаагаа бүр болон түр зогсоожээ. 2020-2022 онд нийт 7,264 ААНБ үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон нь 2017-2019 онтой харьцуулахад 68.2 хувиар өндөр байна. Мөн үйл ажиллагаагаа түр зогсоосон ААНБ-ын тоо КОВИД-19-ийн өмнөх гурван жилээс 45.9 хувиар өссөн байна. 2020-2022 онд үйл ажиллагаа бүр зогсоосон 7,264 ААНБ-ын 7,087 ААНБ буюу 97.6 хувь нь компани, хоршоо, нөхөрлөл, төрийн бус байгууллага хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байжээ. Цар тахлын өмнөх гурван жилтэй харьцуулахад тахлын дараах гурван жилд үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-ын тоо 86 хувиар, дотоодын хувийн ААНБ-ын тоо 68.3 хувиар тус тус өссөн байна.

КОВИД-19 цар тахлын үед бизнесийн байгууллагуудын макро эдийн засгийн байдал, бизнесийн ерөнхий орчин, хөрөнгө оруулалтын орчны талаарх итгэл буурсан байна. Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас нийслэл хот болон орон нутгийн 1416 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан судалсан судалгааны үр дүнд 2019 онд 0.06-тай тэнцэж байсан бизнес итгэлийн индекс 2020 онд -0.28, 2021 онд -0.05 болж, буурсан байна.


Зураг 4.7. Бизнес итгэлийн индекс



Эх сурвалж: Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, 2021

КОВИД-19 цар тахлын үед нийлүүлэлтийн сүлжээ тасалдахын зэрэгцээ бензин, түлш, түүхий эд материалын үнэ нэмэгдэж, ажиллах хүчний зардал болон тээврийн зардал өсөн, үйлдвэрлэлийн зардал тэлсэн байна. 2021 оны байдлаар ААНБ-уудын санхүүгийн байдал хүндэрч, зээл, зээлийн хүүгээ төлөхөд бэрхшээл үүссэн, ажилчдадаа цалин олгох, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, хураамж төлөхөд хүндрэлтэй болсон, түүхий эд материалын эргэлт удааширч, хомсдол үүссэн, үйлчлүүлэгчдийн тоо цөөрсөн, борлуулалт буурсан зэрэг нөхцөл байдалтай байв. ҮСХ-оос 2021 оны 8 дугаар сард хийсэн тандалт судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 43.8 хувь 2022 оны 3-р сараас хойш нийлүүлэлтийн сүлжээ тасалдсан гэж мэдээлжээ. Геополитикийн зөрчилдөөний улмаас ОХУ-аар дамжин өнгөрөх тээвэрлэлт саатаж хойшлогдсон. Харин дотоодын бизнес эрхлэгчдийн худалдааны гол түнш болох БНХАУ-ын импорт, транзит тээвэр “Тэг-КОВИД” бодлогын улмаас удааширалтай байсан. Энэ нь үйлдвэрлэл, худалдааны салбарт ихээхэн хүндрэл бэрхшээл учруулжээ.

Зураг 4.8. Бензин, түлшний үнэ



Эх сурвалж: ҮСХ

КОВИД-19 цар тахлын үед Засгийн газраас зохицуулалт хийж, 2020 оны 4 дүгээр сараас түлшний үнийг бага түвшинд барьж чадсан ч 2021 оны 7 дугаар сараас эргээд өсжээ. 2022 оны эхээс Монгол Улсын бензин, түлшний үнэ хурдтай өссөн байна.

Түүхий эдийн үнэ хурдацтай өсөж байгаа нь бүх ААН-ийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн. Инфляц өндөр байгаа нь нэг талаас




бизнесийн зардлыг нэмэгдүүлсэн, нөгөө талаас өрхийн худалдан авах чадварыг бууруулснаар зах зээлийн эрэлтийг багасгасан. Бензиний үнэ ХАА-н салбар, алслагдсан бүс нутаг, тээврийн хэрэгслээс хамааралтай ААН-ийн зардлыг нэмэгдүүлжээ. Шатахуунаас гадна ОХУ, Украин Улсаас үр, бордоо, машин техник, сэлбэг хэрэгслээ нийлүүлдэг тариаланчдын зардал эрс нэмэгдэж, үр тариа, хүнсний ногооны үнэ өсжээ. Мөн эдгээр улсаас бараа, түүхий эд худалдан авч буй ААН-ийн нийлүүлэлт тасалдаж, төлбөрөө хойшлуулах асуудал тулгарч байжээ.

Цар тахал бичил, жижиг бизнесийн байгууллагуудад сөрөг нөлөө үзүүлсэн байна. ҮСХ-оос 2021 оны 9-р сард 2,394 ААН-аас авсан тандалт судалгааны үр дүнд нийт ААН-ийн 7.7 хувь нь цар тахлаас үүдэж, бизнесийн үйл ажиллагаа тасалдаж, ажилчдаа цомхотгосон бол үлдсэн 92.3 хувь ажлын байраа хадгалж үлдсэн байна. Цомхотгол хийсэн ААН-ийн 91.4 хувь нь 1-9 ажиллагчидтай, 4.9 хувь нь 10-19 ажиллагчидтай, үлдсэн 3.7 хувь нь 20 болон түүнээс олон тооны ажиллагчидтай байв.

КОВИД-19 цар тахлын үед ажиллах хүчний оролцооны түвшин буурсан ба эргэж өсөхгүй байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 2019 онд 60.7 хувьтай байсан бол цар тахлын үед 54.9 хувьд хүртлээ буурч, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвх суларсан байна. 2021 оны хоёрдугаар улирлаас хойш ажиллах хүчний оролцооны түвшин өссөн хэдий ч 2022 оны төгсгөл гэхэд цар тахлын өмнөх түвшингээс 2.8 нэгж хувиар бага байна.

Зураг 4.9. Ажиллах хүчний оролцооны түвшин




Эх сурвалж: ҮСХ

Цар тахал дэгдсэнээс хойш 2021 оны 2-р улирлыг хүртэл 6 улирлын турш нийт ажилгүйдлийн түвшин өссөн ба 2022 оны 1-р улирлаас хойш буурах хандлагатай байна. Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин нийт ажилгүйдлийн түвшний өөрчлөлттэй ижил чиглэлд өөрчлөгдөж байсан буюу цар тахал дэгдсэнээс хойш 6 улирлын турш өсөж, түүнээс цааш буурах хандлагатай байна. Харин эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшний ерөнхий хандлага нийт ажилгүйдлийн түвшний хандлагатай нийцтэй хэдий ч улирлын нөлөөтэй байгаа нь ажиглагдаж байна. **Тодруулбал, эрэгтэйчүүд хүйтний улиралд**

ажилгүйдэлд өртөх магадлал эмэгтэйчүүдээс өндөр байна. 2021 оны 2-р улирлаас эхлэн Засгийн газар цар тахалтай холбоотой нийгэм, эдийн засгийн хязгаарлалтыг алгуур сулруулж, ажлыг байрыг дэмжих хүчин чармайлт гаргасны үр дүнд ажилгүйдлийн түвшин буурч, ажилчдын тоо нэмэгдэн, хөдөлмөрийн зах зээл цар тахлаас өмнөх төлөвтөө шилжихэд нөлөөлжээ.


Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө” баталж, хэрэгжүүлсний үр дүнд бичил, жижиг, дунд ААНБ-ууд ажлын байраа хадгалж үлдсэн байна. Эдийн засгийг сэргээхэд чиглэсэн энэхүү 10.0 их наядын хөтөлбөр хөдөлмөрийн зах зээлд хэрхэн нөлөөлснийг Дэлхийн банк симмуляцийн аргаар судалсан байна. Судалгааны үр дүнд Засгийн газраас уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 168,000-230,000 ажлын байрыг хадгалж үлдсэн байх магадлалтай гэжээ. Тодруулбал, Дэлхийн банк симмуляци хийхдээ улирлын шинжтэй ажлын байрыг тооцохгүйгээр болон тооцох замаар хоёр хувилбартай симмуляци хийсэн ба үр дүнг Зураг-4.10 болон Зураг-4.11-д тус тус харуулав. Зургаас харахад хөтөлбөр хэрэгжсэн бодит нөхцөл байдал (суурь) болон хөтөлбөр хэрэгжээгүй тохиолдолд үүсэх нөхцөл байдлыг харуулсан хоёр ялгаатай симмуляцийн үр дүнд дунджаар 225,000 ажлын байрыг хадгалж чадсан нь харагдана.

Зураг 4.10. Улирлын чанартай ажлын байрыг харгалзаагүй тохиолдолд нийт ажилчдын тоо, мянган хүнээр



Эх сурвалж: Дэлхийн банк, 2022 оны 4-р сар

Зураг 4.11. Улирлын чанартай ажлын байрыг харгалзсан тохиолдолд нийт ажилчдын тоо, мянган хүнээр



Эх сурвалж: Дэлхийн банк, 2022 оны 4-р сар



4.4. Өрхийн амьжиргаа, тогтвортой хэрэглээнд үзүүлсэн нөлөө

Ядуурлыг бууруулж, хүнсний аюулгүй байдлыг хангаж, хоол тэжээлийн чанарыг сайжруулах, өрхийн тогтвортой хэрэглээг хангахад КОВИД-19 цар тахал, геополитикийн зөрчилдөөнт байдал хэрхэн нөлөөлснийг энэ хэсэгт шинжилнэ.

КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн эхэн үед Засгийн газраас ААНБ-ыг дэмжих, ажлыг байрыг хадгалах бодлого, зохицуулалт хэрэгжүүлсний дүнд 2020 онд улсын хэмжээнд өрхийн цалингийн дундаж орлого буураагүй ч нийслэл, хөдөө, орон нутгаас хамаарч ялгаатай байна. **2020 онд нийслэлд амьдардаг өрхийн цалингийн орлого 2.3 хувиар буурсан байхад аймгийн төв, сумын төв, хөдөөд амьдардаг өрхүүдийн цалингийн дундаж орлого буураагүй байна. Харин бус, орон нутгаас хамаарахгүйгээр улсын хэмжээнд өрхийн мал аж ахуй, газар тариалан, мал аж ахуйн бус үйлдвэрлэлээс олох орлого буурсан байна.**

Өрхийн орлогод КОВИД-19 цар тахлын үзүүлсэн нөлөө салбаруудын хувьд ялгаатай ба өдрийн орлоготой, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд илүү хүчтэй нөлөө үзүүлсэн. КОВИД-19 цар тахлын үед албан бус хөдөлмөр эрхлэгчдийн долоо хоногийн дундаж ажлын цаг 6-7 цагаар буурчээ. Мөн ажиллагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийн ажлын цаг эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү буурсан байна. Эдийн засгийн салбар, хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажилтнууд, барилгын салбар дахь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, барилга, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын ажил олгогчид цар тахалд хамгийн их өртсөн байна.

Хамгийн бага хэрэглээтэй буюу хүн амын хамгийн ядуу 20 хувийн хэрэглээнд КОВИД-19 цар тахал онцгой нөлөө үзүүлсэн байна. 2020 онд өрхийн зардал дунджаар өсөж, ядуурлын түвшин, зарлагын тэгш бус байдал бага зэрэг буурсан байна. Хот, суурин газрын хүн амын өрхийн хэрэглээ ялангуяа хөл хорио тогтоосон хугацаанд буурсан бол, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспорт хязгаарлагдсанаас шалтгаалан хөдөө, орон нутгийн хүн амын өрхийн хэрэглээнд цар тахлын хямралын нөлөө оны эхний хагаст илүү ихээр нөлөөлсөн байна.


2020 оны 4-р сараас “Эдийн засгийг эрчимжүүлэх, өрхийн орлогыг хамгаалах бодлого буюу хүүхэд бүрд олгох мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлэх, хугацаа хэтэрсэн зээлийн төлөлтийг хойшлуулах зэрэг иргэдийн орлогыг хамгаалах, эдийн засгийг эрчимжүүлэх бодлогыг хэрэгжүүлснээр цар тахлын хямралаас улбаатай нийт хүн амын өрхийн хэрэглээ, ялангуяа хүн амын хамгийн ядуу 40 хувьд (зарлагаар нь тооцсон) учрах хүндрэлийг сааруулсан байна. (ҮСХ, Сангийн яам, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв, МУИС, НҮБХХ, 2021)

Инфляцын өсөлт нь **орлого багатай, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх болон хөгжлийн бэрхшээлтэй, тусгай халамж шаарддаг гишүүдтэй өрхүүдэд илүү дарамт болсон байна.** Ялангуяа, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд инфляцын дарамт 1-2 пунктээр илүү байна. ҮСХ,

Сангийн яам, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв, МУИС, НҮБХХ (2021)-өөс хийсэн судалгаагаар 2022 оны 6 дугаар сард хамгийн оргил буюу 16.1 хувьд хүрсэн инфляцын дийлэнх хэсгийг хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт тайлбарлаж байсан бөгөөд үнийн өсөлтөд орлого багатай бүлэг илүү их өртсөнийг тогтоосон байна. Түүнчлэн эмзэг бүлгийн өрхийн орлого өдөр тутмынхаа хэрэгцээг хангах боломжгүй байна. Өрхийг төрлөөр нь гурав ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эх, хүнсний талон авдаг өрх, өдөр тутмын хэрэгцээгээ хангах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй гишүүдтэй өрх гэж 3 ангилж үзэж болно. Өрхийн өдөр тутмын хэрэгцээгээ хангах боломжгүй орлоготой өрхийн дийлэнх нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байх нь илүү ажиглагдсан.


Цар тахлын үед Засгийн газраас хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулсан зардал 5 дахин нэмэгдэж өрх рүү хийж буй шилжүүлэг 64 хувиар өссөн байна. Өрхийн орлого нэмэгдсэнээр нь өрхийн хэрэглээг нэмэгдүүлж, эрэлт талаас эдийн засгийг дэмжиж цахилгаан, ус хангамж, боловсрол, эрүүл мэнд болон бусад үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлжээ. Монгол Улс хүүхдийн мөнгөн тэтгэмжийг анх 2005 онд өрхийн орлогыг дэмжих зорилгоор улсын төсвийн 2.1 хувьтай тэнцэх мөнгийг 350.0 мянган хүүхдэд сар бүр 3,000 төгрөгөөр олгож эхэлсэн. 2012 оноос сар бүр 20.0 мянган төгрөгийг олгож, 2020 онд цар тахлын үеийн хүндрэлээс шалтгаалан 100.0 мянган төгрөг болгон 5 дахин нэмэгдүүлсэн.

Зураг 4.12. Хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө (тэрбум төгрөг)



Эх сурвалж: ЭЗХЯ

Зураг 4.13. Өрхийн орлогын бүтэц (хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ



Хүүхдийн мөнгийг 100 мянган төгрөг болгож нэмэгдүүлснээр өрхийн орлого дунджаар 7.1 хувиар нэмэгдсэн бол бага орлоготой 20 хувийн өрхүүдийг орлого хамгийн ихээр буюу 26.3 хувиар нэмэгдсэн байна. Нийт өрхийн бага орлоготой 20 хувьд ЗГ-ийн шилжүүлгийн эзлэх хувь хамгийн өндөр буюу өрхийн орлогын 32.4 хувийг бүрдүүлж байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлснээр бага орлоготой өрхүүдийн орлогыг хамгаалахад хамгийн ихээр нөлөөлсөн байна гэж дүгнэж болохоор байна.

Мөн түүнчлэн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлснээр тэтгэмж авах хүүхдийн тоо жилээс жилд нэмэгдсэн байна.

4.5. Эрүүл мэндийн салбарт үзүүлсэн нөлөө

Тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэхэд бүх насны хүмүүсийн эрүүл амьдралыг хангах, сайн сайхан байдлыг дэмжих нь чухал юм. КОВИД-19 цар тахлын өмнө Монгол Улс хүн амын эрүүл мэндийг сайжруулахад томоохон ахиц, дэвшил гаргасан байна. 2015 онд хүн амын дундаж наслалт 69.89 байсан бол 2019 онд 70.41, 2021 онд 71.01 болж, нэмэгджээ. Энэ хэсэгт цар тахал болон геополитикийн зөрчилдөөнт байдал нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн гурав дахь зорилго буюу бүх нийтээрээ насан турш эрүүл энх, сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах зорилгын хэрэгжилтэд хэрхэн нөлөөлснийг шинжилнэ.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/306 тоот тушаалаар “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөө” батлагдсан ба цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч уг хариу арга хэмжээний төлөвлөгөөг байнга шинэчлэн, хэрэгжүүлжээ.

2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсад КОВИД-19 вируст халдварын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш альфа, бета, гамма, дельта зэрэг вирусийн олон хувилбар үүсэж, өвчлөгчдийн тоог нэмэгдүүлж байв. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2020 оны 1 дүгээр сард КОВИД-19 вируст халдвар дэлхий нийтэд тархсан талаар мэдээлсэн ба Монгол Улсад зөвөөрлөгдсөн анхны тохиолдол 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр, дотоодод халдвар тархсан анхны тохиолдол 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус бүртгэгдсэн. КОВИД-19 вирусийн альфа, бета, гамма, дельта, омикрон зэрэг хувилбарууд үүсэж, халдварын давлагаа урьдчилан таамаглах боломжгүйгээр өрнөж байсан нь эрүүл мэндийн салбарын суурь чадавч, гэнэтийн нөхцөл байдлыг даван туулах чадварыг сорьж, хүндрэл, бэрхшээл үүсгэж байлаа.

Архаг хууч өвчтэй, ахмад настай иргэд КОВИД-19 вируст халдвараар өвдөх, нас барах эрсдэлтэй байв. 2023 оны 4 дүгээр сарын 12-ны байдлаар Монгол Улсад КОВИД-19 вирусийн халдвартай нийт 1,007,943 тохиолдолд бүртгэгдсэн

нь нийт хүн амын 29.2 хувьтай тэнцэж байна. Өвдсөн иргэдийн 2136 нь нас барсан ба нас барсан иргэдийн 78.4 хувь (1,680) хүн архаг, суурь өвчтэй байгаагийн 75.4 хувь (1,267) зүрх судасны өвчтэй байжээ.

2020 онд халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо улсын хэмжээнд 26.2 хувиар буурсан байв. Харин 2020 оны сүүлээр КОВИД-19 вируст халдвар тархаж эхэлснээс, халдварт өвчлөлийн тоо эрс нэмэгдэж, 2020 онтой харьцуулахад 2021 онд 17.3 дахин нэмэгдсэн байна. Цар тахал хүн амын нягтрал ихтэй Улаанбаатар хот, төвийн бүс, хангайн бүсэд илүү ихээр тархжээ.

Хүснэгт 4.3. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо

Засаг захиргааны нэгж	2019	2020	2021
Улсын дүн	45,232	33,376	575,989
Баруун бүс	2,906	2,399	71,761
Хангайн бүс	6,769	4,826	93,057
Төвийн бүс	5,403	4,727	102,298
Зүүн бүс	3,707	2,565	49,611
Улаанбаатар	26,447	18,859	259,262

Эх сурвалж: УСХ

КОВИД-19 вируст халдвараар өвдсөн иргэний бие, сэтгэлтийн эрүүл мэнд харьцангуй дордсон байх магадлалтай байна. Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улсын их сургууль хамтран 2022 оны 2 дугаар сард хийсэн судалгааны үр дүнд уг вируст халдвараар өвдөж, эдгэрсэн иргэдэд бие махбод, булчин сулрах, мартаж, ядрах, уушги гэмтэх, сэтгэл гутралд орох шинж тэмдгүүд нийтлэг илэрч байгааг тогтоосон байна. (Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улсын их сургууль, 2022 оны 2 дугаар сар) Цаашид КОВИД-19 вируст халдварын оношилгоо, эмчилгээг хэрхэн явуулах нь олон нийтэд тодорхой биш, халдварын урт хугацааны үр дагаварт дэлхий нийтээр санаа зовж байгаа энэ үед нөхөн сэргээх эмчилгээ дутагдалтай байна.

Хүн амыг вакцинжуулалтад шуурхай хамруулсан нь иргэдийн амь насыг хамгаалах, бизнес, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааг хэвийн голдиролд хурдан хугацаанд эргэж ороход нөлөөлжээ. Монгол Улсын нийт хүн амын 65.7 хувь буюу 2,272,965 хүн КОВИД-19 вируст халдвараас сэргийлэх вакцинд хамрагдсан ба тэдгээрийн 95.7 хувь нь бүрэн тунд, 45.9 хувь эрчимжүүлсэн тунд хамрагдсан байна. Нийгэм, эдийн засгийн өндөр алдагдсан боломжийн өртөгтэй хөл хориог тогтоож, вируст халдвар дотоодод тархахыг удаан хугацаанд хязгаарлаж, хүн амыг шуурхай дархлаажуулсан нь КОВИД-19 цар тахлаас иргэдийнхээ амь насыг хамгаалахад үр өгөөжөө өгсөн байна. Гэхдээ вирусийн эсрэг дархлаажуулалт нь тухайн хүний биеийн онцлогоос хамаарч, ялгаатай хүндрэл гарах тохиолдол элбэг байгаа бөгөөд тэдгээрийг хянах, хүндрэл гарсан тохиолдолд хуульд заасан арга хэмжээ авах бэлтгэл хангагдаагүй байна.

Шигтгээ 4.2. КОВИД-19 вирус эсрэг дархлаажуулалтын үр нөлөө

КОВИД-19 вирус эсрэг дархлаажуулалт нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад үр өгөөжтэй ба зарим иргэдэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлээгүй хэдий ч зарим бүлгийн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн байна. Тодруулбал,

...Эрэгтэй, өндөр настан: Би вакцин хийлгэхээс өмнө явган аяллын тэмцээнд орж, уулын өөд руу алхдаг байсан. Вакцинжуулалтад хамрагдахыг өөрөө хүсээгүй хэдий ч нийгмийн халамжийн үйлчилгээгээ авахын тулд зайлшгүй хийлгэх шаардлага тавигдсан. Вакцинжуулалтад хамрагдсанаас хойш алхахад амьсгааддаг, зүрх өвддөг болсон ба сонсгол муудаж, маш их мартамахай болсон.

...Эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн: КОВИД-19 вирус эсрэг дархлаажуулалтад хамрагдсаны дараа бие байнга хямардаг болсон. Бид вакцины туршилтад орсон гэж бодож байна. Хүний биеийн онцлогоос хамаарч вакцины сөрөг нөлөө ялгаатай илэрч байна. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сөрөг нөлөө нь их байсан гэж би боддог. Дархлаажуулалтад хамрагдвал Засгийн газраас 50 мянган төгрөг өгнө гэсэн урамшууллын бодлогоор амьжиргааны түвшин доогуур иргэд биеийн онцлогоо харгалзахгүйгээр дархлаажуулалтад хамрагдаж, эрүүл мэндээрээ хохирч үлдсэн.

Эх сурвалж: ҮСДИ 2-ыг бэлтгэх хүрээнд хийгдсэн чанарын судалгааны үр дүнгээс

КОВИД-19 вируст халдвараар өвчлөгчдийн тоо нэмэгдэхийн зэрэгцээ уг вирусийн халдварт өвчтөн эмнэлэгт удаан хугацаагаар эмчлүүлж, эрүүл мэндийн байгууллагын ачааллыг нэмэгдүүлж байв. 2021 онд эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч гурван хүн тутмын нэг нь КОВИД-19 вируст халдвараар өвдсөн иргэд байсан ба тэдгээрийн хэвтэн эмчлүүлэх дундаж ор хоног 9.1 байсан нь бусад шалтгаанаар хэвтэн эмчлүүлсэн улсын дундаж үзүүлэлттэй харьцуулахад 1.8 хоногоор илүү байв. Иргэд олноор өвчлөх үед КОВИД-19 халдварт өвчтөн хүлээн авч, эмчлэх улсын эмнэлгийн ор хүрэлцээгүй болох үед Улсын онцгой комиссоос шуурхай арга хэмжээ авч, хувийн хэвшлийн эмнэлгүүдийг дайчлан, халдвартай бүсээс ирсэн иргэдийг тусгаарлах ажилд зочид буудал, сургууль, цэцэрлэгийн байр, дотуур байруудыг ашиглаж байлаа.


КОВИД-19 вируст халдвар авсан иргэдийг эмчлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнууд үүргээ сайн биелүүлсэн ба тэд ажлын ачаалал өндөртэй ажиллаж байв. Вируст халдварын дийлэнх тохиолдол Улаанбаатар хотод бүртгэгдэж байсан учир хүн хүчний дутагдалд орох эрсдэл байсан. Энэ үед орон нутгаас эмч нарыг дайчлахын зэрэгцээ үндсэн мэргэшлийн сургалтад суралцаж буй резидент эмч, тэтгэврийн насны эмч, эрүүл мэндийн ажилтан, анагаахын чиглэлийн их, дээд сургуулийн оюутныг шаардлагатай тохиолдолд татан оролцуулж байлаа.

Цар тахлын жилүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт зардал өссөн ба түүний дийлэнх хэсгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байв. Зураг 4.14-д 2019-2021 оны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс болон эрүүл мэндийн даатгалын сангаас гаргасан зардлын хэмжээг харуулав.

2019 онтой харьцуулахад улсын төсвөөс санхүүжүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал буурсан байхад эрүүл мэндийн даатгалын сангаас гаргасан зардал эрс өссөн байна. Тодруулбал, цар тахлын өмнө 2019 онд эрүүл мэндийн даатгалын сангаас 346.1

тэрбум төгрөгийн зардал гарч байсан бол 2020 онд 420.3 тэрбум төгрөг, 2021 онд 1199.5 тэрбум төгрөгийн зардал гаргажээ.

Зураг 4.14. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд гарсан зардал



Эх сурвалж: ҮСХ

4.6. Боловсролын салбарт үзүүлсэн нөлөө

Боловсрол бол нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, ядуурлаас ангижрах түлхүүр юм. Дэлхий нийтэд тархсан КОВИД-19 вируст халдварын тархалтаас сэргийлэх зорилгоор Монгол Улсын бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалтыг зогсоож, теле болон цахим хэлбэрийн зайн сургалтад шилжсэн нь тогтвортой хөгжлийн дөрөв дэх зорилго болох хүн бүр чанартай боловсролыг ижил тэгш, хүртээмжтэй эзэмших, насан турш сурч боловсрох боломжид хэрхэн нөлөөлснийг энэ хэсэгт шинжилнэ.

КОВИД-19 цар тахлын улмаас Боловсрол, шинжлэх ухааны яам 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс хойш бүх шатны боловсролын сургалтын байгууллагын танхимын сургалтын үйл ажиллагааг гурван удаа удаан хугацаагаар түр зогсоож, үндэсний хэмжээнд анх удаа бүх түвшний сургалтыг теле, цахим хэлбэрээр алсын зайн сургалтаар явуулсан байна. Энэ нь урьдчилан төлөвлөгдөөгүйгээс гадна удаан хугацаагаар үргэлжилсэн тул сургалтын хүртээмж, тэгш байдал, чанарт сөргөөр нөлөөлсөн байна. Зайн сургалтыг зохион байгуулахтай холбоотой бодлогын орчин сул, хууль, дүрэм, журам хангалтгүй байв. Эрсдэлээс сэргийлэх бэлэн



байдлыг хангасан бодлого байхгүй, шаардлага үүссэн нөхцөл бүрд тохируулсан бодлого, зааварчилгаа боловсруулах байдал голлож байв. Түүнчлэн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд гарсан ч түүний хэрэгжилтэд зориулсан төсөв дутагдалтай, хангалтгүй байжээ.

Боловсролын төсөвт зайны сургалттай холбоотой ямар нэгэн төсөв төлөвлөгддөггүй, хязгаарлагдмал байжээ. Үүссэн онцгой нөхцөл байдалтай уялдуулж, УОК, Засгийн газрын хуралдаанаар сургууль, боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоож, теле хичээл орж эхлэх шийдвэр гарснаар багш нарын нэмэгдэл цалин хөлс, хүүхдийн хоол, үдийн цайны зардал, боловсролын байгууллагын цахилгаан, цэвэр, бохир ус ашиглалттай холбоотой зардал, багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэх зэрэг төсөвлөгдсөн зардлуудыг хэмнэсэн ч, ангилал шилжүүлэх байдлаар санхүүжилтийг шийдвэрлэж ажилласан байна. Салбарын төсвийн дээрх зохицуулалтаас гадна хувийн хэвшил, олон улсын байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд сурагчдын хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх чиглэлд олон талын дэмжлэг, туслалцаа үзүүлж байсан нь салбарын яамны зардлын ачааллаас тодорхой хэмжээнд хуваалцсан байна. Гэхдээ эдгээр санхүүжилттэй холбоотой мэдээлэл нээлттэй бус байна.

КОВИД-19 цар тахлын үед Монгол Улс анх удаа танхимын сургалтыг урт хугацаагаар зогсоож, теле болон цахим хэлбэрээр зайнаас сургалт явуулсан нь сургалтын хүртээмжийг бууруулсан байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны хийсэн судалгаагаар 2020 оны 2-5 дугаар сард сурагчдын теле хичээлд хамрагдалтын улсын дундаж 74.7 хувь, аймгийн дундаж 75.0 хувь, сумын дундаж 69.5 хувь байв. 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс орон нутгийн ЕБС-ийн танхимын сургалтын үйл ажиллагаа эхлэхэд 47,478 хүүхэд хичээл, сургалтад хамрагдаагүй, 1,450 сурагч эцэг, эх, асран хамгаалагчийн хамт оторлож, сургуулиас хөндийрсөн байна.

Боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоосноос үүдэн хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын олон асуудлууд хөндөгдөж, хүүхдүүд хараа хяналтгүй, аюул эрсдэлд өртөх эрсдэл нэмэгджээ. БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран 2020 оны 3 дугаар сард хийсэн судалгаагаар 2-5 насны хүүхдүүдийн 17.1 хувь нь хоол тэжээлийн, 14.2 хувь нь хамгааллын, 25.8 хувь нь аюулгүй байдлын дунд болон өндөр эрсдэлтэй байна гэж тогтоогджээ.

КОВИД-19 цар тахлын хөл хорионы үед хүүхэд, өсвөр үеийнхэн нийгэм-сэтгэл зүйн таагүй байдалд байв. БШУЯ-наас хийсэн судалгаагаар сурагчдын нийгэм, сэтгэл зүйн байдал хэвийн түвшнээс доогуур, бага, дунд ангийн сурагчдын бухимдал хэвийн түвшнээс өндөр, ганцаардаж, уйтгарладаг, сурагчдын дийлэнх нь КОВИД-19 цар тахалд өртөх, сурлагаар

хоцрогдох, анги улирахаас айж, санаа зовниж байна. Сургууль, цэцэрлэг хаагдсанаас гадна бага насны хүүхэдтэйгээ олон нийтийн газраар зорчих, худалдаа, үйлчилгээний төвөөр хүүхэдтэйгээ үйлчлүүлэхийг хорьсон зэргээс хүүхдүүд нийгмийн олон үйл ажиллагаанаас тусгаарлагдаж, гэртээ хорио цээрийн нөхцөлд амьдарсан. КОВИД-19-ийн талаарх УОК, ЭМЯ-ны мэдээллүүд, цахим орчин дахь цуурхал, цахим хүчирхийлэл, таагүй мэдээллүүд, гэр бүлийнх нь орлогын бууралт, ядуурал, орчны архидалт, хүчирхийлэл зэрэг хүчин зүйлээс шалтгаалан хүүхэд, залуусын сэтгэл зүйн байдал таагүй байв.

КОВИД-19 тахлын дэгдэлтийн үед бүх шатны сургалтын үйл ажиллагаа алсын зайн хэлбэрт шилжсэнээр тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлсэн байна. Суралцагчдын ахуй амьдралын нөхцөл, хэлбэр, өрхийн амьжиргаа зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч зайн сургалтыг хүлээж авахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, дэд бүтцийн хүртээмж ялгаатай байсан нь зайн сургалтын тэгш бус байдлыг нэмэгдүүлэхэд хамгийн хүчтэй нөлөөлжээ. Мөн өрхөд байгаа цахим төхөөрөмжөөс хамаарч хүүхдүүдийн суралцаж буй байдал ялгаатай байв. Зурагтаар нэвтрүүлж буй боловсролын сургалт нь улс орон даяар түгээмэл хэлбэртэй байсан бол амьжиргааны түвшин доогуур, хөдөөгийн өрхүүдийн хүүхдүүд компьютер, таблет, ухаалаг утасны хэрэглээ харьцангуй багатай байв. Хөдөөгийн хүүхдүүдийн 21 хувь нь компьютер ашигласан байхад хотын хүүхдүүдийн 51 хувь нь компьютер ашигласан, хөдөөгийн хүүхдүүдийн 69 хувь нь ухаалаг утас ашиглаж сургалтад хамрагдсан байхад хотын хүүхдүүдийн 83 хувь нь ухаалаг утас ашигласан байна. (Дэлхийн банк, ҮСХ, 2020)

Түүнчлэн сум, багийн болон нийслэлийн гэр хорооллын өрхүүд цахилгаан эрчим хүчний чанар, интернэтийн найдвартай байдал сул учраас эдгээр байршилд амьдран сууж буй өрхийн хүүхдүүд зайн сургалтад хамрагдах боломж хамгийн бага байв. Тэдгээрийн дотроос малчин, төв сууринаас алслагдсан, орлогын түвшин доогуур болон эцэг, эхийн анхаарал халамж сул өрхийн хүүхдүүдэд теле хичээлийн хүртээмж хамгийн бага байна.

Харин их, дээд сургуульд суралцагчдын хувьд цахимаар суралцах дэд бүтцийн хүртээмж нь ЕБС-ын сурагчдынхаас илүү сайн байв. Тодруулбал, оюутан, суралцагчдын 80 хувь нь цахим сургалтыг хүлээн авах дэд бүтцээр хангагдсан бол ЕБС-ын сурагчдын 77 хувь нь дэд бүтцээр хангагдсан байжээ.

КОВИД-19 цар тахлын үед хэрэгжүүлсэн зайн сургалтын үр дүнд боловсролын чанар муудаж, суралцагчдын дийлэнх нь хичээлийн агуулгыг бүрэн эзэмшиж чадаагүй, хичээлээс хоцрогдсон байна. БШУЯ-аас 2021 оны 3 дугаар сард 1,140 багшаас асуулгын судалгаа авахад тэдний 92.5 хувь нь сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг 40-50 хувьтай гэж үзсэн байна.



Бага ангийн унших ба математикийн чадварын үнэлгээний урьдчилсан дүнгээр 1-2 дугаар ангийн сурагчдын унших даалгаврын биелэлт 50 хувь, ойлгож унших түвшин 27 хувь, математикийн чадвар 56.6 хувьтай байна. Монгол Улсын БШУ-ны сайдын 2021 оны 5 дугаар сарын 21-ний тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө боловсруулан, 2021-2023 оны хооронд хэрэгжүүлэн ажиллаж байна.

КОВИД-19 цар тахлын үед гадаад улсаас эх орондоо шилжин ирсэн өрхийн тоо нэмэгдсэн ба үүнийг дагаад гадаадаас ирсэн монгол хэлээ сайн мэдэхгүй сурагчдын тоо нэмэгдсэн байна.

КОВИД-19 цар тахлын үед багш нарын ажлын ачаалал нэмэгджээ. Багш нарын хичээлээ бэлтгэн танхимд заадаг гол үүрэг нь цахим хичээлээр телехичээлийг бататган заах, даалгавар шалгах үүргээр солигдож, үүн дээр сурагчидтай холбогдох, эцэг, эх, асран хамгаалагчидтай харилцах, удирдлагад ажлаа тайлагнах нь үндсэн ажил үүргийн нэг болжээ.

Цахим талбар ашиглах чадвар, хэрэглээ нэмэгдсэн байна. Бүх түвшний сургалтад оролцогчдын дийлэнх нь зайн сургалтад оролцож байгаагүй, туршлагагүй, цахим техник, технологи ашиглах чадвар сул байв. БШУЯ-наас хийсэн

судалгаагаар зайн сургалтын эхэн үед багш нарын 73.3 хувь нь өмнө нь зайны сургалтаар хичээл зааж байгаагүй, 75.2 хувь нь зайны сургалтад хэрхэн хичээл заах талаар сургалтад хамрагдаж байгаагүй, 20 хувь нь цахим хэрэгсэл хэрхэн ашиглах талаар мэдэхгүй, 2.8 хувь нь цахим орчны платформ хангалттай ашиглаж мэдэхгүй байжээ. Харин сургалтын төгсгөлд тэд цахим орчинд ажиллах, цахим хичээл заахад шаардлагатай хэрэгсэлтэй ажиллах, харилцаа холбооны шинэ арга хэрэгсэлтэй ажиллах чадваруудад шинээр суралцсан, тэр дундаа хичээл заах арга барилдаа өөрчлөлт оруулсан гэх үзүүлэлт өссөн байна.

4.7. Монгол Улсын дэд бүтцийн салбарт үзүүлсэн нөлөө

4.7.1 Эрчим хүчний салбарт үзүүлсэн нөлөө (ТХЗ 7)

Хүн амын өсөлт, эдийн засгийн хөгжил, хотжилт зэрэгтэй холбоотойгоор эрчим хүч, цахилгаан, дулааны хэрэгцээ жилд дунджаар 5-7 хувиар нэмэгдэж байна (Хүснэгт 4.2). Уул уурхай зэрэг аж үйлдвэрийн салбарууд манай улсын эрчим хүчийг хамгийн ихээр ашигладаг. Гэвч Монгол Улс одоогоор хэрэгцээгээ хангахуйц эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалгүйгээс ОХУ, мөн БНХАУ-аас эрчим хүч импортлодог.

Хүснэгт 4.4. Монгол Улсын 2017-2021 оны эрчим хүчний үйлдвэрлэлийн динамик

	2017	2018	2019	2020	2021
Нэгдсэн дулааны, цахилгаан станц	5,826.9	6,152.4	6,346.6	6,493.6	7,109.6
Дизель станц	3.7	3.7	3.0	2.7	1.1
Нарны эрчим хүч	19.7	51.5	109.0	108.9	156.9
Усан цахилгаан станц	84.5	78.2	85.4	83.3	83.1
Салхин цахилгаан станц	154.4	339.0	459.3	457.2	563.0
Нийт үйлдвэрлэлт	6,089.1	6,624.8	7,003.3	7,145.7	7,913.6
Импорт	1,522.5	1,683.6	1,715.8	1,705.6	1,861.8

Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо: Эрчим хүчний гүйцэтгэлийн статистик мэдээ. 2021.

КОВИД-19 цар тахал болон Орос-Украины зөрчилдөөний дараалсан цочрол нь Монгол Улсын эрчим хүчний салбарыг улам эмзэг болгож байна. **Хятадын “Тэг-КОВИД” бодлоготой холбоотой хилийн хязгаарлалтын улмаас ДЦС-уудын засвар үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж тээвэрлэлт, логистикийн хүндрэлээс үүдэн 3-6 сар хил дээр гацсан, үндсэн, туслах тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, үйлчилгээний аюулгүйн нөөцөд шаардлагатай сэлбэг материалын хомсдол үүссэн.** Олон ханган нийлүүлэгчид нийлүүлэлтийн гэрээгээ сунгах хүсэлт гаргаж, зарим тохиолдолд үнийн өсөлт, валютын ханшийн уналтаас болж гэрээг цуцалсан байна.

Цахилгаан, нефтийн бүтээгдэхүүний импорт SWIFT хориг арга хэмжээ авснаар хумигдсан. Манай улс цахилгааны 25 хувь, нефтийн бүтээгдэхүүний 90 хувийг ОХУ-аас импортлож байна. Багануур, Шивээ-Овоо,

Шарын-Гол зэрэг нүүрсний уурхайн үндсэн үйл ажиллагаанд ашигладаг дизель түлш, мазут, тэсэлгээний материал зэрэг **түүхий эдийн үнэ нэмэгдсэний улмаас уурхайнуудад мөнгөн урсгал хомсдож, улмаар үйл ажиллагаа нь удааширсан.**

Эрчим хүчний эрэлт нэмэгдсэн нь цахилгаан түгээх сүлжээний төхөөрөмжид гэмтэл учруулсан. КОВИД-19 цар тахлын үед Засгийн газраас хэрэгжүүлсэн тусламжийн хүрээнд өрх, зарим ААН-ийг цахилгаан, дулаан, ус, хог хаягдлын төлбөрөөс 7 сарын хугацаанд чөлөөлөх арга хэмжээ авсан нь гэр хорооллын цахилгааны хэрэглээг 40 хувиар нэмэгдүүлсэн. Цахилгаан халаагуурыг хэтрүүлэн хэрэглэснээс бага, дунд оврын цахилгаан түгээх сүлжээний тоног төхөөрөмж оргил ачаалалдаа хүрч, зарим нь эвдэрсэн байна. Цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлтийг ОХУ-аас импортоор нөхөж, цахилгаан дамжуулах шугамын хүчин чадлыг 2022 оны 7 дугаар сард 245 МВт-аас 350 МВт болгон



нэмэгдүүлсэн.

Нийлүүлэлт, тээврийн системийн тасалдал нь эрчим хүчний системийн байнгын засвар үйлчилгээ тасалдахад хүргэсэн. ДЦС-уудын үндсэн болон туслах тоног төхөөрөмжийн материал, сэлбэг хэрэгсэл нь ОХУ, Украин Улсаас ихээхэн хамааралтай байдаг. Эдгээр улсаас нийлүүлдэг том оврын цахилгаан шахуурга, өндөр даралтын хавхлагууд тасалдсан. Мөн ДЦС, дамжуулах, түгээх компаниудын техникийн тогтмол хийх үзлэг, засвар үйлчилгээний ажил удааширч, техникийн гэмтэл, эвдрэлийг ихээхэн нэмэгдүүлсэн юм.

4.7.2 Тээврийн салбарт үзүүлсэн нөлөө

Далайд гарцгүй хөгжиж буй орнуудад тулгарч буй олон улсын зах зээлээс алслагдсан байдал, далайн боомтоос хол зайтай, дамжин өнгөрөх тээврийн асуудал, олон улсын худалдаанд хөрш зэргэлдээ улс орнуудад найдах, худалдааны өндөр зардал, олон улсын худалдаанаас ихээхэн хамааралтай зэрэг өвөрмөц сорилтууд ялангуяа цар тахлын жилүүдэд болон үргэлжилж буй геополитикийн хурцадмал байдлын үед Монголд хүчтэй мэдрэгдэж байсан.

Хятад Улс нь далайд гарцгүй Монгол улсын хувьд дамжин өнгөрөх тээврийн гол зангилаа болж, худалдааны эргэлтийн дийлэнхийг бүрдүүлж бусад улстай худалдаа хийх боломжийг олгодог. Гэсэн хэдий ч КОВИД-19 цар тахлын хязгаарлалт нь ялангуяа Тяньжин, Далянь боомт, Хятад-Монголын хил дээрх Эрээн хотын хуурай замын боомтод удаан хугацаагаар нөлөөлж, тээврийн түгжрэл үүсгэсэн. Нийлүүлэлтийн сүлжээ тасалдсан нь Монгол Улсын худалдааны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн. 2021 онд хоёр улс Монголын нүүрс, зэсийн баяжмалын Хятад руу чиглэсэн хил дамнасан экспортыг нэмэгдүүлэх зорилгоор ачааны машины жолооч

нарт хорио цээрийн дэглэм тогтоох, Ковид-19-ийн шинжилгээнд хамруулах тусгай журмыг хэлэлцсэн. Энэхүү хоёр талын хамтын ажиллагааны үр дүн нь 2022 онд Монголоос Хятад руу хийх экспорт 30 хувиар өсөхөд нөлөөлсөн.

Монгол Улс, БНХАУ-ын Гадаад хэргийн яамд БНХАУ-аас хүнсний бүтээгдэхүүн, эм тариа, барилгын материал, тоног төхөөрөмж зэрэг нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тасралтгүй импортлох талаар нягт хамтран ажилласан. Ингэхийн тулд Монгол Улсын Гадаад харилцааны яам БНХАУ-аас импортлох тэргүүлэх ач холбогдол бүхий бүтээгдэхүүний жагсаалтыг гаргаж, импортыг хөнгөвчлөхийг хүссэн ноот бичгийг БНХАУ-ын гадаад хэргийн яаманд хүргүүлсэн. Энэхүү хамтын ажиллагааны механизмын үр дүнд 2021-2022 онд 15,000 гаруй вагон бараа бүтээгдэхүүн импортлох боломжтой болсон байна. Хятад улс 2023 онд КОВИД-19-ийн хязгаарлалтыг цуцлах шийдвэр гаргасан нь хоёр талын худалдааны эргэлтийг цар тахлын өмнөх түвшинд хүртэл нэмэгдүүлж байна.

Улсын төсөвт ихээхэн хувь нэмэр оруулдаг Монгол Улсын иргэний агаарын салбарт Орос-Украины зөрчилдөөн ихээхэн нөлөөлсөн. Үүний дүнд Монгол Улс Европоос эм, хүнс зэрэг зайлшгүй шаардлагатай бараа бүтээгдэхүүн импортлохоо зогсоож, мөн агаарын тээвэр, ачааны үнэ гурав дахин нэмэгдэж, эдийн засгийг хүндрүүлж байна.

Засгийн газар дижитал өөрчлөлтийг эдийн засгийн тогтвортой өөрчлөлт болон сэргэлтийг идэвхжүүлэгч гэж үзэж байна. Монгол Улсын Засгийн газар авлигатай тэмцэж, төрийн хэт хяналт, хүнд суртлыг бууруулах замаар бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, чөлөөт зах зээлд өрсөлдөх чадварыг дэмжих зорилт тавин ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Засгийн газраас бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор “И-Бизнес” цахим платформыг ашиглалтад оруулаад байна.



БҮЛЭГ 5.

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ХЯЗГААРЛАГЧ ХҮЧИН ЗҮЙЛ: БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ**



5.1. Бүс, орон нутаг руу чиглэсэн хөгжлийн бодлого, төлөвлөлт

"Алсын хараа–2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 8 дугаар бүлэг болох "Бүс, орон нутгийн хөгжил" бүлэгт "Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ" гэсэн зорилгыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд дэд бүтэц, аялал жуулчлал, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжихэд чиглэсэн дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Бүс нутгийн эдийн засгийн интеграцид дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ;
2. Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ;
3. Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.

Дунд хугацааны зорилтот хөтөлбөр болох "Шинэ сэргэлтийн бодлого" нь хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг шийдвэрлэхэд чиглэсэн 6 сэргэлтээс бүрдэх бөгөөд түүний нэг нь Хот, хөдөөгийн сэргэлт бөгөөд дараах зорилтуудаас бүрдэнэ. Үүнд:

1. Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулан багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлж, гол ба үндсэн авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчилж, олон түвшний уулзварыг байгуулан хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын түгжрэлийг бууруулна;
2. Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна;
3. Аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлнэ;
4. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн

бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

Хэдийгээр урт, дунд хугацааны бодлогуудад бүс, орон нутгийн хөгжилтэй холбоотой бодлогын зорилт, арга хэмжээг агуулгын хувьд тодорхойлсон хэдий ч эдгээр нь орон зайн төлөвлөлтийн хувьд тодорхой бүс байгаа нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрэлцээтэй нөхцөл болж чадахгүй байна.

"Алсын хараа–2050" урт хугацааны хөгжлийн бодлогыг орон зайн хувьд хэрэгжүүлэх, салбар дундын бодлого, төлөвлөлтийг нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, байршлын хувьд уялдуулсан хөгжлийн орон зайн төлөвлөлт байхгүй байна.

Үүнийг түлхүүр асуултаар илэрхийлбэл,

1. Улаанбаатар (нийслэл) хот руу чиглэсэн төвлөрлийг сааруулах, бүс, орон нутгийн түвшинд Улаанбаатар хотын эсрэг татах хүчийг нөхцөлдүүлэх, нийгэм, эдийн засаг, экологи, дэд бүтцийн үйлчилгээний ачааллыг өөртөө хуваалцах, нийгэм, эдийн засгийн хөгжилд үүрэг бүхий өсөлтийн төв хот нь хаана байх вэ? Үндэсний хэмжээнд хотын зэрэглэл, статус, үүргийн тогтолцоо бий юу?
2. Хойд, урд хөрш орнууд, өрнө-дорныг холбосон тээврийн дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэгийн газарзүйн маршрут, түүнд суурилсан зам, тээвэр, логистик, хилийн боомт, чөлөөт бүсийн нэгдсэн сүлжээ ямар байх, тэдгээрийн гол зангилаа цэг, байршлыг хаана төлөвлөх вэ?
3. Аль хот, бүс нутагт хэдий хэмжээний хүн ам түлхүү суурьшуулж, улмаар байгалийн болон хөдөө аж ахуйн нөөц, боломжид тулгуурлан ямар үйлдвэрлэл, кластерыг хаана хөгжүүлэх вэ?
4. Хүнс, хөнгөн, боловсруулах аж үйлдвэр, аялал жуулчлалыг газарзүйн байршлын хувьд хаана хөгжүүлж, улмаар бүс, орон нутгийн түвшинд уул уурхайн бус экспортын хэмжээг хэрхэн нэмэгдүүлэх вэ?
5. Улмаар газарзүйн байршлын давуу талаа ашиглан Төв Азийн болон Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн интеграци, олон улсын тээврийн сүлжээ, худалдаанд ямар бүтээгдэхүүн, үйлдвэрлэлээр нэгдэх вэ?
6. Дээрх асуудлууд нь нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтын хувьд өөр хоорондоо хэрхэн уялдаж, эдийн засаг-дэд бүтцийн газарзүйн кластер холболтыг хэрхэн нөхцөлдүүлэх вэ?

зэрэг хөгжлийн орон зайн төлөвлөлттэй холбоотой асуудлууд тодорхой бус байна.



5.2. Бүс, орон нутгийн хөгжилд саад болж буй түлхүүр асуудлууд

Монгол Улс хүн ам цөөн, газар нутаг том, байгалийн болон хөдөө аж ахуйн арвин нөөц баялагтай, далайд гарцгүй ч газарзүйн байршлын давуу тал, боломжоо ашиглан нутаг дэвсгэрээ бүсчлэн хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн орон зайн төлөвлөлтийн суурь үзэл баримтлалаа шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, бүс-хот-хөдөөгийн зохистой тогтолцоог бүрдүүлж, улмаар олон улсын бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх, хөрш орнуудын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны гүүр болох, эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдээ дэмжих, өсөлтийн төвүүдийн үүргийг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

Бүс нутаг, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даасан, тэнцвэртэй тогтолцоог бүрдүүлж, улмаар гадаад зах зээлтэй холбож, үндэсний болон бүс нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх нь үндэсний аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд чухал хүчин зүйл юм.

Бүс, орон нутгийн түвшинд тулгамдсан асуудал, уялдаа, шийдлийг дараах 4 хүчин зүйлээр авч үзлээ. Үүнд:

1. Нийгэм, эдийн засаг, байгаль орчны болон Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулахад тулгамдаж буй асуудлууд;
2. Бүс, орон нутгийн хөгжилд саад учруулж буй салбар дундын шинжтэй, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий бодлогын түлхүүр асуудлууд;
3. Түлхүүр асуудлуудын ТХЗ-ын хэрэгжилтэд үзүүлж буй бэрхшээл, тэдгээрийн холбоос;
4. Бүс, орон нутгийн түвшний хөгжлийн шийдэл, тэдгээрийн учир шалтгаан, гинжин холбоог харуулсан Систем зураглал.

Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд саад учруулж буй бүс, орон нутгийн хөгжлийн тулгамдсан 37 асуудлыг тодорхойлж, тэдгээрээс салбар дундын шинжтэй, уялдаа холбоо бүхий системтэй шийдэл шаардагдах бодлогын зангилаа 8 түлхүүр асуудлыг дараах байдлаар авч үзлээ. Үүнд:

1. Нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгаа нэмэгдэж, орон нутагт сонголт - боломж хомс байна.
2. Хөдөө, орон нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, үндэсний түвшинд хотжих үйл явц зөвхөн Улаанбаатар хотод явагдаж байна.
3. Эрхзүй, эдийн засгийн чадамжгүй орон нутгийн хотууд, тэдгээрийн хөгжилд гүйцэтгэх үүрэг тодорхой бус байна.
4. Тээврийн дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэг, түүнд суурилсан боомт, чөлөөт бүс, логистикийн нэгдсэн сүлжээ бүрдээгүй, энэ тухайд баримтлах бодлого,

төлөвлөлт тодорхой бус байна.

5. Бүсчлэн хөгжүүлэх бодлого, хууль эрхзүй, институцийн тогтолцоо бүрдээгүй.
6. Хөдөө орон нутагт ажлын байрны хомсдол бий болсон. Орон нутагт хүн ам, аж ахуйн нэгж байгууллага шилжин суурьших, хөрөнгө оруулалтыг татах механизм, арга хэрэгсэл тодорхой бус байна. Тухайлбал, буцах шилжилт хөдөлгөөнийг дэмжих механизм тодорхойгүй.
7. Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих хүнсний болон боловсруулах аж үйлдвэрийн бодлого тодорхой бус байна.
8. Уур амьсгалын өөрчлөлтөд мал аж ахуйн салбарын дасан зохицох, эрсдэлийг даван туулах чадавх сул, өртөмтгий байна.

Дээрх бодлогын зангилаа 8 түлхүүр асуудал нь "орц"-ын хувьд өөртөө хамгийн их (14) нөлөөлөл авч, бүсийн түвшинд гол зангилаа асуудал болж байгаа нь "Бүсчлэн хөгжүүлэх бодлого, хууль эрхзүй, институцийн тогтолцоо бүрдээгүй" байдал, (13) "Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих хүнсний болон боловсруулах аж үйлдвэрийн бодлого тодорхой бус" байдал, (11) "Нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгаа нэмэгдэж, орон нутагт сонголт - боломж хомс" гэх асуудлууд байна.

Тогтвортой хөгжлийн бодлогод үзүүлж буй нөлөөллийг нь зорилгын түвшинд авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Тогтвортой хөгжлийн 1 дүгээр зорилгыг хэрэгжүүлэхэд **6** түлхүүр асуудал;
- Тогтвортой хөгжлийн 11 дүгээр зорилгыг хэрэгжүүлэхэд **6** түлхүүр асуудал;
- Тогтвортой хөгжлийн 8 дугаар зорилгыг хэрэгжүүлэхэд **5** түлхүүр асуудал;
- Тогтвортой хөгжлийн 9 дүгээр зорилгыг хэрэгжүүлэхэд **5** түлхүүр асуудал;
- Тогтвортой хөгжлийн 3 дугаар зорилгыг хэрэгжүүлэхэд **4** түлхүүр асуудал;
- Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгыг хэрэгжүүлэхэд **4** түлхүүр асуудал;
- Тогтвортой хөгжлийн 13 дугаар зорилгыг хэрэгжүүлэхэд **4** түлхүүр асуудал;
- Тогтвортой хөгжлийн 6 дугаар зорилгыг хэрэгжүүлэхэд **3** түлхүүр асуудал тус тус бэрхшээл үүсгэж байна.





Бүс, орон нутаг, хөдөөгийн тулгамдсан асуудал, ТХЗ-д үзүүлэх нөлөө



1. Хөдөөгийн ядуурал их, 3 хүн тутмын 1 нь ядуу
2. Улаанбаатар хотод ядуу хүн ам улам ихээр шилжин төвлөрч байна



3. Хөдөөд өрхийн амьжиргааны түвшин, орлого бага байна
4. Хөдөөгийн малчин өрх илүү эмзэг байна
5. Малчин өрхийн, ялангуяа хөдөөгийн ядуу өрхийн хүүхдүүд илүү эмзэг, өртөмтгий байна



6. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй
7. Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн, төрөлжсөн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй
8. Хөдөөгийн иргэд, хүүхэд эрүүл мэндийн үйлчилгээнээс алслагдсан
9. Эрүүл мэндийн ажилчдын хүний нөөц дутагдал
10. Хөдөөгийн малчид эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалт хангалтгүй



11. Ерөнхий боловсролын сургуулийн чанар, хүртээмж хангалтгүй
12. ЕБС-ын дотуур байрны амьдар орчин, нөхцөл хангалтгүй (цэвэр ус, дулаан, ариун цэврийн өрөө)
13. Хөдөөд ЕБ-н ердийн сургалттай сургууль байгаад, харин төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, лаборатори, тусгай, ОУ-ын хөтөлбөрийн сургалттай ЕБС-ын сонголт байхгүй



14. Дээд боловсролын үйлчилгээний хүртээмж, сонголт байхгүй
15. Усны нөөцийн хомстол, цас, мөсний хайлалт нэмэгдэж байна
16. Баталгаат ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын тоо хангалтгүй
17. Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоо хангалтгүй



18. Хөдөө орон нутаг дахь ажлын байрны хомсдол
19. Шинжлэх ухаан, технологи, инновацын орчин, тогтолцоо бүрдээгүй
20. Хөдөө нутагт, ХАА-н салбарт инновац, технологи дамжуулах, нутагшуулах, хөрөнгө оруулалт бага



21. Мал, малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл, боломж, дэд бүтэц бүрдээгүй
22. Малчдын мах, ноолуурын орлого улирлын шинжтэй, бусад дагалдах түүхий эд (арьс шир, ноос, гэдэс дотор г.м) үнэгүйдэж байна
23. Малчин, орон нутгийн тариаланчдын хөдөлмөрийн бүтээмжийн үнэлэмж тодорхой бус, бага




24. Мал, малын гаралтай бүтээгдэхүүн эдийн засгийн эргэлтэд орж чадахгүй байгаа тул малчид малынхаа тоо толгойг өсгөх сонирхолтой -> бэлчээрийн доройтлыг нөхцөлдүүлж байна
25. Малчин өрхүүд үйлдвэр, дэд бүтэц, эдийн засаг, зах зээлээс алслагдсан
26. Экспортыг нэмэгдүүлэх хүнсний болон боловсруулах аж үйлдвэр хөгжөөгүй
27. Дотоодын хэрэгцээг хангах хүнс, хөнгөн аж үйлдвэрийг хөгжил сул



28. Зам, тээвэр, логикийн дэд бүтэц хөгжөөгүй
29. Хотжилтын эрчим УБ хотод хамгийн их явагдаж, орон нутгийн хотууд явагдахгүй байна
30. Орон нутгийн хотуудын зэрэглэл, статус, бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг тодорхойгүй
31. Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, хот, хөдөө нутгийг хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, эрхзүйн тогтолцоо бүрдээгүй
32. Залуу, туслах малчид тогтвортой суурьшихгүй, шилжин нүүж байна. Тэдгээрт зориулсан хөгжлийн хөтөлбөр байхгүй
33. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт үзэгдэл, ган, зуд, хуурайшлын эрчим нэмэгдэж байна
34. Цөлжилт, бэлчээрийн доройтол, талхагдал нэмэгдэж байна
35. Хөдөөгийн малчин өрхийн амьжиргааны үндсэн эх үүсвэр мал аж ахуй бөгөөд байгаль, цаг уураас хараат, өртөмтгий
36. Мал аж ахуйн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхи бүрдээгүй байна
37. Ядуу, орлого бага малчин өрхүүд уур амьсгалын өөрчлөлтөд илүү эмзэг, өртөмтгий

Бүс, орон нутгийн хөгжилд саг түлхүүр асуудлууд (салбар дун бүхий бодлогын зангилаа)






Зураг 5.1. Систем зураглал: Бүс, орон нутгийн хөгжил ба төвлөрөл, тулгамдсан асуудал, саад бэрхшээл, гарц шийдэл, тэдгээрийн учир шалтгаан, холбоо

эд учруулж буй
дын, уялдаа холбоо
асуудал)

ТХЗ-ыг амжилттай
хэрэгжүүлэхэд бэрхшээл
үүсгэж байна

Гарц, шийдэл: Бүс, орон нутгийг
хөгжүүлэх бодлогын шийдэл, арга зам





Дээр дурдсан бүс, орон нутгийн хөгжилд саад учруулж буй бодлогын зангилаа 8 түлхүүр асуудлын тухай нарийвчлан авч үзье.

Нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгаа нэмэгдэж, хөдөө, орон нутагт сонголт хийх боломж хомс байна. Хүний хөгжлийн үндсэн үзэл санаа нь хүмүүст эдийн засгийн, нийгмийн, улс төрийн болон соёлын гэх мэт сонголтуудыг өргөжүүлэх үйл явц, нөгөө талаас сонголт хийх өргөн боломжоор хангах явдал юм. Сонголт нь хувь хүний чадавхтай холбоотой бөгөөд, энэ хүрээнд хувь хүн сайн боловсрол эзэмших, ур чадвараа нэмэгдүүлэх, эрүүл мэнд, соёлын үйлчилгээ авах, хөдөлмөр эрхэлж орлогоо нэмэгдүүлэх, таатай орчин нөхцөлд ажиллаж, амьдах асуудал юм. Харин сонголт хийх өргөн боломжийг бий болгох нь төрийн үүрэг бөгөөд энэ хүрээнд нийгмийн үйлчилгээ (боловсрол, эрүүл мэнд, соёл)-ний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх замаар хувь хүн эрхзүй, эдийн засаг, бизнесийн орчны хувьд өөрийн чадавхад нийцсэн сонголт хийх өргөн боломж бүхий нийгэм, эдийн засгийн таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Хүн орон зайн хувьд Улаанбаатар, бусад хот, аймаг, сум, хөдөө хаана ч суурьшсан эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Орон зайн хувьд хаана энэхүү эрхээ бүрэн дүүрэн эдлэх таатай орчин нөхцөл бүрдсэнийг шинжилж үзвэл үндсэндээ Улаанбаатар хотод л ихэнх сонголт-

боломж төвлөрсөн байна.

Эсрэгээрээ хөдөө орон нутаг, аймаг, суманд хүн нийгэм, эдийн засгийн аятай таатай орчинд ажиллаж амьдах сонголт-боломж хомс байна. Тухайлбал, боловсролын хувьд Улаанбаатар хот болон 21 аймгийн төв хотуудаас бусад бүх 309 сумдад төрөлжсөн лаборатори, гүнзгийрүүлсэн, тусгай, олон улсын хөтөлбөрийн сургалттай ЕБС-ийн сонголт байхгүй байна. Дээд боловсролын хүртээмжтэй үйлчилгээний сонголт зөвхөн Улаанбаатар хотод байгаа бөгөөд бусад 21 аймгийн төв хотууд хүртээмжтэй сонголт хийх боломж байхгүй байна.

Монгол орны нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгаа өнгөрсөн 30 жилд нэмэгдэж, Улаанбаатар хот болон хөдөө орон нутаг, аймаг, сумын нийгмийн хөгжлийн ялгаа нэмэгдсэнийг харуулна. Жишээ нь, өрхийн түвшинд шилжин суурьших сонголт хийх, өрсөлдөхүйц боловсрол эзэмшье гэвэл, өрхийн бүх гишүүд эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлье гэвэл, орчин цагийн соёлын үйлчилгээ бүхий хотод амьдаръя гэвэл зөвхөн Улаанбаатар хотыг сонгож байна. Монгол орны хүн амыг нутагшилт, суурьшлын хувьд авч үзвэл хотын суурьшил, сумын төвийн хагас суурьшил, хөдөө нутгийн нутагшилтын хэлбэр гэж 3 ангилж болно. Нийт хүн амын 69 хувь нь Улаанбаатар хот болон 21 аймгийн төв хот суурин газарт, 11 хувь нь хагас суурьшлын хэлбэр бүхий 309 сумын төвд, 20 хувь нь хөдөө нутагт уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн хөдөлмөр эрхлэн нутагшин амьдарч байна. Хөдөөгийн малчин өрхийн орлогын бүтцийг авч үзвэл, 49.2% малын мах, 41.9% ноос, ноолуур, 2.4% арьс шир, 6.5% бусад орлогоос бүрдэж байна.


Зураг 5.2. Хүн амын нутагшил, суурьшил ба амьдралын хэв шинж



Эх сурвалж: ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн. 2022. "Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний орон зайн зүй тогтол, нөлөөлөх хүчин зүйлс (2022-2024)" суурь судалгааны төсөл. УБ.



Зураг 5.3. Хүн амын өөрчлөлтийн орон зайн тархалт, хот, сумын төв, хөдөө нутгийн суурьшлын хэлбэрээр, 1995-2000, 2000-2010, 2010-2020 оноор



Хүснэгт 5.1. Хүн амын тооны өөрчлөлтийн газарзүйн ялгаа (Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тооны өөрчлөлтийн суурьшлын хэлбэрээр хийсэн дүн шинжилгээ, 1995-2020.

№	Хүн амын тооны өөрчлөлт, суурьшлын хэлбэрээр	1995-2000	2000-2010	2010-2020
Хот /нийслэл, аймгийн төв/				
1	Буурсан	14	6	0
2	Хэвийн өссөн	3	5	13
3	Механик өссөн	5	11	9
4	Нийт	22	22	22
Сумын төв				
5	Буурсан	146	229	162
6	Хэвийн өссөн	28	41	93
7	Механик өссөн	135	39	54
8	НИЙТ	309	309	309
Хөдөө нутаг				
9	Буурсан	118	187	74
10	Хэвийн өссөн	34	55	166
11	Механик өссөн	157	67	69
	НИЙТ	309	309	309

Эх сурвалж: ҮСХ, Зургийг ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнд боловсруулав.

Монгол Улсад оршин суугаа хүн амын тооны өөрчлөлтийг суурьшлын хэлбэрээр (нийслэл, аймгийн төв, сумын төв, хөдөө) харьцуулан үзэхэд 2000-2010 онд (1999-2002 болон 2009-2010 оны ган, зудыг хамарсан үед) хөдөө нутаг болон сумын төвийн хүн амын тоо илүү буурсан бөгөөд, сүүлийн 25 жилийн хугацаанд хөдөөгийн болон сумын төвийн хүн ам хамгийн тогтвортой бус суурьшилтай байна. Тодруулбал, 2000-2010 онд 187 сумын “хөдөөгийн” хүн ам болон 229 сумын “төвийн” хүн амын тоо буурсан нь энэ 10 жилд төв, томоохон хотууд руу хүн ам шилжсэн оргил үе байсныг илтгэж байна.

Хөдөө орон нутагт шилжих хөдөлгөөний “түлхэх хүчин зүйлс” давамгайлж, Улаанбаатар хотод дээд боловсрол, эрүүл мэнд, соёл, ажлын байр зэрэг “татах хүчин зүйлс” төвлөрч, улмаар нийслэл хот руу чиглэсэн нийгэм, эдийн засгийн шилжилт хөдөлгөөн сүүлийн 20 гаруй жил явагдаж байна. Газарзүйн байршил, байгалийн өгөгдөл, экологийн нөхцөл, эдийн засгийн хөгжлийн өөр өөр түвшин, нийгмийн үйлчилгээний харилцан адилгүй чанар, хүртээмжээс шалтгаалан хүн ам хөгжил багатай газар нутгаас ажиллаж амьдрахад илүү таатай орчин, газар нутаг руу шилжин суурьших хандлагатай байна.

Шилжигчид нь илүү сайн боломж, сонголттой, хурдацтай хөгжиж буй хот, бүс нутагт төвлөрөх хандлагатай бөгөөд үүнийг шилжих хөдөлгөөний татах, түлхэх хүчин зүйлсийн онолын үүднээс тайлбарлаж болно. Татах хүчин зүйлсэд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, ажлын байр, зах зээл, эдийн засгийн боломж, дэд бүтэц, соёлын үйлчилгээ зэрэг орно. Харин ган, зуд, уур амьсгалын хатуу ширүүн нөхцөл, орлогын түвшин бага байх, ядуурал өндөр, аюулгүй байдал хангагдаагүй, хөдөлмөр эрхлэх боломж муу зэрэг нь хөдөөгөөс шилжин явах түлхэх хүчин зүйлс болж байна. Ялангуяа, хөдөө орон нутагт уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, ган, зудын гамшигт үзэгдэлд мал сүргээ алдсан иргэд Улаанбаатар хот руу шилжин суурьшиж байгаа нь шилжих хөдөлгөөний түлхэх хүчин зүйлс болж байна. Хүн нийгэм, эдийн засгийн таатай орчин нөхцөлд ажиллаж, амьдрах нь зүйн хэрэг боловч харамсалтай нь Монгол Улсын хувьд бүх татах хүчин зүйлс нь нийслэл хотод төвлөрсөн байна.


2020 оны байдлаар нийслэл хотын хүн ам 1,597.3 мянгад хүрсэн бөгөөд энэ нь улсын нийт хүн амын 47.6 хувь юм. Үүнийг дагаад Улаанбаатар хотод ДНБ-ий 65.8 хувийг үйлдвэрлэж, улсын төсвийн 58.6 хувийг хуваарилж, аж ахуйн нэгж, байгууллагын 63.9 хувь нь үйл ажиллагаа явуулж, өнөөгийн хэт төвлөрлийг бий болгожээ. Өнгөрсөн 30 жил (1990-2020)-д хөдөө, орон нутгаас Улаанбаатар хотод нийтдээ 691.9 мян.хүн шилжин ирсэн бөгөөд, энэ нь 7 томоохон аймагтай тэнцэхүйц хүн ам төдийгүй, өнөөгийн Улаанбаатар хотын хүн амын 46 хувь гэсэн үг юм. Хөдөө, орон нутгаас Улаанбаатар хотод шилжин ирсэн 30



жилийн явцаас хамгийн өндөр байсан жилүүдийг авч үзвэл, 2003 онд 40.2 мянган хүн, 2004 онд 41.6 мянган хүн, 2010 онд 39.7 мянган хүн, 2020 онд 39.5 мянган хүн шилжин иржээ. Эдгээр шилжилт өндөр жилүүдийн шилжих хөдөлгөөний шалтгааныг 1999-2002 оны ган, зудын нөлөө, 2009-2010 оны

өвлийн зудын нөлөө, 2017 оны 01 дүгээр сараас 2020 оны мөн хугацаанд шилжин суурьших хөдөлгөөнийг хязгаарласан Нийслэлийн Засаг даргын захирамжийн үйлчлэх хугацаа хүчингүй болсны дараа 2020 онд шилжилт дахин хөдөлсөн зэргээр тайлбарлаж болно.

Зураг 5.4. Ган, зудын үед хорогдсон малын тоо, Хөдөөгийн малчин өрхийн тоо болон Улаанбаатар хотод шилжин ирсэн хүн амын тооны динамик, 1990-2020 он



Эх сурвалж: ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн. 2022

2020 оны Улаанбаатар хотод шилжин ирэгчдийг насны бүлгээр авч үзвэл, 38.5 хувь нь 20-34 насны залуучууд, 26.5 хувь нь 0-9 насны хүүхдүүд эзлэх бөгөөд, үндсэндээ нийт шилжин ирэгчдийн 65.1 хувийг залуу гэр бүл, залуучууд эзэлж байна. Энэ нь залуус, залуу гэр бүлд нийгэм, эдийн засгийн таатай орчин нөхцөл хангагдсан хотод амьдрах хүсэл, тэмүүлэл илүү байгааг харуулж байна.

Улаанбаатар хотод шилжин ирсэн 1,562 шилжигч өрхийг хамруулсан судалгаагаар шилжилт хөдөлгөөний шалтгааныг тодруулахад, 38.5 хувь нь хөдөлмөр эрхлэлт, бизнес эрхлэх боломжоо нэмэгдүүлэх, 21 хувь нь амьдралын илүү сайн нөхцөл, 20.3 хувь нь боловсрол, 6.4 хувь хүүхдийнхээ ирээдүйн амьдралын төлөө, 5.1 хувь нь гэр бүлийн гишүүдийн хамт шилжсэн гэж хариулжээ. Шилжихээсээ өмнө амьдарч байсан байршлыг суурьшлын хувьд авч үзвэл, 44 хувь нь алслагдмал хөдөө нутагт, 8 хувь нь сумын төвд амьдардаг байсан бол 48 хувь нь аймгийн төвд амьдарч байжээ.

Бүсийн түвшинд төлөвлөлт, төсөвлөлтийн эрхзүйн чадамжгүй, сумын статустай орон нутгийн хотуудтай байна. Монгол Улсын нутаг дэвсгэр нь засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. Үндэсний болон бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хот, суурин газрын гүйцэтгэх үүрэг эрс нэмэгдсэн хэдий ч Улаанбаатар хотыг эс тооцвол хөгжлийн

аливаа төлөвлөлтөд хотын гүйцэтгэх үүргийг орхигдуулж ирсэн. Монгол Улсын одоогийн 21 аймгийн төвийг "хот" гэж ойлгодог ч эрхзүйн хувьд сумын статустай юм. Тодруулбал, Дархан-Уул аймгийн төв Дархан хот нь "Дархан сум", Баруун бүсийн тулгуур төв болох Ховд аймгийн төв Ховд хот нь "Жаргалант сум", Зүүн бүсийн тулгуур төв болох Дорнод аймгийн Чойбалсан хот нь "Хэрлэн сум" гэсэн эрхзүйн статустай байна.

УИХ-ын тогтоолоор бүсийн хөгжлийн тулгуур төвөөр 8 хотыг баталсан хэдий ч эдгээр хотууд нь бүсийн түвшинд төлөвлөлт, төсөвлөлт хийх эрхзүйн чадамжгүй, бүсийн хөгжилд гүйцэтгэх үүрэг хүлээхгүй байна. Бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой үүрэг гүйцэтгэдэг, хүн ам, нийгэм, соёл, аж үйлдвэр, эдийн засаг, дэд бүтцийн бүсийн таталцлыг бий болгох агуулгаар тухайн хотуудын хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг хийх ёстой. Гэтэл бодит байдал дээр эдгээр хотууд нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар "сум" гэсэн эрхзүйн статустай, хөдөөгийн бусад жижиг сумдтай ижил түвшинд зохицуулагдаж байна. Эдгээр хотын төсвийн төсөвлөлт хийх, хөрөнгө оруулах, батлах, зарцуулахтай холбогдсон харилцааг Төсвийн тухай хуулиар "сум" гэсэн статусаар, түүнчлэн төлөвлөлтийн хувьд эдгээр хотууд нь "Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр" гэсэн төлөвлөлтийг хийж байна.



Шигтгээ 5.1. Үндэсний зөвлөлдөх санал асуулга зохион байгуулагдав.

УИХ-аас "Улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх, үндэсний зөвшилцлийг хангах зорилгоор "Зөвлөлдөж шийдье" улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулсан. Үндэсний санал асуулгын хүрээнд 1,750 хүнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон, тэднээс 4 бүлгийн хүрээнд нийт 22 асуултыг асуусан.

Монгол Улс үндэсний хэмжээнд ийм санал асуулгыг 2 дахь удаагаа зохион байгуулж буй үйл явдал бөгөөд, энэ удаагийнх нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт төдийгүй, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг хамруулан нийтийн санал асууснаараа онцлог юм.

Бүс, орон нутгийн хөгжил, төвлөрлийг сааруулахтай холбоотой 3 асуултад иргэд хэрхэн хариулж, улмаар Зөвлөлдөх зөвлөлөөс УИХ-д хүргүүлсэн төвлөрлийг сааруулах, бүс, орон нутгийн хөгжилтэй холбоотой зөвлөмжийг онцлон авч үзье.

Орон нутаг дахь ЖДҮ-ийг дэмжих зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогоос сан бүрдүүлж ажиллахыг Та дэмжиж байна уу? гэсэн асуулт 0.885 оноотой дэмжигдэж, Зөвлөлдөх зөвлөлөөс УИХ-д "орон нутаг дахь ЖДҮ-ийг дэмжих зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогоос сан бүрдүүлэх эрхзүйн орчныг бүрдүүлэх";

Төвлөрлийг сааруулж бүсчлэн хөгжүүлэхтэй холбоотойгоор засаг захиргааны шинэчлэл хийхийг Та дэмжиж байна уу? гэсэн асуулт 0.869 оноотой дэмжигдэж, Зөвлөлдөх зөвлөлөөс УИХ-д "Засгийн газар засаг захиргааны шинэчлэл хийх саналыг боловсруулж, УИХ-аар шийдвэрлүүлэх";

Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулахын тулд орон нутагт оршин суугч болон шилжин суурьшигч иргэдэд тусгайлсан дэмжлэг үзүүлэх бодлогыг өргөжүүлэхийг Та дэмжиж байна уу? гэсэн асуулт 0.896 оноотой дэмжигдэж, Зөвлөлдөх зөвлөлөөс УИХ-д "Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулахын тулд орон нутагт оршин суугч болон шилжин суурьшигч иргэдэд тусгайлсан дэмжлэг үзүүлэх эрхзүйн орчныг боловсронгуй болгох" зэрэг зөвлөмжийг хүргүүлсэн.

Зөвлөлдөх санал асуулга нь иргэдийг төрийн үйл хэрэгт оролцуулах цогц үйл ажиллагаа бөгөөд, энэхүү санал асуулгын үр дүнд гаргасан зөвлөмжийг УИХ, Засгийн газар хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг Зөвлөлдөх зөвлөл болон олон нийтэд эргэн мэдээлэх хуулийн зохицуулалттай юм.



Энэ нь бүс, орон нутгийн түвшинд хотуудын нийгэм, эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүргийг эрхзүйн хувьд хязгаарлаж, тодорхойгүй нөхцөлийг үүсгэж байна.

Шигтгээ 5.2. Иргэдийн төлөөлөгчийн санал



Ц.ЦОГТБАЯР

Ховд аймгийн Жаргалант сумын Засаг дарга, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Ховд хот нь өнөөгийн хууль эрхзүйн зохицуулалтын хүрээнд "Жаргалант сум" гэсэн статустай байна. Хэдийгээр УИХ-ын холбогдох тогтоолд "Баруун бүсийн тулгуур төв Ховд хот" гэж заасан байдаг ч бодит байдалд бусад хууль, эрх зүйн зохицуулалтад баригдан "сум" гэсэн статусаар **төлөвлөлт, төсөвлөлт** хийж байна.

Ховд хотын хувьд хүн ам ихтэй, нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг дагаад хөрөнгө оруулалтын олон ажил хүлээгдэж байна. Гэтэл эрх зүйн орчинд бусад хөдөөгийн сумдтай адилтган авч үзэж байгаа нь зохисгүй юм. Хүн төвтэй хууль, бодлого байх ёстой. Иймд нэн түрүүнд "**хот**" гэсэн зэрэглэл, статусыг олгох хэрэгтэй. Аймгийн ИТХ-аас Жаргалант сумыг **улсын зэрэглэлтэй хотын статустай** болгоё гэсэн санал, санаачилга дэвшүүлээд байна.

Эх сурвалж: ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн, Ховд аймгийн ИТХ, ЗДТГ. 2023. Шинжлэх ухаанд суурилсан бодлого тодорхойлох үйл явцыг бэхжүүлэх зорилгоор зохион байгуулсан "Монгол орны хотуудад улсын болон орон нутгийн зэрэглэл, статус олгох, чиг үүрэг тодорхойлох асуудал ба Ховд аймаг, хот үүрэг, оролцоо" сэдэвт хурал. Ховд хот.



Бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд орон нутгийн хотуудын гүйцэтгэх үүрэг тодорхой бүс байгаа нь Улаанбаатар хотын төвлөрлийг улам нэмэгдүүлэх хандлагатай байна.

Дэлхийн хуурай газрын 2 хувийг хот, суурин газар эзэлж буй хэдий ч, дэлхийн нийт хүн амын 56 хувь нь хотод амьдарч, эдийн засгийн 70 хувийг хотод үйлдвэрлэж, эрчим хүчний 60 хувийг хэрэглэж байна. Цаашид 2045 он гэхэд дэлхийн хүн амын 68 хувь хотод суурьшихаар байна. Энэ агуулгаар дэлхийн түвшинд хотуудыг хөгжүүлэх асуудалд анхаарч НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хүрээнд “хот, хүн амын суурьшил”-тай холбоотой 11 дэх зорилгыг дэвшүүлж, тодорхой зорилт, шалгуурыг тодорхойлсон байдаг. Эквадор Улсын Кито хотноо 2016 онд болсон НҮБ-ын ХАБИТАТ-III хурлаас “Шинэ хотжилтын хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд Монгол Улс энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг.

Монгол Улсад мөн хотжилт эрчимтэй яваг-

даж байна. 1970 онд 44 хувь нь хотод, 1990 онд 57 хувь нь, харин 2020 оны байдлаар нийт хүн амын 69 хувь нь хот, суурин газарт суурьшиж байгаа бөгөөд, үүнээс Улаанбаатар хотод 47 хувь нь амьдарч байна. Цаашид бүсчилсэн хөгжил, хөгжлийн орон зайн бодлого, төлөвлөлтийн тодорхойгүй байдал энэ хэвээр үргэлжилбэл, 2045 онд нийт хүн амын 80 орчим хувь нь хот суурин газарт суурьшиж, бусад нь хөдөө орон нутгийн түвшинд суурьшиж, хүн амын өсөлт явагдахгүй байх сөрөг үр дагавар хүлээгдэж байна. Хот бол Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангахад тодорхой үүрэгтэйгээр оролцогч байхын зэрэгцээ үндэсний болоод бүс, орон нутгийн түвшний нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой үүрэг гүйцэтгэгч байх шаардлагатай. Энэхүү гүйцэтгэх үүрэг нь тухайн хотод тогтоосон зэрэглэл, статусын түвшинд харгалзуулан тодорхойлсон чиг үүргийн тухай ойлголт бөгөөд, энэ нь тухайн хотын хөгжлийн төлөвлөлт, төсөвлөлт хийх үндэс болно.

Зураг 5.5. Хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар, аймгийн төв хотууд болон хөдөө нутгаар, 1990-2045.



М.Алтанбагана, Ц.Отгонхүү, Б.Хэрлэнбаяр. 2020.
Дата эх сурвалж: YCX, Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоонд үндэслэв.

Эх сурвалж: YCX, Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоонд үндэслэв.

2045 он хүртэлх хүн амын хэтийн тооцоогоор Монгол Улсын хүн ам өөдрөг хувилбараар 5.01 сая болж өсөх хандлагатай байна. Энэхүү хүн амын хэтийн тооцоог Улаанбаатар хот, 21 аймгийн төв хот, тосгон болон хөдөө нутаг гэсэн суурьшлын 3 хэлбэрээр авч үзвэл, Улаанбаатар хотын хүн ам 2025 онд 53.6 хувь, 2045 онд 57.3 хувь болж өсөх хандлагатай байна.

Монгол улс 2045 он хүртэл Зураг 5.5-д харуулсан улаан шугамыг **дагасан төлөвлөлт хийх үү?** эсвэл бүс, орон нутгийн түвшинд хүн амыг тогтвортой хадгалж, тэнцвэртэй хөгжлийг хангах **зохицуулсан, удирдсан төлөвлөлт хийх үү?** гэсэн бодлогын сонголтод хүлээгдэж байна. Нийгмийн хөгжлийн нутаг дэвсгэрийн ялгааг багасгах эдийн

засгийн газарзүйн ялгаатай бодлого хэрэгжүүлэх замаар зохицуулсан, удирдсан төлөвлөлт хийсний үндсэн дээр Улаанбаатар хотын хүн амын тоог тогтвортой хадгалах, улмаар бүс, орон нутгийн түвшинд хүн ам шилжин суурьших нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй юм.

Хөдөө нутгаас хотод шилжин суурьшсан өрхүүдийн 86.4 хувь нь буцаж шилжих хүсэлгүй байгаа бөгөөд шалтгааныг авч үзвэл 37.5 хувь нь хөдөлмөр эрхлэх боломж хангалтгүй, 17 хувь нь цалин бага, 16.2 хувь нь боловсролын чанар хангалтгүй, 15.1 хувь нь амьдралын чанар муу гэж хариулжээ. Харин хотоос хөдөөд шилжин ирсэн өрхүүдээс 53 хувь нь тодорхой хугацааны дараа хот суурин газарт буцаж ирдэг байна. Энэ нь дээр



дурдсан хот, хөдөөгийн буюу нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгаа нэмэгдсэн, бүс, орон нутгийн түвшинд нийгэм, эдийн засгийн таатай орчин, нөхцөл, боломж хомс байдлаас шалтгаалж байна.

Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн энэ хэвээр үргэлжилбэл нийгэм, эдийн засагт олон тулгамдсан шинэ асуудлууд үүсэж болзошгүй юм. Тухайлбал, хөдөө орон нутагт боловсрол, эрүүл мэнд, соёл, төрийн албанд төдийгүй хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр зэрэг салбаруудад ажиллах хүчний хомсдол улам нэмэгдэж эрсдэлтэй байна. Засгийн газраас Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, Нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг холбогдох Засаг дарга нарт үүрэг болгосон. Мөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх, мөн жил бүрийн төсөвт 50.0 сая төгрөгөөс доошгүй хөрөнгө зарцуулах бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон.

Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжихэд чиглэсэн “Нээлттэй аймаг хөтөлбөр”-ийн төлөвлөгөөг бүх аймаг батлан хэрэгжүүлж байна.

Цаашид одоогийн хотуудын газарзүйн байршил, байгалийн нөхцөл, нөөц, боломжид тулгуурлан тухайн хот нь бүсийн түвшинд нийгэм, соёл, эдийн засаг, аж үйлдвэр, тээвэр, логистик, худалдаа, үйлчилгээ, дэд бүтцийн хувьд ямар чиг үүрэгтэй байхыг тодорхойлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд хотын оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй.

Нөөц, боломжид тулгуурлан бүс, орон нутгийн түвшинд нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих хүнсний болон боловсруулах аж үйлдвэрийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын орчин тодорхой бүс байна.

Монгол Улсад 2021 онд нийт 15.2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэний 40 хувь нь дотоод (13.2 хувь нь улсын төсвийн, 26.8 хувь нь хувийн хэвшлийн)-ын, 60 хувь нь гадаад (үүнээс 50.2 хувь нь ГШХО)-ын эх үүсвэртэй байна. Салбараар авч үзвэл, 56.1 хувь нь уул уурхай, 0.4 хувь нь хөдөө аж ахуй, 2.4 хувь нь боловсруулах үйлдвэр, 2.1 хувь нь тээвэр, агуулахын салбарт оржээ.

“Алсын хараа-2050” урт хугацааны бодлогод ДНБ-д боловсруулах үйлдвэрийн эзлэх

хувийг 2025 онд 12 хувь, 2030 онд 14.6 хувь, 2050 онд 27.4 хувьд, харин тээвэр, агуулахын салбарын эзлэх хувийг 2025 онд 5.1 хувьд, 2030 онд 4.8 хувьд, 2050 онд 11.6 хувьд тус тус хүргэх зорилтыг дэвшүүлсэн. Гэсэн хэдий ч аж үйлдвэрийн салбарыг орон зайн хувьд бүс, орон нутгийн түвшинд хэрхэн хөгжүүлэх бодлого, төлөвлөлт тодорхой бүс байгаа нь нэг түлхүүр зангилаа асуудал болж байна.

Ялангуяа, бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хүнсний болон боловсруулах үйлдвэрлэл чухал ач холбогдолтой. Хүнсний болон боловсруулах үйлдвэрлэл нь орон нутгийн иргэдээс түүхий эдийг бэлтгэн авах, нийлүүлэх, үйлдвэрлэх, худалдаанд гаргах цикл процесс нь иргэд-бизнес эрхлэгч нарын хамтарсан кластер үүсгэх замаар хийгдэж, үр өгөөж нь орон нутгийн иргэдэд хүрч, улмаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Цаашлаад бүсийн түвшинд экспортыг нэмэгдүүлэх, олон улсын түвшинд бүс нутгийн эдийн засгийн интеграцид харилцан үр ашигтай нэгдэхэд дэмжлэг үзүүлнэ.

Экспортод чиглэсэн бараа, бүтээгдэхүүн нь Дэлхийн худалдааны байгууллагын шаардлагын дагуу гарал үүслийн гэрчилгээ, кодтой байх ёстой. Энэ нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дагуу барааг экспортод гаргахад Олон улсын уялдуулсан системийн жагсаалтад нийцүүлэн кодлох, гэрчилгээжүүлж бүртгүүлэх, гаалийн тарифын болон тарифын бус хязгаарлалтад хамааруулах зэрэг худалдааны тавигдах шаардлагууд бий. Иймд бүс, орон нутгийн түвшинд, ялангуяа экспортод чиглэсэн бараа, бүтээгдэхүүнийг анхан шатнаас эцсийн бүтээгдэхүүн хүртэлх процессын шатанд тухайн барааг тодорхойлж гэрчилгээ олгож, кодлох, уялдуулсан системд нийцүүлэх нь чухал байна. Энэ бүс, орон нутгийн түвшинд экспортыг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй нэг чухал асуудал юм.

Цаашид бүс, орон нутгийн газарзүйн байршил, нөөц, боломжид тулгуурлан хаана, хэдий хэмжээний хүчин чадал бүхий хөнгөн, хүнсний болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, түүнд тулгуурлан хөрөнгө оруулалтын болон ажиллах хүчний хэрэгцээг орон зайн төлөвлөх, улмаар гадаадын болон дотоодын хувийн хэвшил хөрөнгө оруулалтыг татах татварын, тарифын, тарифын бус болон ямар төрлийн хөнгөлөлт, урамшууллын дэмжлэг үзүүлэх эрхзүйн таатай орчныг тодорхой болгож, бүс нутгуудад зарлах нь чухал байна.

Тээврийн дэд бүтцийн босоо, хөндлөн гол тэнхлэг, түүнд суурилсан зам, тээврийн сүлжээ, хилийн боомт, чөлөөт бүс, логистикийн нэгдсэн сүлжээ бүрдээгүй, тодорхой бүс байна. Тээврийн дэд бүтцийн босоо тэнхлэгүүдийг өмнөд-умардын, хэвтээ тэнхлэгийг өрнө-дорнын бүс нутгийн орнуудтай холбож олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Төв Азийн болон Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн интеграци, санаачилга, хамтын ажиллагаанд нэгдэх нь




эдийн засгийн аюулгүй байдлаа хангаж хөгжих нэг суурь нөхцөл юм. Тэнхлэг гэдэг нь нийгэм, эдийн засгийн хөгжилд үүрэг бүхий улсын болон орон нутгийн зэрэглэлтэй гол тулгуур төв хотууд, бүс нутаг, хөдөөгийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын үндсэн холбоосыг бүрдүүлж; бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, технологийн процессыг олон улсын тээврийн сүлжээ болон бүс нутгийн эдийн засгийн интеграцитай холбох замаар худалдаа, экспорт, зорчигч, ачаа эргэлт, мэдээллийн урсгал, солилцоог нэмэгдүүлэх; тэдгээрийн бүсийн хөгжилд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, өөр хооронд нь холбож, харилцан уялдаа холбоотойгоор бүс нутгийн нийгэм, эдийн

засгийн хөгжил, хүн амын нутагшилт, суурьшлын орон зайн оновчтой бүтцийг тэтгэх эдийн засаг-дэд бүтцийн шугаман бүс юм (М.Алтанбагана, Г.Урантамир, 2020).

Монгол Улсын нийгэм, эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, хөрш зэргэлдээ болон бүс нутгийн орнуудтай авто замаар холбох, далайн гарцад хамгийн дөт замаар холбогдох, дотоодын дэд бүтцийн нэгдсэн сүлжээ бий болгох суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд 2001 онд Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэлийн хүрээнд хэвтээ 1 тэнхлэг, босоо 5 тэнхлэгийг баталсан.

Зураг 5.6. УИХ-аас 2001 онд тодорхойлсон Мянганы хөгжлийн зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл




Эх сурвалж: УИХ-ын 2001 оны 09 дүгээр тогтоол. Зургийг ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнд боловсруулав.

Өнөөгийн байдлаар, 21 жилийн дараа тээврийн дэд бүтцийн хэвтээ тэнхлэг болох “Мянганы зам” төслийн их бүтээн байгуулалт бүрэн хэрэгжиж дууссан, харин босоо 5 тэнхлэгээс ердөө 2 тэнхлэгийн бүтээн байгуулалт бүрэн дууссан байдалтай байна. Үүнд, Алтанбулаг-Улаанбаатар-Замын үүд чиглэлийн төв тэнхлэг, Цагааннуур-Өлгий хот-Ховд хот-Булган боомт чиглэлийн баруун босоо тэнхлэгийн авто замын бүтээн байгуулалт орно. Баруун босоо тэнхлэг нь Азийн авто замын сүлжээний АН4, CAREC-ийн коридор 4“а” чиглэлийн нэг хэсэг бөгөөд, Монгол Улсын хувьд тээврийн стратегийн ач холбогдолтой, бүс, орон нутгийн нийгэм, эдийн

засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх авто зам юм. Өнгөрсөн хугацааны бодлого, төлөвлөлтийн залгамж чанаргүй, улс төрийн тогтворгүй байдал, 2001 оноос хойш төр, засгаас баталсан зам, тээвэртэй холбоотой бодлого, хөтөлбөрүүдийн уялдаа, холбоогүй байдлаас шалтгаалан үлдсэн босоо тэнхлэгийн бүтээн байгуулалтын асуудал тодорхой бус байна.

Тээврийн дэд бүтцийн тэнхлэг нь хүн амыг татах нэг хүчин зүйл болж байна. Нийт хүн амын 69 хувь нь Монгол орны тээврийн дэд бүтцийн Алтанбулаг боомт-Улаанбаатар хот-Сайншанд хот-Замын үүд боомтын төв тэнхлэг дагуу суурьшиж байна.

Зураг 5.7. Тээврийн дэд бүтцийн төв тэнхлэг дагуух хүн амын төвлөрөл



Эх сурвалж: Зургийг ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнд боловсруулав.

Үндэсний болон бүс, орон нутгийн хөгжлийг дэмжсэн, газарзүйн байршлын хувьд зангилаа холболтуудыг үүсгэсэн, уялдаа холбоо бүхий нэгдсэн сүлжээ бүрдээгүй байна. Энэ нь бүс орон нутгийн хөгжилд саад учруулж буй нэг түлхүүр асуудал болж байна. Тодруулбал, өнгөрсөн 20 жилд манай улсын тээврийн сүлжээний төлөвлөлт, бүтээн байгуулалтыг зураглалын хувьд авч үзвэл Улаанбаатар хотод “нарны цацраг” мэт төвлөрөн, аймаг, орон нутаг руу сарнисан хэлбэртэй бөгөөд, энэ нь Улаанбаатар хот болон цөөн хэдэн суурин газарт хүн амын төвлөрөл үүсэж, бусад бүс, орон нутгийн түвшинд тэнцвэрт бус буюу нэг төвт тогтолцоог бий болгон, бүс нутгийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсын нийт экспорт 2021 оны байдлаар 9,241.1 сая.ам доллар бөгөөд үүний 81.3%-ийг эрдэс бүтээгдэхүүн, 0.5%-ийг мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн, 0.5%-ийг хүнсний бүтээгдэхүүн эзэлж байна. Цаашид Алсын хараа-2050 бодлогын хүрээнд нийт экспортыг 2025 онд 14,020 сая.ам долларт, 2030 онд 29,660 сая.ам долларт, 2050 онд 139,870 сая.ам долларт тус тус хүргэх зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү зорилтыг хангахын тулд тээврийн дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэгт суурилсан нэгдсэн сүлжээ, зангилаа төв хот, аж үйлдвэрийн тохиромжтой газарзүйн байршилд суурилсан төлөвлөлтөөр хэрэгжүүлэх нь зүйтэй.

Засгийн газраас Монгол Улсын хөгжлийг хязгаарлаад буй хүчин зүйлсийн нэг нь боомтын асуудал гэж үзээд Шинэ сэргэлтийн бодлогод “Боомтын сэргэлт”-тэй холбоотой хилийн боомтуудын ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлэх, чөлөөт бүс шинээр нэмж байгуулах, шинээр 11 боомтыг авто замаар,


4 боомтыг төмөр замаар холбох, 6 боомтыг аялал жуулчлалын боомт болгон хөгжүүлж, зэрэглэлийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээг дэвшүүлсэн. Цаашид урт, дунд хугацаандаа бүс, орон нутгийн түвшинд нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал үүрэг бүхий боомт, чөлөөт бүсүүдийг газарзүйн байршлын хувьд тодорхойлох чухал байна.

Мах, махан бүтээгдэхүүн, боловсруулсан бүтээгдэхүүн, түүхий эдийн экспортыг хилийн боомтуудаар, экспорт хийсэн улс, орнуудаар хийсэн шинжилгээ тээврийн дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэг, түүнд суурилсан боомт, логистикийн уялдаа холбоо бүхий нэгдсэн сүлжээний төлөвлөлт бүс, орон нутгийн хөгжилд яагаад чухал болохыг тодорхой харуулна. Экспортын 80-90 хувийг Алтанбулаг, Замын-Үүд боомтоор гаргасан бөгөөд, Европын Холбооны улсууд Австрали, ХБНГУ, Итали, Их Британи руу хүргэх бараа, бүтээгдэхүүний экспортын хувьд ч энэхүү 2 хилийн боомтоор дамжиж байна. Энэ нь (1) Улаанбаатар хотын хүн амын төвлөрлийг дагаад эдийн засаг, үйлдвэрлэлийн төвлөрөл бий болсон, (2) бизнес эрхлэгч, экспортлогч нар дотоодын тээврийн дэд бүтцийн тэнхлэг төмөр зам, авто замыг сонгон ачаа тээвэрлэх, тухайн тэнхлэгийн таталцал бүхий ойр байршилд бүтээгдэхүүн, үйлдвэрлэл явуулах, (3) гадаад улс орон руу экспорт хийхдээ Монгол Улсын хилээр гараад аль болох богино зайд хойд, урд хөрш орны үндсэн тэнхлэгтэй холбогдох сонирхолтой байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, бүс, орон нутгийн түвшинд экспортын бараа бүтээгдэхүүнийг түргэн шуурхай, их ачааг тээвэрлэх зам тээвэр, логистик, боомтын сонголт хомс, бодлого төлөвлөлт, дэд бүтцийн суурь нөхцөл бүрдээгүй байна.

Бүс, орон нутагт хүн ам шилжин суурьших, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэрэгсэл, түүний газарзүйн ялгарал тодорхой бус байна. Үндэсний хэмжээнд бүс нутгуудын нийгмийн хөгжлийг хангах, төвлөрлийг сааруулах төрөөс үзүүлэх санхүүгийн тусламж, хөнгөлөлттэй зээл, урамшуулал, тээвэр, татварын хөнгөлөлт, ажлын байрны татаас зэрэг эрхзүй, эдийн засаг, хөрөнгө оруулалтын механизмуудыг

хэрэгжүүлэх шаардлагатай байна. Зах зээлийн эдийн засагт суурилсан ардчилсан тогтолцоотой өндөр хөгжилтэй орнуудад бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, сул хөгжилтэй бүс нутгуудын хөгжлийг дэмжихдээ санхүүгийн дэмжлэг үзүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, төлөвлөлт, удирдлагын бүтэц, механизмыг амжилттай хэрэгжүүлж ирсэн туршлага бий.

Зураг 5.8. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт, хилийн боомтуудад газарзүйн байршлаар, дотоодын мах, ноос, ноолуурын үйлдвэрийн байршил, 2021




Эх сурвалж: ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнд боловсруулав. Дата эх сурвалж: Гаалийн ерөнхий газар болон ХХААХҮЯ-ны статистик мэдээ

Өнөөгийн байдлаар, Монгол оронд эдийн засгийн газарзүйн дотоод ялгарлыг нөхцөлдүүлэхэд чиглэсэн эрхзүйн орчин, эдийн засаг, хөрөнгө оруулалтын ялгавартай бодлого, механизм байхгүй байна. Энэ нь өмнө батлагдсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал төдийлөн үр дүнтэй хэрэгжээгүйн нэгэн учир шалтгаан, улмаар Улаанбаатар хотын өнөөгийн төвлөрлийг нөхцөлдүүлэх шалтгаан-үр дагаврын холбоос юм. 1990 оноос өмнөх төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед улсын салбарууд дахь бүх өмч төрийн мэдэлд байж, орон зайн хөгжлийн төлөвлөлтийг төрөөс шууд зохицуулж ирсэн түүхтэй. Харин одоо нөхцөл байдал өөр болсон хэдий ч төрөөс хөгжлийн орон зайн төлөвлөлтөө дэмжихэд тодорхой түвшинд зохицуулалт үгүйлэгдэж байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хувийн хэвшлийн оролцоо нэмэгдсэн бөгөөд, ДНБ-д хувийн хэвшлийн эзлэх хувь 2018 онд 76.0 хувь, 2019 онд 74.5 хувь, 2020 онд 77.1 хувьтай байна. Доорх

зургаас харвал, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ажлын байр, улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд ач тустай боловсруулах үйлдвэр, уул уурхай, мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, үл хөдлөх хөрөнгө, санхүү, даатгал, мэдээлэл холбоо зэрэг салбаруудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хувийн хэвшлийн оролцоо өндөр байна. Иймд эдийн засгийн бүтэц, суурин дээр байгаа иргэд, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчид бүс, орон нутаг руу шилжин суурьших, тэнд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд(1) төрөөс батлан, тогтвортой хэрэгжүүлэх Монгол Улсын бүсчлэн хөгжүүлэх бодлоготой байх, эсвэл Монгол Улсын хөгжлийн орон зайн нэгдсэн концепц (зураглал) ямар гэдэг нь тодорхой байх, (2) уг нэгдсэн концепц, зураглал дээр газарзүйн байршлын хувьд хаана, ямар төрлийн эрхзүй, эдийн засаг, хөрөнгө оруулалтын механизмыг авч хэрэгжүүлэх нь тодорхой байх нь чухал бөгөөд, ийм замаар бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Зураг 5.9. ДНБ-д төрийн болон хувийн хэвшлийн оролцоо



Эх сурвалж: Боловсруулсан М.Алтанбагана, М.Баяржаргал, 2021. ҮСХ, Нэгдсэн мэдээллийн сангийн ДНБ-ий мэдээлэлд үндэслэв.

Засгийн газраас төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутагт бизнес эрхлэхийг дэмжих зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэхээ зарласан. Тодруулбал, орон нутагт ажлын байр шилжүүлэх зоригоор аж ахуйн нэгж, байгууллагад 1 хувийн хөнгөлөлттэй зээл олгох, иргэдэд зориулсан 3 хувийн ипотекийн зээл, цалингийн бүрэлдэхүүнд 20-100 хувийн орон нутгийн нэмэгдэл тооцож байна. Мөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй албан татвар төлөгч нь Нийслэл хотод байрлалтай үйлдвэр, эсхүл агуулахаа бусад аймаг, сумд руу нүүлгэсэн тохиолдолд тухайн нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарсан зардлыг 50 хувиар нэмэгдүүлж албан татвар ногдох орлогоос хасаж тооцох эрхзүйн орчныг бүрдүүлсэн. Эдгээр нь бүс, орон нутаг руу шилжин суурьших үйл явцыг дэмжсэн чухал арга хэрэгсэл юм. Гэхдээ энэ нь нийтлэг шинжтэй, бүх аймаг, суманд хэрэгжих боломжтой бөгөөд бүс, орон нутгийн хөгжлийн орон зайн төлөвлөлтийн тодорхой баримт бичигт суурилагагүй, орон зайн агуулгагүй байгаа нь учир дутагдалтай, цаашид анхаарах шаардлагатай юм.

Засгийн газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтыг тодорхой зорилтот хөтөлбөр лүү чиглүүлж, төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчмын дагуу урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан иргэд, олон нийтээс гар утасны аппликейшнаар санал авч төлөвлөдөг болсон.

Татах хүч, арга хэрэгсэл хоёр нь ялгаатай ойлголт бөгөөд бүс, орон нутгийн түвшинд хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагыг татах гол хүчин зүйлсэд хот, тээврийн дэд бүтэц, логистик, аж үйлдвэр, эдийн засаг, зах зээл, Улаанбаатар хоттой өрсөлдөхүйц дээд боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээ, тэдгээрийн газарзүйн оновчтой байршлын стратегиар тодорхойлогдоно.

Үндэсний хэмжээнд эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, хөгжлийн орон зайн төлөвлөлтийн суурь концепц, зураглалаа тодорхой болгоогүй, мөн иргэн, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын хувьд Улаанбаатар хотоос өөр сонголт-боломж бараг байхгүй байгаа өнөөгийн нөхцөлд "Улаанбаатар хотод төвлөрөөд байна гээд" татвар нэмэх, эдийн засгийн боломжуудыг хязгаарлах, хумих зэрэг захиргааны аргаар зохицуулах гэж оролдох нь асуудлыг шийдэхгүй бөгөөд, энэ нь өөрөө хүний эрхийг зөрчих, хүний хөгжлийн суурь үзэл санаатай харшилна. Харин төр засгаас аль болох нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, үйлчилгээний боломж, сонголтуудыг бүс, орон нутгийн түвшинд нэмэгдүүлэх шаардлагатай.

Иймд эдийн засгийн газарзүйн дотоод ялгарлыг бий болгох, төрөөс бүсчилсэн хөгжил, орон зайн хөгжлийн төлөвлөлтөд суурилсан, уг төлөвлөлтөө хэрэгжүүлэхэд чиглэсэн эрхзүй, эдийн засаг, хөрөнгө оруулалтын ялгаатай бодлого авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, хууль эрхзүйн орчин тодорхой бус, бүс нутгийн түвшинд эрх, үүргийн хуваарилалт тодорхой бус, институцийн тогтолцоо бүрдээгүй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрхийг зохицуулсан бөгөөд, уг зүйлийн 3-д "салбарын ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх" гэж заасан, Гэвч нөгөө талаас Үндсэн хуулийн энэхүү суурь зохицуулалтыг хэрэгжүүлэх салбарын хууль, эрхзүйн орчныг тодорхой болгоогүй байна.

2001 онд УИХ-аас Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2001-2020)-ыг баталж, энэ хүрээнд нутаг дэвсгэрийг Эдийн засгийн 5 бүсэд хуваарилан, бүсийн хөгжлийн тулгуур 8 төв хотууд, тээврийн дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэгийг тодорхойлсон. Улмаар бүсчилсэн хөгжлийн үзэл



баримтлалыг хэрэгжүүлэх эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг баталсан. Эдгээр бүсчилсэн хөгжилтэй холбоотой үзэл баримтлал, хөтөлбөрүүд нь бүсийн түвшний эрхзүйн орчны эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоо болон санхүүжилтийн тодорхой бус байдал, засаглалын тогтвортой бус байдлаас шалтгаалан хэрэгжээгүй юм.

2003 онд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах, эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилготой Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийг баталсан хэдий ч уг хуулийн хэрэгжилтийн байдал хангалтгүй байна. Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлого, төлөвлөлтийн санхүүжилт, хэрэгжүүлэх институцийн тогтолцоо тодорхой бус байна. Тухайлбал, уг хуульд бүсчилсэн хөгжлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүрэг бүхий Үндэсний хороо, хэрэгжилтийг зохион байгуулах Бүсийн зөвлөл, түүний эрх, үүргийг тодорхойлж өгсөн хэдий ч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Мөн уг хуулийн хэрэгжилт нь бусад суурь шинжтэй гол хуулиудаар дамжин хэрэгжих шаардлагатай бөгөөд, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуулиудтай уялдаа бараг байхгүй байна.

Бүсчилсэн хөгжлийн институцийн тогтолцооны хувьд бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх чиг үүрэг Эдийн засаг, хөгжлийн яаманд шилжсэн. Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцэд "Бүсчилсэн хөгжлийн бодлого, салбарын хөгжлийн оновчтой байршлыг тогтоож, бүс, орон нутгийн хөгжлийг тодорхойлж, аж үйлдвэрийн нэгдсэн бодлого, төлөвлөлтөөр хангах, бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх" чиг үүрэг туссан байдаг.

5.3. Бүс, орон нутгийг хөгжүүлэх гарц шийдэл, зөвлөмж

Бүс, орон нутгийн түвшинд тулгамдаж буй түлхүүр асуудлуудыг шийдвэрлэх замаар ТХЗ-ын хэрэгжилтийг ахиулах гарц, шийдлийн саналыг

тодорхойлж байна. Энэхүү гарц шийдэл нь хөгжлийн орон зайн төлөвлөлтийн нэгдсэн цог шийдэлд үндэслэн бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих, эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг уялдаа холбоог байршилд тулгуурлан төлөвлөж, улмаар өрхийн орлого, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд оршино.

2021 онд нийт 15.2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд үүнээс 40 хувь нь дотоодын, 60 хувь гадаадын хөрөнгө оруулалт эзэлнэ. Дотоодын хөрөнгө оруулалтын 26.8 хувь нь хувийн хэвшлийн, харин гадаадын хөрөнгө оруулалтын 50.2 хувь нь ГШХО эзэлж байна. Дотоодын хувийн хэвшлийн болон ГШХО нь их нөөц, боломж байгааг харуулж байгаа бөгөөд үүнийг бүс, орон нутгийн түвшинд хүнд, хөнгөн, боловсруулах, хүнсний аж үйлдвэр, агуулахын салбарыг хөгжүүлэх, нөгөө талаас авто зам, төмөр зам, боомтын шинэчлэл, логистик, агуулахын салбар руу чиглүүлэх, бүс, орон нутагт хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэх замаар энэхүү нөөц, боломжийг бүрэн дүүрэн ашиглах нь зүйтэй. Хөрөнгө оруулалтыг салбараар нь авч үзвэл ХАА, боловсруулах үйлдвэр, тээвэр, агуулах зэрэг бүс орон нутгийн хөгжилд чухал ач холбогдолтой салбаруудын хувь хэмжээ хангалтгүй, бага байгаа юм.

Ийнхүү нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгааг багасгах эдийн засгийн газарзүйн ялгаатай бодлого хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд бүс, орон нутгийн түвшинд зам, тээвэр, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалтыг татах, нэмэгдүүлэх чиглэлийг байршлын тодорхой болгох нь бүсийн түвшинд хэрэглэгч, нийлүүлэгч, хөрөнгө оруулагчдын сонголт, боломжийг өргөжүүлнэ. Ингэснээс бүс, орон нутгийн түвшинд уул уурхайн бус экспортын хэмжээ, хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх суурь нөхцөл бүрдэх бөгөөд энэ нь эдийн засгийн газарзүйн төлөвлөлтийн арга хэрэгслээр ядуурлыг бууруулах ач холбогдолтой.

Нөгөө талаас байршилд тулгуурлан эдийн засгийн тэргүүлэх, гол салбар хоорондын уялдааг хангаж, хөрөнгө оруулалтыг тодорхойлсон хөгжлийн орон зайн нэгдсэн төлөвлөлт нь өөрөө бүс, орон нутгийн түвшинд үйлдвэрлэх хүчний эрэлт хэрэгцээг цаг хугацаа, орон зайн хувьд тодорхойлж, улмаар ажиллах хүчийг оновчтой байршуулах, удирдлага, зохион байгуулалтаар хангахад дэмжлэг үзүүлнэ.

Зураг 5.10. Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих, өрхийн орлого, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх гарц, шийдэл



Нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөл ба Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлогод дэвшүүлсэн зорилт, хүрэх түвшинд

Хөдөөгийн малчин өрхийн орлогын бүтэц

- » 49.2% малын мах ↑
- » 41.9% ноос, ноолуур ↑
- » 2.4% арьс шир ↑
- » 6.5% бусад ↑

Хүн ам, суурьшлаар

- » 47% УБ хотод ↓
- » 22% нь 21 аймгийн төв хотод ↑
- » 11% нь 309 сумын төвд ↑
- » 20% хөдөө нутагт →

Хөрөнгө оруулалт, эх үүсвэрээр (15.2 их наяд.төгрөг, 2021 он)

- » 40% - Дотоод ↑
 - 13.2% улсын төсөв
 - 26.8% хувийн хэвшил
- » 60% - Гадаад ↑
 - ГШХО 50.2%, ХЗ 8.8%, БТ 1%

Хөрөнгө оруулалт, салбараар,

- » 56.1% уул уурхай
- » 0.4% ХАА ↑
- » 2.4% боловсруулах үйлдвэр ↑
- » 2.1% Тээвэр, агуулах ↑

ДНБ-ий салбарын бүтэц, 2021 он & Алсын хараа-2050, ШСБ-ын зорилт

- » 13% ХАА ↑
- » 25.2% уул уурхай ⇕
- » 9% боловсруулах үйлдвэр ↑ (2025->12%, 2030->14.6%, 2050->27.4%)
- » 3% тээвэр, агуулах ↑ (2025->5.1%, 2030->4.8%, 2050->11.6%)
- » Аялал жуулчлал 2050 онд 1 сая, 2030 онд 2 сая, 2050 онд 6 сая жуулчин авна.
- » Бүсийн тээвэр, логикийн тоо 2030 онд 7, 2050 онд 11.

ДНБ-д төр, хувийн хэвшил 77.5% хувийн хэвшил, 2021 он ↑

- » Уул уурхай, боловсруулах үйлдвэр, МАА, газар тариалан, аялал жуулчлал, барилга, зочид буудал, санхүү, даатгал, үл хөдлөх салбаруудын 75% хэвийн хэвшил.

Экспорт, сая.ам доллар, 2021

- Нийт 9,241.1 ↑, (2025->14,020, 2030->29,660, 2050->139,870)
- » 81.3% эрдэс бүтээгдэхүүн
 - » 0.5% мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн ↑
 - » 0.5% хүнсний бүтээгдэхүүн ↑

“Эх сурвалж: М.Алтанбагана, 2023” гэж оруулах




1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийг шинэчлэн найруулж, бусад хууль тогтоомжтой уялдуулахыг зөвлөж байна. Хөгжлийн орон зайн төлөвлөлт, эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэхтэй холбоотой эрхзүйн зохицуулалт, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн тогтолцоог тодорхой болгох шаардлагатай. Бүсчилсэн хөгжилтэй холбоотой ойлголтыг хууль, эрхзүйн орчинд нэг мөр болгох, бүсийн түвшинд аймаг, сумд хоршин, төрөлжин хөгжих төлөвлөлт, институци, санхүүжилтийн эрхзүйн орчныг тодорхой болгож, энэ асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулиудад тусгаж, хууль хоорондын уялдаа холбоог хангахыг зөвлөмж байна. Бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үүрэг бүхий хот, аж үйлдвэр,

тээвэр, худалдаа, үйлчилгээний чиглэлийг хөрөнгө оруулалт, татвар, урамшуулал, хөнгөлөлтөөр дэмжих арга хэрэгсэл, хөшүүргийн эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зөвлөж байна.

2. Бүс, орон нутгийн түвшинд нөөц, боломжид тулгуурлан хөгжүүлэх хүнс, хөнгөн болон боловсруулах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх газарзүйн тохиромжтой байршлыг тодорхойлж, ГШХО болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, чиглүүлэх замаар бүс, орон нутгийн түвшинд иргэд-бизнес эрхлэгч нарын кластер хамтын ажиллагааг бэхжүүлэхийг зөвлөмж байна. Энэ хүрээнд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, үр тариа боловсруулах, арьс, шир, ноос, ноосон бүтээгдэхүүн, ноолуур, ноолууран бүтээгдэхүүн, модон эдлэлийн үйлдвэрлэлүүд хөгжүүлэх тохиромжтой байршлын судалгааг Эдийн засаг, хөгжлийн яам болон ШУА-ийн эрдэмтэн, судлаачдыг дэвшүүлсэн үйлдвэр хөгжүүлэх бүсийн тохиромжтой байршлыг зураглалыг авч үзэхийг зөвлөж байна.

Зураг 5.11. Хөнгөн үйлдвэр хөгжүүлэх бүс (санал)



Эх сурвалж: Д. Баттогтох, Б. Сайнбуян ба бусад, "Аж үйлдвэрийн байршлын нэгдсэн төлөвлөлт, зураглалын аргачлал боловсруулах". Аж үйлдвэрийн яам. Улаанбаатар, 2018.

3. Хөгжлийн орон зайн төлөвлөлтийн тухайд баримтлах бодлого, зураглалыг тодорхой болгож, зарлахыг зөвлөж байна. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах суурь нөхцөлийг бүрдүүлэх, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Тогтвортой хөгжлийн зорилгуудыг үндэсний болон бүс, орон нутгийн түвшинд орон зайн зохион байгуулалтаар хангаж хэрэгжүүлэх Хөгжлийн орон зайн төлөвлөлтийн тухайд баримтлах бодлого, төлөвлөлтийн зураглалыг яаралтай тодорхой болгож, батлах шаардлагатай. Энэ хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам болон эрдэмтэн, судлаачдын

боловсруулж, дэвшүүлсэн "Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн орон зайн төлөвлөлтийн шийдэл, суурь концепци"-ийн саналыг (Зураг 5.13) судалж үзэхийг зөвлөж байна.

Дэвшүүлж буй хөгжлийн орон зайн төлөвлөлтийн зураглал нь "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлоготой уялдуулан тодорхойлсон бөгөөд цаашид дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

4. Хотуудад зэрэглэл, статус олгож, нийгэм, эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх



үүргийг тодорхой болгох. Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд туссан хот, тосгонтой холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, одоогийн сум, багийн статустай хот, суурин газруудад улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, мөн тосгоны статус олгох хэрэгтэй.

Үндсэн хуульд оруулсан улсын болон орон нутгийн зэрэглэлийн үзэл санаанд нийцүүлэн “Хотын зэрэглэл, статус, үүрэг”-ийн тогтолцоог дэвшүүлж байна. Ийнхүү хотын зэрэглэлийг дотор нь хөгжилд гүйцэтгэх үүргийн хувьд 5 эрэмбэ, статус болгох нь бүс, орон нутгийн түвшинд эдийн засгийн газарзүйн ялгаатай бодлого

явуулах нэг суурь нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Эдийн засгийн газарзүйн ялгаатай бодлого хэрэгжүүлсний үндсэн дээр нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгааг үе шаттай бууруулах үндсэн нөхцөл бүрдэнэ. Хотын эрэмбэ, статус бүрд харгалзан тодорхойлсон үүрэг нь тухайн хотын хөгжлийн төлөвлөлтийг нарийвчлан тодорхойлох агуулгын цар хүрээ, эдийн засаг, хөрөнгө оруулалтын үндэс болно. Хотын зэрэглэл, статус, үүргийн гол үзэл санаа, үндэслэл, тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг Хавсралт 5-аас харна уу.

Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуульд “Хотын зэрэглэл, статус, үүрэг”-ийн тогтолцоог тусгах шаардлагатай.

Хүснэгт 5.2. Дэвшүүлж буй Монгол Улсын “Хотын зэрэглэл, статус, үүрэг”-ийн тогтолцоо

Хотын зэрэглэл	Хотын эрэмбэ, статус	Нийгэм, эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх хотын үүрэг, чиглэл
Улсын зэрэглэлтэй хот	I. Улсын нийслэл хот	Олон үүрэгтэй Нийслэл хот
	II. Хөгжлийн стратегийн төв хот	Засаг захиргааны бие даасан чиг үүрэг бүхий бүсийн эдийн засаг, аж үйлдвэр, аялал жуулчлалын кластер төв, соёл, дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновац, төрөлжсөн эрүүл мэндийн үйлчилгээ, тээвэр логистик, үйлчилгээний олон үүрэгтэй хот (бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үүрэг бүхий зангилаа хот)
	III. Хөгжлийн төв хот	Засаг захиргаа, аж үйлдвэр, үйлчилгээний үүрэгтэй хот
Орон нутгийн зэрэглэлтэй хот	IV. Орон нутгийн хөгжлийн төв хот	Засаг захиргаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн үүрэгтэй хот
	V. Орон нутгийн хот	Засаг захиргаа, үйлчилгээний үүрэгтэй хот

Эх сурвалж: “Хотуудад улс, аймгийн зэрэглэл тогтоох, хот, тосгодын чиг үүрэг, статусыг тодорхойлох судалгаа” сэдэвт шинжлэх ухаан, технологийн захиалгат төслийн тайлан. БШУЯ, ШУТС, ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн.

Ховд, Дархан, Даланзадгад, Чойбалсан, Улиастай хотуудад Улсын зэрэглэлтэй Хөгжлийн стратегийн төв хотын статус олгох, Арвайхээр,

Өлгий, Сайншанд, Эрдэнэт, Мөрөн хотуудад Улсын зэрэглэлтэй Хөгжлийн төв хотын статус олгохыг зөвлөж байна.

Зураг 5.12. Хотуудын зэрэглэл, статус, үүрэг, газарзүйн байршил



Эх сурвалж: ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн онолын үндэс, нэгдсэн аргазүй, аргачлалыг шинэчлэн боловсруулах (2019- 2021)” суурь судалгааны төслийн тайлан. УБ.



Хотуудад зэрэглэл, статус олгох асуудлыг өнөөгийн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үүднээс авч үзэх хэрэгтэй. Тодруулбал, өнөөгийн нийгэм, залуус, бизнес эрхлэгчид бүс нутгийн түвшинд сонголт-боломж бүхий өрсөлдөхүйц нийгэм, соёл, эдийн засаг, дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэх, ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдсэн хотыг хүсэмжилж байна. Бүс, орон нутгийн түвшинд Улаанбаатар хоттой өрсөлдөхүйц, Улаанбаатар хотын эсрэг татах хүчийг нөхцөлдүүлсэн, нийслэл хотын нийгэм, соёл, эдийн засаг, дэд бүтцийн үйлчилгээний ачааллыг өөртөө хуваалцах, үр ашигтай, өндөр бүтээмжтэй "Улсын зэрэглэлтэй хөгжлийн стратегийн төв хот"-уудыг тэргүүн ээлжид хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг зөвлөж байна.

5. Бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжил, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн тэнхлэгт суурилсан тээвэр-логистикийн нэгдсэн сүлжээ бий болгохыг зөвлөж байна. Бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үүрэг бүхий, олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх, хөрш орнуудын тээврийн үндсэн сүлжээтэй холбогдох, бүсийн түвшинд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспорт, худалдааг нэмэгдүүлэх суурь нөхцөлийг хангасан Тээврийн дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэгийг тодорхойлж, түүнд суурилсан зам, тээвэр, боомт, чөлөөт бүс, логистикийн уялдаа холбоо бүхий нэгдсэн сүлжээг бий болгох, төлөвлөж, хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Энэ хүрээнд эрдэмтэн, судлаачдын дэвшүүлсэн Үндэсний тээврийн дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэгийн газарзүйн маршрут, тэнхлэгийн дагуу болон зангилаан дээр орших өсөлтийн төв Хөгжлийн стратегийн төв хотуудын газарзүйн байршил, эдгээр суурь төлөвлөлттэй уялдуулсан бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үүрэг бүхий боомт, чөлөөт бүс, логистикийн газарзүйн байршил, төлөвлөлтийн саналыг авч үзэхийг зөвлөж байна (Зураг 5.12-ийг харна уу).

6. Дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновац, соёл, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт болон аж үйлдвэр, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, аялал жуулчлал, эрчим хүч, уул уурхай зэрэг эдийн засаг, нийгмийн гол, тэргүүлэх салбаруудын бодлого, төлөвлөлтийг орон зайн агуулгатай болгож, хөгжлийн орон зайн бодлого, төлөвлөлтийг удирдлага болгон, түүнд суурилсан бүс нутаг руу чиглэсэн төлөвлөлт хийж, хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Ингэснээр нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтын хувьд салбар хоорондын уялдааг хангасан төлөвлөлт хийх нөхцөл бүрдэнэ.

7. "Хот" төвтэй кластер бүсүүдийг тодорхойлж, хөрөнгө оруулалтаар дэмжих. Аливаа бодлогын төлөвлөлт нь нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд оршдог. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд хөгжлийн бодлого, төлөвлөлт хийхдээ нийгэм, эдийн засгийн хөгжилд хотын гүйцэтгэх үүргийг төдийлөн тооцохгүйгээр, асуудалд зөвхөн аймаг, сумдын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн

хил хязгаарт баригдаж ирсэн нь төлөвлөлтийн нэг алдаа болжээ. Гэтэл томоохон хотын нийгэм, эдийн засгийн нөлөөлөл, таталцлын цар хүрээ нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн хязгаарыг давж бусад сум, аймаг, бүсийн түвшинд нөлөөлж байна. Үүнийг төлөвлөлтөд тооцох нэг арга зам бол Улсын зэрэглэлтэй Хөгжлийн стратегийн төв хотын **нийгэм, эдийн засгийн нөлөөлөл-таталцлын кластер бүсийг** тодорхойлж, уг бүсэд эрэлт, хэрэгцээ, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хоршилт, төрөлжилтийн нэгдсэн систем бүхий өөр хоорондоо холбогдсон хөгжлийн кластер төлөвлөлт хийдэг болохыг зөвлөж байна.

8. Бүс, орон нутгийн түвшинд зангилаа бүхий холболтын эдийн засгийг бий болгох. Бүс, орон нутгийн түвшинд өсөлтийн төв хот, тээврийн босоо, хэвтээ тэнхлэг, зам, логистик, боомт, чөлөөт бүс, аж үйлдвэр, аялал жуулчлал, агаарын хилийн гарц, 4С онгоцны буудал зэрэг бүсийн хөгжилд үүрэг бүхий хүчин зүйлс нь өөр хоорондоо холбогдож, харилцан бие биеэ тэтгэж хөгжих **эдийн засаг-дэд бүтцийн газарзүйн кластер холболтуудыг** нөхцөлдүүлэх замаар бүс орон нутгийн "татах хүч"-ийг бий болгох.

Хөгжлийн орон зайн төлөвлөлтийн суурь концепцид суурилсан эрхзүй, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэрэгслүүдийг зарлах. Иргэд, хувийн хэвшил хаана ямар хөрөнгө оруулалт хийвэл үр ашигтай байх нь төлөвлөлтийн хувьд тодорхой байх хэрэгтэй. Үндэсний хэмжээнд тодорхойлсон Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн орон зайн төлөвлөлтийн хүрээнд дэвшүүлж буй төлөвлөлтийн шийдлүүдийг хэрэгжүүлэхэд эрхзүй, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэрэгсэл, зөөлөн бодлогын дэмжлэг зайлшгүй шаардлагатай байна. Хөгжлийн орон зайн тухайд баримтлах бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн, газарзүйн бүртгэлд суурилсан хаана, ямар төрлийн эрх зүй, эдийн засаг, хөрөнгө оруулалтын арга хэрэгсэл байж болохыг тодорхойлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад нээлттэй зарлах, бизнесийн таатай орчныг бүрдүүлэхийг зөвлөж байна. Үүнд,

1. Зээлийн хөнгөлөлттэй нөхцөлөөр дэмжих;
2. Газарзүйн бүртгэлд суурилсан тусгай зөвшөөрөл олгох таатай нөхцөлийг бүрдүүлэх
3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зээлийн тавигдах шаардлагад орон зайн агуулга тусгах
4. Газарзүйн бүртгэлд суурилсан татвар, төлбөр, хураамжийн хөнгөлөлттэй нөхцөлөөр дэмжих эрх зүй, эдийн засаг, хөрөнгө оруулалтын арга хэрэгслийг санал болгож байна.

Энэхүү санал болгож буй арга хэрэгслийг нь хөгжлийн орон зайн төлөвлөлтийн суурь үзэл санаа бүхий "үр ашигтай, өндөр бүтээмжтэй" Улсын зэрэглэлтэй хөгжлийн стратегийн төв 5 хот, түүний нийгэм, эдийн засгийн нөлөөлөл-таталцлын кластер бүсэд эн тэргүүнд хэрэгжүүлэхийг зөвлөж байна.



БҮЛЭГ 6.

ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙ БАЙХ ЗАРЧИМ



Тэгш бус байдал гэдэгт орлого, баялгийн төдийгүй боломж, үйлчилгээний тэгш бус хуваарилалтыг ойлгодог. Боломжийн тэгш бус байдал нь хүний эрхийн хэрэгжилтийг алдагдуулж, нийгмийн хөгжилд саад болж байна. Дэлхий даяар тэгш бус байдал аажмаар нэмэгдэж буйн зэрэгцээ Ковид-19 цар тахлын нөлөөгөөр улам нэмэгдэх хандлагатай байна.

6.1. Хөгжлөөс алслагдсан бүлэг

“Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмын хүрээнд АНДЭЗНХ-оос санал болгосон хөгжлөөс алслагдсан бүлгийг тодорхойлох, боломжийн тэгш бус байдлыг үнэлэх арга зүйг ашиглан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд үндэсний болон бүсийн түвшинд тэгш бус байдлыг үнэлэхийн зэрэгцээ нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжээс хамгийн хол хоцорсон бүлгүүдийг тодорхойлов. *Хөдөөгийн, амьжиргааны түвшин доогуур (хамгийн доод 40 хувь) өрхийн бага боловсролтой, идэр насны болон эрэгтэй хүн ам хөгжлөөс хамгийн алслагдсан бүлгээр үнэлэгдлээ.* Мөн хоёрдогч мэдээллийн эх сурвалжаас буюу өмнө хийгдсэн судалгаа, шинжилгээний үр дүн,

тайлан мэдээллийг шинжлэн үзэхэд, *хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, дотоодын шилжигчид, хүүхдүүд, гэр оронгүй тэнэмэл иргэд энэхүү эрсдэлт бүлэгт хамрагдаж байна.* Тухайлбал, дотоодын шилжин суурьшигчид эдийн засаг, нийгэм, эрүүл мэндийн хувьд эрсдэлд өртөж, шилжигч бус иргэдтэй харьцуулахад эмзэг байдлын түвшин нь илүү нэмэгддэг байна. Ялангуяа өндөр настан, бага боловсролтой иргэд, олон хүүхэдтэй, өрх толгойлсон шилжигч өрхүүд илүү эмзэг байна. Гэр оронгүй тэнэмэл иргэд боловсролын түвшин доогуур, архинд хэт донтсон, гэр бүлийн хүчирхийллийн золиос болсон, засан хүмүүжүүлэх эсвэл асрамжийн газраас насанд хүрээд гарсан хүмүүс байна. Түүнчлэн тэдний ахуйн нөхцөл маш хүнд, эрүүл мэндийн үйлчилгээ авч чаддаггүй, даатгалгүй, бичиг баримтгүй, байнга гадуурхалд өртөж байна. Хөгжлөөс алслагдсан буюу хол хоцорсон бүлгийн нөхцөл байдал, учир шалтгааныг нарийвчлан судлах үүднээс дээр дурдсан эрсдэлт бүлгийн зарим бүлэг, тухайлбал, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 15-19 насны өсвөр үеийнхэн болон 20-40 насны залуучуудтай бүлгийн ярилцлага хийсэн.

Шигтгээ 6.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд – Хөгжлөөс алслагдсан бүлэг

Хөгжлийн бэрхшээл болон гадаад төрхөөсөө болж нийгмийн гадуурхалд байнга өртөгдөж, улмаар нийгмээс өөрсдийгөө тусгаарлах хэрэгтэй болдог. Мөн аливаа нийгмийн үйлчилгээний байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байдлаар тохируулга хийгдээгүйгээс үйлчилгээ авах боломжгүй.

...Эмэгтэй, 25 настай: Би 8 настайдаа сургуульд ороход хүүхдүүд маш их шоолж, дээрэлхэж, ялгаварладаг байсан. Тийм учраас сургуулиасаа гарсан. Миний хувьд өсөлтийн хоцролттой, саажилттай. Би насан туршийн боловсролын төвийн сургалтад хамрагдаж бичиг үсэгтэй болсон, мөн мэргэжлийн үнэмлэхтэй болсон.

...Эрэгтэй, 45 настай: Би сургуульд ерөөсөө сураагүй, сонсголын бэрхшээлтэй болохоор хүмүүстэй харилцаж чаддаггүй, сайн дурын ажил хийх их сонирхолтой, ажил олгогч нар ажилд авах дургүй, хүнтэй харилцахад заавал бичиж харьцах хэрэг гардаг, хүмүүс ингэж харилцах дургүй. Одоо гар утастай болсноор мессеж их бичиж, хүнтэй харьцдаг болсон нь бас сайхан байна. Өмнө би хүнтэй харилцахыг маш их хүсдэг байсан.

...Эмэгтэй, 31 настай: Би сэтгэцийн эмгэгтэй, хүмүүс намайг хараад л шоолдог, дээрэлхдэг, бас намайг хуурч, ашиглах сонирхолтой. Зүгээр цалингүй ажил хийлгэдэг. Би хэзээ ч сургуульд суралцаж байгаагүй, сургуульд орох гээд очиход аваагүй.


Эх сурвалж: ҮСДИ 2-ыг бэлтгэх хүрээнд хийгдсэн чанарын судалгааны үр дүнгээс

ИНБ-уудын 2022 онд хийсэн ТХЗ-ын хэрэгжилтийн явцын үнэлгээгээр, хүүхэд, залуучууд, охид эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, хотын захын болон хөдөөгийн иргэд, сэтгэцийн өвчтэй болон LGBTQI хүмүүс хөгжлөөс орхигдох илүү эрсдэлтэй байна гэж үзжээ.


6.2. Хөгжлөөс алслагдсан байдал: Суурь үйлчилгээний хүртээмжийн ялгаа

Нийгмийн суурь үйлчилгээний хувьд 2018 болон 2021 оны байдлаар цэвэр түлшний хэрэглээ, ариун цэврийн байгууламж, ундны усны хэрэглээний түвшин өрх, хүн амын дунд маш их ялгаатай байна. Тухайлбал, улсын дүнгээр 52 хувь нь цэвэр түлш хэрэглэж байгаа ч хамгийн хол хоцорсон бүлэг нь хүртээмж өндөртэй бүлгээсээ даруй 85-94 нэгж хувиар бага хэрэглээтэй байна.

Зураг 6.1. Суурь үйлчилгээний хүртээмж, боломж ба саад бэрхшээлээр, 2018 он



Зураг 6.2. Суурь үйлчилгээний хүртээмж, боломж ба саад бэрхшээлээр, 2021 он



Улсын хэмжээнд ариун цэврийн байгууламжийн хүртээмж 66-68 хувьтай байхад хамгийн хол хоцорсон бүлгийн хувьд хүртээмж өндөртэй бүлгээсээ харьцангуй хол буюу 84 нэгж хувиар бага байна.


Хүн амын ундны усны хангамж улсын хэмжээнд 85 хувь байгаа хэдий ч хамгийн хол хоцорсон болон хүртээмж өндөртэй бүлэг хоорондын зөрүү бараг 70 орчим нэгж хувь байна.

20-35 насны залуучуудын дунд боловсролд хамрагдах байдал 85 хувьтай байгаа ба хамгийн хол хоцорсон болон хүртээмж өндөртэй бүлэг хоорондын зөрүү их байна.

Харин 35 дээш насны хүн амын дунд боловсролд хамрадалт залуучуудтай харьцуулахад бага (69 хувь) байгаагийн зэрэгцээ хөгжлөөс алслагдмал болон хүртээмж өндөртэй бүлэг хоорондын зөрүү илүү өндөр байна. Дээд боловсролын хувьд 25-35 насны залуучуудын дунд боловсролын хүртээмжийн ялгаа өндөр байна. Мөн сургуулийн өмнөх боловсролын хүртээмж улсын хэмжээнд 62 хувь байгаа ч хамгийн хол хоцорсон болон хүртээмж сайтай бүлэг хоорондын зөрүү мөн л 50 гаруй нэгж хувь байна. Энэ нь бүх шатны боловсролын хүртээмжийн тэгш бус байдал өндөр байгааг илтгэж байна.



Зураг 6.3. Тэгш бус байдал (D индекс), 2018, 2021 он




Харин ТХЗ 3, 5, 7, 17-ын хүрээнд, сонгогдсон зарим үзүүлэлтээр харахад, суурь үйлчилгээний хүртээмжийн түвшнээр хамгийн хол хоцорсон болон хүртээмж сайтай бүлэг хоорондын зөрүү харьцангуй бага байна. Боломжоос алслагдсан буюу хөгжлөөс орхигдсон бүлгийг тодорхойлох шинжилгээний үр дүнгээр дараах бүлгүүд **“хамгийн хол буюу ард хоцорсон”** байна. Үүнд:



- » Суурь үйлчилгээний хүртээмж (ундны ус, ариун цэврийн байгууламж, эрчим хүч, цэвэр түлш, интернет болон гар утасны хэрэглээ)-ийн хувьд ялангуяа, цэвэр түлш, ариун цэврийн байгууламж, ундны усны хэрэглээний түвшнээр *хөдөөгийн, амьдралын түвшин доогуур (хамгийн доод 40 хувь), бага боловсролтой өрх, хүн ам* ;
- » Боловсролын үйлчилгээний хүртээмж (сургуулийн өмнөх боловсрол, бүрэн дунд болон дээд боловсрол)-ийн хувьд *хөдөөгийн, амьжиргааны түвшин доогуур (хамгийн доод 40 хувь) өрх, эрэгтэй хүн ам* ;

- » Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн хувьд гэр бүл төлөвлөлтийн үзүүлэлтээр хотын, *15-24 болон 35 ба түүнээс дээш насны, 2-оос доош хүүхэдтэй эмэгтэйчүүд*, төрөх үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хувьд *бага болон дунд боловсролтой, 15-34 насны, хөдөөгийн эмэгтэйчүүд*, тав хүртэлх насны хүүхдийн антропометрийн хэмжилтийн үзүүлэлтээр өсөлтийн хоцролт - амьжиргааны түвшин доогуур (хамгийн доод 40 хувь), 2 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн эрэгтэй хүүхдүүд, илүүдэл жин болон тураал - *амьжиргааны түвшин доогуур (хамгийн доод 40 хувь), хотын өрхийн хүүхдүүд*;
- » Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн байдлын хувьд *амьжиргааны түвшин доогуур (хамгийн доод 40 хувь), бага боловсролтой хүн ам* илүү өртөж байгаа бөгөөд хамгийн хол хоцорсон бүлгийн хүн ам болж байна.



Зураг 6.4. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүн



Эх сурвалж: ӨНЭЭС 2021-д суурилсан судлаачийн тооцоо



Эх сурвалж: НУТС, 2018-д суурилсан судлаачийн тооцоо



Эх сурвалж: ӨНЭЗС 2021-д суурилсан судлаачийн тооцоо

ӨНЭЗС-ны мэдээллийг ашиглан хүн амын эрсдэлт байдлын тэгш бус байдлыг шинжлэн үзэхэд, эрсдэлт байдал (байгалийн аюулт үзэгдэл, гэмт хэрэг/дээрэм, эсвэл хүчирхийлэл, халдлага, хүний үйл ажиллагаатай холбоотой осол зэрэгт өртөх байдал)-ын хувьд **хөдөөгийн, амьжиргааны түвшин доогуур (хамгийн доод 40 хувь)** өрх хамгийн хол хоцорсон бүлэгт хамрагдаж байгаа буюу эдгээр эрсдэлт байдалд өртөх нь бусад бүлгээс өндөр байна. Зайлшгүй хэрэгцээтэй нийгмийн суурь үйлчилгээг өрх, хүн амд тэгш

хүргэх ёстой. Манай улсын хувьд боловсрол (ТХЗ 4), ариун цэврийн байгууламж (ТХЗ 1), ундны ус (ТХЗ 1, ТХЗ 6), цэвэр түлшний хэрэглээ (ТХЗ 7) зэрэг нийгмийн үндсэн суурь үйлчилгээ өрх, хүн амд тэгш хүрэхгүй байна. Ялангуяа, хөгжлөөс алслагдмал буюу хөгжлөөс хоцрох байдал өрх, хүн амын байршил, боловсрол болон амьжиргааны түвшний ялгаатай байдлаас хамаарч байна. Өрх, хүн амын эдгээр нөхцөл байдал нь хүмүүст боломжийг олгох ёстой байтал эсрэгээрээ тэдний хөгжлөөс хүртэх боломжид сөрөг нөлөөтэй байна.



Шигтгээ 6.2. Хөгжлөөс алслагдсан хүн амд тохиолдож буй хүндрэл, бэрхшээлүүд

- Нийгмийн хөгжлөөс орхигдсон эмзэг бүлгийн буюу зорилтот бүлгийнхний дунд мэдээллийн хүртээмжийн тэгш бус байдал их байдаг. Хэдийгээр ихэнх хүмүүс гар утас, интернэт хэрэглэдэг болсон ч нийгмийн сүлжээгээр цацагдаж буй мэдээлэл хуурамч, хэрэглээ бага байх нь түгээмэл. Албан ёсны, үнэн зөв, хэрэгцээтэй нэвтрүүлэг, ялангуяа эрүүл мэнд, боловсролд хувь нэмэр оруулахуйц мэдээлэл түгээх хэрэгтэй байна.
- Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг нийгэмшүүлэх, ажлын байраар хангаж, хамт олонтой болгох (ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд) хэрэгтэй байна. Гэртээ суудаг, гадагшаа гардаггүй хүмүүсийн зан авир өөрчлөгдөж, хүнтэй харилцах ур чадваргүй, зожиг, хэт тусгаарлагдсан болдог.

- Нийгмийн эмзэг бүлэг, ер нь нийт өрх, хүн амын хувьд өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, эм тарианы үнийн хэт өсөлт (ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд маш хүнд тусч байгаа), хуурамч эм тарианы худалдаа, Ковид 19-ын вакцины сөрөг үр нөлөө, цалин хөлсний үнэлэмж хэт бага байгаа нь амьдрал, амьжиргаанд маш хүнд тусч байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулж буй ажил олгогч нар хөгжлийн бэрхшээлийг ойлгодоггүй, энгийн хүнтэй адил ажиллуулж, ачаалал даах чадваргүй гэсэн хандлагаар ялгаварлан гадуурхах үзэгдэл түгээмэл байна. Ялангуяа, уналт, таталт өгдөг ч хөдөлмөр эрхлэх боломжтой иргэд тохирсон ажлын байраар хангагдаж чадахгүй байна.
- Нийгмийн эмзэг бүлэг, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сэтгэл зүйн эмчилгээ, зөвлөгөө өгдөг үйлчилгээ хомс байна.

Эх сурвалж: ҮСДИ 2-ыг бэлтгэх хүрээнд хийгдсэн чанарын судалгааны үр дүнгээс

Нийгмийн суурь үйлчилгээ, тэр дундаа боловсролын тэгш бус байдал 35 ба түүнээс дээш насны бүлгийнхний дунд өндөр байгаа тул нийгмийн хөгжлийн чиг хандлага, хувь хүний эрх ашигт нийцсэн боловсролыг насан туршдаа тасралтгүй эзэмших боломжийг бүрдүүлэх, иргэн амьдралын чанараа дээшлүүлэхэд шаардагдах боловсролын агуулгыг түгээхэд чиглэсэн насан туршийн боловсролын тогтолцоог бэхжүүлэх, хот хөдөөгийн боловсролын үйлчилгээний чанарын ялгааг бууруулахад анхаарах хэрэгтэй байна. Насан туршийн боловсролын тогтолцоо нь амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн хөтөлбөр эсвэл бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөр бус тодорхой боловсрол эзэмшээд ажлын байран дээр гарсан ч дахин чадавхжих боломжийг олгодог байх ёстой. Ялангуяа, хөдөөгийн, амьжиргааны түвшин доогуур өрхийн эрэгтэйчүүдийн боловсролын түвшнийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Эрэгтэйчүүдийн боловсролын түвшнийг дээшлүүлснээр гэр бүлийн хүчирхийлэл буурах, өрхийн амьжиргааны түвшнийг эрс сайжруулахад эерэг нөлөө үзүүлнэ. Амьжиргааны түвшин доогуур (хамгийн доод 40

хувь) өрхийн цэвэр түлшний хэрэглээ болон ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн түвшин бага байгаа нь тухайн бүлгийн өрх, хүн амын эрүүл мэндийн эрсдэлийг нэмэгдүүлэн, эрүүл амьдрах эрхийг хязгаарлаж байна. Иймд эдгээр өрхийн амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ тухайлбал, ядуу эмзэг бүлгийн өрхийн хямд өртөгтэй, утаа тортог ихтэй түлшний хэрэглээг бууруулах хэрэгтэй. Мөн нийгмийн халамжийн хүрээнд зохион байгуулагддаг олон нийтийн оролцоонд суурилсан нийтийн ажил болон орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэгтэйгээр эдгээр өрхийн ариун цэврийн байгууламжийн нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Өрх, хүн амд нийгмийн нийтлэг суурь үйлчилгээг хүргэж буй аж ахуйн нэгж байгууллага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг өөрсдийн үйл ажиллагаанд мөрдлөг болгож, хүний эрхийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, олон нийт үүнд хяналт тавьж, бүх талын оролцоог хангасан нийгмийн үйлчилгээний хүртээмжийн хяналтын механизмыг цаашид бий болгох хэрэгтэй.



ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Энэхүү ҮСДИ-ээр Монгол Улсад ТХЗ-ыг хэрэгжүүлэх бодлогын орчин, институцийн тогтолцоонд гарсан өөрчлөлт, хэрэгжилтийн ахиц дэвшил, цар тахал, геополитикийн зөрчилдөөний ТХЗ-ын хэрэгжилтэд үзүүлсэн нөлөө, тулгамдаж буй асуудлууд, бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хязгаарлаж буй гол асуудлуудыг тодорхойлж, тогтвортой хөгжлийг хангахад анхаарах бүс, орон нутгийн хөгжлийн сорилтуудыг авч үзэн, дараах байдлаар дүгнэлээ. Үүнд:

- » Монгол Улс хөгжлийн бодлого, төлөвлөлтийн институцийн эрхзүйн орчныг сайжруулж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгээр дамжуулан ТХЗ-ын хэрэгжилтийг хангахын төлөө хүчин чармайлт гарган ажиллаж байна. Засгийн газар, олон улсын байгууллагуудын тогтвортой хөгжлийн төлөөх түншлэл өргөжиж, төр, хувийн хэвшлийн санаачилга, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо идэвхжин, олон талт хамтын ажиллагаа улам бэхэжсээр байгаа хэдий ч олон нийтийн дунд ТХЗ-ын талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй, оролцоо бага байна.
- » ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийн бэлэн байдлыг сайжруулах хүрээнд шалгуур үзүүлэлтийн тоог нэмэгдүүлж, статистик мэдээллийн олон төрлийн эх сурвалжийг эрэлхийлж байна. Гэвч Монгол Улсын ТХЗ-ын үндэсний шалгуур үзүүлэлт, тэдгээрийн зорилтот түвшнийг албан ёсоор баталгаажуулаагүй байгаа нь ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг тайлагнах, хянах, үнэлэхэд учир дутагдалтай байна.
- » ТХЗ-ын хэрэгжилтийн тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээний механизм сул, олон талт оролцоо хангагдахгүй байна.
- » Монгол Улс Тогтвортой хөгжлийн 15 зорилгын хүрээнд тодорхой түвшний ахиц гарсан бол Ядуурлыг бууруулах зорилгын хувьд 2014 оны суурь түвшинтэй харьцуулахад өссөн байгаа нь энэ чиглэлийн арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. 2030 оны зорьсон түвшиндээ хүрэхийн тулд нийт хэмжих боломжтой зорилтын 27,6 хувийн одоогийн хэрэгжилтийн ахицыг хадгалах, 54,5 хувийн хэрэгжилтийг нэн даруй эрчимжүүлэх, харин 17.2 хувьд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.
- » Монгол Улсын хувьд боловсролын хүртээмж, ариун цэврийн байгууламж, ундны ус, цэвэр түлшний хэрэглээ зэрэг нийгмийн суурь үйлчилгээ өрх, хүн амд тэгш хүрэхгүй байгаа нь тэдгээрийн байршил, боловсрол, амьжиргааны түвшний ялгаатай байдлаас ихээхэн шалтгаалж байна.
- » Цар тахал, геополитикийн зөрчилдөөн нь ТХЗ-ын хэрэгжилтэд хүчтэй нөлөө үзүүлжээ. Ялангуяа, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдлыг нэмэгдүүлж, түлш, түүхий эд, эрчим хүчний үнэ өсөж, тээвэр, логистик, нийлүүлэлтийн сүлжээнд тасалдал гарснаар бизнесийн үйл ажиллагаа, өрхийн амьжиргааны түвшин, эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг бууруулжээ. Мөн ажил эрхлэлт, орлогын бууралт, хүнс, тэжээлийн хомсдол, хөл хорио, цахим шилжилтийн үр дагавраар нийгмийн бухимдал нэмэгдэж, олон улсын хүний эрхийн хуулиар хориглосон ялгаварлан гадуурхах явдал ихсэх хандлагатай байна.
- » Нийтийг хамарсан цар тахал дэгдэх үед олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх чадавх сул, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн бэлэн байдал хангагдаагүй байсан нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжид сөрөг нөлөө үзүүлсэн байна.
- » ТХЗ-ын хэрэгжилтийг хангахад бүс, орон нутгийн хөгжлийн ялгаатай байдал томоохон хязгаарлагч хүчин зүйл болж буйг онцолж, тулгамдсан 37 асуудлыг тодорхойлсон ба үүнд нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгаа, хөдөө, орон нутгаас суурин газар, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, хөдөөгийн малчин өрхийн эмзэг байдал, Улаанбаатар хот дахь хүн амын хэт төвлөрөл зэрэг асуудлуудыг авч үзсэн.
- » Нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгааг бууруулахад чиглэсэн эдийн засгийн газарзүйн бодлогыг хэрэгжүүлснээр бүс, орон нутгийн түвшинд ядуурал, тэгш бус байдлыг бууруулах, ажиллах хүчний нөөцийг оновчтой хуваарилах, эдийн засгийн чадавхыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд хөдөөгийн иргэд, нийгмийн эмзэг бүлэг, эдийн засгийн гол салбаруудын дасан зохицох чадавхыг бэхжүүлэх зэргээр ТХЗ-ыг хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой.



ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Хяналт, тайлагнал, үнэлгээний тогтолцоог сайжруулах:

- » ТХЗ-ыг Монгол Улсын дунд, богино хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулах ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтийг хангахын тулд төрийн бүх шатны байгууллагууд хамтын ажиллагааг сайжруулах;
- » ТХЗ-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналын олон талт оролцоотой механизмыг бүрдүүлж, хариуцлагын тогтолцоотой уялдуулах;
- » ТХЗ-ыг хэрэгжүүлэх санхүүжилт, хөрөнгө оруулалтын орчныг тодорхой болгож, олон талын оролцоог идэвхжүүлэх арга хэрэгсэл болгон ашиглах;
- » ТХЗ-ын хэрэгжилтэд иргэд, олон нийтийн, ялангуяа хүүхэд, залуучуудын мэдлэгийг дээшлүүлж, идэвхтэй, тууштай оролцоог бий болгох, тэдний санаачилга, хүчин чармайлтыг дэмжих замаар оролцоонд суурилсан хөгжлийн үйл явц, шийдвэр гаргалтыг нийгмийн соёл болгож хэвшүүлэх.

ТХЗ-ын хэрэгжилтийн ахиц дэвшлийг сайжруулах:

- » Монгол Улсын ТХЗ-ын үндэсний шалгуур үзүүлэлтийн хүрээг албан ёсоор баталгаажуулах, ТХЗ-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналыг сайжруулах;
- » Хэрэгжилтийн түвшин нь хангалтгүй үнэлэгдсэн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүдэд ахиц гаргах, ялангуяа ядуурлыг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхэд бүх оролцогч талуудыг дайчлах.

Цар тахал, геополитикийн зөрчилдөөнийг даван туулах:

- » Нийтийг хамарсан зөрчил, мөргөлдөөн, нийгмийн халдварт өвчин, байгалийн гамшигт үзэгдлийг даван туулах, эрсдэлийг бууруулах, сөрөг нөлөөг багасгах, дасан зохицох үндэсний хэмжээний чадавхыг сайжруулах;
- » Олон улсын түншлэл төдийгүй үндэсний болон бүс, орон нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, технологи, хүний нөөцийн эх үүсвэрийн бэлэн байдлыг хангах зэргээр нийгэм, эдийн засгийн суурь чадавхыг бэхжүүлэх.

Бүс, орон нутгийн хөгжлийн шийдлийг оновчтой тодорхойлох:

- » Бүс, орон нутгийг хөгжүүлэхтэй холбоотой эрхзүйн зохицуулалт, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн тогтолцоог улам тодорхой болгох;

- » Нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг харгалзан "Хотын зэрэглэл, статус, үүрэг"-ийн тогтолцоог тодорхойлж, хотуудад зэрэглэл, статус, үүрэг олгож хөдөө, орон нутагт хотын эдийн засаг, нийгэм, соёлын үйлчилгээг ойртуулах;
- » Хөгжлийн орон зайн төлөвлөлт, газарзүйн байршилд суурилсан бүс, орон нутагт шилжин суурьших үйл явцыг дэмжсэн эрх зүй, эдийн засаг, хөрөнгө оруулалтын арга хэрэгслүүдийг тодорхойлох;
- » Эдийн засгийн тэргүүлэх салбарууд, дээд боловсрол, инновац, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл зэрэг нийгмийн үйлчилгээний гол салбаруудын бодлого, төлөвлөлтөд хөгжлийн орон зайн төлөвлөлтийг удирдлага болгон, түүнд суурилан хэрэгжүүлэх;
- » Бүсийн түвшинд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспорт, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үүрэг бүхий тээврийн дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэг, түүнд суурилсан тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг бий болгох;
- » Нэг талаас, улсын зэрэглэлтэй хот, томоохон хот хоорондын нийгэм, эдийн засгийн нөлөөлөл-таталцлын кластер бүсийг тодорхойлж, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хоршилт, төрөлжилтийн нэгдсэн систем бүхий хөгжлийн төлөвлөлт хийх, нөгөө талаас, бүс, орон нутгийн түвшинд харилцан бие биеэ тэтгэж хөгжих эдийн засаг-дэд бүтцийн газарзүйн кластер холболтуудыг нөхцөлдүүлэх замаар бүс орон нутгийн "татах хүч"-ийг бий болгох.

Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх:

- » Өрх, хүн амд нийгмийн нийтлэг суурь үйлчилгээг зайлшгүй хүргэхдээ "хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим"-ыг баримтлан нийгмийн үйлчилгээг хүргэж буй аж ахуйн нэгж байгууллага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаанд мөрдлөг болгох. Мөн хүний эрхийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, олон нийт үүнд хяналт тавьж, бүх талын оролцоог хангасан нийгмийн үйлчилгээний хүртээмжийн хяналтын механизмыг бий болгох;
- » Боловсролын тэгш бус байдлыг бууруулахын тулд нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн боловсролыг насан туршдаа тасралтгүй эзэмших боломжийг бүрдүүлэх, иргэн амьдралын чанараа дээшлүүлэхэд шаардагдах боловсролын агуулгыг түгээхэд чиглэсэн насан туршийн боловсролын тогтолцоог бэхжүүлэх.



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. IMF. (2021 оны November 29). Mongolia: 2021 Article IV Consultation-Press Release; Staff Report; and Statement by the Executive Director for Mongolia. IMF eLibrary: [https://www.elibrary.imf.org/configurable/content/journals\\$002f002\\$002f2021\\$002f251\\$002farticle-A001-en.xml?t:ac=journals%24002f002%24002f2021%24002f251%24002farticle-A001-en.xml](https://www.elibrary.imf.org/configurable/content/journals$002f002$002f2021$002f251$002farticle-A001-en.xml?t:ac=journals%24002f002%24002f2021%24002f251%24002farticle-A001-en.xml)-ээс Гаргасан
2. IMF. (2021). World Economic Outlook. Washington, DC : IMF.
3. International Labour Organization. (December 2021). The State of Informal Employment in Mongolia: Survey Report. Ulaanbaatar: International Labour Organization, Ministry of Labour and Social Protection of Mongolia and Research Institute of Labour and Social Protection.
4. Schwab, K. (2022). Risks That May Occur in the Coming Years to the World. (W. E. 2022, Ярилцагч)
5. SWIFT. (2022 оны March 20). An update to our message for the Swift Company. SWIFT: <https://www.swift.com/news-events/news/message-swift-community>-ээс Гаргасан
6. United Nations. (2017, 2019, 2021). Global Survey on Trade Facilitation and Paperless Trade Implementation. UN Regional Commissions: <https://www.untfsurvey.org/>.
7. World Bank. (2022). Mongolia Trade. World Integrated Trade Solution: <https://wits.worldbank.org/CountrySnapshot/en/MNG-ээс> Гаргасан
8. Дэлхийн банк. (2018). Монголын эдийн засгийн тойм: Тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтөд чиглэсэн төсвийн бодлого, улсын хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах нь. Улаанбаатар: World Bank Group.
9. Дэлхийн банк. (2022 оны 4-р сар). Монголын эдийн засгийн тойм: Шуурган дунд зүг чигээ олохуй. Улаанбаатар: Дэлхийн банк.
10. Дэлхийн банк, ҮСХ. (2020). Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа. УБ: ҮСХ.
11. МИРИМ Консалтант ХХК. (2022). Монгол Улс дахь дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа. Улаанбаатар: Европын холбооны Switch-Asia хөтөлбөрийн санхүүжилттэй "Монгол Улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төсөл.
12. Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс. (2021). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл. Улаанбаатар: Соёмбо принтинг .
13. Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс. (2022). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
14. Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улсын их сургууль. (2022 оны 2 дугаар сар). Монгол дахь КОВИД-19 цар тахлын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ судалгааны үр дүнгийн тайлан. Улаанбаатар.
15. Монголбанк. (2020 оны 12-р сар). Инфляцын тайлан. Улаанбаатар: <https://www.mongolbank.mn/file/f21426dbf69afca2e1326cd327d3117f/files/202012.pdf>.
16. Монголбанк. (2021 оны 12-р сар). Инфляцын тайлан. Улаанбаатар: <https://www.mongolbank.mn/mn/r/3021>.
17. Монголбанк. (2021 оны 9-р сар). Инфляцын тайлан. Улаанбаатар: <https://www.mongolbank.mn/mn/r/3022>.
18. Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим. (2021). Бизнес итгэлийн индекс. Улаанбаатар: Судалгааны тайлан.
19. МҮХАҮТ, ҮСХ. (2022). Монгол Улсын экспортлогч аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдал сэдэвчилсэн судалгаа. УБ: МҮХАҮТ.
20. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газар. (2021). Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг болон тогтвортой хөгжлийн зорилго хоорондын уялдаа, тойм шинжилгээ. Улаанбаатар: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр.
21. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт. (2021). Монгол Улсын албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал судалгааны тайлан. Улаанбаатар: Олон улсын хөдөлмөрийн байгууллага.
22. ҮСХ. (2021). Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд КОВИД-19 халдварын тархалтаас



- урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөллийн тандалт судалгааны тайлан. Улаанбаатар: ҮСХ.
23. ҮСХ, Сангийн яам, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв, МУИС, НҮБХХ. (2021). КОВИД-19 цар тахлын үеийн ядуурал тэгш буй байдлыг их өгөгдөл ашиглах судлах нь. Монгол Улс: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр.
 24. Эдийн засаг, хөгжлийн яам. (2023). Динамик тооцоологддог ерөнхий тэнцвэрийн загвар ашиглан хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нөлөөг тооцсон судалгаа. Улаанбаатар: ЭЗХЯ.
 25. А.Солонго, Б.Энхцэцэг, Ц.Болормаа. 2020. "Хүний хөгжил" сурах бичиг. МУИС ПРЕСС хэвлэлийн газар. ISBN: 978-99195-0-407-6. УБ.
 26. Lee, E. S. (1966). A Theory of Migration. *Demography*, 3(1), 47–57. <https://doi.org/10.2307/2060063>.
 27. М.Алтанбагана. 2023.01.04. "Нийгэм, улс төр, эдийн засгийн тулгамдсан асуудал: гарц, шийдэл" эрдэм шинжилгээний бага хурал. Сэдэв: "Төвлөрлийг сааруулж, түгжрэлийг бууруулах нь: Орон зайн шинэ төлөвлөлт". Төрийн ордон. УБ.
 28. Ц.Отгонхүү нар. 2022. "Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн зарим асуудлууд" Монголын хүн амын сэтгүүл, №32, ISSN 2226-1389, Хуудас 21-32.
 29. П.Цэенханд, Г.Урантамир, М.Алтанбагана. 2022. "Дархан хотын нийгэм, эдийн засгийн нөлөөлөл-таталцлын кластер бүс тодорхойлох судалгаа". Хүрэл тогоот 2022 эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Хуудас 113-120 УБ.
 30. ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн. 2022. "Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний орон зайн зүй тогтол, нөлөөлөх хүчин зүйлс (2022-2024)" суурь судалгааны төслийн тайлан. УБ.
 31. Institute of Geography and Geoecology, MAS. 2022. International joint project on "Strengthening Local Adaptation Plan Through Integrating Socio-Economic Vulnerability Assessment and Policy Gap Analysis in Mongolia and China (CRRP2022-09MY- Myagmarsuren)". Funding by Asia-Pacific Network on Global Change Research (APN).
 32. ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн. 2022. "Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний орон зайн зүй тогтол, нөлөөлөх хүчин зүйлс (2022-2024)" сэдэвт суурь судалгааны төслийн тайлан. БШУЯ, ШУТИС. УБ.
 33. ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэн. 2023. "Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний орон зайн зүй тогтол, нөлөөлөх хүчин зүйлс (2022-2024)" суурь судалгааны төслийн тайлан. УБ.
 34. М.Алтанбагана, Ц.Отгонхүү, Б.Хэрлэнбаяр, М.Баяржаргал. 2020. "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн онолын үндэс, нэгдсэн аргазүй, аргачлалыг шинэчлэн боловсруулах" суурь судалгааны төсөл. ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн. УБ.
 35. М.Алтанбагана, Г.Урантамир нар. 2022. "Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн орон зайн төлөвлөлт-шийдлийн зураглал, суурь концепц" бодлогын санал, зөвлөмж. ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн. "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн онолын үндэс, нэгдсэн аргазүй, аргачлалыг шинэчлэн боловсруулах (2019-2021)" суурь судалгааны тайлан. УБ.
 36. Монгол Улсын Шинжлэх ухааны академи, ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн. 2022. "Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн орон зайн төлөвлөлт-шийдлийн зураглал, суурь концепц" бодлогын санал, зөвлөмж. "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн онолын үндэс, нэгдсэн аргазүй, аргачлалыг шинэчлэн боловсруулах (2019-2021)" суурь судалгааны төслийн үр дүнд тулгуурлан дэвшүүлсэн. УБ.
 37. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол. УБ.
 38. Шинэ сэргэлтийн бодлого. УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол. УБ.
 39. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр. УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол. УБ.
 40. Хүчингүй болсонд тооцох тухай. УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоол. УБ.
 41. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин. УИХ-ын 2020 оны 52 дугаар



- тогтоолын 3 дугаар хавсралт. УБ.
42. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол. УБ.
 43. Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл батлах тухай. УИХ-ын 2001 оны 09 дүгээр тогтоол. УБ.
 44. "МЯНГАНЫ ЗАМ" төсөл 21 жилийн хугацаанд бүрэн хэрэгжиж дууслаа. <https://montsame.mn/mn/read/299712>
 45. Шинэ сэргэлтийн бодлого. УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол. УБ.
 46. Хөдөөгийн сэргэлт үндэсний чуулган. Сангийн сайд Б.Жавхлан илтгэл. "Төвлөрлийг сааруулах хүрээнд Засгийн газрын дэмжлэгтэйгээр олгогдох дэмжлэгүүд". 2023.03.10. УБ.
 47. Монгол Улсын Үндэс хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь заалт. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
 48. Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол. УБ.
 49. Бүсийн хөгжлийн хөтөлбөр. Засгийн газрын 2005 оны 202 дугаар тогтоол. УБ.
 50. Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар батлах тухай. Засгийн газрын 2022 оны тогтоол 75 дугаар тогтоол. УБ.
 51. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ), 2021. Монгол Улсын Их Сургуулийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төв болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Маастрихтын Инноваци, Технологийн Эдийн Засаг, Нийгмийн Судалгааны Хүрээлэн, 2021. Монгол Улс: Шилжилт Хөдөлгөөн ба Хөдөлмөр Эрхлэлт. ОУШХБ. УБ.
 52. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ), 2021. Монгол Улсын Их Сургуулийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төв болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Маастрихтын Инноваци, Технологийн Эдийн Засаг, Нийгмийн Судалгааны Хүрээлэн, 2021. Монгол Улс: Шилжилт Хөдөлгөөн ба Хөдөлмөр Эрхлэлт. ОУШХБ. УБ.
 53. ҮСХ. 2022. "Монгол Улсын бүсчилсэн хөгжил ба дотоод шилжилт хөдөлгөөн" сэдэвчилсэн судалгаа. УБ.
 54. UN HABITAT report. World Cities Report 2022 - UN-Habitat. <https://unhabitat.org>
 55. ҮСХ. 2017. Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо. УБ.
 56. Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар. "Эдийн засгийн бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлал" илтгэл. "Хөдөөгийн сэргэлт" чуулган. 2023.03.10. Улаанбаатар.
 57. М.Алтанбагана, П.Цэенханд нар. 2023. "Хотуудад улс, аймгийн зэрэглэл тогтоох, хот, тосгодын чиг үүрэг, статусыг тодорхойлох судалгаа" сэдэвт шинжлэх ухаан, технологийн захиалгат төслийн тайлан. БШУЯ, ШУТС, БХБЯ, ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн.
 58. Altanbagana Myagmarsuren, Mungunchimeg Batkhuyag. 2021. "The Role of Education in Strengthening the Resilience of Pastoral Systems to Climate Change Adaptation". Proceedings of the Environmental Science and Technology International Conference (ESTIC 2021). Atlantis Press, Springer Nature. Link: <https://www.atlantis-press.com/proceedings/estic-21/125962232>
 59. Altanbagana Myagmarsuren, Saruul Galtbayar "Climate Change Impact on Social and Economic Sectors in Mongolia". Proceedings of the Environmental Science and Technology International Conference (ESTIC 2021). Atlantis Press, Springer Nature. Link: <https://www.atlantis-press.com/proceedings/estic-21/125962220>.
 60. IPCC, 2022: Climate Change 2022: Impacts, Adaptation and Vulnerability. Contribution of Working Group II to the Sixth Assessment Report of the Intergovernmental Panel on Climate Change [H.-O. Pörtner, D.C. Roberts, M. Tignor, E.S. Poloczanska, K. Mintenbeck, A. Alegría, M. Craig, S. Langsdorf, S. Löschke, V. Möller, A. Okem, B. Rama (eds.)]. Cambridge University Press. Cambridge University Press, Cambridge, UK and New York, NY, USA, 3056 pp., doi:10.1017/9781009325844.
 61. Institute of Geocology and Geology, MAS, Battogtokh D., Altanbagana M., Sainbuyan B. (2018). "Developing the methodology of industrial spatial planning and mapping". UB
 62. Institute of Geocology and Geology, MAS, Altanbagana M., Urantamir G., Tseyenkhand P. (2022). Commissioned research project "A study on the ranking of cities in the country and province, and the determination of the functions and status of cities and villages".



63. IUCN. (2001). Red List categories and criteria, version 3.1. ISBN 978-2-8317-0633-7.
64. Landscapes of Dauria. <https://whc.unesco.org/en/soc/4258/>.
65. Ministry of Environment and Tourism. (2020). Desertification map of Mongolia. [Online] <https://eic.mn/dldbbase/>.
66. Ministry of Environment and Tourism. (2019). Red List of Plants of Mongolia. УБ.
67. UN HABITAT. New Urban Agenda. <https://unhabitat.org/about-us/new-urban-agenda>.
68. UNESCO Biosphere reserves in Asia and the Pacific. <https://en.unesco.org/biosphere/aspac>
69. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол. УБ.
70. Байгаль орчин, аялал жуулчлалын яам.2019. "Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он". УБ.
71. Байгаль орчин, аялал жуулчлалын яам.2019. "Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он". УБ.
72. Байгаль, орчин, аялал жуулчлалын яам. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний 4 дүгээр тайлан, илтгэл. УБ.
73. Байгаль орчин, аялал жуулчлалын яам.2019. "Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он". УБ.
74. Байгаль орчин, аялал жуулчлалын яам.2019. "Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он". УБ.
75. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги. Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоол. УБ.
76. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2019. Үндэсний статистикийн хороо. УБ
77. Монгол орны усны сав газар. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 2009 оны 11 сард 332 тоот тушаал. УБ.
78. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол. УБ.
79. М.Ургамал. 2017. Ургамалын олон янз байдлыг хамгаалах ба улаан данс (4.2 бүрэг). Монгол орны байгаль орчин (I-V боть) бүтээлийн "Монгол орны биологийн олон янз байдал" боть III. Байгаль орчин, аялал жуулчлалын яам. УБ.
80. "Сав газрын зарим захиргаадыг татан буулгаж, нэгтгэн зохион байгуулах, байршлыг тогтоох, бүтэц, орон тоо, дүрмийг батлах тухай". БОНХАЖС-ын 2016.03.24-ны өдрийн №А/83 дугаар тушаал. УБ. ҮСХ. 2021. Хүн ам, орон сууцны улсын 2020 оны тооллогын дүн. УБ.
81. Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн. <https://eic.mn/dldbbase/>
82. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт. Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоол. УБ"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58-р зарлиг. УБ. <https://president.mn/20893/>
83. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний үр дүнд үр, тарьц, суулгацын нөөц 4 дахин нэмэгджээ. <https://president.mn/25146/>



ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтийн тоон мэдээлэл

Д/д	Шалгуур үзүүлэлтүүд	Суурь он	Суурь түвшин	2018	2020	2021	Зорилт-2030
Зорилго 1. Ядуурлыг бууруулах							
1	1.1.1. Ядуурлын олон улсын түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын нийт хүн амд эзлэх хувь	2014	0.30	0.7			0.4
2	1.2.1. Ядуурлын үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын нийт хүн амд эзлэх хувь, насны бүлэг, хот, хөдөө, бус, суурьшлаар	2014	21.6	28.4	27.8		15.0
	Насны бүлэг						
	0-18	2014	28.5	36.4	35.7		20.0
	19-29	2014	19.1	26.3	24.1		15.0
	30-39	2014	21.6	30.0	30.8		15.0
	40-49	2014	18.0	22.8	23.3		15.0
	50-59	2014	13.3	17.7	15.3		10.0
	60<	2014	10.0	13.4	13.5		10.0
	Хот/хөдөө						
	Хот	2014	18.8	27.2	26.5		15.0
	Хөдөө	2014	26.4	34.9	30.5		15.0
	Бус						
	Баруун бус	2014	26.0	31.8	31.5		15.0
	Хангайн бус	2014	25.3	30.8	31.4		15.0
	Төвийн бус	2014	22.2	26.1	25.2		15.0
	Зүүн бус	2014	31.4	37.4	33.3		15.0
	Улаанбаатар	2014	16.4	25.9	25.4		15.0
Суурьшил							
Нийслэл	2014	16.4	25.9	25.4		15.0	
Аймгийн төв	2014	23.8	30.1	29.1		15.0	
Сумын төв	2014	24.7	28.9	30.5		15.0	
Хөдөө нутаг	2014	27.9	32.9	30.5		15.0	
3	1.4.1. Суурь үйлчилгээнд хамрагдсан өрхөд амьдардаг хүн амын нийт хүн амд эзлэх хувь, үйлчилгээний төрлөөр						
	Баталгаат ундны усны үйлчилгээг хүртдэг хүн амын эзлэх хувь			82.5			87.0
	Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн үйлчилгээг хүртдэг хүн амын эзлэх хувь			69.0			75.0
	Цахилгаан эрчим хүчний үйлчилгээг хүртдэг хүн амын эзлэх хувь	2010	96.7	98.1			100.0
	Хөдөлгөөнт холбооны сүлжээний үйлчилгээг хүртдэг хүн амын эзлэх хувь: 3G хэрэглэгч	2015	71.0				85.0
Хөдөлгөөнт холбооны сүлжээний үйлчилгээг хүртдэг хүн амын эзлэх хувь: 4G хэрэглэгч						70.0	
4	1.5.1. Гамшгийн улмаас амь насаа алдсан, сураггүй болсон, шууд нэрвэгдсэн хүний тоо (100,000 хүн амд ногдох)	2015	1,106.4	363.3	192.8		265.0
	Амь насаа алдсан, сураггүй алга болсон хүн						5.9
	Шууд нэрвэгдсэн хүн						270.0
5	1.5.2. Гамшгийн улмаас учирсан эдийн засгийн шууд хохирлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2015	0.5	0.3	0.1		0.0
6	1.5.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны суурь баримт бичигтэй уялдуулсан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратегийг баталж, хэрэгжүүлдэг эсэх (Тийм-1, Үгүй-0)	2015	1	1	1	1	1
7	1.5.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратегийн дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн стратегийг баталж, хэрэгжүүлдэг орон нутгийн засаг захиргааны эзлэх хувь			27.2	100.0		100.0
Зорилго 2. Хүнсний аюулгүй байдлыг хангаж, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэн дэмжих							
8	2.2.1. Өсөлтийн хоцролттой 5 хүртэлх насны хүүхдийн тухайн насны хүүхдэд эзлэх хувь (биеийн өндөр, насны харьцаа нь ДЭМБ-аас боловсруулсан хүүхдийн өсөлтийн стандарт харьцааны голчоос стандарт хазайлт нь " - 2"-оос бага)	2013	10.8	9.4			3.0

9	2.2.2. Хоол тэжээлийн дутагдалтай болон илүүдэл жинтэй 5 хүртэлх насны хүүхдийн тухайн насны хүүхдэд эзлэх хувь, төрлөөр (Биеийн жин, өндрийн харьцаа нь ДЭМБ-аас боловсруулсан хүүхдийн өсөлтийн стандарт харьцааны голчоос стандарт хазайлт нь "+2"-оос их, "-2"-оос бага)							
	Туранхай	2013	1.0	0.9			0.5	
	Илүүдэл жинтэй	2013	10.5	10.5			7.9	
10	2.2.3. Жирэмсэн эмэгтэйчүүдийн цус багадалтын тархалт, хувь	2015	3.9	3.4	3.6		4.0	2.6
11	2.5.1. Урт болон дунд хугацаанд зориулалтын хадгалалтын байгууламжид байгаа хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр ашиглах ургамал, амьтны генетикийн нөөцийн хэмжээ							
	Ургамлын генетик нөөц, мянган ширхэг	2015	20.6	21.5	14.8		15.1	25.0
	Амьтны генетик нөөц, мянган ширхэг	2015	55.7	53.6	61.5		31.5	86.0
12	2.а.1. Улсын нэгдсэн төсвийн зарлагын хөдөө аж ахуйн чиг баримжааг тодорхойлох индекс	2015	0.04	0.06	0.08		0.08	0.12
13	2.б.1. Хөдөө аж ахуйн экспортын татаас	2015	0	0	0		0	0
Зорилго 3. Эрүүл мэндийг дэмжих								
14	3.1.1. Эхийн эндэгдлийн харьцаа (100,000 амьд төрөлтөд ногдох)	2015	25.97	27.09	30.16		94.89	15.00
15	3.1.2. Эмнэлгийн мэргэжилтний эх барьсан төрөлтийн эзлэх хувь	2015	97.65	99.25	99.17		99.20	99.80
16	3.2.1. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1,000 амьд төрөлтөд ногдох)	2015	18.25	16.90	13.97		13.86	9.00
	Нялхсын эндэгдлийн түвшин (1,000 амьд төрөлтөд ногдох)	2015	15.26	13.38	11.51		11.57	8.00
17	3.2.2. Нярайн эндэгдлийн түвшин (1,000 амьд төрөлтөд ногдох)	2015	10.18	8.67	7.82		8.25	5.00
18	3.3.1. ХДХВ-ийн халдваргүй 1,000 хүн амд ногдох тухайн жилд ХДХВ-ийн халдвар авсан хүний тоо	2015	0.006	0.006	0.008		0.005	0.005
19	3.3.2. Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (100,000 хүн амд ногдох)	2015	144.06	110.73	103.53		71.01	40.70
20	3.3.4. В вирус гепатит өвчлөлийн түвшин (100,000 хүн амд ногдох)	2015	16.30	8.52	4.43		1.83	0.50
21	3.4.1. Зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин (10,000 хүн амд ногдох)	2015	33.91	34.52	31.10		35.09	23.58
	Зүрх судасны өвчин	2015	18.86	18.88	16.19		18.93	14.00
	Хорт хавдар	2015	13.45	13.97	13.21		13.89	8.00
	Чихрийн шижин өвчин	2015	0.64	0.57	0.82		1.13	0.79
	Амьсгалын замын архаг өвчин	2015	0.95	1.10	0.89		1.14	0.79
22	3.4.2. Амиа хорлолын түвшин, хүйсээр (10,000 хүн амд ногдох)	2015	16.16	14.09	13.98		14.71	10.00
	Эрэгтэй	2015	28.01	24.45	24.15		25.41	16.40
	Эмэгтэй	2015	4.71	4.05	4.10		4.32	3.60
23	3.5.1. Мансууруулах бодис хэрэглэх эмгэгтэй хүмүүсийн эмчилгээнд хамрагдалтын хувь (эмийн эмчилгээ, сэтгэлзүйн эмчилгээ, нийгмийн нөхөн сэргээх-нийгэмшүүлэх тусламж)			16.5				30.0
24	3.5.3. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэгчдийн хувь	2013	10.3					11.0
25	3.6.1. Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (10,000 хүн амд ногдох)	2015	19.06	16.52	15.10		14.26	7.50
26	3.7.1. Гэр бүл төлөвлөлтийн хэрэгцээгээ жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргаар хангасан нөхөн үржихүйн (15-49) насны эмэгтэйчүүдийн тухайн насны жирэмслэх боломжтой эмэгтэйчүүдэд эзлэх хувь	2013	77.3	63.9				85.0
27	3.7.2. Өсвөр насны 1,000 охидод ногдох тухайн насны бүлгийн охидын төрөлтийн түвшин, насны бүлгээр							
	10-14 насны охидын төрөлтийн түвшин	2015	0.10	0.12	0.08		0.12	0.00
